

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ  
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ  
**ПОЛИТОЛОГИ**  
№ XVIII (534)

МУИС ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР  
2020 он

# ПОЛИТОЛОГИ XVIII ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18 (534)

XVII

ISSN 2227-6904

Key title: Политологи

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

**Эрхлэгч:**

**Нарийн бичгийн дарга:**

**Гишүүд:**

профессор Ж.Төртогтох  
дэд профессор Ц.Батболд  
профессор Ц.Ганболд  
профессор С.Базарпүрэв  
дэд профессор Ц.Мөнхцэцэг  
дэд профессор Я.Төгөлдөр  
доктор Г.Цэнд-Аюуш  
доктор Д.Ундрах  
доктор Д. Бумдарь  
доктор Д.Мягмарсүрэн

**Техник редактор:**

магистр Т.Есүхэй

**Хаяг:**

Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө, МУИС-ийн хичээлийн II байр, 226 тоот,  
Шинжлэх Ухааны сургууль, Улс төр судлалын тэнхим

**Утас:** 976 - 75754400 (2317)

# **POLITOLOGY XVII SCIENTIFIC JOURNAL**

**№ 18 (534)**

**XVIII**

**ISSN 2227-6904**

Key title: Politology

## **EDITORIAL BOARD**

**Editor in chief:** Turtogtokh Janar, National University of Mongolia  
**Secretary:** Batbold Tserendash, National University of Mongolia  
**Board members:** Ganbold Tseren, National University of Mongolia  
Bazarpurev Sambuu, National University of Mongolia  
Munkhtsetseg Tserenjamts, Strategy Academy  
Tuguldur Yanjiv, Mongolian University of Science and Technology  
Tsend-Ayush Galsanpiljee, National University of Mongolia  
Undrakh Davaadorj, National University of Mongolia  
Bumdari Dagva-Ochir, National University of Mongolia  
Myagmarsuren Dashzevge, National Academy of Governance

**Technical Editor:** Yesukhei Tumurbaatar

**Address:** Department of Political Science, School of Arts and Sciences, National University of Mongolia, Zaluuchuud avenue, Ulaanbaatar, Mongolia

**Phone:** 976 – 75754400 (2317)

ПОЛИТОЛОГИ XVII  
Эрдэм шинжилгээний бичиг  
№ 18 (534)

АГУУЛГА

Өмнөх үг ..... 6

**АРДЧИЛАЛ, УЛС ТӨРИЙН ОНОЛ, ҮЗЭЛ САНАА**

Фукуямагийн “Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн” бүтээлд ардчилсан нийгмийн үйл явц дахь эдийн засгийн бус сонирхолын нөлөөллийг авч үзсэн асуудалд ..... 7  
*Ж.Төртогтох, Д.Уртнасан*

The Kantian ideals and the Mongolian young democracy: Achieving peace and democracy through international cooperation (Кантын үзэл санаа ба Монголын залуу ардчилал: олон улсын хамтын ажиллагаагаар энх тайван ба ардчилалд хүрэх замд) ..... 15  
*Т.Заяа*

Ардчиллын төлөөх үйл явцын өрнөл ба эрх чөлөөнд тэмүүлэхүй (Ардчиллын диллема - I) ..21  
*О.Хатанболд, Дамдин Д.Бадараев*

Үндэсний ухамсрыг судлах онол, арга зүйн ялгаатай байдлууд ..... 52  
*М.Мөнхзул*

Коммунизмын түүхийг эргэн сөхвөл ..... 56  
*Д.Ундрах*

**ПАРЛАМЕНТ СУДЛАЛ**

Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудалд ..... 61  
*Ц.Ганболд, С.Жавхлан*

БНСУ -ын 21 дэх удаагийн парламентын сонгуулийн онцлог, нөхцөл байдал ..... 77  
*Э.Саранцэцэг*

Албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлыг шүүн хэлэлцэх хоёр танхимтай парламентын эрх мэдэл ..... 86  
*Д.Сүхболд*

**СОНГУУЛИЙН УЛС ТӨР**

Монгол улсын сонгуулийн хуулийн өөрчлөлт: хэрэгжилт, боловсронгуй болгох асуудалд ..... 94  
*Д.Түмэнжаргал, Г.Эрдэнэбаяр*

Улс төрийн намын гишүүд, дэмжигчдийн орон зайн тархалтыг сонгуулийн газарзүйн үүднээс тодорхойлох судалгаа ..... 117  
*Д.Оюунчимэг, Г.Цогтдэлгэр*

Нэр дэвшигчийн имиж бүрдүүлэлт ба сонгууль ..... 127  
*У.Батцэрэн*

**БОДЛОГО СУДЛАЛ**

Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, шингээх чадварыг сайжруулах бодлогын зарим асуудал ..... 134

*Ц. Чулуунцэцэг, Б.Эрдэнэдалай*

Аялал жуулчлалын бодлогын шинжилгээ ..... 144

*Ц.Ганболд, С.Хасчулуу*

Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын нөхцөл байдалд Хятад Монгол хамтран  
элсэн шуургаас сэргийлэх тухай анхны шинжилгээ..... 158

*Э.Наран*

**Зохиогчдын тухай товч** ..... 166

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний сэтгүүлийн ээлжит дугаар эрхэм уншигч та бүхний гар дээр очиж байна. Сэтгүүлийн маань энэхүү дугаар нь өмнө гарсан цувралуудын ололт, амжилт, туршлага дээр суурилсан болно.

Дэлхий дахины улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр улс төрийн мөн чанар, агуулга улам бүр гүнзгийрч түүний үүрэг роль өсөн нэмэгдсээр байгаа билээ.

Ийм учраас улс төрийн мөн чанарыг ойлгон таниулах, энэ талаарх зөв үнэлэлт дүгнэлтийг өгөх улс төрийн мэдлэгийг бий болгодог улс төрийн шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг их юм. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны аргахэрэгсэл, улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна.

Улс төрийн мэдлэгийн даяарших үйл явц нь дэлхий дахин, бүс нутаг, улс орнуудад ардчилсан хөгжлийн ололт амжилтыг баталгаажуулах, түүнийг хөгжлийн шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид ч гүйцэтгэсээр байх болно.

Монголд шинээр үүсэн төлөвшиж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэн судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм. Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн онол, үзэл баримтлал, улс төрийн институт, ардчиллын онол, практик, харьцуулсан улс төр, эмпирик судалгаа зэрэг улс төрийн шинжлэх ухааны олон чухал сэдвүүдээр эрдэмтэн судлаачдын бичсэн өгүүллүүдийг нийтэллээ.

Энэхүү дугаарт нийтлэгдсэн өгүүллэг тус бүр нь тухайн зохиогчийн үзэл санаа, байр суурь, судалгааны өгөгдөхүүнд тулгуурлаж байгаа бөгөөд МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим, Политологи сэтгүүлийн редакцын байр суурь биш болохыг анхаарч хүлээн авна уу.

Уншигч та сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ Улс төр судлалын тэнхимийн хаягаар ирүүлбэл бид гүнээ талархах болно.

**РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**

## **ФУКУЯМАГИЙН “ТҮҮХИЙН ТӨГСГӨЛ БА СҮҮЛЧИЙН ХҮН” БҮТЭЭЛД АРДЧИЛСАН НИЙГМИЙН ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН БУС СОНИРХОЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АВЧ ҮЗСЭН АСУУДАЛД**

**Ж.Төртогтох**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,  
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, профессор

**Д.Уртнасан**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар,  
Улс төр судлалын тэнхимийн магистрант

### **Хураангуй**

Франсис Фукуямагийн бичсэн “Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн” бүтээл нь Платон, Аристотель, Гегель, Ницше, Локк, Гоббс зэрэг өрнөдийн сэтгэгчдийн үзэл санаанд тулгуурлан, орчин үеийн ертөнцийг бүхэлд нь дахин эргэцүүлэн түүхэн үүднээс авч үзэхдээ а) эдийн засгийн сонирхол, б) эдийн засгийн бус сонирхол гэсэн хоёр үзүүлэлтийг гол болгожээ. Үүнээс хүний мөн чанар, нийгмийн гишүүн байх утга учир, “хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцэл” либерал ардчилалд хэрхэн нөлөөлж байдаг зэрэг эдийн засгийн бус сонирхолын үүднээс нийгмийн үйл явдлыг хэрхэн тайлбарлаж буйг голлон авч үзсэн болно.

**Түлхүүр үг:** Ардчилал, либерализм, хүлээн зөвшөөрөгдөлт, нэр төр, тэгш эрх, эрх чөлөө

### **Удиртгал**

Нийгмийн ухаан тэр дундаа философи, социологи, улс төрийн шинжлэх ухаанд нийтлэг нэгэн зүйл бол нийгмийн сэтгэлгээний тодорхой цаг үед нийгмийн ямар нэг үзэгдэл, үйл явц, асуудлын талаар судлан бичсэн зохиол бүтээл тодорхой хугацааны дараа эргээд дараа дараагийн судалгаа шинжилгээний хувьд судлагдахуун нь болдог явдал юм. Өөрөөр хэлбэл нийгмийн ухааны судлаачид тэдгээр сэтгэлгээнд үндэслэн өөрийн үзэл санааг боловсруулж, шинжлэх ухааны эргэлтэд оруулдаг. Үүний нэгэн адил Франсис Фукуяма<sup>1</sup> улс төрийн шинжлэх ухааны сэтгэлгээний нэгэн томоохон хэсэг болох өрнөдийн улс төрийн сэтгэлгээний талаар болон өрнөдийн улс орнуудын улс төр, нийгмийн амьдралын үйл явдлуудын цаад мөн чанарыг тайлбарлан бүтээлдээ тусгасан байна. Энэхүү шүүмжийг Монсудар хэвлэлийн газраас 2006 онд эрхлэн гаргасан орчуулгын хэвлэлтэнд тулгуурлан бичсэн болно<sup>2</sup>.

<sup>1</sup> Yoshihiro Francis Fukuyama бол Америкийн улс төр судлаач, улс төрийн эдийн засагч, ном бүтээл туурвигч бөгөөд түүнийг 1992 онд бүтээгдсэн “Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн” бүтээл нь дэлхий нийтэд танигдахад гол нөлөөг үзүүлсэн. Түүний үзэл санаанд Аристотель, Ф.Ницше, С.Лэвис, А.Блүүм, Ф.Гегель, С.П.Хантингтон, А.Кожэв, Х.Мэнсфилд, Л.Штраусс, С.М.Липсет зэрэг сэтгэгчдийн үзэл санаа ихээхэн ач холбогдолтой байдаг. Фукуямагийн судалгааны чиглэлд хөгжиж буй улс орнууд, засаглал, олон улсын улс төрийн эдийн засаг, төрийн байгуулал, ардчилал, стратеги болон аюулгүй байдлын асуудлууд багтдаг. Тэрээр неоконсерватизмийн үзэл санааг дэлгэрүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн.

<sup>2</sup> Франсис Фукуяма, *Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн*, Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар, 2006 (Орчуулагч Ш.Цог)

### ***Арга зүй, үндэслэл, үндсэн үзэл санаа***

Уг бүтээлийн ерөнхий аргазүй нь “Механизм” гэж нэрлэгдсэн түүхчлэхүйн аргазүй юм. Орчин үеийн байгалийн шинжлэх ухаанд суурилсан аргазүй бөгөөд хүн төрөлхтний сүүлийн хэдэн зуун жилийн түүхийг бичих гол аргачлал гэж үзсэн. Учир нь Европ, Умард Америкийн хөгжлийн түүхэн туршлагыг хүн төрөлхтний түгээмэл түүхтэй адилтгаж болохгүй болсон явдал түүхчилэхүйн шинэ аргазүйн шаардлага нэмэгдүүлсэн. Ингээд түүхийг үндсэндээ эдийн засгийн онолын үүднээс толилуулах, өөрөөр хэлбэл түүхийг марксист онолын аргаар толилуулж, марксист бус дүгнэлт хийх явдал юм.

Номын зохиогч “Бразил, Папау Шинэ Гвинейн ширэнгэ ойн уугуул омгуудыг эс тооцвол хүмүүн төрөлхтний түүхэн замналаас Механизмд хамаарагдахгүй буюу тайлагдахгүй, цаашилбал, дэлхийн эдийн засгийн түгээмэл зүй тогтол, мөн “Консюмеризм” хэмээх орчин цагийн хэрэглээний аж төрөх хэвшлээс тасарсан хүмүүн төрөлхтний ямар ч салаа мөчир алга” (F. Francis 2006) 140 тал\ хэмээн уг аргазүйн үндэслэгээг гаргаж өгсөн байна. Байгалийн шинжлэх ухаанд суурилсан гэдэг нь технологийн ололт дэвшил дээр суурилсан эдийн засгийн хөрөнгөтөн нийгмийн харилцааг ихэд хөгжүүлж, түүнийг бэхжүүлсэн явдал нь “космополитанизм” хэмээх түгээмэл шинж чанартай соёл иргэншлийг бүрдүүлж чадсанд байгаа юм. Орчин үеийн ертөнцийг бүхэлд нь ойлгохын тулд түүхийг авч үзэхдээ а) эдийн засгийн сонирхол, б) эдийн засгийн бус сонирхол гэсэн хоёр үзүүлэлтийг гол болгон авч үзэж, үүнтэй холбогдол бүхий эрдэмтэдийн үзэл санаанд зохиогчийн байр суурьнаас нэмэлт тайлбар хийх, түүхийн явцад улс орнуудад өрнөж байсан онцлог үйл явдлуудад дүгнэлт хийх байдлаар зохиолын ерөнхий үзэл санааг баяжуулж өгсөн.

Өнөөгийн либерал ардчилсан нийгмийн амьдралын үйл явц дунд лавтай эдийн засгийн бус сонирхолын үүднээс өрнөж буй олон үйл явдлыг ажиглан харж болох бөгөөд ялангуяа улс төрийн амьдрал заримдаа огтхон ч эдийн засгийн үндэслэлгүй, бүр түүний зүй тогтлын эсрэг өрнөх нь ч бий. Энэ талаар зохиогч “Дайн дажин, улс төрийн мөргөлдөөнийг өдөөн хатгаж даамжруулсан хүмүүсийн сэтгэлгээний учир начир, түүний сайн муу тал, байгалиас өгөгдсөн төрхийг тодорхойлох ямар нэгэн ухаалаг хэллэг, нэр томьёо үгүй байсаар байна” (F. Francis 2006) 159 тал\ гэсэн санаагаар тодотгож өгсөн.


Дээрх санааны цаад учир шалтгаан нь улс төрийн амьдрал анх эхэлсэн үеэс үүссэн, оршихуйг маань тодорхойлж байдаг “Хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцэл” байдаг бөгөөд үүнийг илүү гүн гүнзгий ойлгохын тулд Гегелийн хүний тухай үзэл баримтлалыг зөв тайлах хэрэгтэй ажээ. Өөрөөр хэлбэл хүн гэгч амьтны байгалиас заяасан дотоод ертөнцийг ойлгох нь чухал юм. Хүн бусад амьтны адил наад захын байгалийн дуудлагаас \хоол унд хүсэмжлэн олж идэх, хорогдох орон, ичээ олох, амиа хайрлах г.м\ гадна хийсвэр буюу огтхон ч материаллаг бус юм \бусад хүний хүслийг өөртөө ашигтайгаар эргүүлэхийг, өөрийгөө бусдаар хүлээн зөвшөөрүүлэхийг г.м\ хүсдэг байна. Энэ нь хүний нийгэмч сэтгэлгээтэйг илэрхийлж байна. “Хүлээн зөвшөөрүүлэхийн төлөөх тэмцэл” хачирхалтай нь хүн нэр төрийн төлөө өөрийгөө золиослохоос ч буцахгүй байдаг бөгөөд хүн гэдэг утгаар хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө улайрдаг байна.

Хүн төрөлхтний түүхийг нэгтгэн үзэх юм бол эзэнтэн, баатар, ядуу боол ч бай өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө өөр хоорондоо тасралтгүй тэмцэж ирсэн бөгөөд эцэст нь нийгмийн журам сөргөлдөгч хоёр талд харилцан эрх тэгш байдал олгож санасанд нь хүргэжээ. Хүн ямагт нэгээс илүү сонголтоос сонгох ёс суртахууны эрх чөлөөг эдэлдэг ба энэ нь заавал

ашигтай байх албагүй, тухайн мөчид өөрийн дотоод дуудлагын өвөрмөц шаардлагын дагуу сонголтоо хийдэг. Энэхүү дотоод шаардлагыг “Төгс сэтгэлийн дуудлага”<sup>3</sup> (F. Francis 2006) 178 тал, 389 талд уг үзэгдлийн талаарх сэтгэлгээний судалгаануудыг дурьдаж өгсөн\ хэмээгээд эр зориг, өгөөмөр сэтгэл, нийгэм, улсынхаа төлөө зүтгэх эрмэлзлэл, аливаа дарангуйллыг эсэргүйцэн үгүйсгэх, либерал ардчиллыг дээдлэх зэрэг эрхэм дээд мөн чанарын эх үүсвэр болдог. Мөн буруу талруугаа эргэвэл нүглийг төрүүлэх эх үүсвэр ч болох чадамжтай юм.

Чухам юуг хүлээн зөвшөөрүүлэх гэдэг вэ? гэвэл хүн бүр өөрийгөө дотроо үнэлж түүнийгээ бусдаар тэр хэмжээнд нь үнэлүүлэхийг хүсдэг. Нийгмийн хөгжлийн түүхийг үнэлэмжинд тулгуурласан “мегалотими”<sup>4</sup> болон “изотими”<sup>5</sup> гэсэн хоёр үзлээр авч үзэж болно. Мегалотимийг улс төрийн салбарт нийлээд их зөрчил үүсгэж болох сэтгэлийн илэрхийлэл гэдэг бөгөөд анх өөрийгөө үнэлэх даруухан хэлбэрээр эхлээд дараа нь тэр үнэлгээгээ бусдаар хүлээн зөвшөөрүүлэх хүсэл болж хувирдаг бол улам лавширвал бусдыг давамгайлах хэт онцгойрох мөрөөдөл болж мэднэ. Тиймээс уг үзэл санаанд тулгуурлан мегалотимийг тэлэлт байдлаар дүрслэн үзүүлвэл:

**Зураг 1. Мегалотими тэлэлт**



Мегалотими улс төрийн салбарт ороод хэт тэлэлт явагдахад хамгийн түрүүнд үндсэрхэг үзэл газар авдаг бөгөөд шалтгаан нь хүн тодорхой нэгэн томоохон бүлэгт хамрагдаж, тэр нь эхлээд бахархал хэлбэрээр оршидог. Улмаар харгис хийгээд утгагүй аймшигт үр дүнг харуулж болдог учир хувь хүний амьдарлын хэвшлээс дээш гарах нь буруу. Өөрөөр хэлбэл үндэсний бүлгүүд өөрийн төрөлх хэл, зан заншилаа хадгалж, түүнийгээ соёлоор илэрхийлэхээс биш улс төрийн хэрэгсэл болгох нь тохиромжгүй гэж үзэж болно.

Тиймээс мегалотимийг хэт хурц хэлбэрээс ангижрахыг хичээх болсон бөгөөд түүний орон зайг дор толилуулан буй хоёр шинж чанарын хослол эзэлсэн. Үүнд:

1. Ахуй амьдралын бүх хүрээ “экономизац”<sup>6</sup>-д автах болсон. Улс орнууд бие даасан сүр хүч бүхий гүрэн болохоос илүү нэгдсэн \интеграцлагдсан\ хэлбэрийг сонгох болсон.
2. Изотимид төлөвшөх болсон. Үүний үр дүнд бусдаар хүлээн зөвшөөрүүлэх гэж ярихаас илүү “нэр төр” бусдын эрхийг хүндэтгэх”, бие хүний үнэ цэнэ”, хүний эрхээ доромжлуулахгүй байх” гэж ухаарах болсон.

<sup>3</sup> Платоны томьёолсоор “Thymos” буюу хүний өөрийн үнэ цэнийг ухамсарлан эрхэмлэх байдал.

<sup>4</sup> Хүн өөрийгөө бусдын адил, тэпнээс онц ялгарах чадвхгүй гэж хэзээ ч үздэггүй, ингэж өөрийгөө дээгүүр үнэлүүлэх, онцгойрох хүсэл юм.

<sup>5</sup> Хүн өөрийгөө бусдын адил, олны нэг гэж үнэлүүлэх буюу ижилсэх хүсэл юм.

<sup>6</sup> Ахуй амьдралын бүх хүрээ эд хөрөнгө, эд материалын үзүүлэлтийн зүй тогтолд авах явдал.

Өөрөөр хэлбэл аливаа нийгмийн бүлгүүд, улс орнууд өөрсдийгөө хүлээн зөвшөөрүүлэхүйн төлөө улайрахын оронд өөрийн тухтай амьжиргааг баталгаажуулах, энх амгалан орших үзлээр сольж, бусдыг давамгайлахын тэмцлийн оронд бүгдийн түгээмэл эрх тэгш байдлыг баталгаажуулах зарчмыг дээдлэвэл зохино хэмээн үзсэн байна. Харин нийгмийн тэгш бус байдлын шалгаан нь:

- Нийтлэг хэм хэмжээнээс үүдэлтэй факторууд: нийгмийг ангид хуваах, арьсны өнгөөр ялгаварлах, сонгуулийн ялгаатай эрх зэрэг тэгш ёсонд садаа болдог хууль, эрх зүйн зохицуулалт болон эдийн засгийн үйл ажиллагаанд хандах угсаатны болон шашны ялгаатай хандлага зэрэг соёлтой холбоотой факторууд багтдаг.
- Байгалиас үүдэлтэй факторууд: хүн бүрийн тэгш бус чадвар, хүн амын доторх ялгаа болон өмч хөрөнгө олж авах ижил чадваргүй байдал, эдийн засгийн хүрээний хөдөлмөрийн хуваарь, зах зээлийн өршөөлгүй механизм зэрэг багтдаг.

Либерал нийгэмд хэм хэмжээнээс үүдэлтэй шалтгаануудыг арилгахыг эрмэлздэг бол ардчилсан нийгэмд юун түрүүнд хүний бие махбодийн зовлонгоос урьдчилан сэргийлэх асуудлыг тэргүүн зэрэгт тавьж, түүнээс хуваалцахыг урьтал болгодог гэнэ. Үүнээс үзэхэд либерал болон ардчилсан нийгэмүүд нь хүнд хэм хэмжээ болон байгалиас үүдэлтэй тэгш бус байдлыг нь даван туулах, бүдэгрүүлэх цаашлаад арилгахад чиглэдэг гэж болно. Номын зохиолч маань либерализм болон ардчиллыг тодорхойлохдоо: “Либерализм бол хувь хүний тодорхой эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, засгийн газрын хяналтанд орохоос хамгаалдаг хуулийн засаглал. Ардчилал бол улс төрийн эрх мэдэл хуваалцах эрх, өөрөөр хэлбэл иргэн бүр улс төрийн хэрэг явдалд санал өгөх, оролцох тухай эрх.” (F. Francis 2006) 59-60 тал\ Тиймд либерализм, ардчилал хоёр бие биенээ нөхцөлдүүлж оршин байдаг байна.

Сүүлийн хэдэн арван жилийн хөгжлийн чиг хандлагыг харвал либерал ардчилал өөд хүн төрөлхтөн тэмүүлж байгаа агаад өгсөх, уруудахын аль аль нь байж болохыг одоо үгүйсгэх боломжгүй. Тиймээс уг тогтолцооны үзэл санаа хэрхэн бүрэлдснийг хөгжлийн явцад улс төрийн сэтгэгчид хэрхэн үзэж байсныг Гегель болон англи-саксоны уламжлал бүхий Гоббс, Локк нарын үзлээс гаралтай либерал нийгмийн онцлогийн талаарах үзлүүдийг дараах хүснэгтээр харьцуулан үзвэл:

**Хүснэгт 1. Либерал нийгмийн талаар**

| Гегелийн либерал нийгмийн талаарх үзэл                                                                                                                                   | Гоббс, Локк нарын либерал нийгмийн талаарх үзэл                                                                                                                                                                                                                                          |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Харилцан хариуцлага хүлээсэн эрх тэгш хэлэлцээ тохиролцоо мөн боловч, хүмүүсийн нэг нэгнээ хүлээн зөвшөөрөх тал дээр ялгаатай.                                           | Ердийн суурь эрхээ хэрэгжүүлдэг ба энэ нь амьд явах, амиа хамгаалах хүсэл бүхий хүмүүсийн хоорондын нийгмийн тохиролцоонд хүргэсэн гэрээ хамгаална. Тус хэлэлцээ тохиролцоо нь иргэд нэг нэгнийхээ хувийн амьдралд үл оролцох, өмч хөрөнгөд үл халдах гэсэн үндсэн үүрэг хүлээсэн байдаг |
| Хүмүүс нэг нэгнээ оршин тогтнох, аж төрөх түгээмэл дархан эрхийн рационал хүлээн зөвшөөрлийг дээдэлсэн үзэл дээр суурилна. \Биднийг өөрийгөө үнэлдэг хэмжээнд нь үнэлэх\ | Рационал хувийн сонирхол хөөсөн харилцан тохиролцоо                                                                                                                                                                                                                                      |

Либерал нийгмийн онцлог шинж нь:

- Өөрийгөө бусдаар хүлээн зөвшөөрүүлэх үзлийг бүгдэд нэгэн адил хэлбэрээр илэрхийлэх орон зайг өгдөг. Хүн бүрийн хүн гэж үнэлэгдэх эрхийг хамгаалж өгсөн гэсэн үг.
- Эзэн, боолын ялгааг арилгаж өгсөн, элдэв ангигүй, нэг ижил төстэй хамтлаг. Үүний утга учир нь нийгмийн засаглалын эрхийг аль нэг уламжлалыг сохроор дагагч буюу аль нэг шашны үүдэлтэй бие төлөөлөгч шүүрч авах замыг хааж, нийгэм өөрөө бүх нийтийн ил тод, чөлөөт маргаан явуулж, саналаа солилцсоны эцэст ямар төрийн дор хамтран аж төрөх талаар нэгдмэл байр сууринд хүрч, төр засгаа сонгон төвхнүүлэх явдал юм.

Эдгээр нь бидэнд нийгмийн хэмжээнд сэтгэн өөрийн байгалиас заяасан мөн чанараа ухамсарлан таньж, түүнд үйлчилсэн хэм хэмжээ бүхий улс төрийн төрхтэй хамтлаг болж, нийгмийн ухамсартай орших нэгэн хувилбар болох бололцоог олгожээ.

Ардчиллын зорилго нь байгалиас заяасан хүслийг хангах биш, харин өөрийгөө бусдаар хүлээн зөвшөөрүүлэх дуудлагыг хангах явдлыг дархлаажуулахад оршдог. Ардчиллын үйл явцад удирдлагын байр суурь, олон нийтийн санаа бодол гэсэн урьдчилан таах боломжгүй улс төрийн хүчин зүйлс чухал ач холбогдолтой. Тэгэхээр “тогтвортой ардчилал нь улс төрийн урлагийг сайтар эзэмшсэн, хүмүүсийн хандлага тэмүүллийг зөв жолоодож улс төрийн тогтвортой бүтэц байгуулалтаар дархалж чадах ухаантай, бүтээлч төрийн удирдагчгүйгээр бүтэж бүрэлдэхгүй” (F. Francis 2006) 238 тал ажээ.

### ***Ардчилал яагаад сулардаг вэ?***

Үүний гол шалтгаан нь төр ард олны хооронд бүтээлч холбоо, хамтын барилдлага тогтож ирээгүйнх бөгөөд төр нь өөрийгөө ард түмний дээр тавьдаг бол ард түмэн өөрсдөө энэ хорвоогийн хэрэг явдалд орж, гарч яваагаа тэр бүр сайн ухамсарлахгүй байх нь олонтаа учир төр болон ард иргэдийн хоорондох зай холддог байна. Төрийн тогтолцоо нь улс төрийн тодорхой байр суурь, улсаа авч явах ухамсартай сонголтын талбар. Харин ард түмний тогтолцоо нь тэдний ертөнц улс төрөөс доогуур оршдог бөгөөд ямагт нийгэм соёлын хэрэгцээ, хэрэглээний хаос маягийн тулгамдсан цогц асуудал байдаг. Иймд нийгмийн зүй тогтол бүгдийн саналд нийцэх нь үгүй талдаа учир ард түмэн, төр хоёр хэл амаа ололцоход бэрхшээлтэй байдаг байна.

Үүнээс гадна тогтвортой либерал ардчиллыг сулруулдаг соёлын хүчин зүйлсийг дараах байдлаар гаргасан байна. Үүнд:

1. Тухайн ард түмний яс үндэс, омгийн уугуул ухамсарын хэмжээ, шинж чанар \Хэт үндсэрхэг үзлийн илрэл байж болно\
2. Шашин \зарим үед адил тэгш байх үзлийг үгүйсгэх, өөр үзэлтнийг үл тэвчих байдлаар илэрч болдог\
3. Нийгмийн тэгш бус бүтэц бөгөөд түүнээс үүдэн гарах хүмүүсийн үзэл, байр суурийн их ялгааны олон үр дагавар \ийм бүтэцтэй анги давхаргууд нэг нэгнийгээ үзэн ядах, гагцхүү өөрийгөө хичээх байдлаар илэрч гарна\
4. Төрөөс хамаарахгүйгээр иргэний эрүүл нийгэм бүтээн байгуулах чадвар \орон нутгийн ард түмэн өөрийн хотын захиргаа, элдэв олон нийтийн байгууллага, мэргэжлийн холбоодын шугамаар болон боловсролын системээрээ дамжуулан өөрийн тулгамдсан асуудлыг шийдэж сурах явдал болдог\

Хэдийгээр либерал ардчиллын давуу талууд олон ч гэсэн хамгийн сайн тогтолцоо хэмээн үзээгүйг “Либерал ардчиллыг амьдралд нэвтрүүлэхийн утга учир нь энэхүү тогтолцоог одоогийн байдлаар улс төрийн хамгийн ухаалаг хувилбар мөн гэж дүгнэснийх л байна” (F. Francis 2006) 230 тал\ гэснээс харж, наанатай цаанатай дүгнэх хэрэгтэй болж байна.

### **Анхны хүн ба сүүлчийн хүн**

Гоббсынхоор “байгалийн цэвэр нийгэм”, Гегелийнхээр “цуст тулааны дотоод дуудлага” гэдэг нь сэтгэлгээний уугуул төрх байдлаас урган гарсан хэм хэмжээгээр хамтран аж төрөхийг хэлж байгаа бөгөөд уг нийгэм хүн төрөлхтний түүхийн эхний гараан дээр оршиж байгаагүй ч байж болно. Харин Аливаа нийгмийн дотоод жам ёсыг сүйрэх мөчид ил гарч ирдэг далд хүчин зүйлс юм. Учир нь “санал хүсэл төрөх, түүнийг хэрэгжүүлэх, үр дүнд хүрэхийн тулд байгалиас өнгөгдсөн төрх бүхий гараа гэж байх ёстой” (Steven 1986) болж байгаа юм. Өөрөөр хэлбэл “анхны хүн” хэмээх ойлголт нь биологийн хувьд хүнийг онцлон тодорхойлох бус хүн нийгэмийн амьдралд чухам юунаас болж, хэрхэн оролцдог талаар нь авч үзэж буй хэрэг болж байна.

### **Хүснэгт 2. “Анхны хүн”-ий талаар**

| <b>Гоббс</b>                                                                                                                                                                                      | <b>Локк</b>                                                                                                                                                                                                                  | <b>Гегель</b>                                                                                                                                                       |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүнд материаллаг баялгийн хойноос хөөцөлдөх нь нэн тэргүүний зорилт биш бөгөөд хүн харин юуны өмнө өөрөө бахархах улайрсан сэтгэлдээ илүүтэй хөтлөгддөг.                                          | Өөрийгөө бусдаар хүлээн зөвшөөрүүлэх тэмцэлд орохоос өмнө тэр хүслийг нь амиа авч гарах нь дарж, номхруулсанаар тэрээр амьдралын утга бол тав тухтай тансаг амьдрал явдал гэсэн үнэмшлийг эзэмшиж чадсан боловсролтой хүмүүн | Материаллаг эд баялагийг огт сонирхдоггүй гол хүсэл нь бусдын хүслийг эзэмшихэд оршиж, хувийн өмч амьд, явах жаргал гэх “хорвоогийн үнэт зүйлсийг” огт ойшоохгүй.   |
| Хүн аймшигтайгаар үхэхээс айх явдал бол хүний хамгийн хүчтэй дуудлага бөгөөд шудрага ёс, хууль тогтоомж нь хүний амьд үлдэхийг мөрөөдөж, хичээхийг хүндэтгэх зарчим дээр тулгуурладаг байх ёстой. | Олж, хуримтлуулсан өмчөө иргэний нийгмийн гишүүн болсноор сая цааш хязгааргүй аривжуулах боломжоор хангагдах ёстой.                                                                                                          | Хүлээн зөвшөөрүүлэхийг хүсдэг нь хүнийг аахар шаахар хэрэгцээнээсээ татгалзаж бусдын төлөө зүтгэхэд өөрийгөө бэлдэх шалтгаан болж, тэр нь хүнд сэтгэл ханамж өгдөг. |

“Сүүлчийн хүний” талаар Александр Кожээв “ардчилал гарцаагүй ялан дийлэх тодорхой боловч хүн үнэхээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөөх тэмцэл, байгалийг давамгайлах гэсэн хөдөлмөрөөрөө тодорхойлогддог юм бол түүхийн төгсгөлд нэр төрөө хүлээн зөвшөөрүүлэх, материаллаг эд баялаг, элбэг дэлбэг амьдралын аль алийг нь олоод авсан хойноо тэмцэж, хөдөлмөрлөхөө зогсоох учир тэр мөн чанараараа оршин тогтнохоо болих болно” хэмээжээ. “Гэтэл сүүлчийн хүний амьдрал нь аюулгүй байдал, материаллаг элбэг дэлбэг байдал юм бол улс төрчдийн сонгогчиддоо амлаж буй тэр зүйлс биш гэж үү” (F. Francis 2006) 330 тал\ гэсэн нь либерал ардчиллын сул тал, түүний төсгөлийн цэгийг харуулсан гэлтэй.

Түүх төгсөнө гэдэг нь дайн, цуст хувьсгалуудад эцэс ирнэ гэсэн үг бөгөөд үүнийг зөвшөөрөх нь хүн тэмцэл хийх ямарч шалтгаангүй болж, хэрэгцээгээ эдийн засгийн үйл

ажиллагаар хангах болж, тулаанд амиараа дэнчин тавих хэрэгцээгүй болно. Түүхийн төгсгөлд хүн байхаа болих нь сансрын сүүрэл биш харин хүн амьтний хувьд амьд үлдэж, байгаль хийгээд нэгэнт өгөгдсөн оршихуйдаа зохицон амьдарна гэсэн үг ажээ.

### Дүгнэлт

Хүн нийгмийн гишүүн байх хэрэгцээ шаардалага зөвхөн материллаг эд баялал, амь нас, эрүүл мэндээ хамгаалуулахаас гадна өөрийгөө өөрийнхөө үнэлдэг тэр үнэлэмжээр үнэлүүлж, нэр төр, гавьяа зүтгэлээ бусад нийгмийн гишүүдтэйгээ эрх тэгшээр хүлээн зөвшөөрүүлэх чухал байдаг байна. Бусдаар хүлээн зөвшөөрүүлж, үнэлэгдэх нь хүнд таатай байх агаад заримдаа өөрийн гарал угсаа, нийгмийн нөлөө бүхий бүлгийн гишүүн гэж хэт онцгойрох хандлага нь нийгэм, улс төрийн аюултай үйл явдалд хүргэх нөхцөл ч болж болдог.

Тиймээс нийгэмд гишүүд нь эрх тэгш байх, боломжит эрх чөлөөг эдлэх нөхцлүүдийг хангахуйц, амар тайван нийгмийн эрэл хайгуул тасраагүй бөгөөд уг бүтээл бичигдэж байсан үе нь 1) дэлхийн олон улс оронд ардчиллах үйл явц өрнөж байсан, 2) хэт онцгойрох гэсэн хүсэл эрмэлзлэлээс үүдэлтэй дайн, самууны хор уршгийг мэдэрсэн байсан учраас либерал ардчиллын талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

Гэхдээ зохиолч “Либерал ардчиллыг амьдралд нэвтрүүлэхийн утга учир нь энэхүү тогтолцоог одоогийн байдлаар улс төрийн хамгийн ухаалаг хувилбар мөн гэж дүгнэснийх л байна” гэсэн нь либерал ардчиллыг хамгийн сайн тогтолцоо хэмээн үзээгүй бөгөөд хожим хойно өөр тогтолцоогоор солигдох боломжтойг тэмдэглэсэн байна. Уг тогтолцооны сул талууд гүнзгийрснээр нэг талаараа хүн төрөлхтний түүх (цаад утгаараа либерал ардчилалтай холбогдсон) төгсөж, нөгөө талаараа өөр шинэ түүх эхлэх цэгт хүргэх болов уу гэсэн үзэл санааг өгсөн байна.

Ф.Фукуяма өөрийн судалгааны чиглэлээр олон тооны ном бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлснээс дээрх сэдэвтэй хамааралтай, нэмэн дэлгэрүүлэн үзэх боломжтой зарим өгүүллийг уншигч Танд санал болгож байна. Үүнд:

- The End of History?, *The National Interest*, Summer 1989
- Human Nature and the Reconstruction of Social Order, *The Atlantic Monthly*, May 1999
- Social capital and civil society, paper prepared for delivery at the International Monetary Fund Conference on Second Generation Reforms, October 1, 1999
- "Economic, Political, and Cultural Consequences of Changes in Generational Relations," in Mary Ann Glendon, ed., *Intergenerational Solidarity, Welfare and Human Ecology* (Vatican City: Proceedings of the Tenth Plenary Session of the Pontifical Academy of the Social Science, 2005)
- "Liberalism versus State-Building," *Journal of Democracy* 18 (No. 3, July 2007)
- The Future of History; Can Liberal Democracy Survive the Decline of the Middle Class?, *Foreign Affairs*, January/February 2012
- "The Patterns of History", *Journal of Democracy* 23(1), Jan. 2012
- "Why is Democracy Performing so Poorly?" *Journal of Democracy* 26(1), Jan. 2015
- Against Identity Politics - The New Tribalism and the Crisis of Democracy *Foreign Affairs*, September/October 2018

**Ашигласан ном, материал**

Francis , Francis Fukuyama. “The End of History?” *The National Interest NO.16*, Summer 1989: 3-18.

Francis , Fukuyama. *Түүхийн төгсгөл ба сүүлчийн хүн*. Улаанбаатар: "Монсудар" хэвлэлийн газар, 2006.

Steven, Smith. “Hegel's Critique of Liberalism.” *American Political Science Review* 80 NO 1, 1986: 121-139.

Платон. *Төр улс*. Улаанбаатар, 2005.

Fukuyama.stanford.edu

## THE KANTIAN IDEALS AND THE MONGOLIAN YOUNG DEMOCRACY: ACHIEVING PEACE AND DEMOCRACY THROUGH INTERNATIONAL COOPERATION

(КАНТЫН ҮЗЭЛ САНАА БА МОНГОЛЫН ЗАЛУУ АРДЧИЛАЛ: ОЛОН УЛСЫН  
ХАМТЫН АЖИЛЛАГААГААР ЭНХ ТАЙВАН БА АРДЧИЛАЛД ХҮРЭХ ЗАМД)

**Т.Заяа**

ХИС-ийн ОУХНС-ын тэнхимийн багш

### *Summary*

The purpose of this article is to demonstrate how, even in the most remote from Europe country, in this case in Mongolia, the ideas of such great philosophers as Rousseau, Montesquieu and Kant went to this ancient nation to transform it entirely from a communist state to a vibrant democracy.

**Key words:** *democracy, foreign policy, international cooperation, international law*

### *Introduction*

Emmanuel Kant was one of the greatest philosophers in human history. Among other things he advocated for a federation of free States, bound together by a covenant forbidding war. Reason utterly condemns war, which only an international government can prevent. Obviously, people like Woodrow Wilson, George Clemenceau and the founders of the United Nations would have been enthusiastic about such a conclusion.

Emmanuel Kant dreamed of a worldwide democracy and a perpetual peace through international cooperation<sup>1</sup>. Kantian dream became true in the form of the Organization of the United Nations and other multilateral bodies such as the European Union, Organization of American States, the African Union or the ASEAN etc. In all that, the international law played an important role. In this connection, it is necessary to underline the vital importance of the international cooperation, as put it Kant, especially for small states like Mongolia. Moreover, the multilateral institutions are the last refuge for them, since they rely on international law<sup>2</sup> and international institutions.

Mongolia is more than twice as big as Texas and nearly the same size as Alaska. Its area is 1.6 million km<sup>2</sup> (603,000 mi<sup>2</sup>), four times the size of Japan and almost double that of Eastern Europe. This makes Mongolia the sixth-largest country in Asia and 19th in the world, but the population is only 3.2 million, which makes Mongolia one of the least-densely populated areas in Asia. This is a landlocked country located entirely between two major powers such as China and Russia.

From 1921 until the end of the 1980s, Mongolia was a one-party state closely tied to the Soviet Union. It received technical, economic, and military assistance from the Soviet Union and generally followed Soviet guidance in political and economic matters and in the building of a socialist society. These assumptions had led scholars like Owen Lattimore in the sixties to declare that Mongolia was

<sup>1</sup> Russell, Bertrand. "History of western philosophy". Collectors edition. Routledge, 1993. p.692.

<sup>2</sup> Тумурчулуун, Г. "Процесс принятия внешнеполитических решений в малых государствах (на примере Монголии)." (1999). С.15-16.

“a satellite state of the USSR”<sup>3</sup> and outlined the main features of such a state. However, beginning in 1990, forces for change in Mongolia ended the monopoly of political power by the communists in favour of free multiparty elections, coalition government, a new Constitution, greater cultural and religious freedom with more emphasis on Mongolian national traditions, a neutral position in international relations, and a transition to a market economy.

Mongolia was the only country to carry out the transition from socialism and centrally planned economy to democracy and market economy simultaneously without violence. There were street non-violent manifests but not shootings.

As for as foreign policy is concerned the Constitution of 1992 constituted a breakthrough in all foreign relations of the country. Here we can see that the Kantian ideals fulfilled. The Article X of the Constitution entirely is dedicated to foreign affairs. It says that Mongolia shall adhere to the universally recognized norms and principles of international law, and shall pursue a peaceful foreign policy. Mongolia shall enforce and fulfill in good faith its obligations under the international treaties to which it is a State Party. Furthermore, the international treaties to which the country is a Party shall become effective as domestic law upon their ratification by the parliament<sup>4</sup>.

### ***Installing democracy***

Mongolia made those democratic changes first, domestically adopting a new Constitution and second, introducing far ranging changes to foreign relations-related laws and the government action programs. The successive governments of Mongolia made sure that all the citizens of the country participated in a fair and just way in the adoption of the new Constitution as well as in the election of the presidents and members of the Parliament, elected from 1990-ies so far.

The Constitution of Mongolia states: “...the people of Mongolia, whereas respecting and upholding human rights and freedoms, justice and unity of our nation, whereas considering and respecting the accomplishments of human Civilization, aspire towards the supreme goal for building and developing a humane, civic, and democratic society in our Motherland”<sup>5</sup>. It continues “The fundamental principles of the activities of the State are democracy, justice, equality, national unity and rule of law”<sup>6</sup>.

As a result in Mongolia occurred a system change aimed at democracy, a law-based state structure and the Mongolian people managed to install a right division of power between democratically elected the State Great Hural (one chamber parliament) the president and the government. The Constitution also established the Constitutional Court, which is “the competent organ with powers to supervise the enforcement of the Constitution, to make conclusions on the breach of its provisions, and to solve constitutional disputes, and shall be the guarantee for the strict observance of the Constitution.

For Mongolia, at the outset of the new historical epoch, it was crucial to manage wisely its relations with both the Russian Federation and the People’s Republic of China, the only neighbors of the country.

### ***New cooperation through international law***

---

<sup>3</sup> Lattimore, Owen. "The historical setting of Inner Mongolian nationalism." *Pacific Affairs* 9, no. 3 (1936): 388-405.

<sup>4</sup> The Constitution of Mongolia (English translation), 1992. Art. 10.

<sup>5</sup> Ibidem, The preamble.

<sup>6</sup> Ibidem. Chapter One., Art. 1.

Mongolia, in dealing with international relations, followed one of the most important findings of Western political thought consisting in the idea that democracies do not fight each other.

Mongolia applied two new approaches to its international cooperation policies. First, to review former bilateral treaties signed with both Russia and China, second, to make advances in the international institutions, including the regional ones, in which Mongolia has not been represented at all during the socialist period.

The bilateral Treaties with the Russian Federation and the People's Republic of China were revised fundamentally in 1993 and 1994. The new documents signed clearly stated that there will be no more military alliances and coalition and the bilateral relations will be based on universally accepted norms and principles of international relations<sup>7 8</sup>.

A new concept of the "third neighbor" was introduced. Relations with the USA, Japan, Germany, ROK, Turkey, the EU strengthened on the new basis<sup>9</sup>. Working Relations established with World Bank, International Monetary Fund, the Asian Development Bank and the World Trade Organization. Mongolia joined international regimes and conventions, including the Universal Declaration of Human Rights.

A new community of donor countries headed by the USA and Japan emerged to help Mongolia to make the democratic transition.

In 1991 Mongolia became a member of the Non-Aligned Movement. Mongolia declared itself as non-nuclear zone<sup>10, 11</sup>. In 1992, Mongolian President Punsalmaagiin Ochirbat announced that Mongolia would seek to become a one-state Nuclear-Weapon-Free Zone (NWFZ). The last Russian troops had left the country that same year, and Mongolia perceived a change in its geopolitical status and an opportunity for non alignment<sup>12</sup>.

The initiative to become a Nuclear-Weapon-Free Zone was well received by Mongolia's neighbors, the Russian Federation and the People's Republic of China (both nuclear weapons states), as well as by the world community at large.

Mongolia has consistently supported joint efforts of the international community against terrorism in all its forms and manifestations.

It is well-known fact that Mongolia helps to establish peace in war-torn Afghanistan, sending troops. Mongolian peacekeepers are in a number of African countries.

In 2006, Mongolia made its first sizeable contribution to UN peacekeeping when it deployed 250 military personnel to the UN Mission in Liberia, a West African country that was recovering from a violent civil war. Six years later, Mongolia undertook its largest deployment to date when it sent a full battalion of 850 troops to the UN Mission in South Sudan, where they continue to play an important role in protecting civilians<sup>13</sup>.

<sup>7</sup> Монгол-Хятадын харилцааны түүхэн баримт бичгийн эмхэтгэл (1990-2010). Улаанбаатар. 2014. Treaty on Friendly Relations and Cooperation with PRC. 1994. Articles 1, 4.

<sup>8</sup> Монгол-Оросын харилцааны түүхэн баримт бичгийн эмхэтгэл (1992-2014). Улаанбаатар. 2016. Treaty on Friendly Relations and Cooperation with Russian Federation. 1993. Article 2, Articles 4-6.

<sup>9</sup> Гадаад бодлогын үзэл баримтлал. Foreign Policy Concept of Mongolia. 2011. Article 14.

<sup>10</sup> ЕА-н 53/77 дугаар тогтоол. Монгол Улсын олон улсын аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй статус. GA Resolution/Decision: 53/77 D. Mongolia's international security and nuclear-weapon-free status. 1998.

<sup>11</sup> Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, 2000. Law on non nuclear status of Mongolia. 2000. Article 3.1.2

<sup>12</sup> Enkhsaikhan, J. "Mongolia's Nuclear-Weapon-Free Status: Concept and Practice." Asian Survey 40, no. 2 (2000): 342-359.

<sup>13</sup> <https://news.un.org/en/story/2018/03/1004552>

Throughout its decade-and-a-half history in UN peacekeeping, Mongolian contributions to UN peacekeeping have been notable for their high standards of training and for the high number of women (645 women) they deploy<sup>14</sup>.

Mongolia has risen to become the 27th largest contributor to UN peacekeeping, with nearly 900 military and police personnel deployed in five operations. But they have not forgotten their first mission--they continue to send a handful of military observers to Western Sahara.

Peacekeeping is a dangerous business. UN personnel can sustain injuries in the line of duty, the workplace or in vehicular accidents, and harsh conditions and disease can also take its toll. Peacekeeping operations deploy medical contingents contributed by Member States to ensure that UN personnel – troops, police and civilians – receive the best medical care possible.

In Kabkabiya in the Darfur region of Sudan, Mongolia has for several years provided a Level Two Hospital to address this need. The unit consists of 68 personnel, 34 men and 34 women, and is responsible for providing UN personnel with health care, emergency resuscitation and stabilization, life and limb-saving surgical interventions, basic dental care and facilitation of casualty evacuation for more severe cases. It also administered vaccinations and other prophylaxis measures. In addition to serving UN staff, the Mongolian hospital unit treated more than 10,000 people from the local communities<sup>15</sup>.

Since 2003, more than 14,000 Mongolian peacekeepers have served in UN missions around the world. Today, Mongolia deploys nearly 900 peacekeepers to five UN peacekeeping operations – in South Sudan, Abyei, Darfur, the Democratic Republic of the Congo and Western Sahara. The Mongolian contribution consists of troops, police and unarmed military observers<sup>16</sup>.

A key task of the UN Mission for the Referendum in Western Sahara (MINURSO) is monitoring the ceasefire observed by the parties since September 1991 – carried out by some 200 military observers. Seen here, a Mongolian military observer serving with MINURSO, together with colleagues from Ghana, France and Bangladesh, check a map while carrying out an observation patrol in the vast area in Smara<sup>17</sup>.

In recent years, the people of South Sudan have simultaneously endured civil war and high levels of food insecurity. Among their tasks, Mongolian peacekeepers provide security as the UN World Food Programme (WFP) drops much-needed food in Bentiu, South Sudan. Their responsibilities also include protecting civilians, securing UN bases, carrying out patrols, escorting convoys, supporting search operations carried out by UN Police, as well as protecting fellow peacekeepers as they carry out road maintenance and demining operations<sup>18</sup>.

Mongolia also aspires to contribute to the Northeast Asian peace and security. With this aim, it launched Ulaanbaatar Dialogue on Northeast Asian security which has become a valuable mechanism for security and peace.

The last VI Ulaanbaatar Dialogue on Northeast Asian Security was held in June 2019, sponsored by the Mongolian Ministry of Foreign Affairs and The Institute of Strategic Studies of Mongolian National Security Council<sup>19</sup>.

---

<sup>14</sup> <https://www.montsame.mn/mn/read/201305>

<sup>15</sup> <https://news.un.org/en/story/2018/03/1004552>

<sup>16</sup> *Ididem*

<sup>17</sup> Mendee, Jargalsaikhan. *Mongolia's Peacekeeping Commitment. Training, Deployment, and Evolution of Field Information Capabilities*. National Defense Intelligence College. Washington. DC. Center for Strategic Intelligence Research, 2007. 19-20.

<sup>18</sup> <https://unmiss.unmissions.org/mongolian-peacekeepers-provide-much-needed-medical-care-communities-unity>

<sup>19</sup> Ulaanbaatar Dialogue on North East Asian security. VI International Conference Proceedings, Ulaanbaatar. June 2019.

The Ulaanbaatar Dialogue is a process. It pursues three main goals namely, building confidence in NEA, fostering mutual understanding and promoting regional cooperation and finally, setting up an international mechanism of dialogue.

It is important to underline that to achieve mutual trust, parties need to understand the perspective of others. In this regard, intercultural events such as NEA Woman Parliamentarians' symposium, NEA Mayors Forum and NEA Youth Symposium held as part of Ulaanbaatar Dialogue encourage a wide range cooperation in the region. Ulaanbaatar Dialogue aims to reach the long-term goals of regional peace by setting up institutional mechanisms of dialogue in Northeast Asia, an idea similar to that of Kant, who dreamed of signing peace treaties among world nations.

In that context Mongolia, as other nations of the world, always declared that the repeated launch of missiles by North Korea would not help the confidence building and eventual reunification of the two Koreas.

The new foreign policy of the country deserved respect and support on the side of world community, which helped the country to become a member of the UN Council on Human Rights in 2015<sup>20</sup>, to organize in Ulaanbaatar the conference of Foreign ministers of Community of Democracy in 2013 and the ASEM Summit meeting in 2016. The Community of Democracies is a global coalition of states that support adherence to common democratic values and standards enshrined in the Warsaw Declaration<sup>21</sup>.

### **Conclusion**

The experience of Mongolia shows that democracy-building is not an easy endeavor. It takes time to be fully completed. However, Mongolia is full of energy to do so in translating the ideals of Kant into reality through the UN and in the heart of North East Asia. Mongolia's democratic achievements during the last few years constitute also an expression of Kantian thoughts. Kantian ideals remain important in Northeast Asia. To fulfill Kantian dreams in our region confidence-building measures are increasingly important in reducing military tensions between nations and diminishing deeply-rooted mistrust through open discussions in Northeast Asia.

**Түлхүүр үг:** ардчилал, гадаад бодлого, олон улсын хамтын ажиллагаа, олон улсын эрх зүй

### **Товч агуулга**

Энэхүү өгүүллийн гол зорилго нь Европ тивээс багагүй хол зайд орших эртний түүх бүхий Монголд Руссо, Монтескье, Кант зэрэг агуу их сэтгэгчдийн үзэл санаа коммунизмаас ардчилалд хүрэхэд хэрхэн нөлөөлсөн тухай авч үзэхэд оршино.

### **References**

Russell, Bertrand. History of western philosophy: Collectors edition. Routledge, 1993.

Г.Тумурчулуун. Процесс принятия внешнеполитических решений в малых государствах (на примере Монголии). Научная книга. Москва. 1999.

Төмөрчулуун Г. “Монголын Гадаад бодлого 20, 21-р зууны зааг дээр”. Улаанбаатар. 2016.

<sup>20</sup> <https://www.un.int/mongolia/mongolia-and-united-nations-0>

<sup>21</sup> <https://www.aseminfoboard.org/events/12th-asem-summit-asem12>

Enkhsaikhan, J. "Mongolia's Nuclear-Weapon-Free Status: Concept and Practice." Asian Survey 40, no. 2 (2000).

Mendee, Jargalsaikhan. Mongolia's Peacekeeping Commitment. Training, Deployment, and Evolution of Field Information Capabilities. National Defense Intelligence College. Washington. DC. Center for Strategic Intelligence Research, 2007.

Ulaanbaatar Dialogue on North East Asian security. VI International Conference Proceedings, Ulaanbaatar. June 2019.

***Legislation and legal acts:***

The Constitution of Mongolia (English translation). 1992.

Foreign Policy Concept of Mongolia. 2011.

GA Resolution/Decision: 53/77 D. Mongolia's international security and nuclear-weapon-free status. 1998. ЕА-н 53/77 дугаар тогтоол. Монгол Улсын олон улсын аюулгүй байдал ба цөмийн зэвсэггүй статус. GA Resolution/Decision: 53/77 D. Mongolia's international security and nuclear-weapon-free status. 1998.

Монгол-Хятадын харилцааны түүхэн баримт бичгийн эмхэтгэл (1990-2010). Улаанбаатар. 2014. Treaty on Friendly Relations and Cooperation with PRC. 1994.

Монгол-Оросын харилцааны түүхэн баримт бичгийн эмхэтгэл (1992-2014). Улаанбаатар. 2016. Treaty on Friendly Relations and Cooperation with Russian Federation. 1993.

Law on non nuclear status of Mongolia. 2000.

Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль, 2000. Law on non nuclear status of Mongolia. 2000.

<https://news.un.org/en/story/2018/03/1004552>

<https://unmiss.unmissions.org/mongolian-peacekeepers-provide-much-needed-medical-care-communities-unity>

<https://www.montsame.mn/mn/read/201305>

<https://www.un.int/mongolia/mongolia/mongolia-and-united-nations-0>

<https://www.aseminfoboard.org/events/12th-asem-summit-asem12>

<https://www.mfa.Mongolia>

## АРДЧИЛЛЫН ТӨЛӨӨХ ҮЙЛ ЯВЦЫН ӨРНӨЛ БА ЭРХ ЧӨЛӨӨНД ТЭМҮҮЛЭХҮЙ (АРДЧИЛЛЫН ДИЛЕММА – I)

**О.Хатанболд**

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн

Улс төр – эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан

**Дамдин Д.Бадараев**

ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд,

Буддын судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

### **Оршил**

Энэхүү өгүүллийг тэрлэхийн учир нь, ардчилал болон түүний төлөвшил хийгээд гарсан өөрчлөлтийг судалгааныхаа чиглэл болгон сонгон судалж буй зохиогчийн сүүлийн үед хийсэн эмпирик мэдээлэлд анализ хийх хэлбэрээр ардчиллын төлөөх үйл явцад оруулж буй улс орнуудын туулсан замналыг *«Ардчиллын төлөөх үйл явцын өрнөл ба эрх чөлөөнд тэмүүлэхүй»* хэмээх сэдвийн дор нөхцөл байдалд дискурс анализ хийхийг зорьсон болно. Чингэхдээ 1959 онд АНУ-д өрнөсөн Ардчиллын төлөөх оюутнуудын хөдөлгөөн, 1989 онд БНХАУ-д өрнөсөн ардчилал, хүний эрх, авлига, хүнд суртлыг халахын төлөө өрнүүлсэн ширүүн тэмцэл хийгээд Тяньаньмэний талбайд болсон аймшигт явдлын 30 жилийн ойд зориулан эл үйл явдал гарах болсон шалтгаан хийгээд түүнд үзүүлсэн эрх баригчдын хандлага, сөрөг арга хэмжээ, Зүүн европын улс орнуудад дэгдсэн ардчиллын төлөөх цогтой тэмцэл, ЗХУ-ын задрал зэрэг асуудлыг хөндөхийн зэрэгцээ эл үйл явц монголчуудад хэрхэн нөлөөлсөн талаарх үйл явцын мөн чанарыг тодруулахыг зорьсноороо онцлогтой. Мөн ардчиллыг бэхжүүлэх, улмаар түүнийг гажуудахад нөлөөлж буй сүүлийн үеийн үйл явдлыг шинжлэн зохиогчийн ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний цуврал бичиг *«Философи, эрхийн судлал- XXXII»* (Уб., 2017) дугаарт хэвлэгдсэн *«Монголчуудын ардчиллын тухай ойлголтын шинжилгээ: дискурс анализ»* эрдэм шинжилгээний өгүүллийн үргэлжлэл болгон энэхүү өгүүллийг тэрлэв.

Ардчилал амжилттай өрнөх эсэх нь мөн чанараараа ард иргэдээс болон тухайн ардчилсан нийгэмд оршин буй нийгмийн ба улс төрийн сонирхлын бүлгүүдийн хоорондын уян хатан, шударга харилцаанаас шалтгаалдаг үйл явц, харин аль нэг улс төрийн нам, эвсэл хүчирхэг гүрний нөлөөнөөс үл хамаарах учиртай. Тиймээс ардчилал нь түүхийн бэрхшээл, сорилт цаг үеийг туулан хөгжиж боловсорсон үйл ажиллагаа, дэг журмын арга хэмжээ мөн агаад ардчилал бол хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулснаар хүний үзэл бодол, итгэл үнэмшил, бодит үзэгдэл болоод хариуцлагаар дамжин хөгжих арга хэрэгсэл, орчин үеийн төр, нийгмийн хөгжил дэх хамгийн чухал асуудлуудын нэг болон холбогддог<sup>1</sup>. Энэ утгаараа, ардчилал бол

<sup>1</sup> Антони Гидденс. Социологи. ред. Ганхуяг Д. МУИС, НШУС. УБ., 2006. 250 дахь тал.

зөвхөн тухайн улс эсвэл төр засгийн хүрээнд хамаатай зүйл огт биш, харин ардчилсан зарчмууд нь аль ч төрлийн эвлэл холбооноос хамтын шийдвэр гаргахтай холбоотой үйл явц. Үнэндээ төр улсын түвшин дэх ардчилал, нийгмийн бусад харилцаа, институтын хүрээн дэх ардчилал хоёрын хоорондын чухал холбоо юм. Төр улсын хэмжээний институци бол нийгмийн хэргийг бүхэлд нь зохицуулах чиг үүрэгтэй, албадан татвар ногдуулах, гишүүдийнхээ үхэх, амьдрахыг шийдэх хүртэл эрх мэдэлтэй, хамгийн өргөн хүрээг хамардаг учраас төр улсын төвшний ардчилал шийдвэрлэх бол улс орон, ард түмний хөгжил дэвшилд ач холбогдолтой билээ.

### ***Асуудлын үндэслэлийг тодорхойлохуй***

Аль ч улс үндэстэн ардчиллыг үнэт зүйлээ болгох нухацтай учир шалтгаан бий. Учир нь ардчилал бүх хүмүүст адил тэгш хандахыг зорьдог тухай английн эрх зүйн онолч Йереми Бентам, угаасаа зарим хүмүүсийн амьдрал бусдаасаа илүү үнэ цэнэтэй байсан гэж үздэг аристократ үзлийн эсрэг цохилт болгож «хүн бүр хэн нэгний хувьд үнэ цэнэтэй бөгөөд нэгээс олон хүний хувьд хэн ч үнэ цэнэгүй» гэжээ. Эрх тэгш байдлын зарчимд төр засгийн бодлогоор хүмүүсийн ашиг сонирхолд адил тэгш хандахыг шаардаад зогсохгүй тэдний үзэл бодол ч адил тэгш үнэ цэнэтэй байхыг шаарддаг. Тэр утгаараа бидний «сонгодог» гэж нэрлэх дуртай тодорхойлолтууд бүрэн хариулт өгч чаддаггүй. Энд нэг талаас, шинжлэх ухааны тодорхойлолтын агуулга, нөгөө талаас иргэд олон нийтийн ойлголт, төсөөллийн зөв харьцааг тогтоох, ухамсартай үйл ажиллагааг хослуулах чухал болсон.

Иймээс аливаа ард түмэн өөрсдийн өмнө бий болсон асуудлуудын талаар тодорхой буюу рационал санаа бодолтой байдаг бөгөөд тэрхүү санал бодол нь ардчилсан оронд өөрсдийн санаа бодлоо баталгаажуулахын тулд түүнийг хэрэгжүүлэхээр ажиллах, цаашлаад өөрсдийн төлөөлөгчөө сонгодог нь бидний өнөөг хүртэл баримталж ирсэн сонгодог онолын эргэлзээг тайлах гэсэн оролдлого билээ. Нэг үгээр хэлбэл, ард түмний гол үүрэг бол төр засаг болоод гүйцэтгэх засаглалыг бүрдүүлэх эсвэл түүний үүргийг хэрэгжүүлэх завсрын нэгэн байгууламжийг бүрдүүлэхэд оршдог. Тодруулбал, ардчилсан арга гэдэг нь хувь хүмүүс ард олны саналын төлөөх өрсөлдөөнт тэмцлээр шийдвэр гаргах эрх мэдлийг олж авдаг явдлаар илэрхийлэгдсэн улс төрийн шийдвэр гаргах тэрхүү институционал журам юм. Энэхүү өөр хоорондоо холбоотой үйл явцын бодит хэрэгжилт ардчиллыг хөгжүүлэх талаар хүрсэн төвшин, ардчиллын үзэл санааны үнэ цэнийг харуулж, тухайн орон ардчилсан орон мөн, бишийг тодорхойлоход арга зүй үнэ цэнэтэй хэвээр байна. Тиймээс эрх тэгш байдлын зарчимд төр засгийн бодлогоор хүмүүсийн ашиг сонирхолд адил тэгш хандахыг шаардаад зогсохгүй тэдний үзэл бодол ч адил тэгш үнэ цэнэтэй байхыг шаарддаг. Энэ утгаараа бүх нийтийн хэрэгцээ, жирийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахдаа ардчилсан төр засаг бусад төрлүүдээсээ илүү юм. Бодлогын талаар хүмүүс хэдийчинээ их ярьж хэлнэ, тэд өөрсдийн санал бодол, хүсэл зоригийг төдийчинээ ихээр бодлогод тусгуулах боломжтой байдаг. Хэрэв төрийн эрх баригчид бодлогоо олон нийтийн нөлөө буюу хяналтад өртөхгүй байхаар зориуд далд санаа агуулж боловсруулсан бол тухайн бодлого нь ард түмний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, өөртөө үйлчилсэн, ялзарсан бодлого байх болно.

Өнгөрсөн гучин жилийн хугацаанд ардчиллын үзэл санаа олон нийтийн хувьд сэтгэл хөдлөлөөс хальж, тэдний өдөр тутмын аж байдал, үйл хэрэг<sup>2</sup> болсон төдийгүй ардчилал, эрх

---

<sup>2</sup> Хатанболд О. Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуунбаатар Г., Цэцэнбилэг Ц., Ганбат Д нар. «Соёмбо» принтинг. УБ., 2017. 30-33 дахь талууд.

чөлөө гэдэг нь хэн бүхэн өөрийн дураар авирлах, эмх замбараагүй байхын нэр биш юм. Ардчилал, эрх чөлөөг цаг ямагт иргэний үүрэг хариуцлагатай холбож, хэм хэмжээнд нь эдлэх нь бидний оршин буй энэ цаг дор хийгээд ирээдүйд ч илүү их ёс зүйтэй, хэм хэмжээг баримталсан байхыг шаардах нь дамжиггүй. Ардчилал, эрх чөлөө хэрэгжиж уг сурвалж нь зөвхөн хувийн өмчид л тулгуурлана. Зах зээл гэдэг нь мөн л хувийн өмчийн нөхцөлд хэрэгжих ба энэ утгаараа ардчилал-зах зээл-эрх чөлөө хэмээх бие биеэсээ хамааралтай ойлголт<sup>3</sup> хэмээн хэт туйлширсан хандлага буй гэлтэй. Гэтэл өнөө цагт, бидний олж мэдснээр «зах зээл» гэдэг үгийг бие бодисгүй «үл үзэгдэх гар»-аар удирдуулдаг «чөлөөт зах зээл» бүхий «жинхэнэ» капитализм ямар сайхан хэмээн мөрөөдөн байх ахул зах зээл гэдэг нь гагцхүү үзэл суртлын арга маягаар боловсруулсан, бодит байдлаас хол хөндий хийсвэрлэл төдийгүй шинжлэх ухаанаар олдсон бодит байдлыг хэлж буй хэмээн сурталчилдаг онолчдын зохиолуудад улайрсан үзэл суртал гоё сайхан хэлбэртэй зүйл. Угтаа чөлөөт зах зээл бол чөлөөт өрсөлдөөн мөн агаад уг өрсөлдөөнд оролцож байгаа хүмүүс өрсөлдөж буй тухайн хүрээндээ чөлөөтэй, бие биеэс үл хамаарах үйлдэл болой. Угтаа өрсөлдөөн бол амгалан сайхан дүр төрх лүгээ огтхон ч адилгүй, гагцхүү хүн төрөлхтнийг сайн сайхан болгох хэрэгсэл ч биш, харин амьдрахуйн төлөө тэмцэл, өрсөлдөгчөө шахан зайлуулах эцсийн дүндээ өрсөлдөөнийг өөрийг нь устгахад чиглэгддэг тэмцлийн хэрэгсэл, саад тотгор тавих, мэхлэх, хүчирхийлэх, рекламдах, эсрэг талаа устгах, гэмт хэрэг хийх, бүлэглэлд хуваагдан талцан муудалцах явдлын цогцолбор буй. Тэгэхлээр, ардчилсан эрх чөлөөний тухай өрнийн үзэл суртал, ухуулга ятгалгад яригддаг тэр бүх зүйл мөн л худал дэмий хэдий ч эрх чөлөө бол западнизмын үзэл суртлын шүтээн төдийгүй эрх чөлөө бол хүний амьдралын эрхэм дээд үнэт зүйл мөн хэмээдэг. Гэхдээ хүний эрх, иргэний эрх чөлөө гэдэг нь үнэмлэхүй төгс сайн сайхан биш, харин угаас заяагдсан сайн сайхан, муу муухай ч огт биш, зөвхөн иргэн хүний статусыг тогтоосон эрх зүйн хэм хэмжээ<sup>4</sup> төдий зүйл ажээ.

Чингэхлээр ардчиллын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс тухайн ард түмний амьдрал үйл ажиллагаа, нийгэм-улс төрийн бодит практикт биежиж хэрэгжсэн төлөв байдлыг, эсвэл хэрэгжиж биелсэн байх үеийн тухай угтан тоймлосон төсөөллийг тэр улс үндэстний ардчиллын загвар гэж болзмол байдлаар нэрлэж болно. Энэ нь эгэл жирийн иргэний амьдралын хэвийн үйл ажиллагаанаас эхлээд улс төрийн засаглалын хэлбэр, бүтэц хүртэл өргөн хүрээтэй нийгэм, улс төрийн үзэгдэл, үйл явцыг хамарна. Иргэдэд ээлтэй сайн бөгөөд ардчилсан засаглал<sup>5</sup> гэдэг нь иргэдэд тэгш боломж олгох, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй байдал бий болгох талаар нийгэм өөрийгөө зөв зохион байгуулах тухай асуудал юм. Дэлхийн улс орнуудад төлөвшин хөгжиж, бэхжиж буй ардчиллын үндсэн хоёр шалгуур нь улс төрийн эрх, иргэний эрх чөлөөний төвшинг үндэслэн улс орон бүрийн зэрэглэлийг харуулсан судалгаа, баримтуудыг судлан мэдэх нь зайлшгүй хэрэг мөн.

Ардчилал ба төрийн хоорондын уялдаа холбооны тухайд гэвэл, улс төрийн эрх мэдлийг иргэд авснаар ардчиллын эзэд болдог. Мөн иргэдэд субъектив эрхийг хуулиар бүгдэд нь олгодог. Дээд төвшний дүрэм журмаас эхлээд тухайлбал, Үндсэн хуулиас хуулийн тогтолцоо нь иргэдийн чөлөөт сонгуулиар санал өгөх замаар өөрсдөд нь олгосон эрхээ төрөөр дамжуулан хэрэгжүүлэх боломж юм. Иргэд зөвхөн эрхээ эдлээд зогсохгүй, хамтарсан шийдвэр гаргахад

<sup>3</sup> МҮАН. Хараацайн жигүүр цуцахгүй. Бяцхан ном II. УБ., 1996. 172 дахь тал.

<sup>4</sup> Зиновьев А. Өрнө дахин: Западнизмын гоц үзэгдэл. орч. Даш-Ёндон Б, ред. Чулуунбаатар Г. «Соёмбо» принтинг. УБ., 2017. 45, 46, 47, 78 дахь талууд.

<sup>5</sup> МХЗ-9 төсөл. НҮБХХ. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар. орч. Даваадулам Ц. УБ., 2008. 28 дахь тал.

иргэдийн үндсэн эрх ашиг нь анхдагч байна. Орчин үеийн ардчилал нь хүмүүсээр удирдуулах нь ч юу юм, хүмүүст хамаатай, хүмүүсийн төлөө байх ёстой гэдгийг ухамсарлах хэрэгтэй ажгуу. Ардчилал иргэдийн амьдрал ахуйд хэрхэн нөлөөлж буйг шинжлэн судлах байнгын тогтмол, давталттай судалгааг явуулснаар ард түмний ардчиллыг ойлгох эерэг, сөрөг хандлага, нөхцөл шалтгааныг тодруулснаар ардчиллын бодит дэмжлэг хэрхэн өсч мөн хэрхэн буурч байгаа талаарх илэрхийлэхийг олж тогтооно.<sup>6</sup> Өөрөөр хэлбэл, ардчиллын явцад иргэдийн ахуй амьдрал төр засаг, улс төрчдөөс хамаарах байдал аажмаар багасч харин өөрсдийнх нь идэвх санаачилга, хүчин чармайлтаас илүүтэй хамаарах байдал тул удаан боловч нэмэгдэж буй гэсэн үг.

Чингэхлээр, аливаа улсын ард иргэдээ дэмжсэн хууль, бодлого бүрийн гол зорилго нь төрийн тогтолцоог бэхжүүлэх, ардчиллыг гүнзгийрүүлэхэд чиглэгдэж байдгаараа улс үндэсний эрх ашигт үйлчилж байх ёстойгоос гадна улс төрч бүхэн улс төрөөр тоглож, хууль санаачлагч бүр хуулиар тоглоод, зальхай завшигч бүхэн шунал хүсэлдээ хөтлөгдөн хөрөнгө мөнгө завшаад, эрх мэдэлтэй, албан тушаалтай болоод байх нь үндэсний эрх ашигт нийцэхгүйгээс гадна улс орны ирээдүйн хөгжил, хүн ардын итгэл үнэмшлийг уландаа гишгэж, ард олноо гутаан доромжилж хүсэл тэмүүллийг «цаазлан» боомилж буй явдал болно гэдгийг ухах нь ардчиллыг ойлгохуйц үндэслэл оршино.

***Ардчиллын төлөөх үйл явцын өрнөл ба эрх чөлөөнд тэмүүлэхийн учир юунд оршино вэ ...***

Бид энэ хэсэгтээ ардчиллын төлөөх үйл явцын өрнөлт хийгээд түүний түүхийг эргэн харах нь зүйтэй хэмээн үзэв. Дэлхийн улс орнуудад төлөвшин хөгжиж, бэхжиж буй ардчиллын үндсэн хоёр шалгуур нь улс төрийн эрх, иргэний эрх чөлөөний төвшинг үндэслэн улс орон бүрийн зэрэглэлийг харуулсан судалгаа, баримтуудыг судлан мэдэх нь зайлшгүй хэрэг мөн. Ардчилал ба төрийн хоорондын уялдаа холбооны тухайд гэвэл улс төрийн эрх мэдлийг иргэд авснаар ардчиллын эзэд болдог. Мөн иргэдэд субъектив эрхийг хуулиар бүгдэд нь олгодог. Дээд төвшний дүрэм журмаас эхлээд тухайлбал, Үндсэн хуулиас хуулийн тогтолцоо нь иргэдийн чөлөөт сонгуулиар санал өгөх замаар өөрсдөд нь олгосон эрхээ төрөөр дамжуулан хэрэгжүүлэх боломж юм. Иргэд зөвхөн эрхээ эдлээд зогсохгүй, хамтарсан шийдвэр гаргахад иргэдийн үндсэн эрх ашиг нь анхдагч байна. Орчин үеийн ардчилал нь хүмүүсээр удирдуулах нь ч юу юм, хүмүүст хамаатай, хүмүүсийн төлөө байх ёстой гэдгийг ухамсарлах хэрэгтэй ажгуу.

Учир нь дэлхий дахины болон тодорхой улс үндэстний аль ч төвшинд соёл иргэншлийн шинэ цагирагт орох шаардлага гарцаагүй гарч ирсэн үед аль хэдийнээ тэрхүү алсад хүрэх замаа гаргаад нэгэнтээ эхэлсэн буй. Энэ нь «шинэ өөрчлөлт, боловсронгуй дэвшил» байх ёстой бөгөөд зорилго нь хямралаас өмнөх цаг үе, дэг журамд зүгээр нэг буцаж орох явдал биш харин дэлхийн хөгжлийн шинэ хэв загварт шилжих явдал мөн. Үүнтэй холбогдуулан өөрчлөн байгуулалтын туршлагыг бүх талаар эргэж авч үзэх нь сонирхолтой бас ашиг тустай байж болох бөгөөд энэ нь олон улсын хоорондын харилцааны үр дүнтэй, гүн гүнзгий өөрчлөлтийн тэр замд буцваас оруулах шаардлагатайг гэрчлэн харуулж буй юм.<sup>7</sup> Нөгөө талаар, ЗХУ бутарч,

<sup>6</sup> Хатанболд О. Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төр судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлийн хүрээнд хийсэн шинжээчдийн үнэлгээ. «Адмон» ХХК. УБ., 2016.

<sup>7</sup> Горбачев Михаил Сергеевич. Бүх юм өөрийн цаг хугацаатай. орч. Баатар Ч. ред. Жавхлан Н. Анхны хэвлэл. «Монсудар» Хэвлэлийн газар. УБ., 2013. 477 дахь тал.

дэлхийн социалист систем задарснаар энэ бүлэг улсын баримталж ирсэн гадаад бодлогын социалист интернационализм, пролетарийн интернационализм, энх тайвнаар зэрэгцэн орших тухай гурван зарчим аяндаа хүчингүй болжээ. Эл байдлын тод жишээ нь Чехословак, Болгар, Унгар, Польш зэрэг орнуудад мөн ардчилал, эрх чөлөөг шаардсан жагсаал цуглаан өргөн олон түмнийг хамрах болсон нь Зүүн европын социалист орнуудад эрх барьж буй коммунист намууд нь өрсөн даалуу нурж буйн адилаар нуран унаж байв. Угтаа Зүүн европын социалист орнууд өрнөдтэй шууд залгаа оршдог, цаанаас нь хүчирхэг радио долгионоор цацдаг ардчилал, эрх чөлөөний үзэл санааг хүлээн авах боломж нь биднээс хавьгүй илүү байв. Тэнд коммунист дэглэмүүд тогтоод 40 гаруйхан жил болж байгаа, өмнө нь чөлөөт зах зээл, хувийн өмчийн олон зуун жилийн уламжлалтай байсан зэрэг нь ардчилсан өөрчлөлт ийм хурдтай өрнөхөд нөлөөлсөн байх. Өөрөөр хэлбэл, нэр дэвшигч нэг суудлын төлөө өрсөлдөх зөв гэдгийг эрх барьж буй намд зөвлөх явдал өдөр ирэх тусам ойлгон ухамсарлах хүмүүсийн тоо нэмэгдэж<sup>8</sup> байжээ.

Дээр дурдсан нөхцөл байдал нь бидний мэдэх ардчилсан өрнөлтийн хамгийн ойрын үзэгдэл юм. Учир нь, ардчиллын төлөөх үйл явцын өрнөлт социалист блокийн орнуудад өрнөсөн хэмээдэг авч, энэхүү шинэ давлгаа түүнээс өмнө АНУ-д «Дайныг биш хайрыг бий болгоцгооё» (*Make love -not war*) гэсэн уриатай Вьетнамын дайныг эсэргүүцсэн Америкийн залуучуудын энх тайван, хүмүүнлэг нийгмийн төлөөх тэмцэл, капиталист орнуудын улс төрийн сэтгэлгээний өөрчлөлт, шинэчлэлийг эрэлхийлсэн залуусын зоримог алхмаас эхэлснийг энд дурдах нь зүйтэй. Тэдний дэвшүүлсэн эл уриалга нь шинэ эриний залуучуудын өнгө төрхийг бүрдүүлэхийг зорьсон Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөн<sup>9</sup> (*Students for Democratic Society*) зохион байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь буй\*. Энэхүү эхлүүлсэн үйл хэрэг нь дараах байдлаар бодит илрэл болон өрнөжээ. Тус хөдөлгөөн нь АНУ-ыг зөвхөн нийгмийн элит, нийгмийн бодлогыг хянадаг загвар улс төдий төрийн системээс өөрчлөгдөж, иргэдийн өмнө тулгарч буй аливаа хүчирхийллээс ангид байж асуудлыг илүү хүмүүнлэг, яриа хэлцлийн төвшинд шийдвэрлэж байх шинэ нийгэм болгон өөрчлөн хөгжүүлэхийг зорьж байсан нь зарим талаар төрийн албан тушаалтнуудтай тэдний санаа бодол зөрчилддөг байв. Учир нь Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөнийг үүсгэн байгуулагч гишүүд 1962 онд батлагдсан баримт бичигтээ олон улсын энх тайван байдлыг сахин хамгаалах, үр ашиггүй бодлого шийдвэрийг зогсоох, улмаар арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, материализм, милитаризм, ядуурлыг бууруулах зэрэг нийгмийн өмнө тулгамдаж буй олон тооны сөрөг асуудлуудыг шийдвэрлэж чадахгүй байгаа тухайн үеийн Америкийн улс төрийн системийг зоригтой шүүмжилсэн байна. Эл дурдсан асуудлуудыг тус хөдөлгөөний анхны улс төрийн тунхаг бичигт\* иргэдийн амьдрал ахуй хийгээд сайн сайхан байдалд шууд нөлөөлөхүйц нийгмийн шийдвэр гаргаж, улмаар иргэдийг нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд оролцох эрх мэдэл олгох «бүрэн оролцооны ардчилал»-ыг бий болгохыг уриалсан байна. Ийнхүү оролцооны ардчиллыг өргөжин тэлж,

<sup>8</sup> Амарсанаа С. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. Тэргүүн дэвтэр. ред. Төмөрчөдөр Ж. «МН Технологи» ХХК-ний хэвлэх үйлдвэр. УБ., 2011. 47-48 дахь тал.

<sup>9</sup> Дэлгэрэнгүйг <https://www.britannica.com/topic/Students-for-a-Democratic-Society>-ээс үзнэ үү.

\* Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөн нь Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөнийг үндэслэн байгуулсан бөгөөд тус хөдөлгөөн нь 1959 онд Аж үйлдвэрлэлийн Ардчиллын Лиг (*League for Industrial Democracy*) буюу хуучин нийгмийн боловсролын байгууллагын салбар болон хөгжсөн радикал залуучуудын байгуулсан хөдөлгөөн юм. Дэлгэрэнгүйг <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society>-ээс үзнэ үү.

\* Порт Хуруны мэдэгдлийг Мичиганы их сургуулийн оюутны сонины редактор асан 22 настай Том Хайден бичжээ. Дэлгэрэнгүйг <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society>-ээс үзнэ үү.

улмаар оюутнуудын тэмцэл хөдөлгөөн эрчимжихэд нөлөөлсөн зүйл бол Вьетнамын дайн бөгөөд 1966 оны 1 дүгээр сард Ерөнхийлөгч Линдон Б.Жонсон\*(Lyndon B. Johnson)-ы засаг захиргаанаас гаргасан хуулийн төсөл болох дайнд оюутнуудыг автоматаар цэргийн албанд татах болсон нь тэмцлийг үлэмж эрчимжүүлсэн аж. Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөний «Дайныг бус хайрыг түгээцгээе», «Хүмүүсийг бус, хэзрөө шатаа», «Энэ бол там, Бид үгүй гээж хэлнэ, Бид явахгүй!» гэсэн лоозон нь дайны эсрэг хөдөлгөөнийхний гол уриа болж байлаа. Нөгөө талаар оюутан залуучуудын ардчиллын төлөөх эл хөдөлгөөн улам бүр газар авч, улмаар гишүүнчлэл нь нэмэгдэх тусам дотооддоо фракцын хэлбэрт хуваагдан бие биенийхээ үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх, харилцан ойлголцож зөвшилцөх асуудал үлэмж сорилт бэрхшээл болсноор бие биенээ үл тэвчих хурц тэмцэл бий болж тус хөдөлгөөний улс төрийн хөтөлбөрийг удирдан чиглүүлэх, үйл ажиллагаандаа хяналт тавих талд өрсөлдөөн үлэмж хурцадсан. Чингэхэд Холбооны мөрдөх товчооны хатуу мөрдлөгийн дор хөдөлгөөний зарим удирдагчдыг алан хядах ажиллагаатай холбогдуулан байцаалт авах, мөн Че Гевара, Мао Зедун мэтийн хатуу чиг шугам баримталдаг гүн ухааны үзэл хийгээд хэт радикал байр суурийг баримтлагчдын хувьд хорлон сүйтгэх, алан хядах үйл ажиллагаатай холбогдуулан мөрдөн байцаах сэдэв болсноор эл хөдөлгөөний үйл ажиллагаа саармагжиж, тасалдаж улмаар Вьетнамын дайны төгсгөлд буюу 1970-аад оны дунд үеэс эл хөдөлгөөн бүхэлдээ үгүй болжээ. Энэ бол аливаа ардчилсан хөдөлгөөнийг дотроос нь саармагжуулах, идэвхтэй үйл ажиллагааг нь сулруулах улс төрийн тоглоом (Game of Politics)-ын нэг жишээ хийгээд үзэл бодлоо нэгтгэж нэгэн зүгт удирдан жолоодох хүч, дотоод нөөц бололцоогүй байдлаас нөлөөлж буйн тод илрэл гэж болно.



Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөн нь 1959 онд улс төрийн өөрчлөлтийг уриалж Хүчирхийллийн эсрэг залуучуудын бүлэг болон байгуулагдсан түүхтэй. Тэд 1960-аад онд эхэлсэн Вьетнамын дайныг эсэргүүцэж улс төрийн өөрчлөлт хийх, энх тайвнаар оршин тогтнохыг уриалсан залуучуудын тэмцлийг эхлүүлсэн юм. Энэ зураг дээр Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөний нэгэн удирдагч Роберт Пардун 1965 оны 4-р сарын 17-нд Техас муж дахь Линдон

\* Линдон Байес Жонсон (Lyndon Baines Johnson) 1960 онд АНУ-ын дэд ерөнхийлөгчөөр сонгогдсон. Тэрбээр 1963 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр буюу АНУ-ын 35 дахь ерөнхийлөгч Жон Кеннедийн Техас мужийн Даллас хотноо бусдад хорлогдсоноос хэдхэн цагийн дараа Вашингтон уруу ерөнхийлөгчийн онгоцоор (Air Force One) нисэж байх үедээ буюу онгоцондоо ерөнхийлөгчийн тангараг өргөж АНУ-ын 36 дахь ерөнхийлөгч болсон. Тэрбээр 1964 онд Аризона мужаас сенатын танхимын гишүүнээр сонгогдсон Бүгд Найрамдах сенатч Барри Голдоутертын эсрэг ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшин өрсөлдөж, ялалт байгуулан АНУ-ын ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгаатай болж улмаар өөрийн дэвшүүлсэн ерөнхийлөгчийн хөтөлбөрийг конгрессоор батлуулсан байна. Түүний бүрэн эрхийн хугацаанд 1964 оны 7-р сарын 2-ны өдөр Иргэний эрхийн тухай хуульд гарын үсэг зурснаар Мартин Лютер Кингийн «*Надад мөрөөдөл бий/I have a dream*» хэмээх 1963 онд хэлсэн илтгэлийн үнэ цэнийг үлэмж нэмэгдүүлж, түүний мөрөөдлийг биелүүлэхэд Америкийн ард иргэдийг уриалан дуудсан томоохон алхам болсон байна. Тэрбээр мөн 1965 онд Сонгуулийн эрхийн тухай хуулийг Конгрессоор батлуулан гарын үсэг зурсан бол 1968 онд *Шударга орон сууцаар хангагдах эрхийн тухай хууль (Fair Housing Act)*-ийг баталж арьсны өнгө, шашин шүтлэг, үндэсний гарал үүсэл, хүйс дээр суурилсан аливаа худалдаа, түрээс, орон сууцны санхүүжилтийн ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хуулийг баталснаар АНУ-ын хууль эрх зүйд гарсан томоохон ялалт болсон юм. Линдон Б.Жонсон 1969 оны 1 дүгээр сарын 20-ныг хүртэл АНУ-ын ерөнхийлөгчөөр ажилласан бөгөөд дахин сонгогдохоос өөрийн хүсэлтээр татгалзсан нэгэн байв. Тэрбээр 1973 онд таалал төгсжээ. Дэлгэрэнгүйг <https://www.biography.com/us-president/lyndon-b-johnson>-ээс үзнэ үү.

Б.Жонсон эдлэн газрын ойролцоох цэцэрлэгт хүрээлэнд хэвлэлийнхэнд хандан Ерөнхийлөгч Жонсоны засаг захиргаанаас хэрэгжүүлж буй Вьетнам дахь бодлого, үйл ажиллагааг буруушааж эсэргүүцлийн жагсаал хийж буй.

Эх сурвалж: <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society/> Ассошейтэд пресс (The Associated Press)-ийн гэрэл зураг. Зурагчин Ферд Кауфман (Ferd Kaufman).



Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөний гишүүдийн ихэнх нь 1930-аад оны үеийн нийгмийн дэвшилтэт, радикал үзэлтэй залуучуудын нийгэмлэгийн «улаан живэхтэй нялх хүүхдүүд» хэмээн нэрийддэг асан гишүүдийн үр хүүхдүүд байв. Шинэхэн байгуулагдсан Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөн нь 1960 онд анхны хурлаа Мичиган мужийн Анн Арбор хотноо зохион байгуулж Роберт Алан Хаберыг ерөнхийлөгчөөр сонгожээ. Хэдэн зуун иргэд

Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөнийхөнтэй хамтран Вьетнамын дайны эсэргүүцэн жагсаал хийж, Лос Анжелосийн иргэний төвөөс Холбооны байрнаас Шүүхийн байрыг чиглэн эсэргүүцлийн жагсаал хийж буй нь. 1968 оны 1-р сарын 12. Лос Анжелос хот. (Ассошейтэд пресс (The Associated Press)-ийн гэрэл зураг. Зурагчин Харолд Филан (Harold Filan) Эх сурвалж: <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society/>



Ардчилсан нийгмийн төлөөх оюутнуудын хөдөлгөөнийг үүсгэн байгуулагч Том Хайден 1968 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Ерөнхийлөгчийн Хүчирхийлэлтэй тэмцэх комиссын өмнө мэдүүлэг өгч буй нь. (Ассошейтэд пресс (The Associated Press)-ийн гэрэл зураг). Эх сурвалж: <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society> Хэйдэн хожим нь «...Порт Хуроны мэдэгдлийн төсөлд Зөвлөлт холбоот улсыг хүчтэй эсэргүүцсэн хэмээн оруулсан байдаг. Гэхдээ Майкл Харрингтон болон Аж үйлдвэржилтийн ардчиллын лиг (League for Industrial Democracy)-ийн удирдагчдад энэ нь хангалтгүй байсан юм. Тэд үнэмлэхүй тодорхой зүйлийг хүсч байсан, тухайлбал, АНУ цөмийн зэвсгээр хөөцөлдөх энэхүү өрсөлдөөнд ямар ч гэм буруугүй гэдгийг оруулахыг хүсч

байв. Үнэнийг хэлэхэд, оюутны идэвхжлийн шинэ давллагааны бие даасан байдалд заналхийлж байгаа юм шиг санагдаж байж билээ ...» хэмээн бичжээ.

Эх сурвалж: Tom Hayden and Dick Flacks, 'The Port Huron Statement at 40' in *The Nation*, 5 August 2002

Дээрх явдлаас хойш даруй гучин жилийн дараа Ази тивд тэр дундаа БНХАУ-д Дэн Сяопиний санаачилгаар 1978 оноос эхлүүлсэн улс төр, эдийн засгийн өөрчлөлт газар авч, тус улс зах зээлийн эдийн засагт шилжих, мөн улс төрийн хүрээнд зарим талаар либералчлах бодлого явуулах болсноор өмнөх удирдагч Мао Зэдуны эхлүүлсэн хятадын коммунизмын онолын тогтолцоог аядуу зөөлөн болгох бодлого баримтлах болсон аж. Гэвч эл өөрчлөлт нь хэт удаашралтай буйг хятадын оюутан залуус болоод сэхээтний зарим хэсэг шүүмжилж, улмаар улс төрийн тогтолцоогоо өөрчлөх шаардлагатайн дээр Хятадын коммунист нам (ХКН)-ын удирдлагын явуулж буй нийгэм-эдийн засгийн бодлогод сэтгэл дундуур буйгаа илэрхийлсэн нь оюутнуудын тэмцэл эцэстээ хурцатгахад хүргэжээ. Нөгөө талаар, дэлхийн улс орнуудад бий болж буй ардчилал, ил тод байдлын төлөөх тэмцэл, хүний эрхийг дээдлэх уриа лоозон үлэмж нэмэгдэж, улмаар ЗХУ-ын Коммунист намын ерөнхий нарийн бичгийн дарга М.С.Горбачёвын улс төрийн өөрчлөлт шинэчлэлийн үр дүнг анхааралтай ажиглаж байсан хятадын шинэ үеийн оюутан залуус болоод сэхээтний тодорхой бүлгийнхэний өөрийн орны эрх баригчид, төр засгийн удирдлагын хийж буй эл өөрчлөлт нь үнэндээ дүр эсгэсэн хуурамч үйлдэл болохыг хурцаар шүүмжилж, мөн нам төрийн аппаратаас хувийн аж ахуйн нэгжүүдтэй хууль бус гэрээ хэлцэл хийж байгааг эсэргүүцэж улмаар улс орны хэмжээнд авлига хээл хахууль далдуур бугшин цэцэглэж буйг буруушааж «худалдагдсан түшмэлүүд»-ийг төр, нийгмийн өндөр албан тушаалаас зайлуулахын төлөөх<sup>10</sup> тэмцлийн хурц хэлбэр байжээ.



Эх сурвалж: [https://www.youtube.com/watch?v=XMr\\_ksy8R\\_w](https://www.youtube.com/watch?v=XMr_ksy8R_w)

Түүнчлэн ХКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ху Яобаныг 1986-1987 онуудад оюутан залуусын дунд өрнөсөн ардчиллын төлөөх хөдөлгөөнд буруутгаж, оюутнуудын жагсаал цуглааны хариуцлагыг үүрүүлэх ёстой хэмээн үзсэн тул 1987 оны нэгдүгээр сард албан тушаалаас нь огцруулжээ. Тэрбээр 1989 оны дөрөвдүгээр сард зүрхний шигдээсээр нас барсан нь оюутнуудад «шалтаг» болж талийгаач даргын араас эмгэнэл илэрхийлэхийн зэрэгцээ түүнийг 1986-1987 онд болж байсан оюутан залуусын эрх баригчидын эсрэг авлигад идэгдсэн, улс орныг дарангуйлах замаар удирдаж байна, эрс шийдэмгий өөрчлөлт хийхдээ ардчилал, хүний эрх, ил тод байдлаар гүйцэтгэхийн төлөө тэмцэж байсан жагсаал цуглааныг

<sup>10</sup> Оюутан залуусын ихэнх нь намын удирдлагын эрх мэдлийг хязгаарлах, авлигатай тэмцэх, ардчилсан тогтолцоог бий болгохыг шаардаж байжээ. Эсэргүүцлийн хөдөлгөөнийг Ван Дань, Чай Лин, Уэр Кайси, Фэн Цундэ, Пу Жицянь нарын удирдсан Бээжингийн оюутнуудын хараат бус холбоо байснаас энэ үйл явдлыг оюутны эсэргүүцэл гэж нэрлэдэг. Гэтэл энд эрх баригчдын эсрэг илүү хатуу шүүмжлэлтэй хандаж байсан Бээжингийн ажилчдын хараат бус нийгэмлэг багагүй үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тус нийгэмлэгийн удирдагчид нь Хань Дунфан, Цянь Юймин, Бай Дунпин, Лю Хуанвэнь, Лю Сян, Жоу Юнцонь нар байжээ. Дэлгэрэнгүйг <http://atime.mn/view/article/?page=show&id=320>-ээс үзнэ үү.

буруутгасны эсрэг тэд эвлэлдэн нэгдэж төр засагтаа дуу хоолойгоор илэрхийлж ийнхүү нэгдэхэд хүргэсэн. Эсэргүүцлийн хөдөлгөөн газар авч Шанхай, Чунцин, Ухань зэрэг томоохон хотуудад оюутан залуус тэмцэл хүчтэй идэвхжиж эрх баригчид жагсагчдыг тарахыг шаардсан ч эсэргүүцэгчид тэрхүү хүлээж авахаас татгалзсанаар тавдугаар сарын эцэс гэхэд эрх баригчид эсэргүүцлийн хөдөлгөөнийхнийг хүчээр тараах зарчмын шийдэлд хүрсэн байна.

Улмаар эсэргүүцлийн жагсаал зэвсэгт мөргөлдөөн болон хувирч цэргүүд жагсагчид уруу анхааруулаагүйгээр шууд чиглүүлэн гал нээж олон арван хүмүүс амь үрэгдэж шархадсан хүмүүсийг гар дээрээ л барин зөөвөрлөж байсан дүр төрхийг дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн байгууллагынхан нэвтрүүлж байв. Чухам энэ аймшигт дүр зургаас жагсаалд оролцогсдыг онц аюултай гэмт хэрэгтэн хэмээн үзэж ихэнхийг баривчлан, ямар ч шүүхгүйгээр ялласан нь өнөөгийн бидний түүхэнд хараар бичигдэх гунигт үйлдэл<sup>11</sup> болсон юм. Түүгээр ч үл барам, эл эсэргүүцлийн хөдөлгөөнийг цус урсган дарсны дараа ч эрх баригчид тэдний талынхан, дэмжигчдийг хэд хэдэн удаагийн баривчилгаагаар саатуулж, гадаадын хэвлэлээр энэ тухай гаргахыг хориглон, дотоодын хэвлэлдээ хатуу хяналт тавьж хориглосон билээ. Эсэргүүцлийн хөдөлгөөнийг зохион байгуулсан ихэнх идэвхтнүүд гадаадад зугтан гарч, дийлэнх нь Хонконг руу зугтсан байдаг. Энэ аймшигт үйл явдал, хядлага олон улсын анхаарлын төвд орсон төдийгүй БНХАУ-ын засгийн газрын эсрэг дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн орнуудаас болон социалист дэглэмийн улс орнууд ч мөн адил төрөл бүрийн хориг тавьж, шахалт үзүүлэх болсон. Эл хориг, шахалт 1990-ээд оны сүүлч хүртэл үргэлжилсэн байна.

Нөгөөтэйгүүр, Тяньаньмэний талбай дахь 1989 оны үйл явдлаас хойш хятадын эрх баригчид олон нийтийн ой санамжаас аль болох арилгахын тулд дарангуйлалыг үлэмж нэмэгдүүлж ирсэний зэрэгцээ энэхүү эсэргүүцлийн талаарх хэвлэл мэдээллийн элдэв төрлийн мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулахад засгийн газрын зүгээс хяналт тавих, улмаар эл үйл явдлын<sup>12</sup> олон талт хувилбарыг засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай нийцүүлэхийг зорьсоор ирсэн бөлгөө. Тухайлбал, гадаад, дотоодын сэтгүүлчид хийгээд тэдний хамтран ажилладаг хятадын иргэдийн үзэл бодол болон тэднээс ярилцлага авсан сэтгүүлчдийг ч хятад иргэдийн нэгэн адил саатуулж, дарамтлах, сүрдүүлэх явдал байсаар буйг гадны судлаачид<sup>13</sup> ном бүтээлдээ онцлон тэмдэглэсэн байдаг. Үүний нэг жишээ бол, Хятад иргэд энэхүү эсэргүүцэл, ардчиллын төлөөх үйл тэмцлийн талаар ярилцахаас татгалзах, цааргалах нь элбэг байдаг аж. Түүнчлэн 1980 оноос хойш төрсөн залуучуудын дийлэнх олонх нь уг үйл явдлын талаар төдийлэн сайн мэдэхгүй бөгөөд тэдний хувьд аль болох улс төрөөс хүнийсэх, улс төрөөс хараат бус байх явдал ихээхэн ажиглагддаг талаар зарим судалгаанд<sup>14</sup> дурдсан нь бий. Хятадын орчин үеийн залуучууд эл үйл явдлын зах зухаас болон «хүн-танк» (*tank man*)<sup>15</sup>-ны бэлгэдэл, хийгээд дүр зургийг хараад ойлгох,

<sup>11</sup> «The New York Times» сонин дипломат эх сурвалжаас авсан хэмээгээд энгийн 300-1000 хүн амь үрэгдсэн гэж мэдээлсэн бол, Засгийн газрын бус «Олон улсын өршөөл» байгууллагаас 1000 орчим хүнийг цаазалсан гэж мэдээлсэн байна. Харин БНХАУ 200 хүн амь үрэгдсэний 36 нь оюутан, 10 цэрэг, хүчний байгууллагын 13 ажилтан байсан, мөн 7000 орчим хүн шархдаж гэмтсэн гэж албан ёсоор мэдээлжээ хэмээн мэдээлжээ. Дэлгэрэнгүйг <http://atime.mn/view/article/?page=show&id=320> –ээс үзнэ үү.

<sup>12</sup> «China: Tiananmen's Unhealed Wounds». Human Rights Watch. May 13, 2009. [https://en.wikipedia.org/wiki/1989\\_Tiananmen\\_Square\\_protests#cite\\_note-FOOTNOTEGreenslade2014-251](https://en.wikipedia.org/wiki/1989_Tiananmen_Square_protests#cite_note-FOOTNOTEGreenslade2014-251)

<sup>13</sup> Greenslade Roy (June 3, 2014). «Foreign journalists in China harassed over Tiananmen Square anniversary». The Guardian. Retrieved March 30, 2019. <https://www.theguardian.com/media/greenslade/2014/jun/03/press-freedom-tiananmen-square-protests-1989>

<sup>14</sup> Дэлгэрэнгүйг <https://www.youtube.com/watch?v=kMKvxJ-Js3A> –ээс үзнэ үү.

<sup>15</sup> Davidson Helen. Tiananmen Square protests: crackdown intensifies as 30th anniversary nears. The Guardian - Australian edition. May 31, 2019

цаашлаад 6 дугаар сарын 4-ний өдөр тэдний хувьд ямар чухал ач холбогдолтой<sup>16</sup> болохыг ч мэддэггүй. Хуучны зарим хуучин сэхээтнүүд улс төрийн өөрчлөлт хийх эрмэлзлээ аль хэдийнээ орхиж, гагцхүү эдийн засгийн асуудалд гол анхаарлаа хандуулах<sup>17</sup> болсон. Эл эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцож асан хэд хэдэн хүмүүс улс төрийн хоригдлууд болж өөрсдийн үр хүүхдүүдийнхээ ирээдүйг баллахаас айж, улмаар энэ явдлын бодит үнэн хийгээд оролцооны талаарх ямар нэгэн түүхийг хүүхдүүддээ хүүрнэх, тэр байтугай энэ талаарх ямар нэгэн яриа, сэдэв өрнүүлэх, ярилцахаас ч татгалздаг<sup>18</sup> болсон. Энэ үеэр талбайд цугласан хэдэн зуун хүн амиа алдсан ч чухам хэдэн хүн бослогыг хүчээр дарах үед амиа алдсан тодорхой тоо өнөөдөр ч байдаггүй байна. Тухайн үед Хятадын эрх баригчид оюутны бослогыг дарах үед 242 хүн нас барсан гэдэг боловч барууны хэвлэл мэдээллээр мянгаас<sup>19</sup> илүү хүн амь үрэгдсэн гэж мэдээлж байжээ.



*Эх сурвалж: <http://content.time.com/time/magazine/article/0,9171,970278,00.html>*

1990-ээд онд Хятад улс эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлэхэд хөрөнгө оруулалтыг баталгаажуулахын тулд олон улсын эдийн засаг, батлан хамгаалах байгууллагуудад оролцох хүсэлтэй буйгаа удаа дараа илэрхийлсэн нь бий.<sup>20</sup> Тус улсын засгийн газар 1992 онд Зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ, 1993 онд Химийн зэвсгийн тухай конвенц, 1996 онд Химийн болон төрөл бүрийн туршилт явуулахыг хориглох тухай олон улсын гэрээнд гарын үсэг зуржээ.<sup>21</sup> Түүнчлэн, Хятад улс 1986 оны байдлаар олон улсын 30 орчим байгууллагын

<sup>16</sup> Discover Thomson Reuters. *Young clerk let Tiananmen ad slip past censors: paper*. Reuters. June 6, 2007. Retrieved August 5, 2008. <https://www.reuters.com/article/us-china-tiananmen-advertisement/young-clerk-let-tiananmen-ad-slip-past-censors-paper-idUSHKG14616220070606>. (Assessed by October 07, 2019)

<sup>17</sup> Gifford Rob. *China Road: A Journey into the Future of a Rising Power*. Random House Publishing Group. ISBN 978-1-58836-634-4. 2007. pp.167-68.

<sup>18</sup> Lee Lily., Westcott Ben. *They faced down the tanks in Tiananmen Square. Now they want their children to forget it*. CNN. Retrieved June 3, 2019. [https://books.google.mn/books?id=9eq4HT-0rwsC&redir\\_esc=y](https://books.google.mn/books?id=9eq4HT-0rwsC&redir_esc=y) (Assessed by October 07, 2019).

<sup>19</sup> «The Far East and Australia» лавлахад мэдээлснээр амь үрэгдсэн хүний тоог яг 1000 гэсэн байдаг. Бээжин, Шанхай, Нанжин, Гуанжоу болон бусад томоохон хотуудад эсэргүүцлийн энэ хөдөлгөөнд оролцогсдын шүүх ажиллагаа болсон бөгөөд тэдний ихэнх нь ажилчны хөдөлгөөний идэвхтэн, гишүүд байсан гэдэг. Найман хүнийг цаазаар авахаар шийтгэж гүйцэтгэсэн байна. Өөр хэдэн зуун хүнийг шоронд хорих ялаар шийтгэсний зарим нь өнөө хүртэл шоронд байгаа гэж 2008 онд Олон улсын Өмгөөллийн байгууллага мэдээлжээ. Дэлгэрэнгүйг <http://atime.mn/view/article/?page=show&id=320>-ээс үзнэ үү.

<sup>20</sup> Link Perry. *June Fourth: Memory and ethics*. In Béja, Jean-Philippe (ed.). *The Impact of China's 1989 Tiananmen Massacre*. Routledge. 2010. p.19. ISBN 978-1-136-90684-8. <https://books.google.mn/books?id=tgXGBQAAQBAJ&printsec=frontcover#v=onepage&q&f=false> Assessed by October 07, 2019).

<sup>21</sup> Cabestan Jean-Pierre (November 18, 2010). *How China Managed to De-Isolate Itself on the International Stage and Re-Engage the World after Tiananmen*. In Béja, Jean-Philippe (ed.). *The Impact of China's 1989 Tiananmen Massacre*. Routledge. p.199. ISBN 978-1-136-90684-8. (Assessed by October 07, 2019). Дэлгэрэнгүйг <https://books.google.mn/books?id=tgXGBQAAQBAJ&printsec=frontcover#v=onepage&q&f=false> -ээс үзнэ үү.

гишүүнээр элссэн байсан бол 1997 он гэхэд энэ тоо 50-д хүрсэн байна.<sup>22</sup> Хятад улс мөн гадаад харилцаа, хамтын ажиллагаа бизнесийн түншлэлээ өргөн хүрээнд төрөлжүүлэх, үлэмж дэлгэрүүлэх бодлого баримтлах болсон төдийгүй хуучин ЗХУ буюу одоогийн ОХУ-тай<sup>23</sup> дипломат харилцаагаа өргөжүүлэхэд анхаарч, барууны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Тайванийн бизнесийн түншлэлээ нэмэгдүүлэхийг ямагт эрэлхийлэх<sup>24</sup> болсон. Мөн Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагатай хийсэн гэрээ хэлцлийг хурдасгаж, 1992 онд Индонез, Израиль, Өмнөд Солонгос болон бусад улсуудтай харилцаа тогтоож эдийн засгаа төрөлжүүлж эхэлсэн<sup>25</sup> нь нэг талаасаа 1980-аад оныг хүртэл тус улс шууд гадаад зээл тусламжаас хараат, гаднын зээл тусламжийг хүлээн авагч улс байхаас татгалзахын зэрэгцээ цэрэг армид оруулж буй зээл тусламжийн зардлаа бууруулахад<sup>26</sup> голлон анхаарч байв. Түүнчлэн 1990-ээд онд Хятад улс эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлж, хөрөнгө оруулалтыг баталгаажуулахын тулд олон улсын эдийн засаг, батлан хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаан оролцох хүсэлтэй буйгаа<sup>27</sup> харуулахыг хичээх болсон.

Эсэргүүцлийн жагсаалаас хойш тус улсын нөхцөл байдал үнэхээр тэвчишгүй хэмжээнд хүрсэн тул ХКН, БНХАУ-ын шинэ удирдлага «авлига болон ялзралтай тэмцэх» ажиллагааны улс төр, эдийн засгийн зарим эрсдэлтэй эвлэрээд зогсохгүй энэ үзэгдлийг хүн харгалзахгүйгээр шийдвэртэй арилгахад бэлэн байв. Харин авлигын хэргийн гол эзэд нь Зян Зэминь, Ху Зиньтао нарын үед дэвшсэн хүмүүс тул «авлига болон ялзралтай тэмцэх» ажиллагаа өөрөө ХКН, БНХАУ-ын дээд удирдлага дахь улс төрийн тэмцлийн нэг хэсэг мэтээр ойлгогдох нь тов тодорхой юм.<sup>28</sup> Ху Зиньтао нэгэнтээ Хятадын коммунист намын XVIII их хурал дээр авлигатай тэмцэх талаар «...энэ асуудлын оновчгүй шийдэл нам, улс орныг ч залгиж болохыг сануулаад зогсохгүй ХКН-ын гишүүд, ялангуяа удирдах албан тушаалтнуудад “төрөл төрөгсөд болон ойрын хүмүүсээ чангахан хүмүүжүүлж” хянаж байхыг» уриалсан байдаг. Чингэхдээ өөрийн улсын орчин үеийн түүхэнд хамгийн том хар толбо болсон 1989 оны Ардчиллын төлөөх оюутан залуусын эсэргүүцлийн хөдөлгөөнийг хүч хэрэглэн дарсан хэмээх «нэр хочоосоо» бүрэн салахыг ямагт хичээж ирсэн. Тиймээс ч 1990-ээд оноос хойш эрчимтэй хөгжсөн хятадын эдийн засаг, нийгэм-улс төр, цэрэг армийн өнөөдрийн хүрсэн төвшин, хөгжлийн хэтийн зорилт олон жилийн өмнөхөөс эрс өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна. Үүний нэг нь 1989 оны эсэргүүцлийн тэмцлээр хятадын ард түмэн өөрийн улсын эрх баригчид, төр засгаасаа илүү ардчилсан байж ард түмэнд амласан амлалтаа бодитоор биелүүлэх, тэдний эрхийг хамгаалах, эдийн засгийн чадавхтай, хандивлагчдаас хараат бус бие даасан эдийн засагтай Хятадын хөгжлийг хурдасгахад чухал нөлөө<sup>29</sup> үзүүлсээр байгаагийн зэрэгцээ тус улсын улс төрийн болон нийгмийн шинэчлэлийг эрчимтэй үргэлжлүүлэхэд<sup>30</sup> гол түлхэц болж буй. Эл санааг

<sup>22</sup> Cabestan Jean-Pierre (November 18, 2010). *How China Managed to De-Isolate Itself on the International Stage and Re-Engage the World after Tiananmen*. In Béja, Jean-Philippe (ed.). *The Impact of China's 1989 Tiananmen Massacre*. Routledge. p.198. ISBN 978-1-136-90684-8.

Дэлгэрэнгүйг <https://books.google.mn/books?id=tgXGBQAAQBAJ&printsec=frontcover#v=onepage&q&f=false> -ээс үзнэ үү. (Assessed by October 07, 2019).

<sup>23</sup> Мөн тэнд, p.196

<sup>24</sup> Мөн тэнд, p.196

<sup>25</sup> Мөн тэнд, p.199

<sup>26</sup> Kurlantzick Joshua (2003). *The Dragon Still Has Teeth: How the West Winks at Chinese Repression*. *World Policy Journal*. 20 (1): pp. 49–58. doi:10.1215/07402775-2003-2011. JSTOR 40209847.

<sup>27</sup> Link Perry. *June Fourth: Memory and ethics*. In Béja, Jean-Philippe (ed.). *The Impact of China's 1989 Tiananmen Massacre*. Routledge. 2010. p.19. ISBN 978-1-136-90684-8. (Assessed by October 07, 2019).

<https://books.google.mn/books?id=tgXGBQAAQBAJ&printsec=frontcover#v=onepage&q&f=false>

<sup>28</sup> Константин Сыроежкин. «Бар»-ын ав: Хятадад өрнөж буй авлигатай тэмцэх ажиллагаа. орч. Зоригт Д, ред. Нямдорж Ц. АТГ. «Адмон принтинг» ХХК. УБ., 2019. 101 дэх тал // Константин Сыроежкин. Охота на «Тигров»: почему и как в Китае борются с коррупцией. Монография. Казакстанский институт стратегические исследований при Президенте Республики Казакстан. Астана, 2016.

<sup>29</sup> Wang Dan. *The Meaning of June 4<sup>th</sup>*. Project Muse. *Journal of Democracy*, Vol 30, №2, April 2019. p. 36

<sup>30</sup> Elizabeth Economy. *Dissent is not Dead*. Project Muse. *Journal of Democracy*, Vol 30, №2, April 2019. p. 62

одоогийн Хятад улсын дарга Си Зиньпин ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн даргын хувьд анхны илтгэлдээ шинэ байдлаар илэрхийлж гол анхаарлаа «намын эгнээг цэвэрлэх» шаардлага, намын боловсон хүчний хүрэн дэх ялзрал, авлигатай тэмцэх, тэдний дунд байгаа олон түмнээс тасрах, хэлбэрдэх, хүнд суртал гаргах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд хандуулсан юм. Тэрбээр мөн «Авлига болон ялзрал эцсийн эцэст нам, улс орныг залгиж чадахаар болтлоо тулгамдсан асуудал болсон тул, нам даяараа сэхээ авч, түгшүүр зарлаж эхлэх ёстой. Түүнчлэн «...ажлын арга хэлбэр, авлига ялзралын асуудлыг шийдвэрлэхгүй бол намд сүйрлийн цохилт болж, цаашлаад нам, улс орныг залгиж болзошгүй...» хэмээн онцлон тэмдэглэсэн байна. Гэхдээ урьдын адил удирдах албан тушаалтнуудын зүг хандуулсан бөгөөд намын сахилга, хууль ёсыг зөрчигчдөд хувь хүн, албан тушаалтнуудын байдлыг нь үл харгалзан хатуу арга хэмжээ авахаар заасан. Өөрөөр хэлбэл, ХКН-ын шинэ удирдлага үйл ажиллагааныхаа эхний шатанд «намаа цэвэрлэх»-д анхаарч, «авлига ба ялзралтай тэмцэх» ажиллагааг тэргүүлэх чиглэлээ болгосон нь нэгдүгээрт, нөлөө бүхий олон хуучинсаг үзэлтэн татагдан орсон, араас нь авлигын хэргийг дуусгах шаардлагатай байв. Хоёрдугаарт, «нүцгэн түшмэд»-ийн Хятадаас зугтах давалгаа татрахгүй тул шинэ удирдлага түүнийг зогсоох ёстой байсан юм. Гуравдугаарт, «намын цэвэрлэгээ» хийх, авлигачидтай (ялангуяа өндөр албан тушаалын) бодитой тэмцэл явуулах нь ХКН-ын эерэг дүр төрх төдийгүй Си Зиньпиний байр суурийг бэхжүүлэх цорын ганц арга зам<sup>31</sup> байж ч болох юм. Нөгөө талаар, эл үйл явц магадгүй БНХАУ-ын тэртээ гучин жилийн өмнө өрнөсөн оюутан залуусын тэмцлийн нэг чухал шалтгаан болох өндөр албан тушаалтнуудын авлигын асуудал буюу «худалдагдсан түшмэлүүд»-ийн хэрэгтэй шууд холбоотой хэмээн үзэж болно.

Гучин жилийн өмнө болсон ардчиллын төлөөх Хятадын оюутан залуусын Тяньаньмэний талбайд болсон үйл явдалтай холбогдуулан АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майкл Помпеон хийсэн мэдэгдэл<sup>32</sup> ч үүнтэй салшгүй холбоотой ажгуу. Тэрбээр мэдэгдэлдээ «...Хятад улсад нээлттэй, дэлхийн өөр өөр үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрдөг нийгэм байгуулагдана гэсэн АНУ-ын итгэл найдвар талаар боллоо. Учир нь 6-р сарын 4-нд, Хятадын Коммунист Намын удирдлага ардчилал, хүний эрхийг хамгаалж, хүчирхийллийг зогсоох, авлигын асар их хор хөнөөлийг устгахыг уриалсан тайван жагсаалыг хүч хэрэглэн Тяньаньмэний талбай дахь жагсагчид уруу олон тооны танк илгээсэн тэрхүү аймшигт хар өдөр буюу «1989 оны Зургадугаар сарын 4-ний өдөр дуусгавар» болсон хэдий ч энэ бол Хятадын ард түмний «эсэргүүцлийн баатарлаг хөдөлгөөн» байсан юм. Учир нь Бээжин болон Хятадын бусад хотуудад цугларсан олон зуун мянган эсэргүүцэгчид улс орныхоо сайн сайхан ирээдүйн төлөө сэтгэл ихэд зовниж, бас шаналж байв. Амиа алдагсдын тоо одоогоор ч тодорхойгүй байна. Хайртай хүмүүсээ алдаж, өөрсдийн амьралаа эрсдэлд өртүүлэн байж хариуцлага хүлээхийг шаардан, хэзээ ч шантраагүй цуцалтгүй тэмцэж асан Тяньаньмэний зоригт Ээжүүд болон тэдний алдагдсан хайртай хүмүүсийн төлөө бид гүнээ эмгэнэл илэрхийлж байна. Гучин жилийн тэртээх энэ үйл явдлууд өнөөг хүртэл бидний оюун санаа, ухамсарт оршоор байгаагийн дээр дэлхийн өнцөг булан бүрт эрх чөлөөг хайрладаг хүн бүрийн оюун санаанд оршсон хэвээр байгаа билээ. Гучин жилийн тэртээх Тяньаньмэний талбайд зоригтойгоор боссон хятадын ард түмний баатарлаг зоригтнуудад мэндчилгээ дэвшүүлэхийн

<sup>31</sup> Константин Сыроежкин. «Бар»-ын ав: Хятадад өрнөж буй авлигатай тэмцэх ажиллагаа. орч. Зоригт Д., ред. Нямдорж Ц. АТГ. «Адмон принтинг» ХХК. УБ., 2019. 105 дахь тал. // Константин Сыроежкин. Охота на «Тигров»: почему и как в Китае борются с коррупцией. Монография. Казакстанский институт стратегические исследований при Президенте Республики Казакстан. Астана, 2016.

<sup>32</sup> Michael R. Pompeo, Secretary of State. Press statement. On the 30<sup>th</sup> Anniversary of Tiananmen Square. Washington D.C. June 3, 2019. U.S. Department of State. <https://www.state.gov/on-the-30th-anniversary-of-tiananmen-square/>. (Assessed by October 8, 2019)

ялдамд тэдний эрхийг шаардаж байна. Берлиний хана нурж, хэдэн сарын дараа Зүүн Европ дахь коммунизм дуусгавар болсны дараа дэлхий даяар эрх чөлөө, ардчиллыг уриалсан хойч үеийнхэнд урам зориг өгөхийн сацуу эр зоригын бодит жишээ болсон юм. Хятадын нэг намын тогтолцоо бол өөрөөр сэтгэх үзлийг хүлээн зөвшөөрдөггүй, өөрийн эрх ашгийн төлөө цаг үргэлж хүний эрхийг зөрчдөг тогтолцоо хэвээр байсаар байна. Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхийг хүсэж буй хүмүүсийг чөлөөлж, дур зоргоороо баривчилгаа явуулахаа зогсоож, үр ашиггүй бодлогоосоо татгалзахыг бид Хятад улсад уриалж байна. Мөн түүхийн энэ хар цагт үед нэрвэгдсэн олон хохирогчдын амгалан тайван байдлыг хангахын тулд амь үрэгдсэн болон сураггүй болсон хүмүүсийн талаарх бүрэн бүртгэлийг ил болгон зарлахыг Хятадын засгийн газарт уриалж байна. Энэ алхам нь Коммунист намын хүний язгуур эрх, эрх чөлөөг хүндэтгэж буйгаа харуулж буйн эхлэл байх болно. Нөгөө талаар хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхийг хүссэн бүх хүмүүсийг суллах, дур мэдэн баривчлах ажиллагаагаа зогсоох, терроризмыг шашин, улс төрийн илэрхийлэлтэй холбосон эсрэг үр нөлөөтэй бодлогоо цуцлахыг Хятад Улсад уриалж<sup>33</sup> буйгаа албан ёсоор илэрхийлсэн байна.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын энэхүү мэдэгдэлтэй холбогдуулан Хятад улсын засаг захиргааны зүгээс эрс эсэргүүцэж буйгаа илэрхийлж АНУ дахь БНХАУ-ын Элчин сайдын яамны албан ёсны цахим хуудснаа<sup>34</sup> (2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр) нийтэлсэн албан ёсны мэдэгдэлдээ «...1980-аад оны сүүлээр болсон улс төрийн үйл явдлын талаар Хятадын засгийн газар, ард түмэн нэгэнт шийдвэрт хүрсэн. Өнгөрсөн дөчин жилийн турш шинэчлэл, нээлттэй байдлын төлөө Хятад улс идэвхийлэн ажилласаар ирсэн. Өнөөгийн Хятад улсын эдийн засаг, нийгмийн асар хурдацтай өсөлт, хөгжилт нь ардчилал, хууль дээдлэх засаглалд тасралтгүй дэвшил, цэцэглэлтийг бий болгосон төдийгүй ард түмний амьдралын төвшин ч сайжирсан. БНХАУ хүний эрхийг сахин хамгаалж, хятадын онцлогтой социализмыг бүтээн байгуулах түүхэн сонголтыг хийж, Хятадын үндэсний онцлогт нийцсэн хөгжлийн зөв зам сонгон, түүнийгээ бүх ард түмнээрээ дэмжин урагшилж байна. Өөрөөр хэлбэл, Хятад улс энх тайван хөгжлийн замаар замнаж, дэлхийн хэмжээнд хүний эрхийн хөгжүүлэхэд тууштай бодлого баримталж, олон улсын хүний эрхийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулсаар буйг илт гүтгэн буруушааж, хятадын ард түмнийг басамжилсан шударга бус явдал гэж үзэж байна. Хятадын ард түмний хэлэх дуртай нэгэн үгэнд «сайхан амьдралыг хүчээр хэзээ ч зогсоож үл болно. Хятадын ард түмнийг ямар ч нэрээр цоллож, дээрэлхэх, цаг үеийн нөхцөл байдлаар нь эсэргүүцэх «соёл иргэншлийн мөргөлдөөн»-ийг уриалан түүнийг номлож байгаа хэн ч амжилтад хүрэхгүй. Гагцхүү түүхийн төгсгөл буюу үнс нурам болон дуусах болно»<sup>35</sup> хэмээн хариу мэдэгдэлдээ илэрхийлсэн байна.

Эл мэдэгдэлд онцгойлон тэмдэглэсэн нэгэн зүйл бол, Хятад улс үндэсний эдийн засгийн үсрэнгүй хөгжилд хүрсэн авч улс төрийн хөгжил, түүнээс уялдан гарах аливаа асуудлуудын хоорондох ойлголцол, зөвшилцлийг хангахад урт хугацааны хөгжлийн зорилтуудын дэвшүүлэн Евразийн бүс нутгийн хамтын ажиллагаанд тулгуурласан үлэмж хэмжээний амбицыг эхлүүлсэн нь нэг талаар тус улс өөрийн соёл, нийгмийн хөгжлийг дэлхийн улс

<sup>33</sup> Michael R. Pompeo, Secretary of State. Press statement. On the 30<sup>th</sup> Anniversary of Tiananmen Square. Washington D.C. June 3, 2019. U.S. Department of State. <https://www.state.gov/on-the-30th-anniversary-of-tiananmen-square/>. (Assessed by October 8, 2019)

<sup>34</sup> Remarks by Spokesperson of the Chinese Embassy on Secretary of State Mike Pompeo's Statement at the Embassy of the People's Republic of China in the United States of America. (2019.06.04). <http://www.china-embassy.org/eng/zmgxss/t1669295.htm> (Assessed by October 08, 2019)

<sup>35</sup> Remarks by Spokesperson of the Chinese Embassy on Secretary of State Mike Pompeo's Statement at the Embassy of the People's Republic of China in the United States of America. (2019.06.04). <http://www.china-embassy.org/eng/zmgxss/t1669295.htm>. (Assessed by October 8, 2019)

орнуудтай хөл нийлүүлэх, зарим талаар тэднээс гүйцэж төрүүлэхэд онцгойлон анхаарч буйг харуулж байна.

1990 оны зун АНУ-ын ерөнхийлөгч Дорнод Европын социалист цайзыг анхлан нураасан Польш, Унгар зэрэг улсыг дэмжих, тэдэнд зээл тусламж, худалдааны нэн тааламжтай нөхцөл олгох зорилгоор тэдгээр улсуудад айлчилсан нь Дорнод Европын ардчилсан өөрчлөлтийг дэмжиж буйн тод илрэл болов. Тухайлбал, Чехословак улс социалист орнуудын дотор нийгэм-эдийн засгийн хувьд харьцангуй хөгжилтэйд орж байсан тус улсын тухайн үеийн удирдагчид ЗХУ-д өрнөсөн «өөрчлөн байгуулалт», «ил тод байдал» хөрш зэргэлдээ Польш, Унгарт болж буй өөрчлөлтөд болгоомжлон хандаж байсан ч олон нийтийн хувьд байдал өөр байв. 1968 оны хэрэг явдлаас хойших 21 жил өнгөрч тэрхүү үйл явцыг тохиолдуулан хийсэн цуглаанаас тус оронд шинэчлэх үйл явц эхэлсэн бөгөөд тухайн үеийн эх баригчид цуглааныг хууль бус хэмээн хөөн тарааж, олон хүнийг баривчилсан байдаг. Тэдний дотор польш, унгарчууд байсан нь олон улсын хэмжээнд шуугиан тарьсан байна. Цуглаанд оролцогчид 1968 онд Варшавын гэрээний орнууд Чехословакт цэргээ оруулсныг буруушааж, энэхүү ялт ажиллагааныхаа төлөө уучлал гуйхыг шаардсан байна. Энэ тухайд ЗХУ уучлал гуйж, Болгар, Польш, Унгар зэрэг орнууд дэмжсэн нь Чехословакийн шинэчлэлийн хөдөлгөөнд яах аргагүй урам хайрласан ажээ. Үүний нэг жишээ бол Чехословакт «Харти-77» хөдөлгөөнөөс эх авсан ардчилсан шинжтэй олон байгууллагууд үүсэн байгуулагдаж, тэдгээрийг В.Хавел, А.Дубчек нар тэргүүлж байсан агаад 1989 оны 12 дугаар сард Вацлав Хавел ерөнхийлөгчөөр сонгогдож, А.Дубчек парламентын тэргүүн болсноор ЧКН (Чехословакийн коммунист нам)-ын дарангуйлал нуран унаж, Чехословак улс 1989 оны 12 дугаар сарын 17-ны өдөр коммунист дэглэмээс тасран салснаар Чех, Словак хэмээх бие даасан хоёр улс болж, ардчилал, зах зээлийн замыг сонгосон<sup>36</sup> байна.



Эх сурвалж: <https://www.romania-insider.com/romania-30-years-democracy-1990>



Эх сурвалж: <https://libcom.org/history/poland-1980-1982-class-struggle-crisis-capital-henri-simon>

<sup>36</sup> Болдбаатар Ж. Монголын “перестройка” (өөрчлөн байгуулалт)-ийн түүхийн судалгаа. Улс төрийн түүх (1980-аад оны эхнээс 1992 он). ред. Даш-Ёндон Б. ТАХ, ШУА. «Соёмбо принтинг» ХХК. УБ., 2017. 56-57 дахь тал.



Эх сурвалж:

<https://www.google.com/search?biw=1280&bih=579&tbm=isch&sa=1&ei=uj6kXdy7M5mLr7wPm6mJiAc&q=Czechoslovak+early+democracy+photos>



Эх сурвалж:

<https://bitsofbrilliance.wordpress.com/2014/11/09/berlinwall/>

Харин Европт 1989 оны 11 дүгээр сард Румын улсад ардчилал, үний эрх, эрх чөлөө, ил тод байдлын төлөө румыны ард түмэн эвлэлдэн нэгдэж хуран цугларч үзэл бодлоо илэрхийлсний төлөө эрх баригчид мөн л энгийн зэвсэггүй ард түмнийхээ эсрэг цуглаан хийснийх нь төлөө буудан алах тушаал өгч хэдэн арван мянгаар нь устгах аймшигт явдал дахин дэгдэж эцэстээ тус улсын арми нь ард түмнийхээ талд орж аюулаас хамгаалах хүчинтэйгээ байлдаж буй сэтгэл сэрдхийлгэм дүр зураг дахин дэлхий нийтийг айдаст автуулсан юм.<sup>37</sup> Учир нь 1989 оны 12 дугаар сар гэхэд Зүүн Европт социалист систем үндсэндээ задран төгсгөлийн шатандаа нэгэнтээ орчихсон байв. Тухайлбал, энэ үйл явцыг манлайлж байсан Польш улсад 1989 оны 4 дүгээр сард анхны ардчилсан чөлөөт сонгууль болж олон арван жилийн турш төрийн удирдаж байсан коммунист тогтолцоо, коммунизмын эсрэг олон нийтийн тайван тэмцлийг манлайлсан «Эв санааны нэгдэл» сонгуульд ялалт байгуулж тус улсын парламентын бүх суудлыг авч, улмаар ардчилсан Засгийн газраа эмхлэн байгуулсан байв. Харин Болгар улсад 1989 оны 11 дүгээр сарын 10-нд Зүүн Европын социалист орнууд дотор хамгийн удаан хугацаагаар улс орноо толгойлсон Болгарын нам, төрийн тэргүүн Тодор Живков намын болон төрийн тэргүүний албан тушаалаасаа огцорч, мөн эл явдлаас даруй 8 сарын дараа буюу 1990 оны 6 дугаар сард Болгарт чөлөөт сонгууль явагдсан ажээ. Нөгөө талаар, социалист системийн харьцангуй хөгжилтэй гэгддэг Бүгд найрамдах ардчилсан Герман улсад ард иргэд нь Баруун европ уруу хэдэн арван мянгаараа дүрвэн зугатааж, олон түмний эсэргүүцэл цуглаан жагсаал хүчтэй өрнөсний үр дүнд олон арван жил нам, засгийг нь тэргүүлсэн удирдагч Эрих Хоннекер нь 1989 оны 11 дүгээр сарын 18-нд албан тушаалаасаа огцорч, 1990 оны 3 дугаар сард тус улсад чөлөөт сонгууль явагдаж, шинэ эрх баригчид нь Берлиний ханыг нураахаар шийдвэрлэсэн байдаг. Харин 1989 оны 11 дүгээр сард Чехословакт «Хамба хилэн» гэж нэрлэгдсэн тайван хувьсгал гарч, 1989 оны 11 дүгээр сарын 29-нд парламент нь Иргэний чуулганы шаардлагаар «Үндсэн хуулиасаа марксист -ленист онол бүхий коммунист нам бол нийгмийн удирдан чиглүүлэгч хүч» гэсэн, мөн үүнтэй холбоотой 3 заалтыг хассан нэмэлт өөрчлөлтүүдийг баталсан 12 дугаар сарын 10-нд нам, төрийн тэргүүн Густав Гусак албан тушаалаасаа огцорч,

<sup>37</sup> Romania - 30 years of democracy: 1990, the first year of freedom. See detailed on <https://www.romania-insider.com/romania-30-years-democracy-1990/> Accessed by the 20 March, 2019. Romania Insider.

улмаар 1990 оны 6 дугаар сард тус улсын анхны чөлөөт сонгууль болж асан түүхтэй. Ерөнхийдээ 1989 оны 12 дугаар сар гэхэд Зүүн Европт социалист систем үндсэндээ задарч төгсгөлийн шатандаа орчихсон байв. Үүссэн цагаасаа л хүний эрх, эрх чөлөөг хорьж, ард иргэдээ угсаа гарал, нийгмийн байдал зэргээр нь ялгаварлан гадуурхдаг, хүний мөн чанарт харш, коммунизмын эхний шат гэж үздэг социализм нь олон арван сая иргэдийнхээ амь насыг бүрэлгэж, өмч хөрөнгийг хурааж, цус нулимсыг урсган оршин тогтносны эцэст ийнхүү жам ёсоороо бүхэлдээ эгнүүлэн тавьсан даалуу шиг нуран унаж байлаа.

Нөгөөтэйгүүр, хүний мөн чанарт харш, эдийн засгийн хувьд ямар ч баялаг бүтээдэггүй, үр ашиггүй, иргэдээ тэжээж, хувцаслаж, хангалуун амьдруулах чадваргүй энэ нийгэм өөрчлөгдөх ямар ч боломжгүй, үндсээрээ задран унах тавилантай байсныг тэр жилүүдэд эрчимтэй өрнөсөн үйл явдлууд нотлон харуулсан билээ. Энэ системд багтаж ирсэн улс орнуудад хүн төрөлхтний хөгжлийн жам ёсны зам болох ардчилал, зах зээлийн тогтолцоо руу эргэн шилжих, хугацаа шаардсан амаргүй үйл явц өнөө ч үргэлжилсэн хэвээр байгаа авч саад бэрхшээлийг даван туулж ардчиллыг илүү бэхжүүлэхийн төлөө шантрашгүй зүтгэсээр л байна.

Харин бид энд өгүүлэн буй цаг үед коммунист үзэл сурталтай хоёр их гүрний дунд хавчуулагдан оршиж, гадаад ертөнцөөс тусгаарлагдаад «хөмөрсөн тогоон доторх» нөхцөл байдалтай амьдарч байсан учраас тэр бүх үйл явдлын тухай мэдээ, мэдээллийг цаг тухайд нь дэлгэрэнгүй байдлаар хүлээж авах боломж<sup>38</sup> тухайн үед хомс байжээ.



1989 оны 12 дугаар сарын 10-ны өдөр буюу Олон улсын хүний эрхийн өдөр С.Зориг болон бусад идэвхтнүүд Сүхбаатарын талбайд ардчиллын төлөөх тайван жагсаал, цуглааныг зохион байгуулсан бөгөөд тэрхүү цуглаанд 200 гаруй хүмүүс оролцож Улаанбаатар хотноо хийснээр ардчилсан шилжилт хийх явцыг түргэвчлэх алхам болсон юм.

*Ардчилсан хөдөлгөөнийг удирдагч С.Зориг (голд, шилтэй нь), ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржийн хамт. 1990 оны*

*жагсаалын үеэр Сүхбаатарын төв талбай*

Эх сурвалж: [https://www.rferl.org/a/Mongolian\\_Democracy\\_From\\_PostSoviet\\_Success\\_To\\_PostTransition\\_Struggle/1899808.html](https://www.rferl.org/a/Mongolian_Democracy_From_PostSoviet_Success_To_PostTransition_Struggle/1899808.html)

Монгол Улс 1980-аад оны төгсгөлд ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын үйл явц, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг эрчимжүүлэх, мухардлаас гаргах гэсэн оролдлогод аль хэдийнээ татагдан орсон билээ. Энэ үед манай оронд улс төрийн уур амьсгал зөөлрөх тийшээ хандаж, эдийн засагт шинэчлэл хийх гэсэн хандлагууд бий болж эхэлсэн юм. Тухайлбал, 1988 оны 12 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв хорооны V бүгд хурлын шийдвэрт «Эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь нам, ард түмний хойшлуулшгүй зорилт болж байна» гэж тэмдэглэсэн байв. Энэ үед эдийн засгийн салбарт аж ахуйн шинэ механизм нэвтрүүлэх, малчдад малыг гэрээ, түрээсээр өгөх,

<sup>38</sup> Амарсанаа С. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. Тэргүүн дэвтэр. ред. Төмөрчөдөр Ж. «МН Технологи» ХХК-ний хэвлэх үйлдвэр. УБ., 2011. 47-48 дахь тал.

нээлттэй эдийн засгийн бодлого явуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байсан ба 1989 онд эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх шийдвэр гаргасан байна.<sup>39</sup> Энэ үед эдийн засгийн салбарт тавих гол зорилт нь түүнийг зохистой бүтэц, үр ашигтай цогцолбор бүхий бааз дээр суурилан хөгжүүлэх, улмаар эдийн засгийн тэнцвэржилтийг ханган ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэх явдал гэж үзсэн байна.



Эх сурвалж: <https://www.facebook.com/Mongoliademrevolution/posts/1506775182740540/>

Үнэн чанартаа, Монгол Улс ЭЗХТЗ-ийн гишүүн бусад орноос хөгжлийн хувьд хоцорсон хэвээр байв. Эдийн засгийн 40 орчим хувийг ЗХУ-ын зээлээр санхүүжүүлж байв. Үүнээс үүдэн эдийн засаг өөрийгээ тэтгэх чадваргүй болж, өрийн ихээхэн дарамт үүссэн юм. Төрөөс байгуулсан хоршооллын болон улсын гэсэн өмчийн хоёрхон хэвшил ноёлж хувийн өмчийг бүрэн устгасан нь манай нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилд таагүй үр дүн авчрав. Төвлөрсөн төлөвлөгөөний аргаар эдийн засаг нийгмийн харилцааг зохицуулах гэж оролдсон боловч тэр нь хүлээж байсан үр дүнгээ өгөөгүй юм. Ард иргэд баян хоосны ялгаагүй дундаж амьдралтай байсан хэдий ч хүн ам хэрэгцээт зүйлээ сонгох сонголт тун ядмаг байв. Эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх олон оролдлого хийж байсан ч тогтолцооны гажгаас үүдэн хүссэн үр дүнд хүрэхгүй байлаа. Гадаад харилцаа бараг ЭЗХТЗ-ийн орноор хязгаарлагдаж байснаас хөгжилтэй орнуудтай харилцаж шинэ техник, технологи нэвтрүүлэх боломж ихээхэн хязгаарлагдмал байв. Чухам иймээс, Монгол Улсын тусгаар тогтнол нь ард түмэн, хувь хүний үзэл бодлын эрх чөлөөт байдлаас юуны түрүүнд хамаарч, баталгаажихыг бид ХХ зууны эцсээс л ухамсарлах боломжтой болсон юм. Ийнхүү, нийгмийн сэтгэхүйд асар том өөрчлөлт гарах боломжийг 1989-1990 оны заагаас Монгол Улсад өрнөсөн ардчилал олгожээ. Нэг үгээр, ардчилал бол ард түмний амьдрал дунд нийгмийн харилцаанаас өөрөөс нь төрж эсвэл хөгжиж эсвэл хязгаарлагдаж байдаг өргөн олон түмнийг хамарсан үзэгдэл бөгөөд чухамдаа хамтын үйл хэрэг, хамтын бүтээл байдаг болохоор түүнийг хэн нэгэн, тэр тусмаа ямар нэг улс төрийн хүчин өмчилж болдог эд бараа биш юм гэдгийг ухаарах болсон.

1980-1990-ээд оны зааг үеэс монголчуудын ардчиллыг хөгжлийн гол зам хэмээн сонгосон сонголт шинэ зуунд ч хэвээр байх нь эргэлзээгүй. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг дээр социалист систем задран унаж, «хүйтэн дайн» эцэс төгсгөл болсноор дэлхийн түүхэнд нэгэн шинэ үе эхэлсэн гэж хэлж болно. Монгол Улсад ч ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц эхэлж, нээлттэй гадаад бодлого явуулан, гадаад бодлогын хүрээ хязгаар тэлж шулуудав. Өөрөөр хэлбэл, дэлхийн бөмбөрцгийн тал хэсэгт өрнөсөн 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны үйл явдлууд мөн чанар, цар хүрээ, ач холбогдлоороо үнэхээр агуу бөгөөд энэхүү алтан агшинд монголчууд хувь заяаныхаа шинэ сонголтыг хийж чадсанаар хүн төрөлхтний


<sup>39</sup> Намжим Т. Монгол Улсын эдийн засаг. II боть. УБ., 2004. 793 дэх тал.

нийтлэг хөгжлөөс хол хаягдснаа нөхөх боломжтой болсон түүхэн боломжийг төгөлдөржүүлэх амаргүй үйлсэд нийгмийн хамгийн соргог, оюунлаг, эв нэгдэлтэй хүч оюутнууд эхнээс нь идэвхийлэн оролцсон нь хэзээ ч үгүйсгэгдэшгүй<sup>40</sup> билээ. Тухайлбал, Монголын Оюутны холбоо 1990 оны ээлжит бус III чуулганаас «...Өнөөдөр бидний өмнө харгис туршилтад хэлмэгдэж зовсон үй олон хүний амьдрал, хуримтлагдан овоорсон хямралт үзэгдлүүдийг даван туулах бэрхшээлт зорилтууд байгаагийн зэрэгцээ хуучин цагийн сүүлийг мушгиж шинэ эриний үүдийг нээх хувь заяа оногдсноороо азтай улс ч гэж өөрсдийгөө хэлж болно.... Хуучин үеийн тогтолцоог илээр эсэргүүцсэн анхны тэмцэл Ховд хотод оюутнуудын\* дундаас үүссэнийг тэмдэглэх хэрэгтэй....» хэмээн албан ёсоор мэдэгдсэн нь буй. Хүн төрөлхтний төдийгүй аливаа үндэстний хөгжлийн түүхийг тодорхой орон зай, цаг хугацаа, хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсийн үүрэг том, бага үзэгдлүүдийн нөлөө хүчин зүйлстэй холбож дүгнэх нь маш чухал, хийгээд түүхийн эерэг, сөрөг өөрчлөлт бүхэн өөр өөрийн сургамжтай. Чухам энэ үүднээс тусгайлан авч үзвэл XX зууны буюу орчин үеийн иргэншлийн түүх онц сонирхолтой. Ялангуяа XX зууны II хагас дэлхийн II дайнаас хойших үйл явц ихээхэн анхаарал татдаг. Угтаа монголчуудын эхлүүлсэн энэхүү ардчиллын төлөөх хүсэл эрмэлзэл нь гагцхүү өөрчлөн байгуулалтын хувь заяа ардчилал, ил тод байдал, ард олны оюун санааны эрх чөлөө-чөлөөт сэтгэлгээнээс онцгой их хамааралтай болохыг «Шинэ үе» нэртэй улс төрийн нууц бүлгэмээс 1989 оны 1 дүгээр сарын 2-3-ны шилжих шөнө нийслэлийн гудамж талбайгаар наасан **«Залуучуудын сонорт»** хэмээх ухуулах хуудас нь Монголын тухайн үеийн залуучуудыг ардчилсан хувьсгалд уриалан дуудсан<sup>41</sup> гол алхам байв. Энэ бол нийгмийнхээ дотоод хямралд дөрөөлөн Засгийн эрхэнд гарсан үндсэрхэг цэргийн бүлэглэлүүд бусдын газар нутгийг булаан эзэлж, ноёрхох замаар хүндрэлтэй асуудлаа шийдвэрлэн, улмаар дэлхийн улс төр эдийн засгийг атган жолоодохоор Берлин-Ром-Токиогийн тэнхлэгийн орнуудын өдөөсөн дайн өөрсдийнх нь ялагдлаар төгс асар их хохирол учруулсан юм. Дайнд ялсан холбоотон гүрнүүд сэргээн босголтын нөр их ажлыг хажуугаар дахин хуваарилалтын бодлогоо эрчимжүүлснээр хүчний харьцаа эрс өөрчлөгдөн талцаж эхэлсэн түүхтэй.

<sup>40</sup> Эрдэнэцогт С. «Эрх чөлөөний эрэлхийлэлд» Монголд ардчилсан хөдөлгөөн үүссэний 20 жилийн ойд зориулав. «Битпресс» Хэвлэлийн газар, «Соёмбо принтинг ХХК. УБ., 2009. 3 дахь тал.

\* 1989 оны 12 дугаар сарын 7-нд Монголын алс баруун хязгаар Ховд аймагт Багшийн дээд сургуулийн оюутнууд, багш нарын зохион байгуулсан ардчиллын төлөө анхны жагсаал тус хотын Ард Аюушийн нэрэмжит төв талбайд болсон түүхтэй. Эрдэнэцогт С. «Эрх чөлөөний эрэлхийлэлд» Монголд ардчилсан хөдөлгөөн үүссэний 20 жилийн ойд зориулав. «Битпресс» Хэвлэлийн газар, «Соёмбо принтинг ХХК. УБ., 2009.

<sup>41</sup> Амарсанаа С., Майнбаяр С. Монголын ардчилсан холбооны түүхэн цомог. Монголын ардчилсан хувьсгалын 20 жилийн ойд зориулав. УБ., 2009. 5-6 дахь тал.// Жижгээ Ш. Монголын ардчилсан холбооны түүхэн товчоо (1989-1990). Нэгдүгээр дэвтэр. ред. Эрдэнэцогт С. ШУТИС-ийн Хэвлэлийн үйлдвэр, Сургалтын төв. УБ., 2015. 10-11 дэх тал.



Эх сурвалж: 1. <https://www.facebook.com/Mongoliademrevolution/posts/1506775182740540/>

2. Амарсанаа С. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. Тэргүүн дэвтэр.

*Ред. Төмөрчөдөр Ж. «МН Технологи» ХХК-ний хэвлэх үйлдвэр. УБ., 2011. 29 дэх тал.*

Энэхүү талцал нь “нуугдмал” зөрчлүүдийг ил гаргаад зогсохгүй дайнд сүйдсэн Польш, Чехословак, Болгар, Унгар зэрэг орнууд ЗХУ-ын нөлөөгөөр социализмын замыг сонгосон бол, Англи, Франц, Испани мэтийн гүрнүүдийн колони задарч Африк, Ази, Латин Америкийн 100 гаруй улс тусгаар тогтнон ихэнх нь дээрх замд нэгдэж, улмаар АНУ тэргүүтэн, тэдний дэмжлэг хүлээсэн улс орнууд нөгөө талд нь сөрөн зогссон хүн төрөлхтний нүдний өмнө бий болсон бодит түүх мөн. Ийнхүү хоёр талын «хүйтэн дайны үе» гэж нэрлэгддэг 40 гаруй жилийн турш үзэл суртал, эдийн засаг, цэрэг зэвсгээр удтал сөргөлдсөн хоёр туйл задарснаар дэлхийн нутаг дэвсгэрийн 26, хүн амын 33 хувийг эзэлж байсан социалист системд хамрагдсан улс орнуудын хувьд ардчиллын шинэ “*салхи*” салхилан, ардчилал, шударга ёс, чөлөөт шударга сонгууль, үндэсний онцлогоо төвийлгэн гаргах шинэ түүхийн эхлэл гэж болно. Угтаа 1970-аад оны эцсээс хүн төрөлхтний өмөн тулгарч агсан томоохон асуудлуудыг хамтран шийдвэрлэх, унжирсан мөргөлдөөн самууныг нийтийн хүчээр зохицуулах, агаар мандал, далайг энхтайвны зорилгоор ашиглах зэргээр эерэг ахиц болсон. Үндсэндээ, дэлхий нийт шударга бус өрсөлдөөнөөс залхсан төдийгүй эл торгон үе хүртэл улс орнууд шинжлэх ухаан-технологийн хувьсгал ч гэж хэлж болохуйц дэвшилд хүрсэн<sup>42</sup> нь энэ ажгуу.

1989 оны сүүлээс өрнөсөн ардчилсан хувьсгалын өөрчлөлтийн үйл явцын судалгаа харьцангуй өргөн хүрээнд хийгдсэн гэж үзэж болно. Эдгээр судалгаанд тодорхойлохдоо голдуу барууны улс оронд түгээмэл хэрэглэгддэг латин гаралтай «*democracy*» гэдэг үгийг «ардчилал» гэж монгол үгээр хөрвүүлэн орчин үеийн өрнөдийн нийгэмд дэлгэрсэн түгээмэл утгаар нь хэрэглэх болсон билээ. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулинд «ардчилал»-ыг хамгийн өргөн утгаар нь буюу ард түмэнд төрийн дээд эрх мэдлийг эдлүүлэх агуулгаар

<sup>42</sup> Эрдэнэцогт С. Монголд ардчилсан хөдөлгөөн үүссэний 20 жилийн ойд зориулсан «Эрх чөлөөний эрэлхийлэлд» ном. «Битпресс» Хэвлэлийн газар, «Соёмбо принтинг ХХК. УБ., 2009. 8-9 дэх тал.

«хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм»<sup>43</sup> цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгын хэмжээнд тунхагласан. Шинэ Үндсэн хуулийн үзэл санааг онолын нь талаас авч үзвэл, үндсэндээ орчин үеийн ардчиллын хамгийн гол үнэт зүйлсийг багтаасан сонгодог хийгээд либерал онолын тулгуур зарчмуудад үндэслэсэн байдаг. Чингэхлээр эрх чөлөө агаар лугаа амархан бохирддог зүйл бөгөөд нийгэмд эрх чөлөө байгаа учраас байдал хүндрээд байгаа зүйл огт биш, гагцхүү эрх чөлөөг үнэлж чадахгүй, эрх чөлөөг эдэлж мэдэхгүй хүмүүс түүнийг бохирдуулж улам бүр хомс болгоод байгаа<sup>44</sup> тухай дурдсан нь буй. Угтаа тэрхүү эрх чөлөө гэдэг нь хүн бүрт олдож байгаа боломж бөгөөд түүний зөв хэрэглээний шалгуур нь хүний болоод аль нэг албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээ, ёс суртахуун өнөөдөр бидэнд үгүйлэгдэж байна. Энэ бол монголчуудын бидэнд хэдийнээс байсан үнэт зүйл, язгуур соёл маань ямар нэгэн агаар салхинд замхран алга болж, хий хоосон хийрхэл, хэнээрхэлт хандлагыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, Монголын өнөөгийн улс төрийн орчин бол ерөнхий агуулгаар нь ардчилсан хэв шинжийн орчин гэж үзэхийн зэрэгцээ монголын улс төрийн орчинг нэгэнт ардчилсан хэв маяг бүхий орчин хэмээн үзэж буй тохиолдолд улс төрийн орчны судалгааны үндсэн судлагдахуун нь Монголын ардчиллын төлөвшилтийн хүрээний асуудлууд байх нь илэрхий. Үүнтэй холбогдуулан ардчиллын үе шат, үнэлгээ, бэрхшээл сорилт, нөхцөл хүчин зүйл, чанар, хэв загвар, улс төрийн тогтолцоо, хэм хэмжээ, улс төрийн соёл, ухамсрын хүрээний олон цогц асуудлыг онцолж болно.<sup>45</sup>

Улс төр судлаачид Монголын улс төрийн орчны хэв шинжийн тухайд олон янзын байр суурийг илэрхийлдэг. Тухайлбал, тэд Монголын улс төрийн орчинг хэв шинжийн хувьд «шилжилтийн», «завсрын», «хөгжмөл бус» эсхүл «харьцангуй төлөвшсөн», «үндсэндээ төлөвшсөн» гэх зэргээр томъёолон тодорхойлдог. «Шилжилтийн үе» хэмээх нэр томъёог улс төрийн орчны төлөвшилтийн үйл явцтай холбогдуулан хэрэглэх эсэх тухайд судлаачдын байр суурь өнөө хэр нэгдмэл болоогүй байна. Сүүлийн үед судлаачдын нэг хэсэг нь өнөөгийн улс төрийн орчинг шилжилтийн гэж үзэхээс татгалзахыг санал болгож байна. Харин нөгөө хэсэг нь шилжилтийн үе үргэлжилж байна гэгцгээдэг.<sup>46</sup> Чингэхлээр ардчиллын олон зуун жилээр шалгагдсан нийтлэг үнэт чанарын зүйл бидэнд хэрэгтэй юу гэвэл хэрэгтэй. Тэгэхдээ түүнийг Монголын нийгмийн улс төрийн орчин, монгол ухаан сэтгэлгээ, амьдрал уламжлалтайгаа нягт шүтэлцүүлэн хамаатуулж, тэндээс өөрийн орны өвөрмөц онцлогт таарч нийцсэн ажил хэргийн үндэсний гэмээр онол, үзэл, бүтээн байгуулалтын шийдэл гарцыг гаргаж ирэх учиртай билээ. Ингэж чадахгүй бол монгол ардчилал ардчилал биш доороо суурьгүй, гаднын зүйлийн хольц төдий эрлийз гибрид маягийн ардчилал болж хувирах аюултай юм.

Монголын ардчилалд өдгөө ёс зүй, ёс суртахуун, үнэхээр дутагдаж байна. Өнөө үед улс төр, ёс суртахуун хоёр улам бүр салж холдсоор байна. Гэтэл ёс суртахуун, ёс зүй бол ардчиллын амин сүнс гэдгийг эрт эдүгээгийн сэтгэгчид ямагт онцлон сануулсаар иржээ. Аристотель “Дээд суртахуун” гэдэг бүтээлдээ бичихдээ «Олон нийтийн болон төр улсын амьдралд оролцъё гэж бодож байгаа тэр этгээд сайн үйлийн суртахуунтай хүн байвал зохино. Тэгээд бодохлоор ёс зүй бол улс төрийн нэг хэсэг, нэг эхлэл нь (arche) болж түүнд багтан ордог...»<sup>47</sup> гэж бичсэн байдаг. Ёс зүйгүй улс төрчдөөс ёс зүйгүй улс төр төрдөг. Ёс зүйгүй улс

<sup>43</sup> 1992 оны Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн оршил хэсэг.

<sup>44</sup> Ц.Элбэгдорж. Бид шинэ сонголтынхоо эзэн болох цаг ирлээ. МоАХ-ын анхдугаар их хурал хуралдсаны 6 жилийн ойд зориулж хэлсэн үг. МҮАН. Хараацайн жигүүр цуцахгүй. Бяцхан ном II. УБ., 1996. 30 дахь тал.

<sup>45</sup> Болд-Эрдэнэ Д. Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшилт. «Бэмби сан» ХХК. УБ., 2008. 187 дэх тал.

<sup>46</sup> Даваадаш Ч. Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог, ээдрээ. Өдрийн сонин. УБ., 2015 № 187

<sup>47</sup> Аристотель. Дээд суртахуун. орч. Даш-Ёндон Б. Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. УБ., 2006. 20 дахь тал.

төрд ёс бус үйл дагалддаг нь жамын доорх зүйл юм. Өнөөдөр монголын улс төр, ардчиллын үйл явцад ёс зүй, хариуцлага гэж үнэхээр алга байна. Ардчилал бол эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоот нэгдэл мөн. Эрх, үүрэг хоёр нь бие биенээ нөхөн тэтгэхээс гадна ёс суртахуун, ёс зүйд суурилж байдаг. Ёс зүйт эрх, үүрэг нь ёс зүйтэй хариуцлагад тулгуурладаг. Ингэхлээр ёс зүй бол ардчиллын эрх, үүрэг, хариуцлагын тогтолцооны оршихуйн гол цөм, амин сүнс нь болдог. Өнөөдөр манайд ёс зүйтэй улс төрч, ёс зүйг мэдэрдэг төр засаг гэж алга. Төр засаг нь ёс зүйгүй болохоор улс төрчид нь ёс зүй, ёс зүйн зарчим гэгчийг уландаа гишгэх нь аргагүй юм. Манай улс төрчдөд эрх мэдэл л хэрэгтэй болохоос биш тэдэнд ёс зүй, ёс зүйн мэдрэмж гэж үнэхээр хамаагүй бололтой. Ингэж ёс зүйгүй ардчилал манайд бий болсон нь ёс зүйн хариуцлагын тухай сэтгэх аргагүйд хүргэж буй.



Эх сурвалж: <https://www.facebook.com/Mongoliademrevolution/posts/1506775182740540/>

Өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд бидний бүтээж амжуулсан зүйлс Монголын ардчилалд хэрэгтэй түүний суурь нөхцөл болсоноос биш ардчиллын төлөвшилтийн төгс хэмжүүр, баталгаа хараахан биш. Үүнтэй холбогдуулан 2006-2008 онд хийгдсэн «Азийн барометр»-ын судалгааны хоёр дахь шатанд оролцсон судлаачдын байр суурь сонирхол татав. Тэдний үзэж буйгаар «Зүүн Азийн ардчиллын гурав дахь давалгаанд дэлгэрэнгүй, динамик шинжилгээ хийхдээ бид ардчилах үйл явцыг зөвхөн төлөөллийн байгууллагуудыг бий болгох, ардчилсан Үндсэн хуулийг батлах зэргээр тогтохгүйгээр олон талт үзэгдэл гэж ойлгож байна»<sup>48</sup> гэсэн нь анхаарал эрхгүй татаж байна. Улс төр судлаач Роүз бичихдээ посткоммунист улс орнуудын ардчилсан өөрчлөлтийн хүрээнд бий болгосон болон бий болж буй зарим нэг нааштай суурь эхлэл институциональ үндэс нь үнэн хэрэгтээ тэдгээр улсуудын хувьд төлөөллийн ардчиллын «техник хангамж» төдий л зүйл болохоос бус «программ хангамж» нь болж чадахгүй байгаа юм.<sup>49</sup> Эдүгээ Монголд улс төрийн ардчилсан орчны бодит суурийг бүрдүүлсэн хэдий ч ардчилал жинхэнэ агуулга, чанарын төвшинд хараахан хүрч чадаагүй байна. Тиймээс ч Монголын ардчиллыг бэхжүүлж, төлөвшүүлэн төгөлдөржүүлэхийн тулд их зүйл хийх хэрэгтэй. Гэхдээ ардчиллыг сэтгэл хөдлөл, хоосон тунхаглалаар бус бодит үнэлэмж, бүтээлч үйл ажиллагаагаар төлөвшүүлдэг гэдэг нь нэгэнт тодорхой зүйл билээ. Ардчиллыг хэмжээ хязгааргүй эрх чөлөө, хий хоосон хийрхлээр бус тодорхой хэм хэмжээ бүхий эрх чөлөө, хариуцлага, сахилга бат, дэг журам, хууль дээдлэх ёс, жинхэнэ шударга ёсны зарчмаар бэхжүүлэн төлөвшүүлдэг.

Монголын ардчиллын өнөөгийн төлөв байдлыг ерөнхийд нь дүгнэвэл, ардчиллын байгууллагажсан бүтэц хэлбэрүүд зохион байгуулалтын хувьд бий болсон боловч энэ нь

<sup>48</sup> УТБА. Азийн барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ., 2008, 7 дахь тал.

<sup>49</sup> Мөн тэнд., 7 дахь тал.

нийгэм ардчилсан болсныг илэрхийлэхгүй, эдгээр байгууллагуудын оршин байх арга нь, явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь ардчилсан болж чадсан нөхцөлд нийгэм ардчилсан болно гэсэн чанарын талын шалгуураар бол манай ардчилсан хөгжлийн ирээдүйн хандлага тийм ч гэгээлэг харагдахгүй байна. Тухайлбал, Ардчилсан үнэт зүйлс чанарын болоод агуулгын хувьд сайжралыг харуулж байгаа боловч *ардчилсан үнэт зүйлсэд хандах иргэдийн үнэлэмж эргэлзээ төрүүлж байна*. Монгол дахь *ардчилал, зарим талаараа хэврэгшиж байгааг* судалгааны дүнгүүд харуулж байна. Монгол дахь ардчиллын хөгжил төлөвшилтийн цаашдын хандлага, *ирээдүйн дүр зураг ээдрээ төвөгтэй олон зөрчил, бэрхшээл сорилтууд тулгарч байгааг харуулахын зэрэгцээ тэрхүү бэрхшээл, сорилтуудыг хэрхэн шийдвэрлэж чадахаас ардчилсан хөгжлийн цаашдын хувь заяа* шууд хамааралтай болжээ. Монгол Улсын ардчилсан хөгжлийн жилүүдийн зөрчил, бэрхшээл сорилтууд нь өмнөх нийгмийн тогтолцооноос өвлөгдсөн ойлголт, хандлагын инерц, шинэ тогтолцоо бий болох явцад үүссэн дутагдал, гажуудлын аль алинтай нь холбоотой байна. Харин өнөөдөр Монголын нийгмийн хэмжээнд үүсэн бий болоод байгаа бэрхшээл, сорилтууд<sup>50</sup> нь гол төлөв ардчилсан өөрчлөлтийг хэрэгжүүлэх явцад гарсан, цаашид ужгирч хуримтлагдсан алдаа гажуудлуудтай холбоотой гэж үзэж болохоор байна. Түүнчлэн манай судлаачдын хувьд өнөөгийн нөхцөл дэх хүндрэл бэрхшээлтэй асуудлаа зарим нэг нь «системийн хямрал», «монголын ардчиллын мухардал сүйрэл» хэмээн нэлээд эрс өнгө аястайгаар тодорхойлж байхад нөгөө хэсэг нь «ардчиллын жам ёсны өсөлтийн бэрхшээл», «ардчиллын зүй тогтолт зөрчил», гуравдагч хэсэг нь «ардчиллын гажуудал, парадокс» хэмээн үзэж болох юм.



Эцэст нь дүгнэвэл, ардчилал бол хэм хэмжээ мөн. Хэм хэмжээ бол алив оршихуйн жам ёс юм. Жамын дор амьдрана гэдэг нь хэм хэмжээтэй байх хэлбэр юм. Ардчиллын суурь үнэт зүйлс бүхэн хэм хэмжээтэй. Эрх чөлөө, тэгш ёс, шударга ёс ер нь юм бүхэн хэм хэмжээтэй. Ардчиллыг хэм хэмжээ гэж ухаараагүй тэр газар хариуцлагагүй, ёс замбараагүй, шударга бус зүйл ямагт бугшсаар байдаг нь зүй. Тэгвэл манайд ардчиллыг хэм хэмжээ гэж ойлгох ухаан хэдийнээ үгүй болчихоод

байна. Хэм хэмжээний албан ёсны илэрхийлэл нь хууль ёс мөн. Хууль ёсыг сахих зарчим нь ардчиллын суурь үнэт зүйл мөнөөс мөн. Өнөөдөр Монголд хууль ёсыг хэлбэрэлтгүй баримтлах тухай асуудал нэн эргэлзээтэй болсон. Хууль ёсыг уландаа гишгэнэ гэдэг нь ёс зүйгүй авирлах, хариуцлага гэдгийг умартахад хүргэж байна. Хууль ёс жинхэнэ утгаараа оршин үйлчлэх нь улс төрчид ёс зүйтэй, хэм хэмжээтэй, хариуцлагатай байхын чухал үндэс болдог.

Өнөөдөр ардчилсан тогтолцоонд ижил гараанаас шилжин орсон улс орнуудын өмнө тулгамдаж буй чухал асуудал бол хэм хэмжээ, хууль дээдлэх ёс, үүрэг хариуцлагыг жинхэнэ агуулга төрхөөр нь баталгаажуулан амилуулах хэрэгтэй байна. Түүнчлэн ардчилал, засаглал

<sup>50</sup> ФСЭХ, ШУА. Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. Чулуунбаатар Г, Хатанболд О. Монгол дахь ардчиллын төлөвшил. УБ., 2008. 240 дэх тал.

нь олон хэмжигдэхүүнтэй бөгөөд өргөн хүрээтэй, цогц үзэгдэл учир энгийн нэг засвар хийх нь үр нөлөөтэй, тогтвортой үр дүн өгөхгүй. Зарим тохиолдолд улс төрийн ээдрээтэй сонголт нь томоохон саад тотгор болдог бол зарим үед үйл ажиллагааны нарийн цогц стратегийг хэрэгжүүлэхэд төвөгтэй байж болох юм. Засаглалын шинэчлэл хийхэд улс төрийн хүсэл зориг, шаргуу оролдлого, тэсвэр тэвчээр шаардагдана. Чингэхийн тулд, бидэнд ёс зүй, хариуцлага, хамтын ажиллагаа, нийгмийн ёс зүйт хариуцлагад тулгуурласан үндэсний онцлог бүхий хүчин зүйлсийг шат дараалалтайгаар хийж гүйцэтгэх шаардлага бий болж байна. Чингэхийн тулд, (i) улс орон бүр (пост-коммунист болон үндэсний онцлог бүхий ардчиллыг сонгон хөгжиж буй улс орнууд гм) төр ёсны түүхэн уламжлал, нийгэм, иргэншлийн үндэсний хөрс суурь, шашин соёлын өвөрмөц байдалтай холбоотой хүмүүсийн харилцамжийн (*коммунити*) ба бодгаль чанарын (*индивидуальность*) өвөрмөц хослолыг бий болгох. Ингэсэн нь хүмүүсийн үндэсний дархлаа (*национальный иммунитет*)-г бүрдүүлэх замаар ардчиллын суурь үнэлэмжүүдийг үндэснийхээ онцлогт нийцүүлэн хөгжүүлэх. Цаашлаад, (ii) улс орон бүрийн үндэсний уламжлалын онцлог байдлаас хамаарч нийгмийн харилцаанд танил тал, найз нөхөд, нутаг усныхан, хамт ажиллаж байсан хүмүүс, нэг ангийнхан зэрэг хүчин зүйлс, мөн уламжлалт ёс заншил хуулиас хүчтэй үйлчлэх тохиолдолд эрх мэдлийг төвлөрүүлэхээс сэргийлж, хариуцлага хүлээх чадвартай улс төрийн системийг урамшуулдаг ардчилсан механизмтай байх хариуцлагын тогтолцоог төр засгаасаа шаардах эрхтэй, басхүү шаардах ч ёстой. Чингэхлээр, чөлөөтэй, шударга явагддаг сонгууль бол үүнд хүрэх эхний алхам юм. Үүнийг төлөөллийг хангасан, мэдрэмжтэй засаглалын институцийг цаашид бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг хангах, ард түмэнд санал бодлоо илэрхийлэх боломж өгөх зэргээр бататгах хэрэгтэй. Түүнчлэн ардчиллын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс тухайн ард түмний амьдрал үйл ажиллагаа, нийгэм-улс төрийн бодит практикт биежиж хэрэгжисэн төлөв байдлыг, эсвэл хэрэгжиж биелсэн байх үеийн тухай угтан тоймлосон төсөөллийг тэр улс үндэстний ардчиллын загвар гэж болзмол байдлаар нэрлэж болно. Энэ нь эгэл жирийн иргэний амьдралын хэвийн үйл ажиллагаанаас эхлээд улс төрийн засаглалын хэлбэр, бүтэц хүртэл өргөн хүрээтэй нийгэм, улс төрийн үзэгдэл, үйл явцыг хамарна. Иргэдэд ээлтэй сайн бөгөөд ардчилсан засаглал<sup>51</sup> гэдэг нь иргэдэд тэгш боломж олгох, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй байдал бий болгох талаар нийгэм өөрийгөө зөв зохион байгуулах тухай асуудал юм. Үүнтэй холбогдох нэг чухал санаа бол Сеймур Мартин Липсетийн дэлхийн ардчиллын тухай лекцийг эргэн харах нь зүйн. Тэрбээр өөрийн эл бүтээлдээ олон чухал сэдвүүдийг хамруулсан байдаг, тухайлбал, ардчиллын нийгмийн нөхцөл байдал, түүний дотор эдийн засгийн хөгжил, улс төрийн соёл; социализм, фашизм, хувьсгал, эсэргүүцэл, үзэн ядалт, хэт туйлширлын үүсэл гарлын тухай; мөн ангийн зөрчил, бүтэц, шилжих хөдөлгөөн; нийгмийн хагарал, намын тогтолцоо, сонгогчдын замнал; төрийн байгууллагуудад итгэх итгэлийн асуудал хийгээд олон нийтийн санаа бодол, төсөөллийг илрүүлэх<sup>52</sup> судалгааны нэн чухал сэдвүүдийг хөндөн тэдгээрийн мөн чанарыг маш өвөрмөц байдлаар илэрхийлсэн нь өдгөө бидний зайлшгүй судлах гол судлагдахуун болсоор байна. Мөн түүнчлэн бидний өмнө тулгамдаж буй нэг сорилт бол орлогын болон мэдлэгийн хэт их тэгш бус байдал бий болсон нь одоогийн эрх мэдэлтнүүдийн өөрсдийн байр сууриа хадгалж үлдэхийг илүүд үзэх болсон гол шалтгаан болж байна.

<sup>51</sup> МХЗ-9 төсөл. НҮБХХ. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар. орч. Даваадулам Ц. УБ., 2008 он. 28 дахь тал

<sup>52</sup> Please see the details on the <https://www.ned.org/seymour-martin-lipset-lecture-on-democracy-in-the-world>.

Энэ талаар Сеймур Мартин Липсет нэгэнтээ тэмдэглэсэн нь бий: «Тогтвортой ардчилал нь улс төрийн бүхий том намуудыг хүн амынх нь бүхий л давхаргад дэмжигчидтэй байхын зэрэгцээ тэрхүү давхарга бүрт хүрч ажиллахыг шаарддаг. Аль ч намуудын хувьд нийгмийн үндсэн хэсэг бүрт нягт уялдаатай байж чадахгүйгээр өөрсдийн тогтолцоогоо бүрэн дэмжих боломжгүй бүрдэхгүйгээс гадна ардчиллын суурь зарчмуудын нийгмийн хэсэг бүлэг тус бүрт үргэлжлүүлэн түгээх боломжгүй, эс тэгвээс төрийн зөрчилдүүлэхэд хүргэх аюултай тул буулт хийхээс зайлсхийх огт хэрэггүй».<sup>53</sup> Хууль бус дэглэм нь ихэнхдээ өөрсдийн хэрэгцээгээ нэгэн зэрэг нэмэгдүүлээд зогсохгүй өөрсдийн шаардлагыг хангах нэгэн зорилготой нийгмийн хамгийн эмзэг, чадваргүй хэсэг бүлэг хүмүүсийн нэгдэл, эрх мэдлийг эрхэмлэгчдийн нэгдэл болон хувирдаг нь зөрчилтэй, гаж буруу үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл, цөөн хэдхэн “ногоон” санаачилгыг хэрэгжүүлснээр амжилтанд хүрнэ гэнэхээр бодож, өөрсдийгөө хуурч мэхлэхийн оронд тогтвортой байдлыг бүрэн хангасан бодит ажил хэрэгж, утга учиртай үйл хэргийг бий болгох нь чухал. Нөгөөтэйгүүр, тогтвортой төр улс бол хязгаарлагдмал нөөц баялгаасаа аль болохоор татгалзаж, гагцхүү ашиг тусаа алдахгүй, байнгын нөхөгддөг баялгаар ард түмнийхээ үндсэн хэрэгцээг хангах чадвартай улс орныг ирээдүй хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээх явдал юм. Мэдээж хариуцлага тооцох чадвартай, хариуцлагатай байна гэдэг нь дан ганц сонгуулийн үеэр тохиолддог зүйл биш бөгөөд сонгуулиас сонгуулийн хоорондох хугацаанд ч мөн хариуцлагатай байхыг хэлж буй асуудал гэдгийг Роберт А.Даль тун мэдрэмжтэйгээр илэрхийлсэн юм. хариуцлага бус, түүнээс ч илүү өргөн утга агуулгатай ёс суртахуунтай үйлдэл юм.<sup>54</sup> Тиймээс улс орны засаглалын асуудлыг шийдвэрлэхийн тулд тогтвортой, чанартай ардчилалд хүрэх нь гол бөгөөд тэрхүү зорилгын гол түлхүүр нь чадавхтай эдийн засаг тэргүүлэх байр суурийг эзлэх нь дамжиггүй. Эдийн засгийн болон улс төрийн эрх тэгш талбаргүйгээр эдийн засгийн хөгжлийг ханган биелүүлнэ гэдэг нь хий хоосон хэнээрхэл, ямар ашиггүй зорилт байх болно. Ямар ч хяналтгүй, хэт их авлига газар авсан тохиолдолд эдийн засгийн өндөр өсөлтөөр дамжуулан ардчиллыг бэхжүүлнэ гэдэг нь ямар ч боломжгүй зүйл юм. Харин ч эсрэгээрээ хууль эрхийг алдагдуулж, тэгш бус байдлыг үлэмж ихээр нэмэгдүүлэх болно. Тухайлбал, Ларри Даймондын тэмдэглэсэн нэгэн зүйлээс ишлэл болгон энд дурдах нь зүйтэй. Тэрбээр «өнөөдөр дэлхий дээр ардчилалд заналхийлж, мөн айдаст автуулж буй үзэгдэл олон бий. Энэ бол муу засаглал юм».<sup>55</sup> Энэ бол зөвхөн хамаатан садан хийгээд улс төрийн элитүүд, тэдний тойрон хүрээлэгчдийн ашиг сонирхолд үйлчилдэг засаглал юм.


Нөгөөтэйгүүр, энэ нь засгийн газрын хөрөнгө болон элдэв төсөл, хөтөлбөрийн санхүүг захиран зарцуулахад ил тод байдал дутагдаж, зөвхөн ивээлдээ багтаасан хэсэг бүлгийнхэнд үйлчилдэг, эрх мэдлээ урвуулан ашигладаг, авлигад өртсөн, нийгмийн шударга ёсны шаардлагаас зугатсан, алсын хараагүй, дүлий сонсголтгүй болж буй засаглал гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, бодит өөрчлөлт зөвхөн уриа лоозоноос гардаггүй бөгөөд аливаа шинэчлэл, эерэг, ил тод, нээлттэй нийгмийн санаачлагууд нь эрх мэдлийг барьж буй хүмүүсээс бүрэн тууштай байдал, эр зориг, улс төрийн хүсэл эрмэлзэл хийгээд туйлын шударга байдлыг шаарддаг. Энэ бол авторитаризмтай тэмцэх бодит сорилт бөгөөд сайн ардчилал, сайн засаглалыг бий болгох цорын ганц арга зам юм. Тэр утга агуулгаараа, бид ардчиллыг ард түмний өмнө тулгарч буй хамгийн их маргаан дагуулж буй сорилтуудыг шийдвэрлэх хүчирхэг, бүтээмжтэй механизм гэж үзэх ахул тэрхүү бэрхшээлийг эрч хүчтэйгэрэ даван

<sup>53</sup> Seymour Martin Lipset. Political Man: The social bases of politics. New York: Doubleday. 1960. p. 31

<sup>54</sup> Anwar Ibrahim. Confronting authoritarianism. Project Muse. Journal of Democracy, Vol 30. №2, April 2019. p. 8

<sup>55</sup> Larry Diamond et al., A Quarter-Century of Promoting Democracy. Journal of Democracy, Vol 18. October 2007. p.119.

туулж гэмээ нь илүү их үнэ цэнэтэй боломжийг бий болгож чадна. Гэхдээ ардчиллыг сурталчлах нь үндэсний аюулгүй байдалд нэн чухал гэдгийг ард түмэн сурталчилж байгаа нь зөвхөн үнэт зүйл, үзэл санаандаа үйлчлэх бус харин бидний аюулгүй байдал, сайн сайхан байдалд ноцтой асуудал тулгарч, тэр нь сүйрэх аюулд хүргэх ахул түүнээс хамгаалахын тулд олон нийтийн дуу хоолойг өндөрт өргөн эсэргүүцлээ илэрхийлэх нь маргашгүй үнэн бөлгөө.



Нөгөө талаар, ардчилал, эрх чөлөөний талаарх хэт ерөнхий, гэнэн төсөөлөл, улс төрийн соёлын доогуур төвшнөөс хамаарч эрх зүйт төр, ардчиллын хөгжилд бэрхшээл, хүндрэл гарч, улмаар гажуудал, завхрал алхам алхамаар газар авах боллоо. Энэ нь өнөөгийн ардчилсан тогтолцоотой авч тэрхүү тогтолцоонд саад бэрхшээл учирч буй улс орнуудын хувьд иргэний нийгмийн хяналтын үүргийг бэхжүүлж, урамшуулах цаг үеийн шаардлага бий болж буйг харуулахын зэрэгцээ Иргэний нийгмийн байгууллагуудын ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлага өдөр ирэх тусам нэмэгдсээр байна. Чингэхийн тулд тэдний өөрсдийнх нь үйл ажиллагаанд хариуцлага, ил тод байдлын зарчмыг нэвтрүүлэх явдлыг дэмжих хэрэгтэй. Мөн засаг төрөөс иргэний нийгэм санаа бодлоо илэрхийлэх, зохион

байгуулагдах, хөгжлийн үйл явц зэргийг хянахад оролцох, улсын салбарын үйл ажиллагааг хянах үүргийг биелүүлэх, эвсэл, сүлжээ байгуулах, зөвлөх, нөөц баялгийн ашиглалтын тухай шинжээчийн шаардлага хүргүүлэх, улс төрийн хүсэл зоригийг дэмжих, сурталчлах, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, нийгмийн бүлэг, ялангуяа эмзэг, гадуурхагдсан хэсгийг дайчлах зэрэгт зориулан эрх зүй, улс төр, институцийн орон зайг бий болгон санаачлан ажиллах ёстой. Түүнээс биш, өнөөдөр тулгар эх оронч үзлийн үнэлэмж нь хаягдаж, үүнийг олдмол эх оронч үзэлтнүүд овжин ашиглах боломж олсон цөвүүн цагт дор ардчилал бидэнд «үг хэлэх эрх чөлөө авчирсан» хэмээн хэт туйшран хуйлрах нь нэг талаас тэрхүү «үг хэлэх эрх чөлөө» гэж чухам юуг хэлээд байгааг тайлбарлах шаардлагатай. Энэ нь ардчиллын маш энгийн утгаар бол «үг хэлэх эрх чөлөө» гэдэг нь ард түмний хэлсэн үг төр засгийн чихэнд шууд хүрч байхыг л хэлээд буй юм.<sup>56</sup> Эдгээр чиг үүрийг үр дүнтэй хэрэгжүүлдэг байхын тулд иргэний нийгэм нь чадавхтай, санхүүгийн тогтвортой байдлаар хангагдсан, дотоод хариуцлага, ил тод байдлыг нь эрхэмлэсэн байр сууринаас хандах нь аливаа яриа хэлцэл, түншлэл, хамтын ажиллагаа, ил тод байдлаар дамжуулан төр, Иргэний нийгмийн байгууллагуудын хоорондох үл итгэлцэх байдлыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэж, өндөр хариуцлагатай ажиллах учиртай.

Сүүлийн үед ардчилагдсан болон шинээр ардчилагдаж буй олонх улс орнуудад олон нийтийн зүгээс төрийн болон улс төрийн институтэд итгэх итгэлийн бууралт, иргэдийн улс төрийн намуудаас хүнийсэх хандлагын өсөлт, ардчилсан засаг төр, улс төрчдийн авлигад автсан, амиа хичээсэн хариуцлагагүй байдал улам газар авах болсонтой уялдан ардчилалд шүүмжлэлтэй хандах сэтгэл зүй тодорхой илэрч, ажиглагдах болжээ. Үүнтэй уялдан өнөөгийн ардчилал боломжоо шавхаж дууссан тухай гутрангуй өнгө аястай онол, баримтлал гарч ирэх болсон юм. Энэ бүхэн нь «ардчиллын зөрчил» (диллема), «ардчиллын мухардал», «ардчиллын

<sup>56</sup> Энхээ Ч. Ардчилсан хөдөлгөөн (Хөшигний арын нууц). «Сонгох эрх» номын хавсралт 2. ред. Даариймаа Г. «Адмон» ХХК. УБ., 2010. 10 дахь тал.

хямрал», «түүхийн төгсгөл»-ийн тухай сэдвүүдээр тодорхой илэрч байгаа.<sup>57</sup> Гэхдээ ингэлээ гээд тэдний хэн нь ч ардчиллаас ухрах тухай асуудлыг өнөө хэр гаргаж тавиагүй байгаа нь сонин юм.

Үүнээс үзэхүл, ардчилал нь «*өө сэвгүй төгс зүйл*» биш аж. Тэгэхдээ түүнийг төлөвшүүлэх үйл явц нь асар их хүчин чармайлт шаардсан амаргүй бөгөөд төвөгтэй үйл ажиллагаа юм. Орчин үеийн ардчилалд тохиолдож буй сорил бэрхшээл нь улс орон бүхэнд нийтлэг агуулгатай илэрч буй ч тэдгээр улсуудын хөгжлийн төвшин, сэтгэлгээний онцлог, соёл, туршлага, уламжлалтай холбоотойгоор харилцан адилгүй шинж байдлаар илэрч үйлчилж байгаа юм. Тиймээс ч ардчилагдсан улс орнууд тулгарч буй асуудал, бэрхшээлээ өөр өөрийнхөөрөө оношлон томъёолж байгаа юм. Өөрөөр хэлбэл, аливаа шинэ нөхцөл байдлын шинэ өрнөл нь шинэ дуудлага, шинэ боломжуудыг бий болгоод зогсохгүй уламжлалт үзэл баримтлал бүхий улс төрийн намуудын хойноос харамсан гашуудах бус аж үйлдвэржсэн нийгмийн эрхийн үед хурц мөргөлдөөн, хатуу үзэл баримтлалд баригдсан намуудын орчинг бий болгохоос татгалзаж гагцхүү улс төрийн намууд болон улс төрийн төлөөлөлд ямар хариуцлага, хязгаарлалтыг өдөр тутам тавих нь идэвхтэй иргэний нийгмээс шууд хамаарна. Энэ бол иргэний нийгэм сэргэн босохгүйг улс төрийн намууд шинэчлэгдэхгүй, тиймээс ардчилал ч мөн сэргэн шинэчлэгдэхгүй<sup>58</sup> ажээ.

Ардчиллын чанарын үзүүлэлтүүдэд гарч буй хэлбэлзлийг авч үзсэнээр ардчиллын улс төрийн соёлын бодит байдлын талаар шалтгаалын аргаар дэвшүүлсэн таамаглалуудыг нягтлан шалгах нь нэн чухал явдал юм. Бүс нутгийнхаа хүрээнд ардчиллын чанарын үзүүлэлтүүдэд гардаг ялгаа зөрүүтэй талууд тухайн бүс нутагт ажиглагддаг улс төрийн соёлын ялгаа онцлог, тухайлбал хариуцан тайлагнах талаар тогтсон санаа бодол болоод улс төрчдийн итгэл даах чадвар зэргээрээ хоорондоо ялгаатай байдаг онцлогуудтай хэр зэрэг дүйж байгаа талаар шинжилгээ хийх замаар энэхүү дүгнэлтийг гаргахыг хичээв. Түүнчлэн ардчиллыг хөгжүүлэн бэхжүүлэх үндэсний механизм нь хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага, хүний эрхийг хамгаалах төрийн болон төрийн бус төрөлжсөн байгууллагууд, нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувийн хэвшлийн байгууллагууд, олон улсын байгууллагууд зэргээс бүрдэнэ. Эдгээр нь өөр өөрийн эрхлэх ажлын хүрээнд ардчиллыг хөгжүүлэх, бэхжүүлэх, үүрэг, хариуцлагыг хүлээж, зохих хувь нэмрээ оруулах нь монголын ардчилал, ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэх цаашдын төлөв, хандлага байх болно хэмээн дүгнэж байна.

Эрх чөлөө агаар лугаа амархан бохирддог бөгөөд тэрхүү эрх чөлөө гэдэг нь хүн бүрт олдож байгаа боломж бөгөөд түүний зөв хэрэглээний шалгуур нь хүний болоод аль нэг албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээ, ёс суртахуун өнөөдөр бидэнд үгүйлэгдэж байна. Учир нь жирийн олон түмэн юу ч хэлээд, сонсдог төр засаг, албан тушаалтан үгүй боллоо хэмээн ухах олон түмний цөхөрсөн хандлага үлэмж нэмэгдэх болсон. Нэг үгээр хэлбэл, өнөөх бидний “үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө” гэдэг нь хаана оршин буйг бэдрэн хайх цаг дор бид амьдарсаар л. Үг хэлэх эрх чөлөө хаалттай байсан нийгмийг задлахаар тэмцэж, энэ эрх

<sup>57</sup> Чулуунбаатар Г. Шилжилтийн нөхцөл дэх ардчилал, улс төрийн тогтолцооны монгол хувилбарын тухайд. «Шинэ толь» сэтгүүл. УБ., 1994. 47-49 дэх тал.

<sup>58</sup> Клима Михал. Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу. орч. Сайханзаяа Ж. ред. Батсайхан Р ба бусад. «Сэлэнгэ пресс» ХХК. УБ., 2017. 151, 159 дэх талууд.

чөлөөг Монголын ард түмэнд олж өгөхөд хувь нэмрээ оруулсан<sup>59</sup> өнөөх ардчиллагчдын маань анхнаасаа зорьж байсан зорилгууд илт өөрчлөгдөж, ардчилал гэдэг нь хэдхэн хүний албан тушаалд хүрэх шатны гишгүүр болон хувирч,, өнөөх тулгар эх оронч үзэл нь хөрөнгө мөнгө, эрх мэдэл, албан тушаал, өс хонзонгийн төлөөх *«аугаа их ардчилсан хэмээх хуурамч баг зүүсэн, зүсээ хувилгасан шударга бус нийгэм»* болон хувирч буй нь бидний оршин энэ цагт нэгэнтээ тодхон харагдана. Энэ бол монголчуудын бидэнд хэдийнээс байсан үнэт зүйл, язгуур соёл маань ямар нэгэн агаар салхинд замхран алга болж, хий хоосон хийрхэл, хэнээрхэлт хандлагыг бий болгож буйн тод илрэл. Чингэхлээр ардчиллын олон зуун жилээр шалгагдсан нийтлэг үнэт чанарын зүйл бидэнд агаар мэт хэрэгтэй байна. Тэгэхдээ түүнийг Монголын нийгмийн улс төрийн орчин, монгол ухаан сэтгэлгээ, амьдрал уламжлалтайгаа нягт шүтэлцүүлэн хамаатуулж, тэндээс өөрийн орны өвөрмөц онцлогт таарч нийцсэн ажил хэргийн үндэсний гэмээр онол, үзэл, бүтээн байгуулалтын шийдэл гарцыг гаргаж ирэх учиртай билээ. Ингэж чадахгүй бол монгол ардчилал ардчилал биш доороо суурьгүй, гаднын зүйлийн хольц төдий эрлийз гибрид маягийн ардчилал болж хувирах аюул нүүрлэж буй. Эцэст нь хэлэхэд, бид төр нь иргэнээ дарангуйлах эрхийг хуульчилсан, иргэдээ ядуу гуцуу амьдруулж байгаагийнхаа төлөө хариуцлага хүлээдэггүй, ард түмэндээ үйлчилдэггүй, иргэдийнхээ улс төрийн эрхийг нь хаан боогдуулсан, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх явдлыг төрийн нэрээр амыг таглаж барьж хорьдог тийм нийгмийг нурааж эрх чөлөөтэй, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулахын, бас бүтээхийн төлөө тэмцсэн. Эл тэмцэл ч бодит биелэлээ олсон. Гэхдээ бид өнөөдөр эрх чөлөө гэдэг төр, иргэн хочрын харилцан хамаарал бүхий хамтын ажиллагаа, хэн хэнийхээ өмнө хариуцлага хүлээх үүрэгтэй, төр нь иргэний өмнө ямар эрх эдэлж, үүрэг хүлээхийг, иргэн нь ямар эрх, үүрэгтэй байхыг хуулиар зохицуулсан шударга гэрээгээр зохицуулагдах учиртай. Гэтэл энэ байдал өнөөдөр бүрэн биелэгдэж, цогцоороо хангагдсан уу гэвэл эргэлзээтэй хэвээр байна.

Бидний *«ардчиллагчид»* хэмээн нэршиж, бас хүндэтгэж ирсэн нөхөд туулж ирсэн гучин жилийнхээ алдаа оноог эргэн харж, түүндээ шүүмжлэлтэй хандаж улмаар өөрсдийн хийсэн алдаа, дутагдлаа засаж залруулах, *«үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шударга, ардчилсан нийгэм»*-ийнхээ өнөөгийн өнгө төрх, байр байдалд үнэлэлт дүгнэлтээ өгөх цаг ирсэн хэмээн ухаж буй нь энэ буюу.

### **Abstract**

The instrumental importance of democracy is existed on politically voice expressed that should be noticed others notifications in requiring to expression of the views for the people. Along with detailed studies on democracy, that requited to study on the practice of democracy, while a person who are the opportunity to learn from one another, and social values and priorities is construction of helps. Logically, democracy is naturally worth that lives of citizens and political decisions such is the instrumental importance and required to constructive spiritual importance as well. The most political power and influences that an organization or individual can exercise, the higher level of capacity it has. However, many theorists have noted that democracy requires and educated citizenry. Those individuals and groups who have prior understanding of the institutional processing that are able to participate constructively in democratic political processes, they could do with sufficient knowledge to voting and taking part in the political debates. The goal of the capacity building is bringing about

<sup>59</sup> Энхээ Ч. Ардчилсан хөдөлгөөн (Хөшигний арын нууц). «Сонгох эрх» номын хавсралт 2. ред. Даариймаа Г. «Адмон» ХХК. УБ., 2010. 7-15 дахь тал.

a better standard of living within that society by associating with the institutional reform as well; altering acceptance rules of behavior, and developing new polices.

In this article, we attempted to making the analysis on the empirical research materials that made by the author in recent years, in accordance with democratization and its transformation of the way in which the countries in the process of democratization are attempting to analyze discourse under the so-called «*Endeavouring for the Freedom and Demonstration in the Surging for the Democracy Process*». Hereof, the reason of writing this article is attempted to clarify the nature of the process of democratic endeavours such as Students for Democratic Society in 1959, USA, a violent struggle for democracy, human rights, corruption, and bureaucracy in China was wiped out in the Tiananmen Square in the PRC in 1989, that caused by the 30<sup>th</sup> anniversary of the terrible events and the trends of the authorities and the counter-measures the approach of the authorities, and fierce struggle for democracy in Eastern Europe and the collapse of the USSR etc. In addition, recent events of affecting democracy and its subsequent bias have been analyzed by the academic article which was published on the academic issue on 'Studia Philosophiae Et Juris - XXXII' (UB., 2017) from the Institute of Philosophy of the Academy of Sciences, such titled on «*Analysis on the Understanding & Perception on Democracy in Mongolia: Discourse Analysis*», and this article is a continuation of the academic article.

**Key words:** democracy, democratic impact, effect, politics, social values and spiritual importance, way of life, democratic political process, educated citizenry

### Ном зүй

#### Монгол хэлээр

1. Амарсанаа С, (2011). Ардчилсан хувьсгалтын тэргүүн эгнээнд. Тэргүүн дэвтэр. ред. Төмөрчөдөр Ж. «МН Технологи» ХХК-ний хэвлэх үйлдвэр. Улаанбаатар хот, Монгол Улс.
2. Амарсанаа С, Майнбаяр С, (2009). Монголын ардчилсан холбооны түүхэн цомог. Монголын ардчиллын хувьсгалын 20 жилийн ойд зориулав. Улаанбаатар хот, Монгол Улс.
3. Антони Гидденс, (2006). Социологи. ред. Ганхуяг Д. МУИС, НШУС. Улаанбаатар хот, Монгол Улс.
4. Аренд Лийпхарт, (2010). Ардчиллын загвар: гучин зургаан орны төр, засгийн хэлбэр ба илрэл. орч. Ганбат Д. ННФ. Улаанбаатар хот, Монгол Улс.
5. Аристотель, (2006). Дээд суртахуун. орч. Даш-Ёндон Б. Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж. II боть. Улаанбаатар хот, Монгол Улс.
6. Аристотель, (2006). Улс төр. орч. Даш-Ёндон. ФСЭХ. ШУА. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.
7. Болдбаатар Ж, (2017). Монголын «перестройка» (өөрчлөн байгуулалт)-ийн түүхийн судалгаа. Улс төрийн түүх (1980-аад оны эхнээс 1992 он). ред. Даш-Ёндон Б. ТАХ, ШУА. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.
8. Болд-Эрдэнэ Д, (2008). Монголын улс төрийн нам, намын системн төлөвшил. «Бэмби сан» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.

9. Горбачев Михаил Сергеевич, (2013). Бүх юм өөрийн цаг хугацаатай. орч. Баатар Ч. ред. Жавхлан Н. Анхны хэвлэл. «Монсудар» Хэвлэлийн газар. Улаанбаатар хот, Монгол Улс.
10. Даваадаш Ч, (2015). Монголын нийгмийн шилжилтийн зарим онцлог, ээдрээ. Өдрийн сонин. Улаанбаатар хот, Монгол Улс.
11. Дорно, Өрнө сэтгүүл, (1994). Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Улаанбаатар хот, Монгол Улс.
12. Жижгээ Ш, (2015). Монголын ардчилсан холбооны түүхэн товчоо (1989-1990). Нэгдүгээр дэвтэр. ред. Эрдэнэцогт С. ШУТИС-ийн Хэвлэлийн үйлдвэр, Сургалтын төв. Улаанбаатар хот, Монгол Улс.
13. Зиновьев А, (2017). Өрнө дахин: Западнизмын гоц үзэгдэл. орч. Даш-Ёндон Б, ред. Чулуунбаатар Г. «Соёмбо» принтинг. Улаанбаатар хот, Монгол Улс.
14. Константин Сыроежкин, (2019). «Бар»-ын ав: Хятадад өрнөж буй авлигатай тэмцэх ажиллагаа. орч. Зоригт Д, ред. Нямдорж Ц. АТГ. «Адмон принтинг» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.
15. Клима Михал, (2017). Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу. орч. Сайханзаяа Ж. ред. Батсайхан Р., ба бусад. «Сэлэнгэ пресс» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.
16. Монгол Улсын Үндсэн хууль, (1992). Улаанбаатар хот, Монгол Улс.
17. МҮАН, (1996). Хараацайн жигүүр цуцахгүй. Бяцхан ном II. Улаанбаатар хот, Монгол Улс.
18. МХЗ-9 төсөл. НҮБХХ, (2008). Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар. орч. Даваадулам Ц. Улаанбаатар хот, Монгол Улс.
19. Намжим Т, (2004). Монгол Улсын эдийн засаг. II боть. Улаанбаатар хот, Монгол Улс.
20. УТБА, (2008). Азийн барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. Улаанбаатар хот, Монгол Улс.
21. ФСЭХ. ШУА, (2008). Монголын нийгмийн өөрчлөлт. Хамтын бүтээл. Чулуунбаатар Г, Хатанболд О. Монгол дахь ардчиллын төлөвшил. УБ Улаанбаатар хот, Монгол Улс.
22. Хатанболд О, (2016). Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс. Улс төр судлалын доктор (Ph.D)-ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлийн хүрээнд хийсэн шинжээчдийн үнэлгээ. «Адмон» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.
23. Хатанболд О, (2017). Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. ред. Чулуунбаатар Г., Цэцэнбилэг Ц., Ганбат Д нар. «Соёмбо» принтинг. Улаанбаатар хот, Монгол Улс.
24. Чулуунбаатар Г, (1994). Шилжилтийн нөхцөл дэх ардчилал, улс төрийн тогтолцооны монгол хувилбарын тухайд. «Шинэ толь» сэтгүүл. Улаанбаатар хот, Монгол Улс.
25. Элбэгдорж Ц, (1996). Бид шинэ сонголтынхоо эзэн болох цаг ирлээ. МоАХ-ын анхдугаар их хурал хуралдсаны 6 жилийн ойд зориулж хэлсэн үг. МҮАН. Хараацайн жигүүр цуцахгүй. Бяцхан ном II. Улаанбаатар хот, Монгол Улс.
26. Эрдэнэцогт С, (2009). «Эрх чөлөөний эрэлхийлэлд» Монголд ардчилсан хөдөлгөөн үүссэний 20 жилийн ойд зориулав. «Битпресс» Хэвлэлийн газар. «Соёмбо принтинг» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.
27. Энхээ Ч, (2010). Ардчилсан хөдөлгөөн (Хөшигний арын нууц). «Сонгох эрх» номын хавсралт 2. ред. Даариймаа Г. «Адмон» ХХК. Улаанбаатар хот, Монгол Улс.

*Англи хэлээр*

1. Anwar Ibrahim, (2019). Confronting authoritarianism. Project Muse. Journal of Democracy, Vol 30. №2, April.
2. Kurlantzick Joshua, (2003). The Dragon Still Has Teeth: How the West Winks at Chinese Repression. World Policy Journal. 20 (1): [doi:10.1215/07402775-2003-2011](https://doi.org/10.1215/07402775-2003-2011). JSTOR 40209847.
3. Wang Dan, (2019). The Meaning of June 4<sup>th</sup>. Project Muse. Journal of Democracy, Vol 30, №2,
4. Elizabeth Economy, (2019). Dissent is not Dead. Project Muse. Journal of Democracy, Vol 30, №2,
5. Seymour Martin Lipset, (1960). Political Man: The social bases of politics. New York: Doubleday.
6. Anwar Ibrahim, (2019). Confronting authoritarianism. Project Muse. Journal of Democracy, Vol 30, №2, April
7. Dahl A. Robert, (1976). Polyarchy: Participation and Opposition. New Haven. Yale University Press.
8. Larry Diamond et al., (2007). A Quarter-Century of Promoting Democracy. Journal of Democracy, Vol 18. October.
9. Larry Diamond, (1995). Promoting Democracy in the 1990s: Actors and instruments, issues and imperative. A report to the Carnegie commission on preventing deadly conflict. Carnegie Corporation of New York. December.

*Цахим эх сурвалж*

1. <https://www.britannica.com/topic/Students-for-a-Democratic-Society>
2. <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society>
3. <https://www.mtsu.edu/first-amendment/article/1201/students-for-a-democratic-society>
4. <https://www.biography.com/us-president/lyndon-b-johnson>
5. <http://atime.mn/view/article/?page=show&id=320>
6. <http://content.time.com/time/magazine/article/0,9171,970278,00.html>
7. [https://en.wikipedia.org/wiki/1989\\_Tiananmen\\_Square\\_protests#cite\\_note-FOOTNOTEGreenslade2014-251](https://en.wikipedia.org/wiki/1989_Tiananmen_Square_protests#cite_note-FOOTNOTEGreenslade2014-251)
8. <https://www.theguardian.com/media/greenslade/2014/jun/03/press-freedom-tiananmen-square-protests-1989>
9. <https://www.youtube.com/watch?v=kMKvxJ-Js3A>
10. <https://www.reuters.com/article/us-china-tiananmen-advertisement/young-clerk-let-tiananmen-ad-slip-past-censors-paper-idUSHKG14616220070606>.
11. [https://books.google.mn/books?id=9eq4HT-0rwsC&redir\\_esc=y](https://books.google.mn/books?id=9eq4HT-0rwsC&redir_esc=y)
12. <http://atime.mn/view/article/?page=show&id=320>
13. <https://books.google.mn/books?id=tgXGBQAAQBAJ&printsec=frontcover#v=onepage&q&f=false>
14. <https://www.state.gov/on-the-30th-anniversary-of-tiananmen-square/>
15. <http://www.china-embassy.org/eng/zmgxss/t1669295.htm>
16. <https://www.ned.org/seymour-martin-lipset-lecture-on-democracy-in-the-world>.
17. <https://www.romania-insider.com/romania-30-years-democracy-1990>

18. <https://www.pewresearch.org/global/2017/10/16/many-unhappy-with-current-political-system/>
19. <https://www.biography.com/us-president/lyndon-b-johnson>

## ҮНДЭСНИЙ ӨӨРИЙН УХАМСРЫГ СУДЛАХ ОНОЛ АРГА ЗҮЙН ЯЛГААТАЙ БАЙДЛУУД

**М.Мөнхзул**

ХААИС, Эдийн Засаг Бизнесийн Сургууль  
ХААХЭЗТэнхимийн дэд профессор

### *Хураангуй*

Үндэсний өөрийн ухамсарт тухайн ард түмний өнгөрсөн түүх, хэл, соёл, түүний дотор уламжлал, ёс зүйн дүрмүүд, мөн угсаатны өөрийн ухамсар илүү холбоотой байдаг. Үндэстэн нь угсаатнаас илүү нийгмийн дээд хэлбэр боловч үүнээс өөр үзэл хандлагууд байна. Үүний шалтгаан нь примордаль хандлагын хүрээнд тухайн ард түмэн гэхээс илүүтэй нийгмийн элитүүдээр илэрхийлэгддэг тул үндэсний өөрийн ухамсрыг ярих боломжгүй юм. Үндэсний өөрийн ухамсрыг угсаатны өөрийн ухамсрын шинж чанараар тодорхойлно.

**Түлхүүр үг:** Үндэсний өөрийн ухамсар, угсаатны ухамсар, үндэсний адилсал, үндсэрхэг үзэл, үндэсний үзэл, примордиализм, инструментализм, конструктивизм.

Үндэсний өөрийн ухамсрыг дараах гурван хандлагаар судлах боломжтой: примордализм, инструментализм, конструктивизм. Үндэсний өөрийн ухамсар нь нийгмийн өвөрмөц нэгэн үзэгдэл учраас үүнийг контруктив үзлийн үүднээс судлах нь илүү үр дүнтэй. Өрнөдийн судлаачдын үзэж байгаагаар рациональ инструменталь хандлага нь өрсөлдөөний шинж чанартай учраас эдийн засгийн жигд бус тархалтыг өдөөж, үндэсний адилсалыг улам ихээр бий болгодог байна. Тиймээс энэ үүднээс улс төрийн үйл явцыг шинэчлэх, хөгжүүлэх явцад улс төрийн ухамсар болон үндэсний өөрийн ухамсрыг автоматаар улам нэмэгдүүлдэг<sup>60</sup>.

Инструменталь үзлээс ялгаатай нь примордаль үзэл нь үндэсний адилсал ба үндэсний өөрийн ухамсрын шинж чанарыг судлахдаа огт өөр тайлбартай байдаг. Зарим эрдэмтэд примордаль ойлголтыг амин чухал буюу органицизм (Хүн нийгмийн үйл ажиллагааг байгалийн үзэгдэлтэй холбон тайлбарладаг үзэл) гэж үздэг<sup>61</sup> бөгөөд энэ нь үндэсний өөрийн ухамсар нь түүхэн гүн гүнзгий үндэстэй, туйлын гэсэн итгэл үнэмшилд суурилдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь үндэсний үзэлтэй адил ба боломжоороо мөнхөд таатай нөхцөлд орших болно гэсэн үг. Үндсэндээ үндэсний өөрийн ухамсрын анхдагч суурь хэмжээс нь хэл, шашин, соёл гэх мэт түүнийг бүрдүүлэгч хэсгүүд нь төрөл садан, эх орон дээр суурилсан харилцаанаас хамаагүй бага ач холбогдолтойг харуулж байна.

Инструментализмын тусламжтайгаар үндэсний өөрийн ухамсар нь юунаас бүрддэг, үндэсний түвшин дэх тухайн нийгмийн байдал нь субъектив ашиг сонирхлоос хэрхэн бүрддэг болохыг мэдэж болно. Энэ хандлага нь примордаль үзлийг хязгаарладаг бөгөөд үндэсний

<sup>60</sup> Gellner.E. Nations and nationalism. Oxford.,1993. P 24

<sup>61</sup> Андерсон.Б. Нация и национализм. М.,2003 стр.46

өөрийн ухамсрын бодит хувьсагч хэмжэгдэхүүнийг ойлгох урьдчилсан нөхцлийг бий болгодог.

Конструктив үзэл нь үндэсний өөрийн ухамсар дахь олон нийтийн болон угсаатны бүлгийн объектив анхдагч бүрэлдэхүүн (примордиализм), хувь хүний субъектив байдлыг хадгалах боломжийг олгодог бөгөөд энэ нь зөвхөн нийгмийг бүрдүүлээд зогсохгүй түүний хөгжлийн хөдөлгөгч хүчийг бий болгодог.

Ийнхүү конструктив үзлийн үүднээс авч үзвэл үндэсний өөрийн ухамсар нь бусад үндэстэн, ястнуудтай яриа хэлцэл хийх үед үүсэх зайлшгүй үйл явц<sup>62</sup> бөгөөд энэ нь улс төрийн болон соёлын элитүүдийн түвшинд тэдний субъектив сонирхлыг илэрхийлж байдаг мэдлэгийн дээд хэлбэр юм.

Ухамсар нь нийтийн болон хувь хүний өөрөө өөрийгөө танин мэдэж ухамсарлах хэлбэр бол үндэсний өөрийн ухамсар нь нэлээд онцгой зүйл юм. Ухамсар нь бодит байдлыг дагаж мөрддөг бол үндэсний өөрийн ухамсар нь хувь хүний түвшинд нийгмийн үзэл санаа, тогтолцоо, зарчмуудыг бий болгож дагаж мөрддөг байна.

Үндэсний өөрийн ухамсрыг судлах хамгийн боломжтой сайн арга зүй бол конструктивизм боловч мөн примордиаль аргыг ашиглан өөр өөр өнцгөөс авч үзэх боломжтой юм. Примордаль хандлагын байр сууринаас үзэхэд үндэсний өөрийн ухамсар нь түүхэн ой санамж, уламжлал, соёлын хэлбэрээр илэрхийлэгдсэн түүхэн үйл явдлын тусгал юм. Түүний гол үүрэг нь өнөөгийн нөхцөл байдалд өөрсдийгөө олж илрүүлэх, таних мэдэх явдал юм.

Инструментализмын үүднээс авч үзвэл үндэсний өөрийн ухамсар нь тухайн хүний нийгэмлэгийг бүрдүүлдэг бөгөөд өөрөөр хэлбэл, хувь хүний өөрийн ашиг сонирхлыг нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхолд нийцүүлэх явдал юм. Конструктивизмын үүднээс үндэсний өөрийн ухамсар нь улс төр болон оюуны элитүүдийн бүтээл болох нийгмийн бүтээн байгуулалт, түүхэн соёл, иргэдийн ой санамжийг идэвхжүүлж, орчин үеийн үндэсний тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нийгмийг дайчлах зорилготой юм.

Тэгэхээр дээрх хандлагуудыг үндэслэн дүгнэвэл: үндэсний өөрийн ухамсрын тухай ойлголтын жинхэнэ тусгал нь конструктивизм хандлага болохыг харуулж байна.

Угсаатны ухамсар нь угсаатны өөрийн ухамсраас ялгагдах байдал нь угсаатны ухамсар нь тухайн хүний нийгэм хүмүүстэй харилцан ойлголцох, төвийг сахисан шинжтэй байдаг бол угсаатны өөрийн ухамсар нь тухайн угсаатанд өөрийгөө хамаатуулж тодорхойлсон хэлбэрээр илэрхийлэгдсэн, ухамсартай үйл ажиллагаагаар дамжуулан тухайн хүн өөрийн нийгэмлэгтэйгээ холбоо тогтоох явдал юм. Үндэсний ухамсрыг үндэсний өөрийн ухамсартай харьцуулбал үндэсний ухамсар нь тухайн хүнийг нийгэм, улс төрийн түүх, улс төрийн хамтын нийгэмлэг буюу нийгмийн ой санамжийн түвшинд холбох явдал юм. Харин үндэсний өөрийн ухамсар нь нийгэмлэгүүдтэй холбох механик холбоо биш, харин түүнийг хүлээн зөвшөөрдөг ухамсартай хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, үндэстний өмнө хүлээсэн үүрэг хариуцлага юм.

Хэрэв үндэсний ухамсар нь гол төлөв олон түмний түвшинд илэрхийлэгддэг бол үндэсний өөрийн ухамсар нь үндэсний элитүүдийн түвшинд илэрхийлдэг. Энд үндэсний болон угсаатны ухамсрын ялгааны талаар асуулт гарч магадгүй, учир нь тэр ойлголтууд нь примордиаль хандлагад хамаардаг. Тэдний гол ялгаа нь тухайн хүний нийгмийн нийгэмлэгүүдтэй харилцах харилцааны ялгаан дээр оршдог. Угсаатны ухамсрын харилцаа удамшил, цустай холбоотой байдаг бол үндэсний ухамсар нь нийгмийн нэгдэлтэй харилцах

<sup>62</sup> Авксентьев.А.В. Этнические проблемы современности и культура межнационального общения. Ставрополь.1993 стр.77

нийгмийн ой санамж, түүхээр дамждаг бөгөөд энэ нь удамшилтай ямар ч холбоогүй байдаг байна. Генетик ой санамж нь угсаатны ухамсарт, нийгмийн ой санамж нь үндэсний ухамсарт чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэднийг нэгтгэдэг бүх зүйл нь ой санамж, гэхдээ энэ нь янз бүрийн хэлбэрээр илэрхийлэгддэг.

Хэрвээ угсаатны өөрийн ухамсрыг улс төрийн институтаар дамжуулан илэрхийлж чадвал тэд угсаатныхаа эрх ашгийг төлөө үйлчилж чадна. Ийм төр улсын үндсэн чиг нь угсаатан төвт үзэлтэй байдаг. Угсаатны чиг баримжаатай улс төрийн институт нь примордаль хандлагын хил хязгаараас давж гарч чадахгүй<sup>63</sup>. Гэсэн хэдий ч өөрийн ухамсрын энэ түвшин нь үндсэндээ хувь хүн бүрт хамаарагдах анхдагч ойлголт юм.

Угсаатны өөрийн ухамсар нь үндэсний өөрийн ухамсраас ялгаатай нь хэдийгээр угсаатны онцлогийг илэрхийлдэг боловч иргэний улс төрийн хувьд шийдвэртэй бус зан төлөвийг тусгадаг. Аливаа үндэстэн нь хувь хүний, бүлгийн, угсаатны ашиг сонирхлоос илүү үндэсний эрх ашгийг дээгүүр тавьдагаараа чухал ач холбогдолтой юм. Хэрвээ угсаатны өөрийн ухамсарт түүх, соёл, уламжлал, олон түмэн ордог бол үндэсний өөрийн ухамсарт улс төрийн болон иргэний харьяалалын зарчим давамгайлдаг. Үндэсний өөрийн ухамсар нь нийгмийн конструктивизмын хандлагаар дамжуулан улс төрийн түвшинд өөрийгөө илэрхийлдэг бөгөөд энэ нь үндэстэн өөрийгөө танин мэдэж ухамсарлах объектив нөхцөл болдог бол угсаатны өөрийн ухамсар нь анхдагч (примордиаль) орон зайд өөрийгөө ухамсарладаг.

#### ***Үндэсний үзэл, үндэсний адилсал, үндэсний өөрийн ухамсрын хоорондын харилцан хамаарал***

Үндэсний үзэл ба үндэсний өөрийн ухамсар нь үндэсний адилсалтай хэрхэн харилцан хамааралтай байхыг судлах нь тэдгээр нийгмийн үзэгдлүүдийн байр суурийг тодорхойлох, зарчмыг нь тодорхойлох боломж олгодог. Үндэсний адилсал нь үндэсний өөрийн ухамсрыг одоо байгаа нийгмийн олон категориос ялгаж, байр сууриа олох боломжийг олгодог бөгөөд энэ нь нийгэм, улс төр, эдийн засаг, соёл тэр ч бүү хэл шашны харилцааны илэрхийлэл болдог. Энэ утгаараа үндэсний эрх ашиг нь үндэсний өөрийн ухамсрын түвшинг тусгасан байдаг бөгөөд энэ нь эдийн засаг, улс төрийн ашиг сонирхлыг ихэвчлэн тусгадаг. Мөн үүнээс гадна үндэстэн өөрийгөө танин мэдэх соёлын түвшинг ч бас тусгадаг. Үндэсний эрх ашиг бол үндэсний өөрийн ухамсрын инструменталь илэрхийлэл юм. Хэрэв үндэсний өөрийн ухамсар нь үндэсний төр улсын төлөв байдлын тусгал бол үндэсний эрх ашиг нь үндэсний өөрийн ухамсрыг нийгэмшилт болгох хэрэгсэл юм. Хэрэв үндэстэн өөрийгөө ухамсарлах нь бүтцийн тусгал юм бол үндэсний эрх ашиг нь түүний чиг үүргийн тусгал юм.

Үндэсний өөрийн ухамсрын бас нэгэн чухал зүйл нь үндэсний үзэл болдог бөгөөд үндэсний эв нэгдлийг бэхжүүлэгч хүчин зүйл нь болдог. Үндэсний үзэл нь үндэсний өөрийн ухамсрын тогтвортой, нэгдмэл байдлыг илэрхийлдэг бол үндэсний эрх ашиг нь үндэсний өөрийн ухамсрын динамик өөрчлөлтийг илэрхийлдэг<sup>64</sup>.

Үндэсний үзэл ба үндэсний эрх ашиг бол үндэсний өөрийн ухамсрын үйл ажиллагааны багаж хэрэгсэл нь болдог. Үндэсний өөрийн ухамсар нь үндэсний үзлийн үйл ажиллагаа, үндэсний эрх ашгийн өөрчлөлтийн үр дүн гэж хэлж болно. Үндэсний үзэл, үндэсний эрх ашгийг бий болгогч субъектүүд бол үндэсний өөрийн ухамсрыг өдөөгч улс төр, оюуны элитүүд билээ.

---

<sup>63</sup> Авксентьев.А.В. Этнические проблемы современности и культура межнационального общения. Ставрополь.1993 стр 28

<sup>64</sup> Gellner.E. Nations and nationalism. Oxford.,1993 p 98

Үндэсний эрх ашгийг хувь хүний эрх ашгаас ялгаж салгах нь инструменталь эсвэл субъектив хандлага юм. Нийгмийн ашиг сонирхлын гол байр суурийг үндэсний эрх ашиг голлож байдаг нь инструментализмын орон зайтай холбоотой. Энэ бол үндэстэн өөрийгөө танин мэдэх арга хэрэгсэл бөгөөд конструктивизм нь үндэсний үзлийг илэрхийлдэг. Үндэстэн өөрийгөө ухамсарлах нь үндэсний үзэл, үндэсний эх оронч үзлийн нийлмэл бөгөөд энэ нь нийгмийн төлөв байдлын ерөнхий үзүүлэлт байдаг гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Угсаатны болон иргэний үндсэрхэг үзэл нь нийгмийн тусгал юм. Үндэсний өөрийн ухамсрын ухамсарлагдаагүй хэлбэр нь үндсэрхэг үзэл, иргэний үндэсний үзэл нь эх оронч ухамсрыг илэрхийлдэг бөгөөд эдгээрийн нийлмэл нь үндэсний өөрийн ухамсар юм.

Үндэсний үзэл нийгмийн хөгжилд биеллээ олж байгаа нь үндэсний өөрийн ухамсар нэмэгдсэний үр дүн боловч үндэсний үзлийн тархалт нь үндэсний өөрийн ухамсрын зөвхөн параметрийн хэсгийг л илэрхийлдэг. Тиймээс үндэсний өөрийн ухамсар нь үндэсний үзлийг үнэмлэхүй шинжтэй болгодог хэдий ч түүний мөн чанарыг бүрэн дүүрэн таних боломжгүй. Энэ байдлаас үзэхэд үндсэрхэг үзэл нь хүмүүсийн примордиаль түвшинд үзэл суртлын үүрэг гүйцэтгэдэг гэсэн үг. Зарчмын хувьд үндсэрхэг үзэл нь примордиализмтай холбоотой бол үндэсний үзэл нь инструментализмтай холбоотой, үүний туйлын илрэл нь либераль үзэл юм.

### ***Дүгнэлт***

Үндэсний өөрийн ухамсар нь примордиализм, иснтрументализм хэмээх хоёр зүйлийг нэгтгэдэг бөгөөд олон түмний ухамсарт өөрийн байр сууриа олдог. Үндсэрхэг үзэл бол үндэсний өөрийн ухамсрын зөвхөн нэг л бүрдэл хэсэг юм. Үндсэрхэг үзлээр нийгмийн танин мэдэхүйн бүх үзэгдлийг тайлбарлаж эхэлвэл нэг хүнийг юмуу нэг үзлийг тахин шүтэх үзэл бий болж өөрөөр хэлбэл, тоталитар дэглэм бий болох аюултай. Үүнтэй холбогдуулан үзэл суртлын аливаа хэлбэрийг туйлшруулахаас сэргийлж, олон ургальч үзлийг үндсэн хуулиар зөвшөөрч, улмаар төр дэх олон үнэт зүйлсийн оршин тогтнох орон зайг хамгаалагч нь үндэсний өөрийн ухамсар юм.

### ***Краткий обзор***

Если сознание можно определить в терминах всеобщей абстрактности, выраженной в дорефлексивных и эмоциональных параметрах сознания: самосознание в терминах инструментализма, где превалирование выбора и индивидуальных интересов выходит на первый план: то национальное самосознание можно выразить в форме категории особенного, а именно, конструктивизма. Национальное самосознание можно изучать со стороны, как было отмечено выше, трех основных подходов: примордиализма, инструментализма и конструктивизма.

### ***Ашигласан ном зохиолууд:***

1. Авксентьев.А.В. Этнические проблемы современности и культура межнационального общения. Ставрополь.1993
2. Андерсон.Б. Нация и национализм. М.,2003
3. Кессиди.Ф.Х. Народ и нация. Киев.,1992
4. Gellner.E. Nations and nationalism. Oxford.,1993

## КОММУНИЗМЫН ТҮҮХИЙГ ЭРГЭН СӨХВӨЛ

**Д.Ундрах**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн дэд профессор

### *Хураангуй*

Өнгөрсөнгүй өнөөдөр үгүйн адил, өнөөдөргүй ирээдүй оршихгүй тул өмнөх үеэ сэргээн судлаж, харьцуулан баримжаалж зарчим үнэт зүйсээ тодорхойлж явах нь чухлын учир бидний хувьд тун саяхныг хүртэл ач холбогдолтой, амин чухалд тооцогдож явсан коммунист онол, үзэл суртал, үйл явцын талаар эргэн хөндөхийг зорьлоо.

**Түлхүүр үг:** коммунизм, коммунист онол, үзэл суртлын хувьсал өөрчлөлт

### *Ориил*

Түүхэн хөгжлийн өнгөрсөн баримтууд одоогийн үндэс, одоо нь харин ирээдүйг угтан баримжаалах суурь болдог тухай нэгэнтээ улс төр судлаач Д.Болд-эрдэнэ тэмдэглэсэн нь бий<sup>65</sup>. Тэгвэл улс төрийн онол хийгээд философи мэдлэгийн сонгодог ба орчин үеийг харьцуулах явдал эрт, эдүгээгийн нийгэм улс төрийн амьдрал, хөгжлийн зүй тогтлыг олж харахад тус болох нь дамжиггүй. Улс төрийн онолын хувьд коммунизм нь өөрчлөгдсөөр ирсэн ч зарим философичид, улс төрчдөд төдийгүй иргэдэд ч өнөөг хүртэл ач холбогдолтой, одоогийн улс төрийн мэтгэлцээн хийгээд капитализмын шүүмжийн хүрээнд чухал сэдвийн нэг хэвээр байна. Энэ ч утгаараа коммунизмын үзэл санааг түүний улс төрийн хэрэгжилтээс ялгах шаардлагатай. Ингэхдээ коммунизмыг улс төрийн үзэл санаа, дэглэм, зохион байгуулагдсан институт болохынхоо хувьд хэрхэн хөгжин хувьсч ирснийг тоймлон харуулахыг хичээнэ.

*Коммунист үзэл санааны хувьсал.* Коммунист үзэл санаа хавьгүй эртний угшилтай бөгөөд хувь хүний хөрөнгөжин баяжих явдлыг устгаж, хүний туйлын тэгш байдлыг хангах нийгмийн үзэл санаан дээр үндэслэдэг. Энэ тухай Платоноос эхлээд XVIII зууны утопи социалистууд, Зөвлөлтийн үеийн судлаачид ба орчин үеийн нийгмийн онолчид зэрэг олон тооны сэтгэгчдийн бүтээлд дурдагдсан байдаг.

Коммунизм болон коммунист гэх нэр томъёо нь анх XI зууны Францад тариачдын зарим эрх, ашиг сонирхол, түгээмэл үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэгдэж гарч ирсэн түүхтэй. Францын хувьсгалын үед зарим зохиолчид коммунизм гэх үгийг хувьсгалын үр дүнд үүсч, нийт баялгийг эн тэнцүү хуваах дэглэм хэмээн орчин цагийн утгад нь нэлээд дөхүүлэн ашиглаж байв. Улмаар Роберт Оуэн, Этиенн Кабэ, Вилхэм Вэйтлин, мөн Мозэс Хэсс нарын зарим нь уг нэр томъёог “солилцоо болон хуваарилалтанд суурилсан шинэ утоп нийгмийн тогтолцоо”-г тодорхойлоход ашиглах болов. Харин XIX зууны дунд үеэс коммунизмын суурь үзэл санаа илүү олон нийтэд түгэх болсон нь 1847 онд Карл Маркс, Фредрих Энгельс нарын байгуулсан Коммунист холбоо, мөн тэдний 1848 онд хэвлүүлсэн “Коммунист намын тунхаг”

<sup>65</sup> Д.Болд-эрдэнэ. Улс төрийн философи.1 боть. 122 дахь тал.

зэрэг бүтээл коммунист үзэл санааг улс төрийн бүтцэд оруулж, тодорхой уялдаа холбоо бүхий сургаал номлол болох түүхэн үе, үйл явдлын эхэн байв. Коммунизм гэх нэр томъёо нь реформист буюу шинэчлэгч үзэл санаанаас эрс ялгарахуйц ерөнхий төсөөлөл, улс төрийн үйл ажиллагаа болон улс төрийн үзэл суртлыг бодит бөгөөд хүчирхэг шинжлэх ухаанаар төлөөлүүлсэн үг болов. Германы сонгодог философи, Английн улс төрийн эдийн засгийн ухаан, Францын утопи социализмаас эхтэй Марксын үзэл санааны ундарга философи, улс төрийн эдийн засгийн ухаан, социализм-коммунизмын тухай онол сургаалиудад илрэлээ олсон байдаг. Марксын боловсруулсан тухайн түүхэн цаг үеийнхээ капиталист ертөнцийн улс төрийн амьдралын дотоод мөн чанрыг нээн шинжилсэн улс төрийн онол, үзэл санааг “түүхийн бүх цаг үед таарах мэтээр хэт эдүгээчлэн догмчилсон”<sup>66</sup> нь түүний онол, сургаалийн мөн чанрыг будлиантуулахад хүргэсэн тухай судлаачид тэмдэглэдэг. Маркс хөгжлийн диалектик зүй тогтлыг дагаж ангит нийгмийн зөрчил тэмцлээр илрэх капиталист нийгмийн хөгжлийн үр дүнд ангигүй нийгэм буюу социализм, хамтын өмчит нийгмийн байгууламж болох коммунизм байгуулах үзэл онолын үндсийг боловсруулсан. Ингэхдээ өмнөх үеийн утопи социалистуудын капитализмыг буруушаан зэмлэж, шилдэг нийгмийг мөрөөдөхөөс илүү гарахгүй байсан мухардалд цэг тавьсан. Гэхдээ хүнлэг бус, харгис капиталист нийгмийг өөрчилж эрс хувьсгал хийх үзэл санаа XIX зуунд баруун Европын орнуудад бие биенээсээ төдийлөн хамааралгүй үүсчээ. Англид улс орныг хамарсан ядуурал, хоосрол, ёс суртахууны доройтол зэрэг бодит хэрэгцээ шаардлагаар, Францчуудад улс төрийн эрх чөлөө, тэгш ёсыг шаардах улс төрийн тэмцлийн замаар, Германд философи замаар тус тус мөлжлөггүй нийгэм, хамтын өмчлөл бүхий нийгмийн байгууламжийн тухай үзэл санаа үүсэн хөгжсөн болохыг тэмдэглэх нь зүйтэй.<sup>67</sup>

Марксын хувьд коммунизм гэдэг нь дан ганц нийгмийн тэгш байдал, хувийн өмчийг устгах санаа төдийгүй пролетарын дарангуйллыг тогтоож, капиталистууд хийгээд хөрөнгөтнүүдийг үндсээр нь устгах зохион байгуулалтай ангийн тэмцэл дээр суурилсан, зайлшгүй хувьсгалыг хэлж байв<sup>68</sup>. Энэхүү анхны алхамыг хийсний дараа нийтийн өмч бүхий төгс шинэ хэв журмыг тогтоож, нийгэм дэх ангийн ялгаа үгүй болж, аажмаар төр ч өөрөө үгүй болох болно гэж үзэв. 1917 оноос өмнө социализм ба коммунизм хоорондын харилцаа хамаарлын талаар олон улсын ажилчны хөдөлгөөний дунд будлиан гарч байсан бол, 1917 оны Оросын хувьсгалын дараа Ленин Большевик намд Коммунист хэмээх нэрийг өгч, 1919 онд гурав дугаар интернационализмыг байгуулснаар коммунист, социал-демократ, социалист намуудын хоорондын ялгаа улам тодорчээ. Ленин ба түүний нөхөд өөрсдийгөө Марксын цорын ганц өв залгамжлагчид хэмээн итгүүлж Марксизмын талаарх бусад олон ойлголт, тайлбаруудыг няцаажээ.

Марксизм-Ленинизм нь XX зууны коммунист үзэл суртлын хамгийн гол бөгөөд хүчтэй билэгдэл болж түүний бодит загвар нь ЗХУ болсон билээ. Коммунизмын анхны бодит биелэл гэгдэх ЗХУ-ын дараа асар удалгүй буюу дэлхийн хоёрдугаар дайны дараа бусад улс орнууд тухайлбал Маогийн Хятад, Ким Ир Сений Хойд Солонгос болон Фидел Кастрогийн Куба зэрэг улсууд коммунист дэглэмийн өөр өөрийн хувилбарыг цогцлоосон билээ.

*Коммунизм-Улс төрийн дэглэм болох нь.* Коммунизм, марксизмтай холбогдсон эдгээр улсууд оршин байснаараа коммунизмыг улс төрийн дэглэмийн нэг төрөл хэмээн

<sup>66</sup> Д.Болд-эрдэнэ. Улс төрийн философи. I боть. 455 дахь тал.

<sup>67</sup> Б.Даш-Ёндон. Нийгмийг танихуй: Түүх-хөгжлийн философи. УБ., 2014. 137-138 дахь тал

<sup>68</sup> Г.Цэнд-Аюуш. XIX-XX зууны улс төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм. Тэргүүн дэвтэр. УБ., 2015. 58 дахь тал.

тодорхойлоход хүргэнэ. Ингэхдээ коммунист тогтолцоог өөр өөрсдийн түүхэн цаг үед, үндэсний болон нийгмийн орчинд хэрхэн хэрэгжүүлсэн нь тэдний нэн өвөрмөц талыг харуулдаг. Тэдгээрийн хооронд нийтлэг зүйлүүд, нэн ялангуяа коммунист дэглэмийг бий болгохын тулд нийтийг хамарсан хядлага, геноцид, эрүүдэн шүүх, цөллөг, баривчилагаа, улс төр, соёлын болон шашны “дайснуудад” зориулсан хорих лагериуд, мөн намын доторх өрсөлдөгчдөөс ангижрах цуст цэвэрлэгээ гээд аймшиг, хүчирхийллийн бачим цаг үе бас бий. Коммунист хядлагын хамгийн аймшигтай жишээнүүдийн тоонд Камбожид өрнөсөн Улаан Кхмерчүүдийн үйлдсэн 1-1.5 сая хүнийг хядсан хядлага орно.

Ихэнхдээ коммунист дэглэм дэх цочмог хэлмэгдүүлэлтийн үе нь аажмаар сулрах байдаар үргэлжилж байсан ба энэ нь 1953 онд Сталиныг нас барсны дараа Зөвлөлтөд болон Зүүн, Төв Европт илэрч 1956 онд Хрущевын эхлүүлсэн сталинизмыг халах гэсэн оролдлогоос харагддаг. Гэсэн хэдий ч энэ үед эрх чөлөөний хязгаарлагдмал байдал хэвээр байж, өмнөх дарангуйллын дурсамжаас үүдэлтэй айдас оршсоор байжээ. Коммунизмын бусад нийтлэг шинжүүдийг дараахь байдлаар тодорхойлж болно<sup>69</sup>. Үүнд:

- 1945 оноос хойш Зүүн ба Төв Европын зарим оронд байсан шиг олон ургальч үзлийг дэмждэг цөөн тооны жижиг холбоотнуудтай нэг намын дүрмээр эсвэл жанжлагч коммунист нам байгуулах;
- Улс төр, эдийн засаг, нийгэм, оюуны болон соёлын гэх мэт бүхий л салбарын үйл ажиллагааг төрөөс монополичлох замаар эрчимтэй суртал ухуулга хийхэд ашиглах;
- Намын хийгээд нийт хүн амын дунд үзэл суртлын ач холбогдлыг онцлон тэмдэглэх;
- Нийгмийн хатуу хяналт ба удирдлага хэрэгжүүлэх;
- Үзэл сурталд автсан, намд үнэнч, бүхнээ золиослоход бэлэн "шинэ хүн" бий болгох эрмэлзэл;
- бүх удирдлагыг ялангуяа соёл, угсаатан, шашин ба газар зүйн ялгаатай олон хэлбэр, нөхцөл бүхий орнуудад төвлөрүүлэх;
- Сталин, Мао, Ким Ир Сен, Хо Ши Мин, Кастро шиг (зохион байгуулалттай шашны бүлгэм мэт) удирдлагыг тахин шүтэх гм. орно.

1920-1930 оны хооронд улмаар Дэлхийн II дайны дараа эдгээр шинжүүд нь коммунист дэглэм хийгээд түүний ангилалын талаар олон тооны асуулт, шүүмжийг судалгааны эргэлтэд оруулжээ. Тэд үнэн хэрэгтээ хаашаа явж байна, дарангуйлалын шинэ хувилбар уу, авторитаризмын шинэ төрөл үү, эсвэл бүр тоталитаризмд харьяагдах уу? гэх мэт ширүүн мэтгэлцэн өрнөсөөр байв. Жишээлбэл Ханна Арент, Реймонд Арон нар “1956 оны Унгарын бослогын дараа ЗХУ-ыг пост-тоталитари дэглэм эсвэл бурангуй авторитаризм руу шилжиж улс төр-эдийн засгийн гүнзгий хямрал нүүрэлсэн, удирдан зохион байгуулах шинжээ алдаж эхэлсэн<sup>70</sup>” гэж дүгнэсэн байдаг. Олонхи судлаачид тоталитаризмын үндсэн шинжүүд эхнээсээ төгсгөл хүртлээ тогтвортой байдгийг онцолдог ч тоталитаризмын хурц болон намжмал хэлбэрүүдийн хооронд ялгаатайг хүлээн зөвшөөрдөг. Эсрэгээрээ бусад эрдэмтэд коммунизм дахь тоталитар үзэл баримтлалын хамаарлыг үгүйсгэж, үүнийг фашизмтай харьцуулах үндэслэлийг шүүмжилдэг. Тэдний хувьд тоталитаризм нь харьцуулахад хэт өргөн хүрээтэй ба схемчлэгдсэн байдаг гэж үздэг. Юутай ч коммунист дэглэм нь бусад оронд дарангуйллын жишээнд тооцогдож байв.

<sup>69</sup> George T. Kurian. The Encyclopedia of Political Science. SAGE. Washington DC. 2011. pp.311

<sup>70</sup> George T. Kurian. The Encyclopedia of Political Science. SAGE. Washington DC. 2011. pp.313

*Коммунизм-Идеаль загвар болох нь.* Хэдийгээр коммунист дэглэмүүд шашныг хүчтэй дарангуйлж байсан ч коммунизм нь өөрөө дэлхийн буюу улс төрийн шашны хэлбэртэй байсан гэж олон судлаачид үздэг. Европт коммунизм нь протестантаас илүү католик ба ортодокс шашинтай улс орнууд, зарим еврей нийгэмлэгүүдын дунд илүү амжилттай тархаж байв. Исламын шашин зонхилгч улсуудад коммунизм бүтэлгүйтсэн ч буддист, даоист ба күнзийн сурталт орнуудад цэцэглэн хөгжсөн юм. Эдгээр орнуудад коммунизмыг уламжлалт шашныг “орлогч”, уламжлалт шашны итгэл үнэмшлээсээ шинэ итгэл үнэмшилд шилжих шилжилтийн үр дүн гэж үзэж болно.

Коммунизмыг хүн амын олон анги давхаргад боловсролгүйгээс аваад сэхээтнүүд хүртэл хүлээн авч, өөрсдийн итгэл үнэмшлээрээ улс төрийн оролцооны үндэс сууриа тавьж байв. Энэ нь нэг талаас Зөвлөлтийн ашиг сонирхолыг хамгаалахтай нягт холбогддог ч мөн нөгөө талаасаа дэлхийн хөдөлмөрчин ард түмнүүдийн ахан дүүсийн ган бат найрамдал-социалист интернационализмд оруулж буй хувь нэмэр гэж хүлээж авах нь их байв. Юутай ч коммунизм тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэгч жишээлбэл Вьетнам, Камбож зэрэг улс орнуудад үндсэрхэг үзлийн дор нэгдэн нягтрах явдлыг бэхжүүлж өгсөн нь үнэн билээ.

### *Дүгнэлт*

Мэдээжийн хэрэг коммунизм бол онолын хувьд тэгш ёс, эрх чөлөө, боолчлол ба хамжлага ёсыг халах, ардчиллыг хүсэн тэмүүлэх соён гэгээрлийн үеийн үр хөврөл. Хэдийгээр коммунизм болоод фашизм, нацизм зэрэг тоталитар хөдөлгөөнүүдийн хооронд ялгаа байвч практик дээр коммунизмыг дарангуйлагч дэглэм гэж хүлээж авч байв. Өрнөдийн орнуудад коммунист намууд “хөрөнгөтний” ба “нэр төдий” ардчиллыг шүүмжилж байсан ч дэлхийн II дайны дараагаар Баруун Европт нөлөө бүхий байсан коммунист намуудын дийлэнх нь фашизмын эсрэг болон колоничлолын эсрэг хөдөлгөөнүүдэд идэвхтэй оролцох замаар аажмаар ардчилсан зарчмуудыг хүлээн авч өөрсдийн намын зохион байгуулалтыг өөрчлөх болсон<sup>71</sup>.

Тэгвэл одоо асуудлын гол нь коммунизм өөрөө улс төрийн “үеэ өнгөрөөсөн” үзэгдэл үү эсвэл орчин үетэйгээ хөл нийлэн оршсоор байна уу гэдгийг тогтоох явдал юм. Ангигүй нийгмийн тухай үнэт зүйлс, үзэл санааг баталгаажуулдагынхаа хувьд капитализм, зах зээлийн эдийн засаг, индивидуализм, либерал ба төлөөллийн ардчиллыг үгүйсгэхийн учир “үеэ өнгөрөөсөн”-д тооцогддог. Гэсэн хэдий ч Франц, Итали зэрэг хүчтэй коммунист намуудтай ардчилсан орнуудад нийгмийн эмзэг буурай хэсгийг хамгаалах халамжийн төрийн бодлогын үндсийг тавьснаараа коммунист намуудын оршин тогтнол чухалд тооцогддог.

Өдгөө коммунист дэглэм Төв, Зүүн Европт нуран унаж, баруун Европын коммунист намууд ч уналтанд орж, өөрсдийн нэр, үнэт зүйлсээ өөрчлөөд байна. Коммунизм бүхэлдээ эрчээ алджээ. Гэвч коммунизм нь Хойд Солонгос мэт зарим улсад тоталитар дэглэмээр, Хятадад зах зээлийн эдийн засаг болон нэг намын ноёрхлын хэлбэрээр оршсоор байна.

Коммунизмын үлдээсэн нэн чухал өвийг дурдалгүй өнгөрч болохгүй. Энэ нь тэгш байдал, нийгмийн халамжийн бодлого. Тэрчлэн зарим улс оронд коммунистууд өнөө ч нэр хүндтэй байгаа нь тэдний удирдсан ангийн болон фашизмын эсрэг тэмцлийн үнэ цэнэ өдгөө ч хэвээр хадгалагдаж буйтай холбоотой. Цаашилбал коммунист соёлын зарим элементүүд анти-капитализм, утопи тэмүүлэл, радикал хувилбарын эрэл хайгуул, ардчиллын бодит байдлыг

<sup>71</sup> Eric Foner. The story of American Freedom. Norton, NY. 1999. p.273

сорих сорил, реформизмтой тэрслэх явдал өнөөдөр ч хэвээр байна. Өөрөөр хэлбэл коммунизм нь улс төрийн хувьд төвлөрсөн, авторитари, зохион байгуулалттай хөдөлгөөнийхөө хувьд дуусгавар болсон байж болох ч үзэл санаа, хүсэл эрмэлзлийн хувьд одоо ч оршсоор байна.

***Abstract***

Since there is no present without past as well as no future without present, it is important to re-examine our past path and values which had been vital for us very recently. This is about communist party and ideology which was orienting the lives of nearly one third of world population over two decades.

***Ашигласан ном, материал***

Д.Болд-эрдэнэ. Улс төрийн философи. I боть. УБ., 2015

Б.Даш-Ёндон. Нийгмийг танихуй: Түүх-хөгжлийн философи. УБ., 2014.

А.Жамбал. Улс төрийн философийн судлах асуудлын тухайд. Философи, эрх зүй судлал XXVII боть.

Г.Цэнд-Аюуш. XIX-XX зууны улс төрийн сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм. Тэргүүн дэвтэр. УБ., 2015.

К.Поппер. Нээлттэй нийгэм ба түүний дайснууд. II боть. УБ.,

Улс төрийн шинжлэх ухаан. /ред.Ё.Довчин/ УБ., 2010

Ричард Поупкин., Аврум Стропп. Гүн ухаан. УБ., 1998.

***Англи хэл дээр:***

Bertrand Russell. History of Western Philosophy. Routledge. Canada. 1995

Great political theories. Vol 2. By Michael Curtis. NY. Harper Collins Publishers. 1981

George T. Kurian. The Encyclopedia of Political Science. SAGE. Washington DC. 2011

Eric Foner. The story of American Freedom. Norton. NY. 1999

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙГ СОНГОГЧДЫН САНАЛААР ЭГҮҮЛЭН ТАТАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ АСУУДАЛД

**Ц.Ганболд**

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,  
Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор

**С.Жавхлан**

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,  
Улс төр судлалын тэнхимийн докторант

**Түлхүүр үг:**Мандат, парламентын гишүүний бүрэн эрх, улс төрийн хариуцлага, сонгогчдын саналаар эгүүлэн татах.

### *Парламентын төлөөллийн тухай ойлголт, өөрчлөлтийн мөн чанарын зарим асуудал*

Парламентын төлөөлөл нь нийгмийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэх хэрэгсэл болох талаар Г.Еллинек “Нийгэмд хэзээ ч нэгдсэн хүсэл зориг байгаагүй, парламент өөрийнхөө шийдвэрт нэгдмэл хүсэл зоригийг тусгах ёстой” гэж тайлбарласан бол нийтлэг ашиг сонирхол нь зөрчилдөж буй сонирхлуудын өрсөлдөөн биш гэсэн санааг Ж.Ж.Руссо дэвшүүлж, тухайн улсын бүх иргэний “байнгын” ашиг сонирхол л нийтлэг ашиг сонирхол гэж тайлбарлажээ.

Энэхүү нийтлэг ашиг сонирхол нь тодорхой бүлгийн хүсэл зоригийн нийлбэр биш учраас хууль тогтоох байгууллага сонгогчдын даалгавраас чөлөөлөгдөж, үндэсний бүрэн эрхт байдлыг хэрэгжүүлэгч гэж хүлээн зөвшөөрдөг байна. Уг утгаар авч үзвэл “төлөөлөгч буюу сонгогдсон хүний хүсэл зориг сонгож байгаа хүний хүсэл зоригийн илэрхийлэл...” гэсэн Английн парламентын төлөөллийн үзэл санааг парламентын гишүүн өөрийн сонгогдсон бүлэг, давхаргыг бус, харин бүх ард түмний хүсэл зоригийн төлөөлөгч байна гэсэн утгатай гаргалгааг судлаачид хийжээ<sup>1</sup>.

Орчин үед улс төрчдийг хариуцлагатай байхыг шаардсан иргэдийн эрэлт хэрэгцээ нь улс төрийн төлөөллийн талаарх мэтгэлцээний гол сэдэв болж байна. Энэ талаар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Олон улсын парламентын холбоо хамтран гаргасан “Дэлхийн улс орнуудын парламентын тайлан<sup>2</sup>-д дэлгэрэнгүй тусгасан байдаг. Энэхүү тайлангаас үзэхэд улс төрийн хариуцлагыг сайжруулах олон нийтийн шахалтаас үүдэлтэйгээр парламентын төлөөллийн мөн чанар өөрчлөгдөж байгаа ажээ. Сонгуульт хугацаандаа улс төрчид үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол хугацаанд мэдээлж байх үүрэгтэй гэж үзэх болов. Энэ нь “**чөлөөт мандат**” гэх уламжлалт тогтсон ойлголт өөрчлөгдөх шаардлагатай болж буйг илэрхийлж байна.

Мөн тайланд тусгаснаар сүүлийн жилүүдэд улс орнуудын парламентын гишүүдэд олон нийтийн зүгээс үзүүлж буй шахалтыг дараах үндсэн 3 хэсэгт хуваан авч үзсэн байна. Үүнд:

<sup>1</sup> П.Амаржаргал.Парламентын онол үзэл баримтлалын асуудал 2015 172 дахь тал

<sup>2</sup> Inter-Parliamentary Union | United Nations Development Programme “The changing nature of parliamentary representation” April 2012

- Нэгдүгээрт, илүү ил тод нээлттэй, ялангуяа хувийн ашиг сонирхлын талаар ил тод байх;
- Хоёрдугаарт, парламентын хяналтын байгууллагыг хөгжүүлж түүгээр дамжуулан ажлыг нь үнэлж, дүгнэх, эгүүлэн татах зэрэг хариуцлагын хэлбэрийг бий болгон мөрдүүлэх;
- Гуравдугаарт, парламентын гишүүд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан үйл ажиллагаагаа тогтмол мэдээлдэг байх нь зүйтэй гэж үзэх болжээ.

Аль ч орны улс төрчид эдгээр хандлагыг ялангуяа өөрсдөд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бүрдүүлэх тухай асуудлыг эрс эсэргүүцдэг. Гэвч цаашид парламентын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх талаарх иргэдийн шахалт улс орон бүрд улам хүчтэй өрнөх бөгөөд тэднийг иргэдэд нээлттэй ил тод үйл ажиллагаа явуулахыг олон нийт хүссэн хүсээгүй шаардах болно гэж үзэж байна<sup>3</sup>.

***Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэх удаа дараагийн санаачилга гарч байгаа талаар***

Сүүлийн жилүүдэд улс төрчид, улс төрийн нам, иргэдээс гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх, сонгогчид эгүүлэн татдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг хөндөх болсон. Энэ ч үүднээс гишүүнийг эгүүлэн татах зохицуулалтыг тусгасан хуулийн төслийг 2016<sup>4</sup>, 2019<sup>5</sup> онуудад боловсруулан Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлээд байна. Эдгээр хуулийн төслийн үзэл баримтлалд төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, төрийн өндөр албан тушаалтны эрх зүйн байдлын онцлог зэргээс хамаарч Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын хариуцлагын тогтолцоо бүх хүрээнд үйлчилдэггүй, мөн төрийн өндөр албан тушаалтнуудыг огцруулах, чөлөөлөх эрх зүйн зохицуулалт бодит байдалд хэрэгждэггүй явдал байсаар байгааг тусгасан байв.

Мөн энэ хуулийг санаачлагчид хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэлээ тайлбарлахдаа Монгол Улсад гишүүнийг гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор батлагдсанаас бусад тохиолдолд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин бүрхэг байгааг дараах үндэслэлээр тайлбарлажээ. Үүнд:

- Гишүүний гэм буруутай үйл ажиллагааг шалгаж тогтоох, улмаар хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй боловсронгуй бус байна;
- Гишүүний халдашгүй бүрэн эрхийн үйлчлэх хүрээ, орон зай нь тодорхой бус байгаа нь түүнд хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учруулж байна;
- Гишүүний ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа дүрэм нь боловсронгуй бус байна;
- Гишүүнд улс төрийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн боломжгүй байгаа зэрэг асуудлыг дурьджээ.

Үүнээс гадна Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2019 оны 6 дугаар сарын 06-нд нэр бүхий 62 гишүүн Улсын Их Хуралд өргөн барьсан. Үүний үндсэн дээр<sup>6</sup> Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газраас хуулийн төсөл,

<sup>3</sup> Inter-Parliamentary Union | United Nations Development Programme “The changing nature of parliamentary representation” April 2012

<sup>4</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох тухай” 2016 он

<sup>5</sup> Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл 2019 он

<sup>6</sup> Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1-т “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөл санаачлах үеэс эцэслэн батлах хүртэл бүхий л үйл ажиллагаанд иргэд, улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллагын оролцоог хангах;”, 5.4.7-д “төслийн хэлэлцүүлгийн үе шат хоорондын хугацааг иргэд, тэдгээрийн хамт олон, байгууллагад санал бодлоо илэрхийлэх боломж олгохуйцаар тогтооно” гэж тус тус заасан байдаг.

хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээллийг нийтэд зарлан мэдээлэх, төслийг нийтэлж санал авах, дүнг нэгтгэн боловсруулах, санал дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Энэхүү хугацаанд гишүүд үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг иргэдэд танилцуулж санал авах ажлыг зохион байгуулсан бөгөөд дүнг эцэслэн гаргахад нийт 18 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 40930 иргэнээс санал авсан байна<sup>7</sup>. Энэхүү санал авах ажиллагааны дүнгээр иргэдээс хамгийн олон удаа давтагдсан санал нь гишүүний үүрэг, хариуцлагыг сайжруулах, сонгосон гишүүнээ эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэх байжээ.

### ***Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал***

Дээрх байдлаас үзэхэд цаашид Монгол Улсад төдийгүй олон улсад ч парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг шаардсан иргэдийн шахалт улам нэмэгдэхээр байна. Гэвч сонгогчдын саналаар эгүүлэн татдаг улс төрийн хариуцлагын энэхүү хувилбар нь төдийлөн нийтлэг арга биш бөгөөд засаглалын хэлбэр, төрийн удирдлага, улс төрийн соёл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан улс орон бүрд харилцан адилгүй үр нөлөөтэй байна. Иймд парламентын засаглалтай, 1 танхимтай, “Мажоритар” системээр гишүүнийг дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаагаар иргэдээс шууд сонгодог Монгол Улсын хувьд энэхүү зохицуулалтыг бүрдүүлэх тохиолдолд дараах хүчин зүйлсийг зайлшгүй анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа баталснаас хойш парламентын 7 удаагийн сонгуулийг зохион байгуулсан. Үүнээс 1996, 2000, 2004, 2016 онуудад сонгуулийн жижиг тойрогт Мажоритар системээр, 2012 онд томсгосон тойрогт Пропорционал, мажоритар холимогоор, 1992, 2008 онуудад томсгосон буюу олон мандаттай тойрогт Мажоритар системээр тус тус зохион байгуулсан байна. Сонгуулийн тогтолцооноос хамаарч тухайн парламент нь өөр өөр арга замаар бүрддэг тул эгүүлэн татах асуудлыг тодорхойлоход сонгуулийн аль системд, ямар хувилбар тохирохыг тооцсон байх учиртай. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ны нэмэлт өөрчлөлтөөр цаашид Монгол Улсын Их Хурлын сонгуулийг “Мажоритар” системээр зохион байгуулах тухай заалтыг тусгасан байдаг. Иймд сонгуулийн “Мажоритар” системд эгүүлэн татах асуудлыг хэрхэн дэвшүүлэх тухай асуудлыг энд авч үзье.

### ***Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх (мандат)-ын тухай асуудал***

Гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудлыг шинжлэхийн тулд юун түрүүнд Үндсэн хуулийн эрх зүйн онолын “парламентын гишүүний мандат”-ийн тухай асуудлыг авч үзэх шаардлага тулгарна. Мандат буюу Mandate гэдэг нь англиар бүрэн эрх, даалгавар гэсэн утгыг илэрхийлдэг (Д.Алтангэрэл.Англи-Монгол толь. УБ.2002 он. 298 дахь тал). Олон улсын нийтлэг хандлагаар мандат гэдэг нь ард түмэн буюу сонгогчдоос иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх зорилготой төлөөлүүлэх бүрэн эрх гэж ойлгодог. Төлөөлөгчийг парламентад илгээхдээ олгодог энэ бүрэн эрх тухайн парламентын шинж чанараас хамаарч Чөлөөт болон Захирагдмал гэсэн 2 хэлбэртэй байдаг. Захирагдмал хэв шинжийн мандатын хувьд парламентын гишүүн гагцхүү тойргийнхоо сонгогчдын захиа, даалгаврыг биелүүлэх үүрэгтэй байдаг ба биелүүлээгүй гишүүнийг сонгогчид дуртай цагтаа огцруулдаг зарчимтай

<sup>7</sup> (Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны тэмдэглэл).

(Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ.2008. 208 дахь тал). Харин чөлөөт шинжийн мандатын хувьд парламентын гишүүн тойргийнхоо сонгогчдыг бус, нийт ард түмнээ төлөөлдөг учраас сонгогчид итгэл хөсөрдүүлсэн гэсэн үндэслэлээр бүрэн эрхийн хугацаанаас өмнө эгүүлэн татах журам байдаггүй гэж үздэг (Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ.2007. 226 дахь тал).

Монгол Улсын хувьд парламентын гишүүний мандатын шинжийг үндсэн хуулиар дам тогтоож өгсөн байдаг. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 23 дугаар зүйлд “Улсын Их Хурлын гишүүн бол нийт ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж заасан байдаг нь захирагдмал бус чөлөөт шинжийн мандаттай болохыг нь харуулж байна. Энэхүү агуулгаар авч үзвэл гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудал нь эрх зүйн хувьд боломжгүй мэт харагдаж байна. Гэвч парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татдаг олон оронд парламентын гишүүн нь захирагдмал бус чөлөөт мандаттай байна.

*Хүснэгт-1 Парламентын гишүүнийг эгүүлэн татдаг орнуудын  
парламентын гишүүний мандатын хэв шинж*

| <b>Чөлөөт мандаттай</b> |                                                                                                                                                                                                                               | <b>Захирагдмал мандаттай</b> |
|-------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|
| Улс орнууд              | АНУ, Австрали, Алжир, Белизе, Венесуэл, Гамби, Герман, Канад, Кени, Крибати, Лихтенштейн, Мьянмар, Негир, Палау, Панами, Тайвань, Тували, Унгар, Уганда, Чех, Шинэ зеланд, Швейцарь, Энэтхэг, Этиоп, Эквадор, Их Британи, ОХУ | Беларус, Куба, БНАСАУ, БНХАУ |

Дээрх хүснэгтээс харахад парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татдаг 31 орны дийлэнх нь хуулиараа “Чөлөөт” мандатын орчинг бүрдүүлжээ. Социалист үзэл санааг баримталсан, нэг нам төвт нийгмийн тогтолцоотой улс орнууд ч парламентын гишүүний цэвэр Императив мандатаас татгалзах болсон байна. Парламентын гишүүнийг императив мандаттай байлгах нь шийдвэр гаргагчид “нийгмийг бүхэлд нь цогц систем гэж үзэхгүй байгаагийн илрэл буюу онолын үүднээс зөв биш арга хандлагын тусгал” гэж үздэг ажээ<sup>8</sup>. Гэтэл парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудал нь Императив мандатын орчинд илүү тохиромжтой гэж үзэх хандлага байдаг. Ардчилсан орнуудын үндсэн хуулийн агуулга, үзэл санаа нь бүхэлдээ парламентын гишүүнд хэн ч тусгайлан үүрэг, даалгавар өгөх, хариуцлага ногдуулах эрхгүй” буюу чөлөөт мандатыг зөвшөөрч байна.

Гэвч сонгуулийн эрх зүйгээр мэргэшсэн судлаачдын (Францын М.Прело гэх мэт) үзэж байгаагаар улс төрийн нам төвт тогтолцоонд бодит байдалд парламентын гишүүн сонгуульд нэр дэвшихээс эхлэн сонгогчдоос төдийгүй улс төрийн намаас хараат байдалд байдаг. Иймд парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудлын мөн чанар, эрсдэл, боломж зэрэг хүчин зүйлийг эрх зүйн орчинд тодорхой уялдуулж чадсан тохиолдолд “Захирагдмал” мандаттай орнуудаас илүү “Чөлөөт” мандаттай улс орнуудад тохиромжтой гэж үзэх хандлага ч бас байна.

<sup>8</sup> Улсын Их Хурлын тамгын газрын судалгаа, шинжилгээний хэлтэс, Судалгааны эмхэтгэл. XVII боть. УБ.2014. 187 дахь тал).

Түүнчлэн улс орнуудын эрдэмтэн, судлаачид төлөөлөгчийн мандатын улс төр, эрх зүйн байдал болон халдашгүй бүрэн эрхийн баталгаа нь сонгогчдын саналаар эгүүлэн татахад хэрхэн нөлөөлөх асуудлаар судалгаа явуулж олон талын саналыг дэвшүүлсэн байдаг. Беларусийн эрдэмтэд аль ч шатны төлөөлөгчийг гаргасан зөрчил, алдаа дутагдалд нь тулгуурлан бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө эгүүлэн татах асуудал нь зайлшгүй байх ёстой хариуцлагын нэг хэлбэр, харин сонгогчдын саналаар эгүүлэн татаж буй нь өөрөө тухайн улсад Ардчилал төлөвшиж байгаагийн илэрхийлэл гэж үздэг байна.

### **Эрх зүйн зохицуулалт**

Парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татдаг улс орнуудад улс төрийн хариуцлагын энэхүү хэлбэрийг хуульчлан мөрдүүлдэг ч эрх зүйн баримт бичигт тусгагдсан байдал нь харилцан адилгүй байна. Тухайлбал, зарим улсад зөвхөн үндсэн хуульдаа парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах зохицуулалтыг тусгасан байх бөгөөд хэдийд эгүүлэн татах нөхцөл бүрдсэн гэж үзэх, хэдийд хориглох зэрэг ерөнхий заалтуудыг тусгаж өгсөн байна. Мөн хуульд тусгагдаагүй ч парламентын гишүүний ёс зүйн дүрэм, чуулганы хуралдааны дэгийн тухай журам зэрэг баримт бичигт нийгмийн хэм хэмжээг зөрчсөн гишүүний бүрэн эрхийг парламентаас нь түдгэлзүүлж, эгүүлэн татах эсэх асуудлыг сонгогчдоор нь шийдвэрлүүлдэг хувилбар цөөн оронд байна. Харин холбооны улс орнуудын хувьд Муж, БНУ тус бүр өөр өөр зохицуулалттай байна.

#### *Хүснэгт-2 Парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах харилцааг зохицуулсан улс орнуудын хууль, эрх зүйн орчин*

| Зөвхөн үндсэн хуульд эгүүлэн татах нөхцөлийг тусгасан | Үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулсан | Гишүүний ёс зүйн дүрэм зэрэг эрх зүйн актад гишүүнийг эгүүлэн татах заалттай |
|-------------------------------------------------------|----------------------------------------------|------------------------------------------------------------------------------|
| Куба                                                  | АНУ (муж тус бүр өөр)                        | БНХАУ <sup>9</sup>                                                           |
| Венесуэл                                              | Австрали                                     | Шинэ Зеланд                                                                  |
| Лихтенштейн                                           | Алжир                                        | Панами                                                                       |
| Палау                                                 | Беларусь                                     |                                                                              |
| Унгар                                                 | Гамби                                        |                                                                              |
| Чех                                                   | ИБУИНВУ                                      |                                                                              |
| БНАСАУ                                                | Канад                                        |                                                                              |
| Мянмарь                                               | Кени                                         |                                                                              |
| Уганда                                                | Крибати                                      |                                                                              |
|                                                       | Негир                                        |                                                                              |
|                                                       | Тайвань                                      |                                                                              |
|                                                       | Швейцарь (муж тус бүр өөр)                   |                                                                              |
|                                                       | Энэтхэг                                      |                                                                              |
|                                                       | Этиоп                                        |                                                                              |
|                                                       | Эквадор                                      |                                                                              |

<sup>9</sup> Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал ба бүх шатны орон нутгийн ардын төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар бүлэг “Депутатуудын үйл ажиллагаанд тавих хяналт, эгүүлэн татах, нэмэлт сонгууль явуулах журам” гэсэн бүлэгт хуульчлагдсан. [www.chinalawinfo.ru](http://www.chinalawinfo.ru)

|  |                         |  |
|--|-------------------------|--|
|  | Белизе                  |  |
|  | Герман                  |  |
|  | Тували                  |  |
|  | ОХУ(БН Улс тус бүр өөр) |  |

Хүснэгтээс үзэхэд үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулдаг хувилбарыг улс орнууд илүү түгээмэл ашигладаг болох нь харагдаж байна. Эдгээр орны туршлагаас авч үзэхэд үндсэн хуульдаа “парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татаж болно, татах эрхтэй байна” гэх зэргээр зааж сонгогчдын саналаар парламентын гишүүний бүрэн эрх (mandate)-ийг дуусгавар болох үндсэн нөхцөлийг тодорхойлсон байх бөгөөд бусад харилцааг холбогдох эрх зүйн бусад баримт бичгээр зохицуулахаар тусгасан байна.

### **Монгол Улсын хувьд**

Монгол Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх тохиолдолд юун түрүүнд ардчилсан ёс, эрх чөлөө, тэгш байдал, засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх тухай Үндсэн хуулийн заалтад тулгуурлан сонгогчдын саналаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх (mandate)-ийг дуусгавар болох нөхцөлийг тодорхойлж өгөх шаардлагатай. Ингэхдээ Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үйл явц нь төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар, сонгогч өөрийн үзэл бодолд тулгуурлан (*заавал гэм буруутай үйлдэлд нь тулгуурлах шаардлагагүй*)<sup>10</sup> эгүүлэн татах эрхтэй байх нөхцөлийг тусгаж өгөх нь зүйтэй юм. Тухайлбал, “Иргэн бүр төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй байхаас гадна хууль тогтоох байгууллагад сонгосон төлөөлөгчийнхөө үйл ажиллагааг **хангалтгүй** гэж үзвэл эгүүлэн татах асуудлыг дэвшүүлэх, хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй” зэргээр цэвэр улс төрийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг нь илүү тодотгож өгөх нь зүйтэй. Ингэж үндсэн хуульдаа тусгаагүй тохиолдолд парламентын гишүүнийг эгүүлэн татах үйл явц төрийн аль нэг байгууллага, албан тушаалтны шийдвэрээс хэт хамааралтай болж, бодит байдалд хэрэгждэггүй болохыг олон орны туршлага харуулж байна.

Харин гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах үйл явцтай холбоотой үүсэх бусад харилцааг бие даасан хуулиар тодорхой зохицуулж өгөх нь зүйтэй бөгөөд эгүүлэн татах үндэслэл, хэрэгжүүлэх процедур, сонгогчдын саналын хувь зэрэгт дор дурдсан асуудлуудыг анхаарах нь зүйтэй.

### **Эгүүлэн татах үндэслэлийн тухай**

Парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудлын үндсэн гол зохицуулалт нь эгүүлэн татах үндэслэлийг хууль, тогтоомжид хэрхэн тодорхойлж тусгах асуудал байдаг. Учир нь үүнээс шалтгаалан парламентын гишүүний бүрэн эрх (mandate)-ийг хэдийд түдгэлзүүлэх, хэдийд хориглох тухай хүрээ, хязгаарыг тогтоодог. Улс төрийн хариуцлагын энэхүү хувилбар нь парламентын тогтворгүй байдлыг үүсгэх, улс төр дэх намуудын хүчний харьцааг хууль бусаар өөрчлөх зэрэг олон сөрөг үр дагавар тул түүнээс

<sup>10</sup> Хэрэв парламентын гишүүнийг заавал гэм буруутай үйлдэл, үйл ажиллагаанд нь үндэслэн эгүүлэн татах зохицуулалттай бол энэ нь улс төрийн хариуцлага бус хуулийн хариуцлага гэж үзэхэд хүргэдэг бөгөөд түүний гэм буруутай эсэхийг нь тогтоох хуулийн байгууллагын оролцоо нэмэгддэг тул цэвэр сонгогчдын үзэд бодолд тулгуурлан улс төрийн хариуцлага хүлээлгэж буй хэлбэр бус болдог байна.

сэргийлэх арга зам нь эгүүлэн татах үндэслэлийг үндсэн хуульдаа маш тодорхой тусгаж, бусад арга хэлбэрээр татахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх гэж судлаачид үзэж байна.

Бусад орны зохицуулалтаас үзэхэд эгүүлэн татах үндэслэлийг цэвэр улс төрийн хариуцлага хүлээлгэх зорилгоор тодорхойлдог нь харагдаж байна. Жишээлбэл, Беларусь Улсад орон нутгийн болон төлөөлөгчдийн танхимын гишүүнийг сонгогчдын итгэлийг алдсан, хуульд заасан гишүүнийхээ үүргийг биелүүлээгүй, албаны нэр төр, алдар хүндийг гутаасан бол, Угандад нийгмийн хэм хэмжээг зөрчсөн, иргэдийн дунд нэр хүнд нь унасан бол, ИБУИНВУ-д сонгуулийн амлалтаа биелүүлээгүй, бусдын нөлөө, эрх ашигт автсан, санхүүгийн хувьд шударга бус эсхүл нэр төрд “сэвтэй” үйлдэл гаргасан, сонгогчдынхоо итгэлийг алдсан, АНУ-ын Жоржиад тангарагаа зөрчсөн, хуульд заасан гишүүний албан үүргээ биелүүлээгүй тус тус тохиолдолд парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татахаар заасан байна. Энэ байдлаар улс төрийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг илүү тодотгож хуульчилсан улс орнуудад сонгогчид нь төрийн аль нэг байгууллага, албан тушаалтнаас хамааралгүйгээр өөрийн үзэл бодлоор сонгосон төлөөлөгчдөө хариуцлага тооцох давуу талтай байна.

Харин цөөн оронд парламентын гишүүн хууль зөрчсөн, эх орноосоо урвасан зэрэг гэмт хэрэгт холбогдсон нь тогтоогдсон тохиолдолд сонгогчид эгүүлэн татаж болох тухай хуульчилжээ. Жишээлбэл АНУ-ын Миннесотад бүрэн эрхийн хугацаандаа хуульд заасан татварыг төлөөгүй, Вержиниад эрх мэдлээ урвуулан ашигласан, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл гаргасан, төрийн өмчид хохирол учруулсан гэж холбогдох байгууллагаас үзвэл эгүүлэн татах нөхцөл бүрддэг байна. Парламентын гишүүний гэм буруутай үйлдэл, үйл ажиллагаа, зөрчилд зэрэгт нь тулгуурлан эгүүлэн татах дээрх үндэслэл нь зарим сөрөг үр дагавартай болохыг судлаачид анхааруулж байна. Тухайлбал, дээрх үндэслэлүүдийн аль нэг нь бүрдсэн гэж сонгогчид үзээд эгүүлэн татах асуудлыг дэвшүүлэх тохиолдолд парламентын гишүүний гэм буруутай болохыг хуулийн байгууллага тодорхой баримт, нотолгоонд тулгуурлан тогтоох шаардлага үүснэ. Гэтэл энэ процесс нь бүхэлдээ хуулийн байгууллагын хяналт, эрх мэдлийн хүрээнд явагдах бөгөөд улс төрийн нам, төрийн өндөр албан тушаалтнуудын оролцоо нөлөө үүсэх эрсдэлтэй гэж судлаачид үзэж байна. Нөгөө талаар энэ үндэслэлээр эгүүлэн татах нь сонгогчдын хүсэл, сонирхлын илэрхийлэл биш бөгөөд гэм буруутай үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж буй учир улс төрийн хариуцлага гэхээс илүү хуулийн хариуцлагын нэг хэлбэр гэж үздэг байна.

Түүнчлэн ямар нэг үндэслэл шаардахгүйгээр парламентын гишүүнийг сонгогчдын саналаар шууд эгүүлэн татдаг орнууд ч байна. Тухайлбал, Канад, Негир зэрэг улсад ямар нэг үндэслэл шаардахгүйгээр парламентын гишүүнийг эгүүлэн татах эрхийг сонгогчид эдэлдэг байна. Эдгээр орны туршлагаас харахад сонгогчид итгэл үнэмшилдээ тулгуурлан сонгосон төлөөлөгчөө хэн нэгнээс хараат бусаар эгүүлэн татах эрх эдэлж байгаа ч эгүүлэн татах нөхцөл бүрдсэн эсэх асуудлаар тогтмол маргаан гарч, парламентын тогтвортой үйл ажиллагаанд саад учруулах, намууд улс төрийн зорилгоор уг асуудлыг хөндөх зэрэг сөрөг үр дагавартай байна.

### ***Монгол Улсын хувьд***

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй бүрэн эрх, парламентын тогтвортой байдал зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан улс төрийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг нь илүү тодотгож өгөх нь зүйтэй. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүний албан үүрэг, сонгуулийн амлалтаа хэрэгжүүлж буй байдал болон ёс зүй, нийгмийн хэм хэмжээг сахин биелүүлэхтэй холбоотой

зөрчлөөс, дутагдлаас бусад үндэслэлээр сонгогчдын саналаар эгүүлэн татахгүй байх нөхцөлийг хуульд тусгаж өгөх шаардлагатай. Мөн парламентын тогтвортой үйл ажиллагааг саатуулахгүй байх үүднээс дор дурдсан тохиолдолд эгүүлэн татахыг хориглох нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн эхний жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж буй байдал болон сонгуулийн амлалттай холбоотой аливаа үндэслэлээр эгүүлэн татахыг хориглох<sup>11</sup>;
2. Улсын Их Хурлын гишүүнийг зөвхөн тойргийн сонгогчид эгүүлэн татах саналыг дэвшүүлэх, хэлэлцэн шийдвэрлэх эрхийг эдлэх<sup>12</sup>;
3. Улс төрийн нам, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл болон бусад ашиг сонирхлын бүлгүүд гишүүнийг эгүүлэн татах асуудлыг дэвшүүлэх, эгүүлэн татах үйл явцад оролцох, нөлөөлөхийг хориглох;
4. Зөвхөн эрх бүхий байгууллагаас сонгогчдын дунд санал хураалт хэлбэрээр (*гарын үсэг цуглуулах, цахимаар санал хураах, уулзалт, цуглааны үеэр иргэдээс санал авах зэргийг хориглох*) зохион байгуулсан хэлэлцүүлгийг хүчинтэйд тооцох.

### ***Эгүүлэн татах саналыг дэвшүүлэх, сонгогчдоор хэлэлцүүлэх, эгүүлэн татах***

Гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах процедур улс орнуудад харилцан адилгүй үе шатуудтай байна. Улс орнуудын зохицуулалтыг ерөнхий байдлаар авч үзэхэд эгүүлэн татах саналыг дэвшүүлэх, сонгогчдоор хэлэлцүүлэх, эгүүлэн татах гэсэн 3 үндсэн үе шатыг дамжин хэрэгжиж байна.

Эгүүлэн татах саналыг дэвшүүлэх эрхийг ихэнх улсад зөвхөн тойргийн сонгогчид эдэлдэг бол цөөн хэдэн оронд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан санал, шийдвэрийг сонгогчид референдумыг замаар дэмжих буюу няцаах аргаар шийдвэрлэдэг хувилбар байна. Зөвхөн тойргийн сонгогчид эгүүлэн татах саналыг дэвшүүлэх эрхийг эдлэх нь улс төрийн болон бусад зорилгоор парламентын гишүүнийг эгүүлэн татахаас сэргийлэх, парламентын тогтвортой үйл ажиллагааг алдагдуулахгүй байх зэрэг давуу талтай гэж үздэг. Харин эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас эгүүлэн татах санал гаргаж байгаа хувилбар нь төдийлөн түгээмэл ашиглагддаггүй бөгөөд иргэдийн хүсэл сонирхлыг илэрхийлдэггүй, хэт нэг талын нөлөө, шийдвэрийн дор хэрэгждэг зэрэг сул талтай болох нь улс орнуудын туршлагаас харагдаж байна.

Иргэдээс гаргасан парламентын гишүүнийг эгүүлэн татах санал бүрийг тойргийн нийт сонгогчдоор хэлэлцүүлэх боломжгүй тул сонгогчдын тодорхой хувийн дэмжлэгийг авсан санаачилгыг хэлэлцүүлэхээр журамласан байна. Мөн хүн ам цөөнтэй, сонгуулийн жижиг тойрогтой зарим улсад сонгогчдын тооноос хамаарч хувь, хэмжээ нь тойрог бүр дээр харилцан адилгүй байхаар зохицуулжээ. Тухайлбал, Филиппинд сонгогчдосон албан тушаалтныг эгүүлэн татахад 70.000 хүртэл сонгогчтой бол 20-оос багагүй хувь, 70.000-300.000 бол 15-аас багагүй хувь, 300.000 дээш бол 10-аас доошгүй хувь нь дэмжсэн үед тойргийн сонгогчдын дунд эгүүлэн татах эсэх асуудлаар санал хураалт зохион байгуулдаг байна. Түүнчлэн зарим улсад тухайн парламентын гишүүн сонгогчдосон жилийн сонгуульд оролцож саналаа өгсөн иргэд л

<sup>11</sup> Улс орнуудын туршлагаас үзэхэд парламентын гишүүнээр сонгогдсон эхний жил бүрэн эрхээ хэрэгжүүлэх, сонгуулийн амлалтаа биелүүлэх хангалттай хугацаа биш гэж үздэг тул энэ хугацаанд уг үндэслэлээр эгүүлэн татахыг хязгаарладаг нийтлэг жишиг байна.

<sup>12</sup> Улс төрийн нам, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл болон бусад сонирхлын бүлгүүдийн зүгээс парламентын гишүүнд нөлөөлөх, өөрт ашигтай шийдвэр гаргуулах зорилгоор түүнийг эгүүлэн татах асуудлыг гишүүнчлэлээрээ дамжуулан илэрхийлэх эрсдэлтэй байдаг учир улс орнууд парламентын гишүүнийг зөвхөн сонгосон тойргийн иргэд нь эгүүлэн татах эрхтэй байхаар зохицуулж өгсөн байдаг.

эгүүлэн татах санал хураалтад оролцох эрхтэй байна. Энэ нь төлөөллийн асуудалтай холбоотойгоос гадна өөр тойргийн сонгогчид эгүүлэн татах санал хураалтын дүнд нөлөөлөхөөс сэргийлдэг байна.

Гишүүний бүрэн эрхийг нь дуусгавар болгох процедур улс орнуудад мөн харилцан адилгүй байдлаар зохицуулагдсан байна. Ихэнх улсад тойргийн нийт сонгогчдын санал хураалтаар эгүүлэн татах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд парламент эсхүл сонгуулийн ерөнхий хорооноос нь уул гишүүний мандатыг хүчингүй болгож, эгүүлэн татдаг байна. Өөрөөр хэлбэл эдгээр оронд эгүүлэн татах асуудлыг сонгогчид нь эцэслэн шийдвэрлэж байгаа бөгөөд тухайн улсын парламент нь зөвхөн соёрхон батлах үүрэгтэйгээр оролцож байна. Цөөн хэдэн оронд тойргийн сонгогчдын санал хураалтаар эгүүлэн татах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд парламентаар хэлэлцэж дийлэнх олонхын саналаар эгүүлэн татсанд тооцож байна.

### ***Монгол Улсын хувьд***

Сонгуулийн 76 жижиг тойрогтой, тухайн тойргууд дахь сонгогчдын тоо нь бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй цөөн зэрэг өвөрмөц онцлогтой учир Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах процедурыг эрх зүйн орчинд илүү тодорхой, нарийвчилсан байдлаар зохицуулж өгөх шаардлагатай. Ингэснээр улс төрийн намууд болон төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл зэрэг сонирхлын бүлгүүд улс төрийн болон бусад зорилгоор эгүүлэн татах процедурд нөлөөлөх эрсдэлийг хязгаарлана. Мөн процедурд оролцогчдын эрх хэмжээг тодорхой болгосноор эрх бүхий байгууллага, албан тушаалтны нөлөөг багасгана гэж үзэж байна.

Гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах зохицуулалтыг дараах байдлаар үе шат бүрийг нь нарийн тодорхой байдлаар дэлгэрэнгүй зохицуулж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

### **Эгүүлэн татах асуудлыг дэвшүүлэх:**

- Эгүүлэн татах санаачилга гаргах (*Эрх зүйн чадамжтай, 18 нас хүрсэн дурын иргэн буюу сонгогч өөрийн тойргоос сонгогдсон гишүүнийг эгүүлэн татах санал гаргах эрхтэй байх. Мөн эгүүлэн татах санал гаргах эрхгүй байх субъектуудыг тодорхой дурдаж өгөх шаардлагатай. Тухайлбал, улс төрийн намын албан тушаалтан, ашиг сонирхлын зөрчилтэй этгээд гэх зэргээр зааж өгөх*).
- Эгүүлэн татах асуудлаар сонгогчдын цуглаан санаачлах (*Эгүүлэн татах саналыг дурын сонгогч гаргах эрхтэй ч тойргийн нийт сонгогчдоор хэлэлцүүлэхийн тулд тойргийн сонгогчдын тодорхой хувийн дэмжлэг авсан байх шаардлагыг тусгаж өгөх. Тухайлбал, тойргийн 250-аас доошгүй тооны сонгогчид эгүүлэн татах нь зөв хэмээн үзсэн тохиолдолд*<sup>13</sup> **Сонгогчдын цуглаан** зохион байгуулах хүсэлтийг гаргах эрхтэй болох).
- Сонгогчдын цуглаан зохион байгуулагдах (*Дээрх тооны сонгогчид санал нийлсэн тохиолдолд эгүүлэн татах цуглаан зохион байгуулах хүсэлт Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр гаргах эрхтэй байх. Энэхүү хүсэлтэд тухайн гишүүнийг эгүүлэн татах болсон үндэслэл, санаачлагдын сонгогчийн мэдээллийг заавал тусгаж, гарын үсгээ зурж баталгаажуулсан байх шаардлагыг тусгах. Сонгуулийн ерөнхий хороо энэхүү шатанд эгүүлэн татах болсон үндэслэл нь Үндсэн хууль болон бусад хуульд*

<sup>13</sup> Улсын Их Хурлын сонгуулийн 76 жижиг тойрог дахь сонгогчдын дундаж нь 25.000 байдаг бөгөөд үүний 1 хувь нь гэж үзэхэд 250 ба түүнээс дээш сонгогч дэмжсэн байх шаардлагатай болно.

нийцээж буй эсэх, санаачлагчдын сонгогчийн мэдээллийг шалгаж тухайн тойргийн сонгогч мөн эсэх, өмнөх сонгуульд оролцсон байдал зэргийг нягталж хариу хүргүүлэх үүрэгтэй байх. Хэрэв зөвшөөрсөн бол сонгогчдын цуглаан зохион байгуулах товыг хүргүүлэх, зөвшөөрөөгүй бол үндэслэлийг нь тодорхой дурдаж хариу мэдэгдэх үүрэгтэй байх. Санаачлагчид үүнтэй санал нийлэхгүй бол шүүхэд гомдол гаргаж болохоор зохицуулах).

- Сонгогчдоос гарын үсэг цуглуулах, Сонгуулийн ерөнхий хороонд хүсэлт гаргах багийг томилох (Сонгуулийн ерөнхий хорооноос зөвшөөрөл өгсөн тохиолдолд тухайн товын дагуу цуглаан зохион байгуулах бөгөөд ирсэн байх шаардлагатай сонгогчдын тоог тогтоож өгөх. Цуглаанаар гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хэлэлцээд дэмжсэн тохиолдолд тойргийн нийт сонгогчдын дунд эгүүлэн татах санал хураалт зохион байгуулахыг дэмжсэн иргэдийн гарын үсгийг цуглуулах баг, бүрэлдэхүүнийг эндээс томилох. Эдгээрийг хэлэлцсэн тухай цуглааны протоколыг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэхээр тусгах).
- Сонгогчдын гарын үсгийг цуглуулах (Цуглааныг зохих журмын дагуу явагдсан бөгөөд оролцогчид эгүүлэн татах санал хураалт явуулах нь зөв гэж үзсэн тухай протокол бусад мэдээлэлд тулгуурлан сонгуулийн ерөнхий хорооноос гарын үсгийг цуглуулах эрх бүхий багийг бүртгэж, зөвшөөрөл олгох. Мөн зөвшөөрөл олгогдсон өдрөөс тодорхой хугацааны дотор гарын үсгийг цуглуулсан байхаар тусгах. Хэрэв заасан хугацаанд шаардлагатай тооны гарын үсэг цуглуулж чадаагүй бол гарын үсэг цуглуулах ажиллагааг зогсоох эрхтэй байх нь зүйтэй).
- Санал хураалт зохион байгуулах шийдвэр гаргах (Тогтоосон хугацаанд шаардлагатай тооны гарын үсгийг цуглуулсан бол энэхүү процесс нь хуулийн дагуу явагдсан эсэхийг сонгуулийн ерөнхий хороо хянан үзээд тойргийн нийт сонгогчдын дунд эгүүлэн татах эсэх асуудлаар санал хураалт зохион байгуулах шийдвэрийг гаргах нь зүйтэй).

*Хүснэгт-3 Тойргийн сонгогчдын хэдэн хувийн дэмжлэгийг авсан тохиолдолд эгүүлэн татах санал хураалт зохион байгуулдаг талаар*

| № | Улс орнууд  | Сонгуулийн тойргийн тоо         | Нэг тойрог дахь хүн амын дундаж тоо  | Сонгогчдын хувь |
|---|-------------|---------------------------------|--------------------------------------|-----------------|
| 1 | Австрали    | Сенатын 76<br>Төлөөлөгчдийн 150 | Сенат 200.000<br>Төлөөлөгчид 100.000 | 10%             |
| 2 | Беларусь    | 110                             | 63.000                               | 20%             |
| 3 | Венесуэл    | 24 <sup>14</sup>                | 120.000 <sup>15</sup>                | 20%             |
| 4 | Шинэ Зеланд | 71 <sup>16</sup>                | 25.000 <sup>17</sup>                 | 10%             |
| 5 | Энэтхэг     | 36 <sup>18</sup>                | 1.5 саяаас 36 сая хүртэл             | 10%             |

<sup>14</sup> Үндэсний асамблейн 167 гишүүний 113-г нь сонгуулийн нийт 24 тойргоос сонгодог. Үүний 23 тойрог нь 2-12, 1 тойрог нь 1 мандаттай. 51 гишүүнийг пропорционалиар сонгодог, 21 тойргоос 2-г, 3 тойргоос 3-г нь сонгодог.

<sup>15</sup> Нийт 20,526,978 сонгогч бүртгэлтэй /2018.05.20/. Үндэсний асамблейн 167 гишүүнд хуваахад дунджаар 120 мянга орчим хүн 1 сонгуулийн тойрогт байдаг гэж үзэж болох юм. Гэхдээ заримыг нь пропорциональ гэдгийг тооцох хэрэгтэй.

<sup>16</sup> Сонгуулийн тойргийн тоо өөрчлөгддөг /2006 онд 70 тойрог байсан/. Хамгийн сүүлд буюу 2017 оны сонгуульд 71 тойрог болсон.

<sup>17</sup> 120 гишүүний 71-г мажоратор, 49-г жагсаалтаар сонгодог. Нийт 3.57 сая сонгогч бүртгэлтэй. /Парламентын сонгууль 2017.09.23/

<sup>18</sup> 545 гишүүнтэй Лок Сабхатай, 2019 оны сонгуульд 543 гишүүнийг сонгож, 2 гишүүнийг томилсон. 1-80 хүртэл мандаттай 36 сонгуулийн тойрогтой /29 муж, 7 холбооны тойрог/.

Харин Монгол Улсын Их Хурлын 2015 оны сонгуулийн тухай хуульд зааснаар Улсын Их Хурлын 76 гишүүнийг тус бүр нэг мандаттай 76 жижиг тойргоос сонгосон. Үүнийг дэлгэрэнгүй авч үзвэл.

*Хүснэгт-4 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог,  
тойрог дахь сонгогчдын тоо*

| №                   | Аймаг                    | Хэдэн<br>тойрогтой<br>болох | Бүртгэлтэй сонгогч | Нэг тойрог дахь<br>сонгогчдын дундаж тоо |
|---------------------|--------------------------|-----------------------------|--------------------|------------------------------------------|
| 1                   | Архангай                 | 3                           | 59.538             | 19.846                                   |
| 2                   | Баян-Өлгий               | 3                           | 56.537             | 18.845                                   |
| 3                   | Баянхонгор               | 3                           | 55.609             | 18.536                                   |
| 4                   | Булган                   | 1                           | 39.490             | 39.490                                   |
| 5                   | Говь-Алтай               | 1                           | 35.501             | 35.501                                   |
| 6                   | Говьсүмбэр,<br>Дорноговь | 2                           | 51.894             | 25.947                                   |
| 7                   | Дорнод                   | 2                           | 49.440             | 24.720                                   |
| 8                   | Дундговь                 | 1                           | 29.659             | 29.659                                   |
| 9                   | Завхан                   | 2                           | 45.370             | 22.685                                   |
| 10                  | Өвөрхангай               | 3                           | 72.316             | 24.105                                   |
| 11                  | Өмнөговь                 | 2                           | 40.831             | 20.415                                   |
| 12                  | Сүхбаатар                | 1                           | 38.692             | 38.692                                   |
| 13                  | Сэлэнгэ                  | 3                           | 68.704             | 22.901                                   |
| 14                  | Төв                      | 3                           | 60.449             | 20.149                                   |
| 15                  | Увс                      | 3                           | 51.890             | 17.296                                   |
| 16                  | Ховд                     | 3                           | 51.418             | 17.139                                   |
| 17                  | Хөвсгөл                  | 3                           | 84.920             | 28.306                                   |
| 18                  | Хэнтий                   | 3                           | 46.916             | 15.638                                   |
| 19                  | Дархан-Уул               | 3                           | 63.285             | 21.095                                   |
| 20                  | Орхон                    | 3                           | 64.757             | 21.585                                   |
| <b>Улаанбаатар</b>  |                          |                             |                    |                                          |
| 22                  | Баянзүрх                 | 6                           | 201.761            | 33.626                                   |
| 23                  | Хан-Уул                  | 4                           | 98.216             | 24.554                                   |
| 24                  | Сүхбаатар                | 4                           | 103.619            | 25.904                                   |
| 25                  | Чингэлтэй                | 4                           | 124.476            | 31.119                                   |
| 26                  | Баянгол                  | 4                           | 125.023            | 31.255                                   |
| 27                  | Сонгинохайрхан           | 6                           | 190.736            | 31.789                                   |
| <b>Улсын дундаж</b> |                          |                             |                    |                                          |
| <b>Нийт</b>         |                          | <b>76</b>                   | <b>1.911.047</b>   | <b>25.145</b>                            |

/2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн дүн мэдээ/ Сонгуулийн ерөнхий хороо

Дээрх хүснэгтээс харахад Улсын Их Хурлын 2016 оны сонгуульд 76 тойрогт нийт 1.911.047 сонгогч бүртгэгдсэн байгаа ба улсын дунджаар сонгуулийн нэг тойрог дахь сонгогчдын дундаж тоо нь 25.000 байна. Энэ нь сонгуулийн тойрог дахь сонгогчдын тоо нь бусад орнуудаас харьцангуй цөөн болохыг харуулж байна. Ийм нөхцөлд гишүүнийг эгүүлэн

татах санал хураалт зохион байгуулахыг дэмжсэн байх шаардлагатай сонгогчдын хувийг бусад орнуудын жишгээр 10-20 хүртэл хувиар тогтоох нь олон эрсдэлийг дагуулж болзошгүй. Учир нь сонгуулийн тойргууд дахь сонгогчдын тоо нь улсын дунджаар 25.000 байгаа нөхцөлд бусад орнуудын адилаар 10 хувиар тогтоож өгвөл 2500 орчим сонгогчийг цуглуулахад л эгүүлэн татах санал хураалтыг зохион байгуулаад байх эрх үүсэхээр байна. Энэ нь өнөөгийн бодит нөхцөлд энэ хэмжээний ажилтантай аж ахуйн нэгжийн захирал хувийн эрх ашгийн үүднээс гишүүнийг татах асуудлыг сонгогчдоор хэлэлцүүлээд байх боломжийг олгохоор байна.

Мөн газар нутгийн онцлог, хүн амын тархан суурьшсан байдал, үндэстний бүтэц зэрэг хүчин зүйлээс шалтгаалан Улсын Их Хурлын сонгуулийн тойргуудын хуваарилалт харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Булган аймаг сонгуулийн нэг тойргоос нэг гишүүн сонгогдож, 33.490 сонгогчийг төлөөлсөн байхад Хэнтий аймаг 3 тойргоос гурван гишүүн сонгогдож нийт 46.916 сонгогчийг төлөөлсөн байна. Түүнчлэн аймгуудаас сонгогдсон гишүүд болон Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүдийн иргэдийг төлөөлж буй байдал нь харилцан адилгүй байна.

#### *Иймд*

*Нэгдүгээрт, тойргийн сонгогчдын дунд Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах санал хураалт зохион байгуулахыг дэмжсэн байх шаардлагатай иргэдийн хувь, хэмжээг тогтоохдоо бусад улс орнуудаас өндөр тогтоож өгөх.*

*Хоёрдугаарт, Филиппины туррлагаар сонгуулийн тойргийн сонгогчдын тооноос хамаарч хувь хэмжээ нь харилцан адилгүй байхаар зохицуулж өгөх нь шаардлагатай гэж үзэж байна.*

#### **Санал хураалт зохион байгуулах:**

- Эгүүлэн татах санал хураалтын өдрийг товлон зарлах (*Гишүүнийг эгүүлэн татах санал хураалтын товыг сонгогчдын хангалттай тооны гарын үсэг цуглаж, албан ёсоор хүсэлт гаргасан өдрөөс хойш тодорхой хугацааны дотор Сонгуулийн ерөнхий хороо тогтоох. Мөн эгүүлэн татах санал хураалтыг зохион байгуулах шийдвэр гаргасан талаараа олон нийтэд зарлан мэдээлэх, сонгуультай холбоотой бэлтгэл ажлыг хангах үүргийг Сонгуулийн ерөнхий хороо хүлээх нь зүйтэй*).
- Эгүүлэн татах сонгуулийг хүчинтэйд тооцох (*Тухайн тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын 50 буюу түүнээс дээш хувь нь санал хураалтад оролцсон бол хүчинтэйд тооцох. Хэрэв оролцоогүй бол нэмэлт саналт хураалт явуулахгүй байх нь зүйтэй бөгөөд хүчингүй болсонд тооцох. Учир нь гишүүнийг эгүүлэн татах процедур нь сонгогчдын хүсэл, сонирхлын илэрхийлэл гэж үзэх нь зөв бөгөөд оролцоогүй сонгогчдыг уг асуудлыг дэмжээгүй гэж үзэх. Харин санал хураалт зохион байгуулагдахаар товлосон өдөр сонгогчдын санал өгөх боломжийг харьяалах байгууллагууд нь хангах талаар хуульд тусгаж өгөх шаардлагатай*).
- Санал тоолох, дүнг Монгол Улсын Их Хуралд танилцуулах (*Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулалт, санал хураалтын явц, үр дүн болон бусад процедур хуулийн дагуу явагдсан эсэхийг нягталж тогтоол гарган Монгол Улсын Их Хуралд танилцуулах. Санал хураалтад оролцсон сонгогчдын олонх буюу 50+1 хувь эгүүлэн татахыг дэмжсэн тохиолдолд тухайн гишүүнийг эгүүлэн татсанд тооцох нь зүйтэй*).

**Гишүүний бүрэн эрхийг дүүсгавар болгож, эгүүлэн татах:**

- Монгол Улсын Их Хурлаас гишүүнийг эгүүлэн татах тогтоолыг баталгаажуулах (Энэ шатанд сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн эгүүлэн татсанд тооцох тухай тогтоолыг Улсын Их Хурал хэлэлцээд соёрхон батлах үүрэг хүлээх, сонгогчдын гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, нөлөөлөх эрхгүй байх. Ихэнхи оронд тойргийн нийт сонгогчдын санал эцсийн шийдвэр байхаар зохицуулагдсан байдаг бол цөөн оронд тойргийн сонгогчдын саналыг парламент хэлэлцээд эцэслэн шийдвэрлэдэг. Парламент эгүүлэн татах асуудлыг шийдвэрлэдэг оронд тодорхой ашиг сонирхлын үүднээс гишүүнийг татахгүй авч үлдэх, эгүүлэн татах процесст нөлөөлөх зэрэг эрсдэл үүсч буй туршлага байна).
- Улсын Их Хурлын гишүүний эрхийг хамгаалах (Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу түр хороо<sup>19</sup> байгуулж гишүүний эрх зөрчигдөх, эгүүлэн татах процедур хуулийн дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих эрхийг хэрэгжүүлэх. Сонгуулийн ерөнхий хорооноос гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах санал хураалт зохион байгуулах шийдвэрийг гаргасан үеээс эхлэн Монгол Улсын Их Хурлаас хяналт тавих үүрэг бүхий “Түр хороо” байгуулах эрхтэй байх нь зүйтэй. Түр хороо нь эгүүлэн татах үйл явцад гишүүний эрх зөрчигдсөн, хуулийн дагуу явагдаагүй гэж үзвэл холбогдох албан тушаалтанд зөвлөмж боловсруулан хүргүүлнэ. Мөн зөрчлийг арилгах хүртэл эгүүлэн татах процессийг түдгэлзүүлэх эрхийг эдлэх ч бүхэлд нь хүчингүй болгох эрхгүй байна).

**Эгүүлэн татах процесст оролцогчдын эрх хэмжээ, тэнцвэр**

Эгүүлэн татах процедурд оролцогчдын эрх хэмжээг улс орнууд харилцан адилгүй байдлаар тогтоож өгсөн байдаг. Тухайлбал дийлэнх улсад тойргийн сонгогчид нь эгүүлэн татах бүх үе шатанд давуу эрхтэй оролцдог бол зарим улсад сонгуулийн төв байгууллага нь давуу эрх эдэлдэг байна. Мөн цөөн улсад эгүүлэн татах асуудлыг парламент нь хянаж байх нь зүйтэй гэж үздэг бөгөөд парламентын дарга бусдаас харьцангуй давуу эрх эдэлдэг ажээ. Сонгогчдын саналаар эгүүлэн татдаг орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлахад төрийн удирдлага, засаглалын хэлбэрээс<sup>20</sup> шалтгаалан эгүүлэн татах процедурд оролцогчдын эрх хэмжээ нь харилцан адилгүй байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн болон Парламентын, Үндсэн хуульт хаант засаглалтай орнуудад сонгогчдын саналаар эгүүлэн татах санал гаргах, эцэслэн шийдвэрлэх эрх дийлэнхдээ сонгогчдод хадгалагдаж байгаа бол Социалист засаглалтай орнуудад сонгогчид эгүүлэн татах санал гаргаж, эрх баригчид шийдвэрлэдэг хувилбар илүү түгээмэл байна. Эгүүлэн татах асуудалд эрх баригчид давуу эрх эдэлж байгаа энэ хувилбарыг судлаачид сонгогчдын саналаар гишүүнд хариуцлага хүлээлгэж буй хэлбэр биш бөгөөд бодит байдалд эрх бүхий байгууллага, албан тушаалтан л эгүүлэн татах эсэхийг эцэслэн шийдвэрлэдэг гэж шүүмжилж байна.

<sup>19</sup> Монгол Улсын Их Хурлын 25 дугаар зүйлд Тодорхой асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухай бүр тогтооно. Түр хороо нь хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангахдаа Байнгын хороотой адил эрх эдэлнэ. Түр хороо нь хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангаж, ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулан зохих шийдвэр гаргуулмагц түүнийг Улсын Их Хурал татан буулгана гэж заасан байдаг.

<sup>20</sup> Эрдэмтэн, судлаач болон улс төрийн шинжлэх ухааны олон улсын салбар хүрээлэнгүүд улс орнуудыг төрийн удирдлагын хэлбэрийн хувьд янз бүрээр ангилан хуваасан байдаг нь багагүй маргаан дагуулдаг. Нийтлэгээр төрийн эрх мэдлийг хэн хэрэгжүүлж байгаагаар нь Бүгд Найрамдах ба Хаант гэж хуваадаг. Бүгд Найрамдах Улс нь Ерөнхийлөгчийн, Хагас Ерөнхийлөгчийн, Парламентын засаглалд хуваагддаг. Харин Хаант засаг нь хэмжээт болон хэмжээгүй эрхт засаг гэх бөгөөд Хэмжээт эрхт засаг нь Үндсэн хуульт хаант засаг, хоёрдмол шинж бүхий засаглал гэж ангилж байна.

### **Монгол Улсын хувьд**

Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах үйл явцад тойргийн сонгогчид давуу эрхтэйгээр оролцох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь эгүүлэн татах үйл явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь давуу эрхтэй оролцсоноор сонгогчдын хүсэл сонирхол бодит байдалд хэрэгжих боломжийг хязгаарладаг болохыг олон орны бодит туршлага харуулж байна. Жишээлбэл, Беларусь Улсад парламентын гишүүнийг эгүүлэн татахын тулд эхний шатанд заавал сонгогчдын цуглааныг зохион байгуулсан байх шаардлагатай байдаг бөгөөд цуглаан зохион байгуулах зөвшөөрлийг парламентаас авдаг байна. Гэтэл бодит байдалд парламентаас эгүүлэн татах хангалттай үндэслэл бүрдээгүй, баримт бичгийн бүрдэл дутуу гэх зэрэг шалтгааныг дурдаж цуглаан зохион байгуулах зөвшөөрлийг олгодоггүй байна. Үүнийг батлах нэг жишээ нь Беларусь Улсад 2007 онд буюу 1 жилийн хугацаанд сонгогчдоос парламентын гишүүнийг эгүүлэн татах 30 гаруй удаагийн санал гарч байсан боловч нэг нь ч цуглаан зохион байгуулах зөвшөөрлөө парламентаасаа авч чадаагүй байна. Мөн тойргийн нийт сонгогчдын санал хураалтын дүнгээр парламентын гишүүнийг эгүүлэн татах нь зүйтэй гэж үзсэн ч эцсийн шийдвэрийг парламент нь гаргадаг тул эгүүлэн татах зохицуулалт нь бодит байдалд тун ярвигтай асуудал байдаг ажээ.

Эндээс үзэхэд Улсын Их Хурлын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах процедурт сонгогчид давуу эрхтэйгээр оролцох нь зүйтэй боловч бусад субъектүүдийн эрх, үүргийг тэнцвэртэй хангаж өгөх шаардлагатай ажээ. Тухайлбал,

- Сонгогчид нам, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар өөрийн сонгосон гишүүнийг эгүүлэн татах саналыг дэвшүүлэх, энэхүү асуудлаар цуглаан зохион байгуулах, эгүүлэн татах санал хураалт явуулах хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй байх. Мөн тойргийн нийт бүртгэлтэй сонгогчдын олонх оролцсон буюу ирцийг хангалттай бүрдүүлсэн санал хураалтын дүнгээр эгүүлэн татах нь зүйтэй гэж үзвэл тэр нь эцсийн шийдвэр байх бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтнаас энэхүү шийдвэрийг хэлэлцэх, хүчингүй болгох эрхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь нэгэнт сонгогчдын олонх нь сонгосон төлөөлөгчөө эгүүлэн татахыг дэмжсэн тул энэхүү шийдвэрийг байгууллага, албан тушаалтан хэлэлцэх, цааргалах эрхгүй. Харин сонгогчид эгүүлэн татах үе шатуудад Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжийг дагаж мөрдөх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавих хууль ёсны шаардлагыг биелүүлэх зэрэг үүрэг хүлээнэ.
- Сонгуулийн төв байгууллагын хуульд зааснаар Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж, явуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо мөн тул эгүүлэн татах санал хураалтыг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг нэгтгэн “Тогтоол” батлах үүрэгтэй байх нь зөв гэж үзэж байна. Энэхүү тогтоол нь эгүүлэн татах санал хураалт хуулийн дагуу явагдсан эсэх, саналаа өгсөн нийт сонгогчдын олонх нь гишүүнийг эгүүлэн татахыг дэмжсэн эсэхийг баталгаажуулах баримт болно. Харин сонгуулийн ерөнхий хороо эгүүлэн татах процедур хуулийн дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавих, хууль зөрчигдсөн гэж үзвэл зөрчлийг арилгах хүртэл эгүүлэн татах процедурыг түр түдгэлзүүлэх эрхтэй байх нь зүйтэй. Гэхдээ сонгогчдын гаргасан эгүүлэн татах санал, зохион байгуулсан цуглаан, цуглуулсан гарын үсэг зэргийг хүчингүй болгох, эгүүлэн татах асуудлыг бүхэлд нь цуцлах эрхгүй байна.
- Парламент нь тойргийн сонгогчдын дийлэнх гишүүнийг эгүүлэн татахыг дэмжсэн тухай Сонгуулийн ерөнхий хорооноос гаргах тогтоолд үндэслэн зөвхөн “Соёрхон батлах”

үүрэгтэй оролцох бөгөөд сонгогчдын эгүүлэн татах шийдвэрийг хэлэлцэх, цааргалах эрхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна. Гэхдээ гишүүний бүрэн эрхийг Улсын Их Хурлын шийдвэрээр баталгаажуулдаг тул эгүүлэн татах асуудлыг нэгдсэн чуулганы хуралдаанд танилцуулж батлуулах шаардлагатай. Монгол Улсын Их Хурал эгүүлэн татах процедурд хяналт тавих үүрэгтэй “түр хороо”-г байгуулж, гишүүний бүрэн эрх зөрчигдөх асуудалд хяналт тавих эрхтэй байх нь зүйтэй. Жишээлбэл, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан түр хороо<sup>21</sup> нь эгүүлэн татах процедур хуулийн дагуу явагдаж буй эсэх, гишүүний эрх зөрчигдөх асуудалд хяналт тавих эрхийг эдэлнэ.

### *Дүгнэлт*

Энэ бүхнээс үзэхэд парламентын гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах энэхүү арга хэлбэр нь улс төрийн шинжлэх ухаанд төдийлөн судлагдаагүй сэдэв болох нь харагдаж байна. Мөн улс орнуудын төрийн удирдлага, засаглалын хэлбэр, иргэдийн улс төрийн соёл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан улс орон бүрд өөр өөр үр нөлөөтэй байгааг анхаарч авч үзэх шаардлагатай аж. Нөгөөтэйгүүр эгүүлэн татах процедурд оролцогчдын эрх хэмжээ, хяналт, тэнцэлийг тогтоож өгөхгүй байх нь парламентын тогтворгүй байдлыг үүсгэх, парламент дахь хүчний харьцааг хууль бусаар өөрчлөх зэрэг сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй байна.

Иймд гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэх тохиолдолд мандатын хэв шинж, бүрэн эрхийн тухай асуудал, эгүүлэн татах үндэслэл, оролцогч субъектуудын эрх хэмжээ зэргийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид маш тодорхой тусгаж өгөх нь шаардлагатай гэж үзэв.

### *Abstract*

In an effort to improve discipline and accountability of elected members of the Mongolian parliament, calls for legislative recall mechanisms have gained momentum in recent years. Though such practice is fairly uncommon, the notion of creating a mechanism which would allow voters to be able to exercise control over elected officials and hold those who have failed to represent their constituents' best interests accountable has become increasingly popular. This paper aims to highlight key factors to be taken into consideration if such a procedure is to be legislated.

### *Ашигласан ном, зохиолын жагсаалт*

#### *Ном, зохиол*

- Улсын Их Хурлын судалгаа шинжилгээний хэлтэс. “Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагаа, гишүүний ёс зүй, хариуцлага” сэдэвт хэлэлцүүлэг 2018.05.13. Улаанбаатар хот
- Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. 2008 он Улаанбаатар хот
- П.Амаржаргал Парламентын онол, үзэл баримтлалын асуудал. 2015 он Улаанбаатар хот

#### *Цахим эх сурвалж:*

- <https://www.mmtimes.com/opinion/16253-why-mps-fear-the-right-of-recall-bill.html>

<sup>21</sup> Монгол Улсын Их Хурлын 25 дугаар зүйлд Тодорхой асуудлыг шалган судалж санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий түр хороог Улсын Их Хурлын тогтоолоор байгуулан ажиллуулж болно. Түр хороо зөвхөн гишүүдээс бүрдэх бөгөөд түүний бүрэлдэхүүн, ажиллах хугацааг тухай бүр тогтооно. Түр хороо нь хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангахдаа Байнгын хороотой адил эрх эдэлнэ. Түр хороо нь хариуцуулсан ажлын гүйцэтгэлийг хангаж, ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулан зохих шийдвэр гаргуулмагц түүнийг Улсын Их Хурал татан буулгана гэж заасан байдаг.

- [http://www.revparl.ca/english/issue.asp?param=149&art=1001&fbclid=IwAR37rzQGaO\\_L-RRdBM9NPekCRaxa-x\\_TnGx-7zC\\_KZc80RNhu58SK5IMzTs](http://www.revparl.ca/english/issue.asp?param=149&art=1001&fbclid=IwAR37rzQGaO_L-RRdBM9NPekCRaxa-x_TnGx-7zC_KZc80RNhu58SK5IMzTs)
- <sup>1</sup>[http://www.parl.ca/DocumentViewer/en/36-2/bill/C-269/first-reading/page-31?fbclid=IwAR1F1X39zx\\_1nZtm7UsQ\\_Hxb\\_jdemQtzgs-e8YNdZzgxtdp-mqX2kQHK3ig](http://www.parl.ca/DocumentViewer/en/36-2/bill/C-269/first-reading/page-31?fbclid=IwAR1F1X39zx_1nZtm7UsQ_Hxb_jdemQtzgs-e8YNdZzgxtdp-mqX2kQHK3ig)

## **БНСУ-ЫН 21 ДЭХ УДААГИЙН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

**Э.Саранцэцэг**

БНСУ-ын Сүншил их сургуулийн

Улс төр судлалын докторант

### ***Товч хураангуй***

Дэлхий нийт сонгуулийн тухай бодох ч сөхөөгүй, COVID19 хэмээх халдварт өвчний тархалттай борви бохисхийлгүй тэмцэж буй хүнд үед БНСУ парламентын ээлжит сонгуулиа хойшлуулалгүй, товлосон хугацаандаа амжилттай зохион байгуулсан төдийгүй, халдварт өвчнийг хяналтандаа авч чадсанаар дэлхий дахины анхаарлыг татаж байна. Тиймээс БНСУ-ын 21 дэх удаагийн парламентын сонгуулиа явуулсан нөхцөл байдал, онцлогийн талаар товч бичихийг зорилоо.

**Түлхүүр үг:** Парламентийн сонгууль, Үндэсний Ассамблей, сонгуулийн тухай хууль, сонгогч, нийгэм эдийн засаг, ажил эрхлэлт

### ***Оршил***

БНХАУ-ын Хубэй мужийн Үхань хотод үл мэдэгдэх уушгины хатгалгаа гарсан нь ДЭМБ-ын Хятад улс дахь оффисд 2019 оны 12-р сарын 31-нд анх мэдээлэгджээ. 2020 оны 1-р сарын 30-нд Олон Улсын Эрүүл Мэндийн Яаралтай Тусламжийн Байгууллагаас өвчний дэгдэлтийг зарласан ба улмаар 3-р сарын 11-нд ДЭМБ-аас COVID-19-ийг цар тахал-ын хэмжээнд хүрсэн гэж мэдээллээ.<sup>1</sup> Ийнхүү дэлхийн зарим улсууд онц байдал зарлаж, халдварт өвчинтэй өдөр шөнөгүй тэмцсээр өдийг хүрч байна. Энэ хугацаанд дэлхийн өнцөг булан бүрт хөл хорио тогтоож, олон нийтийн арга хэмжээ, нийтийг хамарсан бүхий л үйл ажиллагаанууд тодорхойгүй хугацаагаар хойшилж, эсвэл цуцлагдаж байгаа ба түүний нэг нь улс төрийн сонгуулиуд хүртэл үл мэдэгдэх хугацаагаар хойшлогдсоор байна. Жишээ нь: 2020 оны 4 сарын 14-ний байдлаар АНУ, Англи, Франц, Шриланк гэх мэт нийт 47 орон улс төрийн сонгуулиа хойшлуулахаар шийдвэр гаргасан ба Шинэ-Зеланд ирэх 9 сарын 19-нд парламентын сонгууль явуулах ёстой боловч одоохондоо хойшлуулах эсэх нь тодорхойгүй байна.<sup>2</sup> Харин БНСУ энэ пандемик цаг үед 21 дэх удаагийн парламентын ээлжит сонгуулиа амжилттай зохион байгуулснаар дэлхий нийтийн анхаарлыг татахын сацуу дэлхийн тавцанд өөрийн улсын байр сууриа улам бүр бэхжүүлээд байна.

### ***БНСУ-ын парламентын тухай***

БНСУ нь ерөнхийлөгчийн засаглалтай бөгөөд хууль тогтоох төрийн дээд байгууллага болох парламентыг Үндэсний Ассамблей гэдэг. Үндэсний Ассамблей нь нэг танхимтай, бүх

<sup>1</sup> Мицүо Какү “COVID19 халдвараас урьдчилан сэргийлэх гарын авлага” УБ., 2020 он

<sup>2</sup> [https://biz.chosun.com/site/data/html\\_dir/2020/04/15/2020041500589.html](https://biz.chosun.com/site/data/html_dir/2020/04/15/2020041500589.html)

нийтийн сонгуулиар 4 жилийн хугацаагаар сонгогддог.<sup>3</sup> Үндэсний Ассамблей нь тойргоос сонгогдсон 253, хувь тэнцүүлсэн системээр сонгогдсон 43 гишүүн, нийт 300 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.<sup>4</sup> 21 дэх удаагийн ээлжит сонгуулиар байгуулагдах Үндэсний Ассамблейн гишүүний бүрэн эрх нь 2020 оны 5 сарын 30-ны өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай байна


Сонгогдох ба сонгох эрх:

25 нас хүрсэн иргэн парламентын сонгуульд нэрээ дэвшүүлэх эрхтэй. Энэ заалт нь 1948 оны 5 сарын 10-ны өдрийн сонгуулиас эхэлж мөрдөгдсөн бөгөөд одоог хүртэл өөрчлөлт ороогүй, хэвээр байна. Харин 21 дэх удаагийн парламентын сонгууль хүртэл тус улсын сонгууль өгөх эрхтэй нас нь 19 байсан боловч 2019 оны 12 сарын 27-ны өдрийн Сонгуулийн тухай хуулийн өөрчлөлтөөр сонгууль явуулах өдөр 18 нас хүрсэн иргэн сонгох эрхтэй байхаар тусгаж өгсөн. Ингэснээр 12-р анги төгсөж буй сурагчид саналын эрхтэй болж байгаа ба тус сонгуульд санал өгөх эрхтэй нийт 43,994,247<sup>5</sup> хүн байв.

Сонгуулийн систем:

Энэ удаагийн ээлжит сонгууль нь 253 гишүүнийг нэг мандаттай тойргоос мажоритар тогтолцоогоор, харин 47 гишүүнийг намын нэрийн жагсаалтаас пропорциональ тогтолцоогоор сонгоно. Пропорциональ буюу хувь тэнцүүлэх тогтолцоогоор сонгогдох 47 гишүүдийн суудлыг өмнө нь дан параллель арга (parallel method)-аар хуваарилдаг байсан бол энэ удаагийн сонгуулиар суудал хуваарилах аргаа шинэчлэн 47 суудлын 30-ыг нь semi-compensatory аргаар, 17-г нь хуучин аргаараа буюу параллель аргаар хувь тэнцүүлэн хуваарилахаар болжээ.<sup>6</sup> Учир нь ард иргэдийн төлөөлөл парламентад бүрэн орж ирж чадахгүй байгаа нь сонгуулийн тогтолцоотой шууд холбоотой гэж үзсэний улмаас сонгуулийн тогтолцоог өөрчлөн 2019 оны 12 сарын 27-ны өдөр сонгуулийн хуулийг өөрчлөн баталсан байна. Жишээлбэл,

Доорх хоёр графикаас харахад 2016 оны 4 сарын 13 нд болсон БНСУ-ын 20 дахь удаагийн парламентын (Бүрэн эрхийн хугацаа нь 2016 оны 5 сарын 30-ны өдрөөс эхлэн 2020 оны 5 сарын 29 хүртэл) сонгуулийн үр дүн сонгуулийн системээс хамаараад өөр дүн гарч байгаа юм. Хэрэв хувь тэнцүүлсэн системээр бодсон бол доод талын зурагны дагуу үр дүн гарах байсан билээ.



\*Эх сурвалж: <https://m.post.naver.com/viewer/postView.nhn?volumeNo=27500349&memberNo=44644797&vType=VERTICAL>

<sup>3</sup> Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” УБ., 2010 он

<sup>4</sup> БНСУ-ын сонгуулийн тухай хууль 21-р зүйл

<sup>5</sup> БНСУ-ын Сонгуулийн Ерөнхий хороо


<sup>6</sup> МУ-ын Сонгуулийн Ерөнхий хороо <https://www.gec.gov.mn/blog/2595>

Сонгуулийн хугацаа:

Сонгуулийн кампанит ажлын хугацаа 14 хоног байх ба нэр дэвшигчийг бүртгэж дууссан өдрийн 6 дахь өдрөөс эхлэн сонгуулийн өдөр хүртэлх хугацаанд байна.<sup>7</sup> Сонгууль явуулах өдөр нь парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахын өмнөх 50 өдрийн дараах, эхний Лхагва гариг байна. БНСУ 21 дэх удаагийн парламентын Сонгуулийн албан ёсны сурталчилгаа нь 2020 оны 4 сарын 2-ны өдрийн 0 цагаас эхлэн 4 сарын 14-ний өдрийн 24:00 цаг хүртэл үргэлжилсэн ба сонгуулиа 2020 оны 4 сарын 15-ны өдрийн Лхагва гаригт өглөөний 6:00 цагаас оройны 18:00 цаг хүртэл, нийт 14330 санал авах байранд улс орон даяар амжилттай явууллаа.

Урьдчилсан санал хураалт:

Харин урьдчилсан санал хураалтыг улсынхаа аль ч нутаг дэвсгэрт тухайн хүний саналыг хүргэх боломжит хугацааг тооцон тухайн сонгуулийн санал авах өдрөөс 5 өдрийн өмнө, 2 өдрийн турш зохион байгуулдаг.<sup>8</sup> Энэ удаагийн урьдчилсан санал хураалтыг 2020 оны 4 сарын 10-ны өдрөөс 11-ний өдрийн турш 06:00-18:00 цагийн хооронд 26,7%-ийн ирцтэй явуулсан. Доор графикаар 2016 оноос хойших шат шатны сонгуулийн нийт дүн болон урьдчилсан санал хураалтын дүнг үзүүлэв. Уг графикаас харахад 2016 оны 20 дахь удаагийн парламентын сонгуулийн ирц 58%, урьдчилсан санал хураалтын ирц 12.19%, 2017 оны 19 дэх удаагийн ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 77.2%, урьдчилсан санал хураалтын ирц 26,06%, 2018 оны 7 дахь удаагийн орон нутгийн сонгуулийн ирц 60.2%, урьдчилсан санал хураалтын ирц 20.14%, харин 2020 оны 21 дэх удаагийн парламентын сонгуулийн ирц **66,2%**, урьдчилсан санал хураалтын ирц **26,7% (11,742,677)**-ийн үзүүлэлттэй гарсан нь өмнөх сонгуулиудын санал хураалтын ирцтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан юм. Энэ үзүүлэлт нь тус улсын түүхэнд сүүлийн 28 жилийн хугацаанд гараагүй амжилт юм.



\*эх сурвалж: YONHAP NEWS

БНСУ-ын сонгуулийн тухай яривал, орхиж болшгүй зүйлийн нэг бол урьдчилсан санал хураалтыг амжилттай хэрэгжүүлж байгаа явдал юм. Энэ системийг 2000 онд Америк дараа нь Япон, БНСУ хэрэгжүүлж байна. Энэ нь тухайн хүн өөрийн харьяалалын дагуу оршин

<sup>7</sup> БНСУ-ын сонгуулийн тухай хууль 33-р зүйл

<sup>8</sup> БНСУ-ын сонгуулийн тухай хууль 148-р зүйл

суугаагүй болон сонгуулийн товлосон өдөр санал өгөх боломжгүй, хүндэтгэн үзэх шалтгаантай хүмүүс урьдчилж саналаа өгөх үйл явц юм. Ингэснээр өөр хот дүүрэгт амьдарж байгаа хүмүүс байгаа газраа саналаа өгч, өгсөн санал сонгууль болох өдөр хүртэл тухайн хүний албан ёсны хаягийн дагуу хүргэгдэж, өөрийн харъяалалын дагуу саналаа тоолуулах боломжоор хангагдаж байгаа юм.

Сонгогчдын өдөр:

2012 оны 1 сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр БНСУ-ын Сонгуулийн тухай хуулийн 6-р зүйлд сонгууль түүний утга учрыг ойлгуулах, сонгогчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд жил болгоны 5 сарын 10-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацааг “Сонгогчдын өдөр” хэмээн нэрлэж, Сонгуулийн ерөнхий хороо болон холбогдох байгууллагууд сонгогчдын боловсролыг дээшлүүлэх аливаа үйл ажиллагааг зохион байгуулахаар тусгасан.

Сонгуулийн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал:

БНСУ-д 2020 оны 1 сарын 20-ны өдөр короно вирусын анхны тохиолдол илэрснээр 2020 оны 5 сарын 17-ны өдрийн байдлаар нийт өвчтний тоо 11050-д хүрээд байгаа ба доорх графикаар БНСУ болон дэлхий нийтийн корона вирусын өсөлтийн түвшинг харууллаа.



\*Эх сурвалж: БНСУ-ын Эрүүл мэнд, Нийгмийн Хамгааллын Яамны тайлан


Энэхүү графикаас харахад 2 сарын 29-нд хамгийн их буюу 813 өвчтөн нэмэгдсэн байна. 3 сарын 15-ны өдрөөс эхлэн шинээр нэмэгдсэн өвчтний тоо 2 оронтой тоонд орж, өсөлтийн хувь өнөөдрийг хүртэл тогтмол буурлаа. Гэвч Солонгосын засгийн газар халдварт өвчний тархалтыг хяналтандаа авч чадсан хэдий ч эдийн засгийн өсөлт буурч, ажилгүйдлийн түвшин сүүлийн 21 жилийн хугацаанд тохиолдож байгаагүйгээр өсчээ.

Ажил эрхлэлтийн түвшин бол 15 ба түүнээс дээш насны хүн амын ажил эрхлэлтийг хэлэх ба БНСУ-ын Статистикийн ерөнхий газрын 5 сарын 13-ны өдрийн тайлангаас<sup>9</sup> харвал 2020 оны 4 сарын байдлаар ажил эрхэлж байгаа нийт хүний тоо 26562000 байсан нь өнгөрсөн оныхоос 1.8%(476000)-иар багасч, ажил эрхлэлтийн түвшин буурсан үзүүлэлттэй гарлаа. Энэ нь 1999(-658000) оны 2 сарын эдийн засгийн их хямралаас хойших 21 жил 2 сарын хугацаан дахь хамгийн их буурсан үзүүлэлт юм. Ажил эрхлэлтийн түвшний бууралтыг ерөнхийд авч үзвэл хүмүүс ихээр цуглардаг дэн буудал болон зоогийн газрууд -9.2%(212000), боловсролын

<sup>9</sup> [http://kostat.go.kr/portal/korea/kor\\_nw/1/1/index.board?bmode=read&aSeq=382415](http://kostat.go.kr/portal/korea/kor_nw/1/1/index.board?bmode=read&aSeq=382415)

байгууллага -6.9%(130000), бөөний худалдаа болон жижиглэнгийн худалдааны газрууд -3.4%(123000), үйлдвэрийн ажил эрхлэлт, усан замын экспорт уналтанд орсноор тухайн салбар -1.0%(44000)-иар тус тус багассан. Харин эсрэгээрээ эрүүлийг хамгаалах байгууллага болон нийгмийн халамжийн байгууллага 77000(3.5%), хөдөө аж ахуй, газар тариалан болон ойн аж ахуйн үйлдвэрүүд 5.2%(73000), хүргэлт үйлчилгээний компаниуд 2.4% (34000)-иар ажил эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. Насны хувьд авч үзвэл 60-аас дээш насныхан 274000, 50-60 насныхан 143000, 40-50 насныхан 190000, 30-40 хүртэлх насныхан 172000, 20-29 насныхан 159000 хүнээр тус тус ажилгүйдлийн түвшний хэмжээ нэмэгдсэн байна.

### 2019 ба 2020 оны ажил эрхлэлт ба ажилгүйдлийн түвшин



\*Эх сурвалж: <https://newsis.com/>

“Covid-19” вирус “ПАНДЕМИК” буюу “ЦАР ТАХАЛ”-ын хэмжээнд хүрсэн нийгэм эдийн засгийн ийм хүндрэлтэй нөхцөлд БНСУ парламентын ээлжит сонгуулиа явуулах уу?, үгүй юу? гэдэг нь олны анхаарлыг татаж байлаа. Гэсэн хэдий ч энэ нөхцөл байдал сонгууль хойшлуулах хууль, эрх зүйн үндэслэл болохгүй гэж үзэн, товлосон ёсоор сонгуулиа зохион байгуулж чадсан юм. Хүснэгтээр сонгууль хойшлуулах тухай холбогдох заалтыг өөрийн орны хуультай харьцуулан орууллаа.

### Сонгууль хойшлуулах шалтгаан

| Улсын нэр | Хойшлуулах шалтгаан                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|-----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Монгол    | МУ-ын Сонгуулийн тухай хуулийн 9.4-т МУ-ын Үндсэн Хуулийн 25-р зүйлийн 2,3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас ээлжит сонгууль явуулах боломжгүй болсон бол УИХ ээлжит сонгуулийг хойшлуулж болно.<br>* МУ-ын ҮХ-ийн 25-р зүйлийн 2-т: Дараах онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно. |

|          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|          | <p>1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;</p> <p>2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.</p> <p>* МУ-ын ҮХ-ийн 25-р зүйлийн 3-т: Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.</p> |
| Солонгос | <p>Сонгуулийн тухай хуулийн 196-р зүйлийн 1-т: Байгалийн гамшиг болон зайлшгүй шалтгаанаар сонгуулийг явуулах боломжгүй болсон тохиолдолд парламентын болон ерөнхийлөгчийн сонгуулийг ерөнхийлөгч, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгуулийг тухайн сонгуулийн тойргийн сонгуулийн ерөнхий хорооны дарга тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллагын даргатай зөвшилцөн сонгуулийг хойшлуулна.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |

*\*Эх сурвалж: МУ-ын Үндсэн Хууль ба БНСУ-ын Сонгуулийн тухай хууль*

Ийнхүү сонгууль хойшлуулах хууль эрх зүйн үндэслэл байхгүй хэмээн үзэн сонгуулиа гаргасан төлөвлөгөөний дагуу явуулахаар бэлтгэл ажилдаа орон, 2020 оны 3 сарын 7-ны өдөр сонгуулийн тойргийг баталсан. Доорх хүснэгтээс сонгууль явуулах календарчилсан төлөвлөгөөг ерөнхийд нь харж болно.

| Он сар өдөр |                         | Гариг         | Хэрэгжүүлэх ажил                                         |
|-------------|-------------------------|---------------|----------------------------------------------------------|
| 2019 он     | 10 сарын 18-11 сарын 15 | Баасан-Баасан | Хүн амын тоог эцэслэн гаргах                             |
|             | 12 сарын 7              | Бямба         | Сонгуулийн зардлын тогтоосон хэмжээг зарлах              |
|             | 12 сарын 17             | Мягмар        | Нэр дэвшигчдийн урьдчилсан бүртгэл                       |
| 2020 он     | 2 сарын 15              | Бямба         | Хилийн чанад дахь сонгуулийн иргэдийн бүртгэлийг эцэслэх |
|             | 3 сарын 16              | Даваа         | Хилийн чанад дахь иргэдийн бүртгэлийг баталгаажуулах     |
|             | 3 сарын 27              | Баасан        | Нэр дэвшигчдийг бүртгэж дуусах                           |
|             | 3 сарын 28              | Бямба         | Санал өгөх иргэдийн жагсаалтыг гаргах                    |
|             |                         |               | Оршин суугчдын нэрсийн жагсаалтын бүртгэлийг гаргах      |
|             |                         |               | Цэргүүдэд сонгуулийн мэдээллийг илгээх эцсийн өдөр       |

|  |            |        |                                                                  |
|--|------------|--------|------------------------------------------------------------------|
|  | 4 сарын 1  | Лхагва | Хилийн чанад дахь сонгуулийг эхлүүлэх                            |
|  |            |        | Сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх                                |
|  | 4 сарын 2  | Пүрэв  | Сонгуулийн хугацааг албан ёсоор зарлах                           |
|  | 4 сарын 3  | Баасан | Сонгогчдын нэрсийн жагсаалтыг баталгаажуулах                     |
|  | 4 сарын 5  | Ням    | Оршин суугчдад саналын хуудас, санал өгөх зааврын тухай мэдээлэх |
|  | 4 сарын 6  | Даваа  | Хилийн чанад дахь иргэдийн санал өгөх сүүлийн өдөр               |
|  | 4 сарын 10 | Баасан | Урьдчилсан санал хураалт эхлэх                                   |
|  |            |        | Усан онгоцон дээр байгаа иргэдээс санал авах өдөр                |
|  | 4 сарын 11 | Бямба  | Урьдчилсан санал хураалтын сүүлийн өдөр                          |
|  | 4 сарын 15 | Лхагва | Саналаа өгөх өдөр (06:00-18:00 хүртэл)                           |
|  |            |        | Санал хураалтын дүн                                              |

*\*Эх сурвалж: БНСУ-ын Сонгуулийн ерөнхий хороо*

Улмаар сонгууль явуулахдаа халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанарын өндөр түвшинд авч хэрэгжүүлсэн ба саналаа өгөхөөр ирж буй иргэддээ дараах зөвлөмжийг БНСУ-ын Сонгуулийн Ерөнхий хорооноос гаргасан юм. Энэ нь:

1. Бичиг баримтаа бэлтгэх
2. Бага насны хүүхдийг сонгуулийн байр луу авч явахгүй байх,
3. Санал авах байр луу очихын өмнө гараа савандаж, 30 секундын турш угаах
4. Маск зүүх (Бичиг баримтын тулгалт хийж шалгах үед л маскаа түр авах)
5. Санал авах байранд орохдоо халуунаа үзүүлэн гараа ариутган, нэг удаагийн бээлий өмсөх
6. Санал авах байрны гадна, дотор 1 метрийн зай барих
7. Санал өгөх байрны гадна болон дотор хоорондоо аль болох ярилцахгүй байх
8. Халуурах болон бусад шинж тэмдэг илэрсэн тохиолдолд түр санал өгөх байранд санал өгсний дараа эрүүл мэндийн төв рүү очих зэрэг багтсан байна.

Ийнхүү олон хүн цугларах боломжгүй, гар ч барьж болохгүй нийгэм, эдийн засгийн хүнд үед сонгуулийн сурталчилгаагаа амжилттай хийсэн төдийгүй, баталсан төлөвлөгөөнийхөө дагуу сонгуулиа явуулж, санаанд оромгүй гайхамшиг мэт үр дүнг авчирсан Солонгосын ард түмнийг АГУУ хэмээн дэлхий нийт онцолсон билээ.

Нэр дэвшигчдийн тухайд авч үзвэл, тус сонгуульд нийт 253 тойрогт 21 намаас нийт 1118 (Өмнөх сонгуульд нэр дэвшигчийн тоо 1102) нэр дэвшигч өрсөлдсөнөөс 905 эрэгтэй, 213 эмэгтэй байсан ба насны ангилалаар нь харьцуулахад 48.2 хувь нь 50-60 насных бөгөөд нэр дэвшигчдийн дундаж нас 54 байгаа юм. Тус сонгуулийн хамгийн залуу нэр дэвшигч нь 1994 оны 25 настай эмэгтэй байгаа бол хамгийн ахмад 1937 оны 83 настай хүн байсан байна.<sup>10</sup>

БНСУ-ын хувьд сонгогчид юуг харж, хэрхэн санал өгөх нь шат шатны сонгууль бүрт өөр өөр ба эдгээр нь нас, хүйс, гэр бүлийн хэв маяг, нийгэмд эзлэх байр суурь, эрхэлсэн ажил, үзэл

<sup>10</sup> БНСУ-ын Сонгуулийн Ерөнхий хорооны мэдээ

баримтлал гэх зэргээс хамаарах үзүүлэлттэй харагддаг ч ихэвчлэн эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, БНАСАУ-руу чиглэсэн бодлого, АНУ болон БНСУ-тай холбоотой асуудлууд сонгууль бүрт сонгогчдын сонголтонд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг судлаачид онцолдог.

Харин энэ удаагийн сонгуульд оролцож буй улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрийг ерөнхийд нь авч үзвэл орон сууц, боловсрол, нийтийн тээвэр, сургууль, автобус, эмнэлэг, цэрэг, ажлын байр, хот төлөвлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэсэн 10 үндсэн асуудлыг онцолж байгаа юм байна.

Ингээд хүнд хэцүү цаг үед, санаанд оромгүй үр дүнг авчирсан тус сонгуулийн дүнгээс дурьдахад нийт сонгогдсон 300 гишүүний 180 суудлыг Ардчилсан нам буюу одоогийн ерөнхийлөгчийн нам авснаар дахин эрх баригч нам боллоо. Үүнийн зургаар илэрхийлвэл:



\*Эх сурвалж: [https://en.wikipedia.org/wiki/2020\\_South\\_Korean\\_legislative\\_election](https://en.wikipedia.org/wiki/2020_South_Korean_legislative_election)

Сонгогдсон нийт гишүүдийн хүйсийн харьцааны хувьд 57 нь эмэгтэй (19%), 243 нь (81%) эрэгтэй гишүүд эзэлж байна. Үүнээс Добүро Минжү буюу Ардчилсан нам 20 эмэгтэй гишүүний суудал авсан нь сонгуульд өрсөлдсөн улс төрийн намуудаас хамгийн олон эмэгтэй гишүүний суудалтай нам болсон ба нийт 25-30 настай гишүүний тоо 13-аас хэтэрсэнгүй. Хүйсийн харьцааг өмнөх сонгуулийн үр дүнтэй харьцуулвал,

Гишүүдийн хүйсийн харьцаа

| № |         | 21 дэх удаагийн сонгууль |      | 20 дахь удаагийн сонгууль |       |
|---|---------|--------------------------|------|---------------------------|-------|
| 1 | Эмэгтэй | 57                       | 19%  | 51                        | 15.9% |
| 2 | Эрэгтэй | 243                      | 81%  | 249                       | 84.1% |
| 3 | Нийт    | 300                      | 100% | 300                       | 100%  |

Үүнээс харахад энэ удаагийн парламентад эмэгтэй гишүүний тоо өмнөх парламентаас буурсан үзүүлэлттэй харагдаж байна.

### Дүгнэлт

Ийнхүү БНСУ 21 дэх удаагийн парламентын сонгуулиа 2020 оны 4 сарын 15-ны өдрийн өглөөний 6:00 цагаас оройны 18:00 цаг хүртэл нийт 14330 санал авах байранд улс орон даяар

амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн сонгууль нь өмнөх сонгуулиудаас онцлох зүйл их байв. Тэдгээрээс онцлон дурьдвал,

1. Дэлхий дахиныг хамарсан цар тахлын үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулан, иргэдийг санал өгөх боломжоор хангав.
2. Сонгуулийн саналын ирц сүүлийн 28 жил тохиолдож байгаагүй өндөр хувьтай гарав.
3. Сонгуулийн шинэ системийг хэрэгжүүлэв.
4. 18 нас хүрсэн иргэд санал өгөх эрхээр хангагдав.
5. БНСУ-ын иргэдийн төр засагтаа итгэх итгэлийг улам нэмэгдүүлж, төр иргэн хоёрын харилцааг бэхжүүлэх гүүр болов.
6. Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр ихэвчлэн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудалд төвлөрч байв.
7. Одоогийн засгийн газрын үйл ажиллагаанд дүн тавьж, эрх баригч нам болох Ардчилсан намын нэр хүнд улам өсөн ерөнхийлөгч Мүн Жэ Ин-ий дахин сонгогдох боломжийг нэмэгдүүлэв.

Түүнчлэн БНСУ-ын ерөнхийлөгч Мүн Жэ Ин сонгуулийн дараа ард түмэндээ хандаж хэлэхдээ: “Та бүхнээрээ бахархаж бас хүндэтгэж байна. Агуу ард түмний баярт сонголтын өмнө нэн чухал үүрэг хариуцлагыг мэдэрч байна. Мөн энэ удаагийн парламентын сонгууль нь дэлхий нийтийг гайхан бишрүүллээ. Ард түмэн та бүхний идэвхитэй хамтын оролцооны үр дүнд дэлхий дахин Корона 19 гэх халдварт өвчнөөр амьсгалсан үед ганцхан манай улс парламентын сонгуулиа амжилттай явууллаа” гэхийн зэрэгцээ “Иргэд та бүхэн нийгмийн зай барилт болон халдварт өвчнөөс сэргийлэх дүрэм журмыг чанд баримтлан, эмх цэгцтэй сонгуульдаа оролцон, тусгаарлагдсан иргэд хүртэл сонгуульдаа оролцож, гайхамшиг мэт сонгуулийн ирцийг үзүүлээ”<sup>11</sup> гэж онцолсон байна.

### ***Abstract***

South Korea captures the world's nations attention as it held a The 21<sup>st</sup> National Assembly election since the coronavirus epidemic began without postponing as scheduled and managed to control Covid19 outbreak. Therefore, in this article I decided to write regarding the circumstances and features of the parliamentary election.

### ***Ашигласан материал***

1. БНСУ-ын Сонгуулийн тухай хууль
2. МУ-ын Үндсэн хууль
3. БНСУ-ын Статистикийн газрын тайлан
4. БНСУ-ын Сонгуулийн Ерөнхий Хорооны тайлан
5. Ж. Төртогтох “Парламент судлалын гарын авлага” УБ., 2010 он

---

<sup>11</sup> Yonhap news <https://en.yna.co.kr/>

## АЛБАН ТУШААЛТАНД ХАРИУЦЛАГА ТООЦОХ АСУУДЛЫГ ШҮҮН ХЭЛЭЛЦЭХ ХОЁР ТАНХИМТАЙ ПАРЛАМЕНТЫН ЭРХ МЭДЭЛ

Д.Сүхболд

Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн ахлах багш

### *Хураангуй*

Төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох (импичмент) асуудлыг шүүн хэлэлцэх хоёр танхимтай парламентын эрх мэдэл, хоёр танхимтай парламентын бүтцээр дамжуулж импичмент явуулдаг олон улсын практик, парламентын мөрдөн шалгах хороо зэргийн талаар өгүүлж, төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох тогтолцооны талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл ямар төвшинд байгааг судалж үзэв.

### *Онол, арга зүйн үндэслэл*

Тус өгүүллэгийн онолын үндэслэл нь анх дундад зууны Английн сонгодог хоёр танхимтай парламентад үүссэн “импичмент”-ийн (зэмлэл) тогтолцоо юм. Тодруулбал Английн парламент нь төрийн өндөр албан тушаалтнуудыг хариуцлагад татах импичментийн шүүхийг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй байдаг. Энэ тохиолдолд Нийтийн танхим импичмент үүсгэх саналыг дэвшүүлж, Лордын танхим нь эцсийн шийдвэр гаргах шүүхийн үүрэг гүйцэтгэдэг.

### *Арга зүйн хувьд*

Импичментийн онол сэтгэлгээний үндсийг тодруулж гаргахад түүхэн арга зүй, түүний олон улсад хэрэгжсэн туршлага, парламентын мөрдөн шалгах хороо зэрэг асуудлыг судлахад харьцуулах арга зүй, төрийн өндөр албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох механизмын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэлд хийсэн судалгаанд социологийн онолын болон эмпирик арга зүй ашиглагдав.

### *Удиртгал*

Монголд төрийн өндөр дээд албан тушаалтнуудтай<sup>1</sup> холбоотой авилга, хээл хахуулийн шинжтэй хэргүүд олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байгаа бөгөөд хамгийн гол нь тэдэнтэй улс төрийн хариуцлага тооцох механизмгүй улмаас олон нийт зөвхөн шуугиад л өнгөрдөг эмгэнэлтэй байдал Монгол нэгэнт бий болоод байгааг бүгд бэлхнээ харж байна. Тухайлбал Чингис, Самурай бондын захиран зарцуулалтын асуудал, Оюутолгой болон Дубайн алдаатай гэрээ, 60 тэрбумын хэрэг, Эрдэнэтийн 49%-ийн асуудал, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас авсан УИХ-ын гишүүдийн зээл гэх мэт олон нийтийн бухимдлыг барсан олон асуудлуудад хариуцлага тооцох боломжгүй нөхцөл үүсээд байна.

<sup>1</sup> Төрийн өндөр албан тушаалтан гэдэгт Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн дарга, Улсын ерөнхий прокурор, хуульд заасны дагуу Улсын Их Хурлаас томилогддог бусад албан тушаалтнууд багтана.

Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд зааснаар Монгол улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор нарыг Монгол улсын Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл огцруулах, эргүүлэн татах асуудлыг Үндсэн хуулийн цэц хуралдаанаараа шийдвэрлэж, дүгнэлт гаргахаар<sup>2</sup> ерөнхий байдлаар зохицуулсан ч энэ нь хангалтгүй юм гэдгийг дээрх хариуцлага тооцох боломжгүй төрийн өндөр албан тушаалтнуудын холбогдсон хэргүүд харуулж байна.<sup>3</sup> Иймд сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл, журмыг тодорхой болгох хэрэгцээ, шаардлага нийгмээс урган гарч буй агаад энэхүү асуудлыг юуны өмнө эрдэм судлалын хүрээнд судалсны эцэст улс төрийн практикт хэрэгжих үндэслэл бий болох юм. Иймээс энэхүү өгүүллэгээр төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох тогтолцоо буюу импичментийн асуудлыг онол, практикийн төвшинд авч судлах зорилгыг тавьснаас гадна манай иргэдийн энэ талаарх мэдлэг ямар хэмжээнд буйг судлахыг зорив.

### ***Нэг: Импичментийн онол, сэтгэлгээний үндэс, олон улсад хэрэгжсэн туршилага***

Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаа мөчирт хуваагаад, тэдгээрийг төлөөлсөн албан тушаалтнуудыг ард түмнээс сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулж хянадаг хариуцлагын тогтолцоог парламентат ёсонд “импичмент” (зэмлэл) хэмээн нэрлэдэг. Импичмент нь анх Англид үүссэн бөгөөд тус улсын парламент нь төрийн өндөр албан тушаалтнуудыг хариуцлагад татах импичментийн шүүхийг хэрэгжүүлэх хууль ёсны онцгой эрхтэй байдаг. Энэ тохиолдолд Нийтийн танхим шүүн таслах газар болдог бол Лордын танхим нь шүүхийн үүрэг гүйцэтгэдэг. 1376 онд Лорд Летимерийг авч хэлэлцсэн импичмент шүүх хамгийн эртний нэрд гарсан тохиолдол болсон бол сүүлийнх нь 1804 онд Хатан хааны тэнгисийн флотын өндөр албан тушаалтан Мэлвиллийг нярвын албан тушаалдаа хохирол учруулсан гэсэн үндэслэлээр импичмент шүүхэд татсан<sup>4</sup> ажээ. Ийнхүү импичмент нь сонгодог утгаараа хоёр танхимтай парламент анх үүссэн Англид анх хэрэглэгдэж эхлээд дараа нь Английн төрийн тогтолцоог үндэслэл болгож өөрийн Үндсэн хуулийг боловсруулсан АНУ болон бусад улсууд улс төрийн практиктаа загвар болон хэрэглэж эхэлжээ. “1787 онд боловсруулж, 1789 онд албан ёсоор батлагдсан АНУ-ын Үндсэн хуулийг санаачлагчид нь Британийн имперээс цагаачлан ирэгсэд байсан бөгөөд Нэгдсэн Холбооны Улсын Үндсэн хуулийг хуучин эх орныхоо улс төрийн тогтолцоог дуурайлгахыг хүсэж, 1875 онд Франц улс XIX зууны Английн парламентын хаант ёсыг Бүгд найрамдах хэлбэр шинж болгосон лугаа адил 1787 оны Америк XVIII зууны Английн хэмжээт хаант засгийг Бүгд найрамдах хөрсөнд суулгажээ.”<sup>5</sup>

Орчин үед импичмент нь Их Британийн парламентын хувьд “унтаж буй” онцгой эрх мэдэл<sup>6</sup> хэмээгддэг байна. Өөрөөр хэлбэл импичмент нь парламентын практикт бага хэрэглэгддэг. Тухайлбал АНУ-ын Конгрессын Сенатын танхим түүхэндээ 12 удаа импичментийн асуудлыг авч хэлэлцсэнээс ердөө дөрвөн хэрэгт л шийтгэл оноосон байна. Мөн Францын Үндсэн хуулиар парламентын дээд танхим болох Сенат нь импичментийн шүүхийн

<sup>2</sup> <https://www.legalinfo.mn/law/details/365>

<sup>3</sup> Тэгээд ч Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн энэ хэсгийг Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон

<sup>4</sup> Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 177 дахь тал. УБ., 2010

<sup>5</sup> М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 201 дахь тал. УБ., 2007

<sup>6</sup> Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 58 дахь тал. УБ., 2010

үүрэг гүйцэтгэх эрхтэй боловч улс төрийн практикт энэ эрхээ хэрэглэх тохиолдол гараагүй юм. Энэ нь импичментийн тогтолцоо тухайн улсын төрийн өндөр дээд албан тушаалтнуудын ёс зүй болоод улс төрийн хариуцлагатай байх явдалд шууд нөлөөлдөгтэй холбоотой.

Олон улсын практикаас үзэхэд парламентын доод танхим шүүхэд шилжүүлэх саналыг дэвшүүлж, дээд танхим уг хэргийг шүүх эрхтэй байдаг. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улсад Ерөнхийлөгч болон бусад төрийн дээд албан тушаалтнууд Үндсэн хууль зөрчсөн, эсвэл эрх зүйн шинжтэй алдаа гаргасан бол хариуцлагад татах тухай асуудлыг хэлэлцдэг. Ингэхдээ Төлөөлөгчдийн танхим импичмент үүсгэх тухай санал гаргана. Шийтгэл нь зөвхөн албан тушаалаас халах явдал бөгөөд эцсийн шийдийг Сенат гаргана. Шийдвэр гаргахын тулд танхим тус бүрийн гуравны хоёрын саналыг авсан байх ёстой.

Оросын холбооны улсын төрийн Дум нь Ерөнхийлөгчийг импичментийн асуудалд холбогдуулан яллагдагчаар татах онцгой бүрэн эрхтэй (энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд гуравны хоёрын санал шаардагддаг) бөгөөд Холбооны Зөвлөл нь Ерөнхийлөгчийн импичментийн асуудлыг хянах эрхтэй байдаг.

Тайланд улсад Төлөөлөгчдийн танхим болон Сенатын хамтарсан хуралдаанаар Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид, Сонгуулийн хорооны гишүүд, Авилгыг эсэргүүцэх хорооны гишүүд, Улсын аудитийн хорооны ерөнхий аудитор болон гишүүд, Хүний эрхийн комиссын гишүүд, зэрэг төрийн өндөр албан тушаалтнуудыг импичмент үүсгэж огцруулах бүрэн эрхтэй.

Хоёр танхимтай парламентад ийнхүү импичментийн тогтолцоо үйлчилдэг учраас төрийн өндөр албан тушаалтнуудыг илүү хариуцлагатай, илүү ёс зүйтэй байх нөхцөл уруу түлхэж өгдөг. Бүхэлд нь дүгнэвэл хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн төрийн эрх мэдлийн байгууллагуудыг Үндсэн хууль болоод бусад хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж чадаж байна уу үгүй гэсэн хяналтыг хоёр танхимтай парламентын тогтолцоо илүүтэй хэрэгжүүлж чаддаг.

***Хоёр:Төрийн өндөр албан тушаалтан огцруулах асуудал нь парламент, тэр дундаа хоёр танхимтай парламентын бүтэцтэй холбогдох ёстойг онолын хувьд тайлбарлах нь***

Төрийн өндөр албан тушаалтнуудын эх сурвалж нь сонгуулийн зарчим байдаг учраас тэднийг огцруулах асуудал нь ярвигтай үйл явц байх нь дамжиггүй. Албан тушаалаас огцруулах шалтгаанууд нь эрх мэдлээ урвуулан ашиглах, ёс зүйн зөрчил гаргах зэргээр олон нийтийн итгэл хүндлэлийг алдсан үйлдлүүд юм. Ийнхүү хэн нэгэн албан тушаалтанг огцруулах асуудал нь намын хуваагдлаас гадна нийт иргэдийн дунд ч талцал маргаан үүсгэх нөхцөлийг бүрдүүлж болно. Тэрхүү талцал нь даамжирвал албан тушаалтанг огцруулах нь буруу зүйл хийсэн гэх хүчин зүйлээсээ хальж, аль хүчтэй, эрх мэдэлтэй талд шийдэгдэх эрсдэлийг ч дагуулна. Төрийн өндөр албан тушаал нь түүнийг эрхэлж буй хүнд олгосон итгэл, нэр хүндтэй холбоотой учраас маш эмзэг сэдэв байдаг. Иймээс энэхүү нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэж чадах цорын ганц институт бол сонгуулийн зарчмаар, тодорхой хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлдэг, ард түмний төлөөлөгчдийн байгууллага болох парламент юм.<sup>7</sup> Учир нь албан тушаалаас огцруулах үйл ажиллагаа нь тухайн албан тушаалтанг үндэсний хэмжээнд буруу зүйл хийснийг нь шүүн хэлэлцэж буй үйл явц ажээ. Тэгвэл үндэсний хэмжээнд энэ асуудлыг ард иргэдийн төлөөллийг хэрэгжүүлэгч институт хариуцах нь зүйн

<sup>7</sup> 1787 оны АНУ-ын Үндсэн хуулийн хуралдай энэ бүхнийг харгалзан үзээд төрийн өндөр албан тушаалтанг огцруулах санал гаргах эрхийг Төлөөлөгчдийн танхимд, харин эцсийн шийдвэр гаргах эрхийг Сенатад олгожээ. (The Federalist papers 65 - Objections to the Power of the Senate To Set as a Court for Impeachments Fur ther Considered. Alexander Hamilton)

хэрэг бөгөөд энэ тохиолдолд парламент хоёр танхимын бүтцээр зохион байгуулагдсан байх шаардлагатай.<sup>8</sup> Энэ нь хоёр шийдвэрийг нэг байгууллага гаргах эрсдэлээс сэргийлж байгаа хэлбэр юм. Тухайлбал Төлөөлөгчдийн танхим огцруулах саналыг гаргаж, Сенат уг саналыг шүүн хэлэлцэж байгаа нь энэ хоёр институт бие биенийхээ гаргасан шийдвэрт харилцан хяналт тавих механизм болжээ.<sup>9</sup> Тэгэхээр төрийн өндөр албан тушаалтан буруутай эсэхийг хэлэлцэх саналыг парламентын доод танхим гаргаж, албан тушаалаас огцруулах уу, үгүй юу гэх эцсийн шийдвэрийг шүүх болж хувирсан парламентын дээд танхим гаргах ажээ. Төрийн өндөр албан тушаалтанг шүүх маш хариуцлагатай энэхүү шүүн таслах ажиллагааг бие даасан, тогтвортой, гаднын нөлөөнд автахгүй хэрэгжүүлж чадах институт бол нийгмийн олон янзын эрх ашгууд дундаас сонгогдож болон томилогдсон, шигшмэл элитүүдээс бүрдсэн парламентын дээд танхим юм.

***Гурав: Импичмент үүсгэх эрх бүхий парламентын мөрдөн шалгах хорооны тухай***

Импичментийн асуудал яригдахтай зэрэгцэн парламентын “мөрдөн шалгах” хорооны тухай ойлголт гарч ирнэ. Энэ нь тусгай асуудлыг хянан шалгаж, шийдвэрлэхээр парламент дахь улс төрийн бүх намын төлөөллөөр байгуулддаг парламентын “мөрдөн шалгах хороо” юм. Судлаач Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт бүтээлдээ тус хороог “шүүн байцаан шинжих хороо”<sup>10</sup> хэмээн нэрлэжээ. Тодруулбал хоёр танхимтай парламентын тогтолцоонд төрийн өндөр дээд албан тушаалтнуудад ипичментийн асуудлыг үүсгэх болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагаатай холбоотой бүх асуудлаар парламент бүрэн мэдээлэл авсан байх ёстой гэдэг зарчмаас үүдэн шүүн байцаан шинжих эрхтэй хороод ажилладаг. (Seleg Committee)<sup>11</sup>

Тухайлбал АНУ-д<sup>12</sup> мөрдөн шалгах хороо нь онц эрхтэй байдаг бөгөөд тэрхүү эрхээ шаардлагатай үед эргэлзэх юмгүй хэрэглэдэг. Тус хороо нь зарлан дуудахаар хэнийг ч хуралд дуудах эрхтэйгээс гадна ирээгүй тохиолдолд торгож шийднэ. Мөрдөн шалгах хороо нь голдуу захиргааны асуудлыг байцаан шинждэг боловч уг чанартаа үйл ажиллагаа нь нэлээд өргөн буюу уг ажилд хамаарагдсан яам, албаны улс төрийн тэргүүн болон удирдлагатай холбоотой асуудлуудыг хянан шинждэг. Өөрөөр хэлбэл Конгрессын хороод мөрдөн байцаах эрх эдлэх бөгөөд энэ нь гүйцэтгэх засаглалыг далайцтай хянах, шүүмжлэх үүрэгтэй<sup>13</sup>. АНУ-ын Конгресс төрийн захиргааны байгууллагыг хянан шалгах эрхтэй, үүнд уг байгууллагыг үүсгэн байгуулах онцгой эрх болон үйл ажиллагааг нь тодорхойлох, санхүүгийн ажиллагааг нь хянах эрхтэй. Конгресс импичмент журамлалыг хэрэглэн шүүн таслах зарим эрх эдэлдэг нь холбооны ажилтан төрийн эсрэг ноцтой гэмт хэрэг үйлдсэн, тухайлбал урвасан, хээл хахууль авсан, төрийн хуулийг ноцтойгоор зөрчсөн хэргүүдийг шүүх эрхийг хэлж буй<sup>14</sup>. Төлөөлөгчдийн танхим санаачлан мөрдөн байцаах комисс байгуулж, комиссын дүгнэлтийн дагуу ял ногдуулах эсэхийг шийдэх шүүх болж хувирсан Сенатад шилжүүлэх бөгөөд Сенат

<sup>8</sup> Төрийн өндөр албан тушаалтанд хариуцлага тооцдог систем болох импичмент нь сонгодог утгаараа хоёр танхимтай парламент анх үүссэн Англид анх хэрэглэгдэж эхлээд дараа нь Английн төрийн тогтолцоог үндэслэл болгож өөрийн Үндсэн хуулийг боловсруулсан АНУ болон бусад улсууд улс төрийн практиктаа загвар болон хэрэглэж эхэлжээ. Өөрөөр хэлбэл импичмент нь хоёр танхимтай парламенттай улсуудад илүү нийтлэг, сонгодог байдлаар хэрэглэгддэг.

<sup>9</sup> The Federalist papers 66 - Objections to the Power of the Senate To Set as a Court for Impeachments Fur ther Considered (Alexander Hamilton)

<sup>10</sup> Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 162 дахь тал. УБ.,2014

<sup>11</sup> Тусгай асуудлыг хянан шалгаж, шийдвэрлэхээр парламентын гишүүдээс бүрдсэн хороо. Тус хороог парламент дахь улс төрийн бүх намын төлөөллөөр байгуулдаг. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 190 дэх тал. УБ., 2010

<sup>12</sup> Мөн тэнд

<sup>13</sup> М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 203 дахь тал. УБ.,2007

<sup>14</sup> М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 204 дахь тал. УБ.,2007

хаалттай хурлаар хэргийг шүүнэ, шийтгэл нь гол төлөв албан тушаалаас нь огцруулах байдаг. Ингэхдээ Сенатын гишүүдийн гуравны хоёрын саналаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болно.<sup>15</sup> Нэлээдгүй тохиолдолд парламентад төрийн дээд албан тушаалтны эсрэг хэрэг үүсгэх эрх олгодог. Тухайлбал Болгарын Үндсэн хуулийн дагуу парламент нь төрөөс төрөөс урвасан болон Үндсэн хуулийг зөрчсөн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийн асуудлыг шийдвэрлүүлэхээр эрхтэй байдаг.

Японд<sup>16</sup> төрийн өндөр албан тушаалтан байцаан шинжих хорооны асуултанд хариулахаас татгалзсан тохиолдолд түүний учир шалтгааныг парламентад болон зохих яамдад тайлбарлах үүрэгтэй. Хэрэв 10 өдрийн дотор зохих яам хариу эс өгвөөс гэрчлэгч мэдүүлгээ өгөх ёстой байдаг.

Харин Герман улсад яг ийм тохиолдол гарвал холбогдох яамнаас зөвшөөрөл шаарддаг ба шаардаж буй мэдээллийг өгөхөд “Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулах болон аюулд хүргэх, эсвэл улсын ажил алба гүйцэтгэхэд хүндрэлтэй болгох аваас яам хариу өгөхөөс татгалзаж болно” гэсэн байдаг. Парламентын мөрдөн шалгах хороо нь олон улсын практикт төдийлөн түгээмэл бусаар хэрэглэгддэг ба жишээ нь Норвеги, Финлянд, Швед зэрэг улсуудад ийм өндөр эрх хэмжээтэй хянан шалгах хороо байдаггүй. Зарим парламентын байцаан шинжих хорооны үйл ажиллагаа нь улс төрийн хяналтын гүйцэтгэх хүрээнээс халин гарч эрүүгийн хэрэг үүсгэхэд хүрдэг. Тухайлбал Италийн Үндсэн хуулийн 82-р зүйлд “Мөрдөн шалгах хороо нь шүүх эрх мэдлийн байгууллагатай ижил эрх, хязгаарлалтай шинжилгээ шалгалт явуулах эрхтэй” гэж заажээ.

***Дөрөв: Төрийн өндөр албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох механизмын талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэлд хийсэн судалгааны үр дүн***

Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлтийн асуудал хүчтэй өрнөн буй энэ үед тус өгүүллэгээр хөндсөн импичмент болон парламентын мөрдөн шалгах хорооны талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл хэр байна вэ гэдэг дээр судалгаа хийж үзэв. Судалгаанд 35-60 насны эдийн засаг, нийгмийн ухаан, инженер, сэтгүүлч, багш зэрэг дээд боловсролтой, санамсаргүй түүврээр сонгогдсон нийт 40 хүн хамрагдав.

Судалгааны гол асуулт болох:


1. Өнгөрсөн 27 жилийн туршид төрийн өндөр дээд албан тушаалтнуудыг ард түмний зүгээс хянах, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог хэрэгжүүлж чадсан уу гэсэн асуултад судалгаанд хамрагчдын 90 хувь нь чадаагүй 10 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ.

<sup>15</sup> Мөн тэнд


<sup>16</sup> Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 162-163 дахь тал. УБ.,2014



2. Та төрийн өндөр албан тушаалтнуудад хариуцлага тооцох механизм болох импичментийн талаар мэдлэг мэдээлэлтэй юу? Гэсэн асуултад судалгаанд хамрагдагчдын 15 хувь нь мэднэ, 30 хувь нь энэ талаар сонссон, 55 сайн мэдэхгүй гэж хариулжээ.



3. Та Парламентын мөрдөн мөрдөн шалгах хорооны талаар ямар мэдлэг мэдээлэлтэй вэ? Гэсэн асуултад 7 хувь нь мэднэ, 20 хувь нь сонссон, үлдсэн 73 хувь нь сайн мэдэхгүй гэж хариулжээ.



4. Харин төрийн өндөр албан тушаалтнуудад тооцох шаардлагатай юу гэсэн асуултанд 100 хувь шаардлагатай гэж хариулжээ.



### Дүгнэлт

1. Импичмент болон парламентын мөрдөн шалгах хорооны талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл ийнхүү маш хангалтгүй байгаа нь энэ талын мэдлэг мэдээлэл зөвхөн эрдэм судлалын хүрээнд л яригддаг, судлагддаг, асуудал гэдгийг харуулж байна.
2. Төрийн өндөр албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцдог механизм Монголд ус агаар мэт хэрэгтэй байгаа нь дээрх асуулгын аргаар авсан судалгаагаар нотлогдож байна.
3. Засаглагчдын хяналтгүй эрх мэдлийг хязгаарлах оновчтой шийдэл нь парламентыг хоёр танхимд хувааж, төрийн өндөр дээд албан тушаалтнуудад хариуцлага тооцдог импичментийн тогтолцоог хэрэгжүүлэх явдал бөгөөд ингэснээр төрийн өндөр албан тушаалтнуудыг дур зоргоороо авирлах явдлыг таслан зогсоох боломж бүрддэг байна. Энэ талаар Францын судлаач Морис Дюверже, “Улс төрийн олон байгууламжийн дотроос зарим нь засаглагчдын эрх мэдлийг хязгаарлах, нөгөө хэсэг нь түүний эрх дархыг өргөжүүлэх хандлагатай байдаг. Засаглагчдын эрх мэдлийг хязгаарлах хамгийн үр дүнтэй арга бол улс төрийн байгууламжаар хязгаарлах арга юм<sup>17</sup>” хэмээн бичсэнийг санууштай.

<sup>17</sup> М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” 186 дахь тал УБ., 2007

**Санал, зөвлөмж**

Монгол пахь парламентын бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчилж хоёр танхимтай болголоо гэхэд парламентын доод танхим нь төрийн өндөр дээд албан тушаалтнуудад улс төрийн хариуцлага тооцох импичментийг үүсгэх эрхтэй байх агаад доод танхимаас үүсгэсэн импичментийн асуудлыг дээд танхим хянан хэлэлцэх, шүүх эрхтэй байна. Ингэхийн тулд парламентын доод танхим санаачлан тусгай асуудлаар хянан шалгах эрх бүхий парламентын мөрдөн байцаах хороо байгуулах агаад тус хорооны дүгнэлтийн дагуу ял ногдуулах эсэхийг шийдэх шүүх болж хувирсан дээд танхимд шилжүүлэх бөгөөд дээд танхим хаалттай хурлаар хэргийг шүүх бөгөөд шийтгэл нь гол төлөв албан тушаалаас нь огцруулах явдал байх ёстой. Ингэхдээ парламентын дээд танхимын гишүүдийн гуравны хоёрын саналаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болно. Импичментийг зөвхөн төрийн өндөр албан тушаалтнууд болох Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, парламентын дарга, дэд дарга, парламентын гишүүд, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор зэрэг албан тушаалтнуудад хэрэглэнэ.

**Abstract**

We have discussed the jurisdictional authority of bicameral parliament on the accountability of high ranking state (senior) officials (impeachment), international practice of impeachment through bicameral parliamentary structure and the parliamentary inquiry committee and have studied the degree of public awareness and information on the system of accountability for senior officials in public administration

**Ашигласан эх сурвалжууд**

1. М.Дюверже “Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2007
2. “Улс төрийн шинжлэх ухаан” 40-41 дэх тал. УБ., 2001
3. Руссо, Жан Жак. “Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд” орч, Равдангийн Янжмаа УБ., 2002
4. Л. Өлзийсайхан “Парламент” УБ., 2001
5. Д.Сүхболд Бүгд найрамдахчуудгүй Бүгд найрамдах улс” МУИС “Политологи” сэтгүүл №13/ 442. 137 дахь тал. УБ., 2016
6. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 58 дахь тал. УБ., 2010
7. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” 177 дахь тал. УБ., 2010
8. Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 60 дахь тал. УБ., 2014
9. Д.Лүндээжанцан “Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт” 162 дахь тал. УБ., 2014
10. А.Юндэндорж, Ю.Атар “Өрнө дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургааль” II-III дэвтэр Хөх хот 2003
11. “The Federalist papers” by Alexander Hamilton, James Madison, and John Jay. Introduction and Notes by Charles R.Kesler. Copyright 1961.
12. The Anti-Federalist Papers and the Constitutional Convention Debates. Introduction by Ralph Ketcham. 2003

## **МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ: ХЭРЭГЖИЛТ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД**

**Д.Түмэнжаргал**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

**Г.Эрдэнэбаяр**

МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбар,  
Философи, шашин судлалын тэнхимийн дэд профессор

### ***Товч утга***

Энэ өгүүллийн хүрээнд өмнө нь хэрэгжиж байсан Сонгуулийн тухай багц хууль болон 2019 оны 12-р сарын 20-нд батлан гаргасан УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийн тус тусдаа хуулийн зүйл заалтуудыг нэг бүрчлэн бүгдийг багтаах боломжгүй. Иймд Монгол улсад мөрдөгдөж ирсэн сонгуулийн хуулийн зарим өөрчлөлт, түүний хэрэгжилт, үр дагавар, УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн зарим зүйл заалтын ялгаа, сонгуулийн хуулийг боловсронгуй болгох зүй ёсны шаардлага зэргийн талаар авч үзэв. Өмнө нь мөрдөгдөж байсан Сонгуулийн тухай хуулийг 2019 онд шинээр баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн зарим заалтын ялгааг гаргахдаа улс төрийн намтай холбоотой зохицуулалтын зарим хэсгийг харьцуулж, ялгаатай талуудыг гаргаж ирэхийг зорьсон болно.

**Түлхүүр үг:** Ардчилал, ардчилсан сонгууль, сонгуулийн байгууллага, сонгуулийн зарчим, нам, сонгогчдын оролцоо, УИХ-ын сонгууль.

Сонгуулийн хууль тогтоомж нь сонгууль явуулах зарчим, журам, аргыг цогцоор багтаасан эрх зүйн сурвалж юм. Сонгуулийн тухай хуулиудыг Үндсэн хуулийн дараахь эрх зүйн эх сурвалж гэж үздэг. Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 28 жил өнгөрсөн байна. Энэ хугацаанд Монгол улсад болж өнгөрсөн УИХ-ын 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016 оны нийт 7 удаагийн сонгууль нь зохион байгуулагдсан цаг үеийн өвөрмөц онцлог, эдийн засгийн байдал, намын болон төрийн бодлого шийдвэр, нийгмийн цаг үеийн уур амьсгал, сонгуулийн тогтолцоо, сонгуулийн хуулийн өөрчлөлт зэргээс хамаарч өөр өөрийн өвөрмөц онцлогуудтай байсан. Эдгээр асуудлуудын нэг гол хүчин зүйл нь сонгуулийн эрх зүйн зохицуулалттай холбоотой асуудал юм.

Сонгуулийн хууль эрх зүйн хүрээ нь Үндсэн хууль, 2015 оны сонгуулийн тухай багц хууль (16-р бүлэгт УИХ-ын сонгууль, 17-р бүлэгт Ерөнхийлөгчийн сонгууль, 18-р бүлэгт Орон нутгийн хурлын сонгууль), 2006 оны сонгуулийн төв байгууллагын тухай хууль, 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль болон СЕХ-ны журам зэргээс бүрддэг.<sup>18</sup>

<sup>18</sup> Холбогдох бусад хуулиудад Улс төрийн намын тухай хууль, Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн аудитын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон шүүх засаглал, хэвлэл мэдээллийг зохицуулах бусад хууль тогтоомжууд орно.

Мөн түүнчлэн Сонгуулийн хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн асуудлаар Монгол улсын Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн ажлыг зохион байгуулж явуулахад шаардлагатай дүрэм, журам, аргачилсан заавар, үлгэрчилсэн загвар, маягтууд батлан гаргадаг. Эдгээрийг эрх зүйн бусад акт гэж үздэг. Энэ дүрэм, журам, заавар, маягтыг сонгуулийн ажлыг явуулахдаа дагаж мөрддөг.

Монгол улсын 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн 3-р зүйлд: "Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцон, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ". 16-р зүйлд: "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно"<sup>19</sup> гэж ардчилсан сонгуулийг хуульчлан бататгасан байдаг.

Монгол улсад Улсын Их Хурлын сонгууль, Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль тус тус 7 удаа явагдаж өнгөрсөн.

### ***Нэг. Сонгуулийн хуулийн өөрчлөлт, түүний үр дагавар***

Монгол улс сонгуулийн өмнөх жил бүрийн 12 дугаар сард буюу сонгууль болохоос 6 сарын өмнө эцсийн хугацааг нь тулган холбогдох хуулиа өөрчилдөг нь Монголын онцлог бөгөөд жишиг болон хувирсан байсан. Тухайлбал:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 1992 оны 04-р сарын 04-ний өдөр, 2005 оны 12-р сарын 29-ний өдөр, 2008 оны 12-р сарын 19-ний өдөр, 2011 оны 12-р сарын 25-ны өдөр, 2015 оны 12-р сарын 25-ны өдөр тус тус шинэчлэн батлагдсан. Мөн 1996 оны 01-р сарын, 2006 оны 06 сарын 16-ны өдөр нэмэлт өөрчлөлт, 2007 оны 12-р сарын 26-ны өдөр, 2012 оны 11-р сарын 01-ний өдөр, 2015 оны 11-р сарын 26-ны өдөр, 2016 оны 05-р сарын 05-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан<sup>20</sup>. Мөн өнөөгийн байдлаар Сонгуулийн тухай хуулийг тус тусдаа бие даасан УИХ-ын, Ерөнхийлөгчийн, Орон нутгийн сонгуулийн хуулийн шинэчилэн боловсруулж ард түмний саналыг авч баталгаажуулсан байна.

1992 онд УИХ-ын сонгуулийн тухай хууль батлагдаж хэрэгжсэнээс хойш тухайн жил бүрийн сонгуулиудыг хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу явуулж ирсэн. Сонгуулийн хуулиудад оруулсан нэмэлт өөрчлөлтийг харахад УИХ-ын сонгуулийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдтэй холбоотой алдаа дутагдал нилээдгүй байдаг. Тодруулбал, 1992, 1996, 2000, 2004, 2008 оны УИХ-ын сонгуулиудаар сонгуулийн хуульд сонгуулийн мажоритар тогтолцоог өөрчлөөгүй явж ирсэн бөгөөд тойргийн хувьд нэг мандаттай эсвэл олон мандаттай болгож өөрчилж байснаас өөр онцын нөлөөлөхүйц томоохон нэмэлт өөрчлөлтүүд бага байсан гэж хэлж болно. Ийм учраас энэ үеийн сонгуулийн хуулинд зарим зүйл заалтууд дутуу, хуулийн цоорхой ихтэй байсан. Мөн улс төрийн нам, нэр дэвшигчид бохир арга хэрэглэж сонгуульд өрсөлдөх явдал их байсан. Тухайлбал, нам, нэр дэвшигчид сонгогчдын саналыг худалдаж авах, намууд насгүй, богино хугацаанд хэрэгжих халамжийн шинжтэй мөрийн хөтөлбөр гаргах, сонгуулийн бохир технологи хэрэглэх, сонгуулийн сурталчилгаандаа бусдыг гүтгэх, доромжлох, сөрөг сурталчилгаа явуулах нь ихсэх, мөнгө, эд материал сонгогчдод тараах, бэлэглэх зэрэг сөрөг асуудлууд ихэссэн. Мөн сонгогчдод эмнэлэг,

<sup>19</sup> Монгол улсын Үндсэн хууль. 1992 он

<sup>20</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хороо

сувиллын үнэгүй үйлчилгээ үзүүлэх, соёл урлаг, спортын арга хэмжээгээр үнэгүй үйлчилж сонгогчдын сэтгэл зүй, саналыг өөрчлөх зэрэг хууль бус үйлдэл, зөрчлүүд ихээр гарч ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг алдагдуулж байсан нь өмнөх сонгуулиудын үйл явцаас тодорхой харагдсан.

Харин 2011 оны 12-р сарын 15-ны өдөр УИХ-ын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн баталж, дээрх зөрчил дутагдлуудыг арилгах зүйл заалтууд оруулж өгсөнөөр сонгуулийн бохир технологи хэрэглэх явдал эрс багассан. Мөн сонгуулийн санал тоолох автомат машин ашиглах, сонгогчид ухаалаг үнэмлэх ашиглаж сонгууль өгөх, гадаадад суугаа Монгол улсын иргэдээ сонгуульд оролцуулах гэх мэт томоохон дэвшилтэт өөрчлөлтүүдийг хуулиар баталгаажуулсан нь өмнөх сонгуулиудаас шинэлэг болж байсан.

Гэсэн хэдий ч 2012 оны УИХ-ын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулахаар өөрчлөхдөө томоохон алдаа гаргасан. Тухайлбал, Энэ хуулийн өөрчлөлтийн дагуу холимог тогтолцоог ашиглахдаа УИХ-ын нийт 76 гишүүн сонгогдохоос 48 нэр дэвшигчийг 1-3 мандаттай, сонгуулийн томсгосон 26 тойрогт өмнөх хэрэглэж ирсэн мажоритар тогтолцоогоор явуулсан. Харин үлдсэн 28 нэр дэвшигчийг намын нэрийн жагсаалтаар сонгосон намууд нь өөрсдөө нэрээ тодруулсан. Ийм учраас үлдсэн 28 гишүүний нэрсийг сонгогчид мэдэх боломжгүй бөгөөд зөвхөн намын нэрийг дугуйлсанаас биш тухайн нэр дэвшигчийн нэрийг дугуйлаагүй. Ийм учраас 2012 оны УИХ-ын сонгууль нь сонгуулийн шууд байх зарчмыг ноцтойгоор зөрчсөнөөс гадна бүх нийтийн зарчмыг ч мөн алдагдуулсан гэж үзэж болно.

2008 оны УИХ-ын сонгуулийн хуулийн 4-р бүлгийн 20-р зүйлийн 20.1-д сонгогчдын нэрийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг дарга гаргана гэж заасан<sup>21</sup>. 2008 оны УИХ-ын сонгууль хүртэл нийт 5 удаагийн УИХ-ын сонгуулийг энэ хуулийн дагуу явуулсан. Ингэж заасан нь сум, дүүргийн Засаг дарга нь улс төрийн албан тушаалтан, мөн ИТХ-д улс төрийн намуудын үүрэг оролцоо их байсан нь энэ хуулийн заалтын дутагдалтай тал байсан.

Харин 2012 оны УИХ-ын сонгуулиар энэхүү заалтад нэмэлт өөрчлөлт оруулж 2011 оны 12-р сарын 15-ний өдрийн УИХ-ын сонгуулийн шинэчилсэн найруулга 4-р бүлгийн 20-р зүйлийн 20.3-т заахдаа "Аймаг, нийслэл дэх улсын бүртгэлийн салбар, нэгж нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан маягтын дагуу тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны хүн амын хаягийн бүртгэлийг үндэслэн сум, дүүрэг, хорооны улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтны гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ"<sup>22</sup> гэж өөрчилсөн. Дэлхийн бусад улс орны туршлагаас харахад Франц улсад сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргахдаа тухайн орон нутгийн төлөөллөөс гадна дээд шатны шүүхийн нэг төлөөлөгч хамтран оролцож гаргадаг. Харин Англи улсад сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргадаг тогтмол эрхэлдэг орон тооны нэг түшмэл байдаг байна.

Сонгуулийн тухай шинэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 25-нд сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэн баталсан нь сонгуулийн нэгдсэн эрх зүйн хүрээг бий болгоход чиглэсэн нэг дэвшил болсон.<sup>23</sup> Гэхдээ 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн хуулиар зарим зүйл заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулж, зарим зүйл заалтуудыг хассан байна. Гол томоохон

<sup>21</sup> УИХ-ын сонгуулийн тухай хууль. УБ., 2008

<sup>22</sup> УИХ-ын сонгуулийн тухай хууль. УБ., 2011

<sup>23</sup> Ерөнхийлөгчийн сонгууль, УИХ-ын сонгууль аймаг, нийслэлийн болон сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийг зохицуулсан 4 хуулийг шинэ хуульд нэгтгэсэн.

өөрчлөлтийн нэг нь УИХ, НИТХ, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг хамтад нь нэг зэрэг зохион байгуулж явуулсан. 2019 оны шинэ хуулийн хүрээнд УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийн хуулийг тус тусад нь авч үзэж хуульчлахаас гадна УИХ, НИТХ, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг тусад нь зохион байгуулахаар заасан.

Сонгуульд санал өгөх эрхийн талаар шүүхээс эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон, үйлдсэн гэмт хэргээсээ хамаарахгүй хорих ял эдэлж байгаа иргэд санал өгөх эрхгүй гэж тус тус заасан байдаг. Мөн гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж байгаа болон шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бүх этгээдээс бусад 18 насанд хүрсэн, эрх зүйн чадамжтай бүх иргэн санал өгөх эрхтэй. Энэ ерөнхий эрх нь олон улсын стандартуудтай зөрчилдсөн тэгш бус хязгаарлалыг бий болгож байна гэж зарим судлаачид үздэг.<sup>24</sup>

Монгол улсын 2015 оны 12-р сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 2-р бүлгийн 11-р зүйлийн 11.2 дахь хэсэгт *“Монгол улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа, сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуульд заасан журмын дагуу Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслийн төлөө болон Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй”*<sup>25</sup> гэж заасан байсан. Гэтэл Сонгуулийн тухай хуульд 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн хуулиар *“Монгол улсын дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа, сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуульд заасан журмын дагуу Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй”*<sup>26</sup> гэж нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу УИХ-ын сонгуульд гадаадад суугаа иргэдээс санал авахыг хүчингүй болгож, гадаадад амьдарч байгаа Монгол улсын 250.000 гаруй иргэдийн сонгуульд оролцох эрхийг хассан. Гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч байгаа Монгол иргэд нь нийт сонгогчдын 18 хувийг эзэлж байсан юм. Энэ нь бүх нийтийн байх ардчилсан сонгуулийн үндсэн зарчмыг ч алдагдуулсан.

2016 оны УИХ-ын сонгуулийн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог дэмжиж, тэдний сонгуулийн эрхийг хуулиар баталгаажуулсан. Тодруулбал: 2015 оны 12-р сарын 25-ны өдрийн батлагдсан Сонгуулийн тухай хуулийн 87-р зүйлийн 87.4 дэх заалтад *“Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байна”*, 87.6 дахь заалтад *“Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна”*<sup>27</sup> гэж тус тус заасан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санал өгөх боломжийг бий болгож өгсөн томоохон дэвшил, өөрчлөлт болсон юм. Энэ заалт нь Ерөнхийлөгчийн болон Орон нутгийн сонгуулийн хуулийн шинэ төсөлд мөн ижил тусгагдсан.

Мөн Монгол улс 2009 оноос хойш хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцид нэгдэж орсон. 2016 оны хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгосон. Мөн түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэр дэвших эрхийг дэмжих зэрэг үүргийг оруулан зааж өгсөн. Зарим улс төрийн намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудлыг тусгасан бөгөөд хурал цуглааны үеэр энэ асуудлыг

<sup>24</sup> "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ын 25-р зүйлд өгсөн НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25-р ерөнхий тайлбарын 14 дэх хэсэгт "хэрэв гэмт хэрэг үйлдсэний төлөө"

<sup>25</sup> Монгол улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2016

<sup>26</sup> Монгол улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2017

<sup>27</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2016.

хөндөж ярьж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог сурталчлахад зориулсан хэвлэл мэдээллийн хязгаарлагдмал хөтөлбөр нэвтрүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй нэг иргэн сонгуульд өрсөлдөж байсан.<sup>28</sup>

2015 оны Сонгуулийн тухай шинэ хуульд нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэй байхаар заасан жендэрийн квотыг 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 20 хувь болгож бууруулсан. Ийнхүү квотыг багасгасан нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо бууруулсан эрх зүйн зохицуулалт болсон юм<sup>29</sup>. Сонгуулийн тухай хуулиар сонгуулийн тойрог бүрт сонгогчдын ирц 50 хувьд хүрвэл сонгуулийг хүчинтэй гэж үздэг. Хэрэв энэ ирц хүрэхгүй тохиолдолд нэмэлт санал хураалтыг эрх бүхий сонгогчдын 50-иас доош хувийн ирцтэй оролцсон хэсгүүд дээр зөвхөн эхний санал хураалтад оролцоогүй сонгогчдоос санал авахаар заасан. 2019 онд боловсруулсан УИХ-ын сонгуулийн хуулийн шинэ төсөлд **“Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна”**<sup>30</sup> гэж заасан нь жендерийн квотод өөрчлөлт ороогүй ч аль нэг хүйсийн гэж оруулсан учраас зөвхөн эмэгтэйчүүдэд хамааралтай гэж ойлгох нь өрөөсгөл ойлголт юм. Эрэгтэй нэр дэвшигчдэд ч хамааралтай асуудал юм.

2015 онд шинээр баталсан Сонгуулийн тухай хуульд сонгуулийн хууль эрх зүйн орчинтой холбоотой өргөдөл гаргах үйл явц болон хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын эрхтэй холбоотой зөвлөмжүүдийг нэмж тусгасан ч гол чухал асуудлуудыг тусгаж өгөөгүй. Сонгуулийн тухай хуульд иргэдийн сонгох, сонгогдох эрх болон сонгуулийн сурталчилгааг хязгаарласан, мөн хуулийн цоорхойтой, хоорондоо зөрчилдсөн, тодорхой биш заалтууд бий. Заримаас дурьдвал: Сонгуулийн хуулийг баталсны дараа Үндсэн хуулийн цэцэд УИХ-ын сонгуулийн хуулийн зарим заалтуудын талаар арван өргөдөл ирсэн<sup>31</sup>. Ялангуяа УИХ-ын сонгуулийн тухай өмнөх хуулинд байсан сонгууль болохоос 6 сарын дотор ямар нэгэн нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглох тухай чухал заалтыг шинэ хуулиас хассан. Үүнээс үүдэн сонгуулийн хууль тогтоомжуудад оруулсан гол гол нэмэлт, өөрчлөлтүүдийг, тухайлбал сонгуулийн тогтолцоог хожимдож танилцуулж байсан.

2015 онд Сонгуулийн тухай хуулийг батлах үед сонгуулийн хувь тэнцүүлэх болон мажоритар тогтолцоог нэгтгэн холимог тогтолцоогоор парламентын сонгуулийг явуулахаар төлөвлөж байсан<sup>32</sup>. Гэвч 2016 оны 04 р сарын 22 өдөр Үндсэн хуулийн цэц 2 өргөдлийг шийдвэрлэж сонгуулийн хувь тэнцүүлэх буюу пропорциональ тогтолцоог сонгогчдын "шууд" сонгох Үндсэн хуулийн эрхийг зөрчсөн гэж үзэн хүчингүй болгосон<sup>33</sup>. УИХ нь Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх эрхтэй. Мөн хуульд заасан хугацаа байхгүй ч дүнгэлтийг хүлээн зөвшөөрч 2016 оны 05 сарын 05-ний өдөр Сонгуулийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан бүрэн мажоритар тогтолцоогоор зохион явуулахаар батласан<sup>34</sup>.

<sup>28</sup> 2016 оны УИХ-ын сонгуулиар параолимпийн алтан медальт тамирчин Тусгаар тогтнол, эв нэгдэл эвлээс нэр дэвшиж байсан.

<sup>29</sup> Бүрэн эрх нь дуусгавар болсон УИХ-ын гишүүдийн 14 хувь нь эмэгтэйчүүд байсан.

<sup>30</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл

<sup>31</sup> Сонгогдох эрх болон сонгуулийн сурталчилгаа чөлөөтэй явуулахыг хязгаарласан заалтуудтай холбоотой өргөдлүүд байсан. Сонгуулийн тогтолцооны пропорциональ буюу хувь тэнцүүлэхээр заасан нь Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна гэсэн өргөдлөөс бусад өргөдлүүдийг хууль зүйн үндэслэлгүй байхгүй гэж үзэж няцаасан. Эдгээр өргөдлийг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн шийдвэр олон нийтэд ил болоогүй байсан.

<sup>32</sup> 48 гишүүн олон мандаттай 26 тойрог дээр мажоритар системээр сонгогдож, нэг мандаттай үндэсний хэмжээний тойрог дээр 5 хувийн босгоор 28 суудалд сонгогдох ёстой.

<sup>33</sup> 2011 оны Сонгуулийн тухай хуучин хуулинд холимог тогтолцоо байсан. Харин 2012 онд бүрэн эрх нь дуусгавар болсон парламент энэ тогтолцоогоор сонгогдсон. 2016 оны 01-р сарын 27-нд гаргасан эхний өргөдлийг Үндсэн хуулийн цэцийн 2012 оны шийдвэрийн дагуу хувь тэнцүүлэх тогтолцоо нь Үндсэн хуулийг зөрчөөгүй гэж үзэн няцаасан. 2016 оны 02-р сарын 29-нд Үндсэн хуулийн цэцэд давж заалдахад өргөдлийг авч хэлэлцсэн. Хоёр дахь өргөдлийг 2016 оны 4-р сарын 13-нд гаргасан бөгөөд эхний өргөдөлтэй нэгтгэсэн.

<sup>34</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2017.

2019 оны 11-р сард энэ алдаа дутагдлыг арилгах үүднээс ардчилсан намын зүгээс Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд УИХ-ын гуравдугаар хэлэлцүүлгээр холимог тогтолцоогоор сонгуулийг явуулах, ингэхдээ намын нэрийг биш нэр дэвшигчийн нэрийг дугуйлдаг байхаар тооцоолж санал оруулсан ч гишүүдийн олонхийн санал авч чадаагүй энэ асуудал унасан юм. Ийнхүү сонгуулийн холимог тогтолцоог хэрэглэх асуудал хэд хэдэн удаа яригдаж хэлэлцэгдсэн ч дэмжигдээгүй. Хэдийгээр манай улс сонгуулийн холимог тогтолцоогоор хоёр удаагийн сонгуулийг явуулж байсан боловч алдаа дутагдал зохих хэмжээнд гарч байсныг дээр дурьдсан. Гэсэн хэдий ч сонгуулийн хэд хэдэн тогтолцоог авч хэрэглэж, туршлага хуримтлуулах нь нэг талдаа өмнөх алдаа дутагдлыг засаж сайжруулах, ахиц дэвшлийг бий болгох эерэг талтай байж болох талтай. Гэхдээ сонгуулийн тогтолцоог солих сонирхол одоогийн эрх баригч намд байсангүй.

Харин яг өнөөгийн түвшинд яригдаж байгаа сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах тойргийн асуудлыг авч үзвэл 76 гишүүний 50 гишүүнийг жижиг тойргоор сонгохоор, харин 26 гишүүнийг нэг том тойргоос сонгох, гэхдээ сонгогчид шууд нэр дэвшигчийг сонгох хувилбартайгаар УИХ-ын 2019 оны 12-р сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Бусад улсын туршлагыг судлахад 75 улсыг судлахад 37 нь намын хаалттай тогтолцоогоор, 38 намын нээлттэй тогтолцоогоор явуулсан. Нэр дэвшигчийн хувьд цагаан толгойн үсгийн дарааллаар 26 хүнийг танилцуулна. Ард түмний авсан саналын тоогоор эрэмблэгдэж жагсааснаар олон санал авсан хүн ялалт байгуулахаар яригдаж байна. Сонгуулийн тогтолцоонууд давуу болон сул талтай. Мажоритар тогтолцоо савладаг, сонгогчдын санал гээгддэг тогтолцоо юм. Сонгуулийн хуульд холимог тогтолцоог оруулах нь зөв гэсэн байр суурьтай гишүүд байсан. Ард түмэнд шууд сонгох эрхийг олгох нь зөв. 26 нэр дэвшигчээс 1 нэр дэвшигчийг сонгох нь зөв. 28 орон Скандиновын орнууд, Финланд Истон зэрэг оронд холимог тогтолцоогоор явсан. Австри, Бельги, Чех, Дани зэрэг улсууд улсын хэмжээнд нээлттэй иргэд шууд сонгох тогтолцоог хэрэглэдэг. Энэ туршлагаар намын ард ямар хүн нуугдахыг байлгах боломжгүй. 26 улс нэг тойрог, бүсчилсэн тойрог, аймаг нэг тойрог олон мандат, 76 жижиг тойрог. Тойрог байгуулах, мандатын тоог тогтоохдоо анхаарч нухацтай хандах хэрэгтэй. Газар нутаг эзэнгүй болох уу, 2-3 гишүүнтэй аймгууд хоёр дахин хэрүүл хийж байж арай илүү төсөв авдаг. Зарим аймгуудад олон гишүүн гарсан бол их төсөв өгдөг. Цөөн хүн амтай аймгуудад төсөв бага, мандатын тоо хуваарилахдаа цөөнөөр заадгийг болих хэрэгтэй. Гэхдээ сонгуулийн тогтолцоо ямар байхаас мандат их шалтгаалж байна. Говь-Алтай 37918, Булган 41,0, Хэнтий 50,0 Хэнтий ойролцоо мөртлөө 3 Их хурлын гишүүнтэй. Энэ тухайн үед зарчим алдагдсан. 1 УИХ-ын гишүүн хэдэн хүний төлөөлөл болох гэдгийг судалж үзсэн. Нийт сонгогчид 28.0-30.0 нэг гишүүнд оногдож байна. Хүний тоо, газар нутгийн хэмжээ, тойрог байгуулах зарчим зэргэлдээ сум, баг, дүүргүүд нэг тойрог болох нь зүйтэй. 12.0-37.0 мянган сонгогчидтой гишүүн байна. Харилцан адилгүй байна. Хүн амын тооны хувьд. Нутгийн удирдлагатай холбоотой Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр аймгууд хотын статустай болсон. Аймгийн хэмжээний хот ч байх талаар 2020 оны 05-р сарын 25-нд мөрдөгдөж эхлэнэ. Сум, орон нутагт анхан шатны төсөв хөрөнгийг захирах эрхийг өгөх ийм зохицуулалт хийгдсэн байгаа. Иргэдэд ойлгомжтой, тодорхой, логикийн зөрчилгүй байх ёстой. Саналаа өгч сонгуульд оролцоход чирэгдэлгүй байх ёстой. 2012-2020 оны хооронд 230.0 орчим шинэ залуу сонгогчид орж ирсэн. Өргөн барьсан хуулийн төслөөр саналаа өгсөнөөр 4 саналын хуудаснаас саналаа өгөх болж байна. 910 хүний нэрнээс, дээр нь өөрийнх нь тойрогт нэр дэвшиж байгаа хүмүүсээс дугуйлах болчихоод байна. 26-гишүүн яаж сонгогдох нь ойлгомжгүй. 1 хүнийг дугуйлна гэхээр бусад 25 хүн нь

сонгогдохгүй юм уу. Иргэдийн сонгуулийн боловсрол дээшилсэн. Олон улсын байгууллагатай хамтарч ажиллаж байна. Сонгогчдын сонгох эрхийг баталгаажуулах ёстой гэж үзсэн. Ард түмний өгсөн саналаар эрэмбэлэгдэж жагсаалт гаргаж 26 хүнийг сонгоно. Чөлөөтэй, шууд сонгох эрхийг олгож байна. Хүнийг сонгоно. 26 жагсаалтаар цагаан толгойн дарааллаар сонгоно. Эмэгтэйчүүдийн тухайд өмнөх сонгуулийн үед 20 хувийн квот тогтоосон. Энэ нь 28 улс төрийн намтай зөвшилцөж, 420 санал ирсэн. 310-ийг авч хэлэлцүүлэгт хийсэн. Хуучин намын хаалттай жагсаалтаар оймсонд хавчуулагдаж байсан асуудал байсан. Харин намын нээлттэй жагсаалтаар явуулах гэж байгаа нь ямар нэг ард нь нуугдаж гарч ирэх нэр дэвшигч байхгүй. Гулсах 26 хүний нийлбэр дүн 50 хувьд хүрсэн бол 13 нь МАН-д суудал. Өндөр рейтингтэй нэр дэвшигч намдаа олон суудал авна. Өндөр рейтингтэй жижиг намын хүн орхигдох магадлалтай. Авсан саналаараа эрэмбэлэгдэж орж ирж байна. Нам эрэмбэлэхгүй. Намын гишүүд санал аваагүй мөртлөө өндөр санал авсан хүнээ дагаж шууд гишүүн болохгүй. Мөнгөний саналыг эрс багасгах шаардлагатай. Намуудаас нэрээс нэр дэвшиж байгаа хүмүүсийн квотыг нэмэгдүүлэх шаардлагатай. Холимог тогтолцоог Үндсэн хуульд оруулаад унагасан. Гэтэл сонгуулийн хуульд холимог тогтолцоотой өнгө ижил хууль зөрүүлээд оруулж ирсэн нь Үндсэн хуулийг зөрчсөн асуудал болох байх магадлалтай. 2019 оны 12-р сарын 06-ний өдрийн УИХ-ын хуралдаанаар Сонгуулийн хуулийн төсөл, сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, сонгуулийн автоматжуулсан системийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн томьёолол дээр санал хураалт явуулахад нийт гишүүдийн 40 гишүүн санал хураалтад оролцож 27 буюу 67.5 хувь нь дэмжиж төрийн байгуулалтын байнгын хороонд эхний хэлэлцүүлэгт оруулахаар шилжүүлсэн.

2019 оны 11-р сарын 14-ний өдөр Монгол улсын Үндсэн хуульд зарим нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Үүний нэг гол өөрчлөлт бол Монгол улсын төрийн байгуулал болох гуравдугаар бүлгийн хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. *Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.*<sup>35</sup> Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан. Энэ заалт нь нилээдгүй чухал ач холбогдолтой заалт болсон. Учир нь сонгууль болохоос 6 сарын өмнө болгон эрх барьж буй улс төрийн хүчнүүд дур мэдэн яаран сандран сонгуулийн хуулийг өөрчилдөг байсан энэ гажуудлыг засах эхлэл тавигдсанаараа онцлогтой заалт болсон.

Мөн 2019 онд боловсруулж баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуулийг 2015 онд батлан гаргасан одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулийн ерөнхий зарчмыг баримтлан Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж УИХ-ын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал хэсэгт дурьдсан.<sup>36</sup> Улсын Их Хурлын даргын 2017 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 195 тоот Захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн төслүүдэд санал авахаар Сонгуулийн ерөнхий хорооны вэб сайтад байршуулсан байна<sup>37</sup>.

<sup>35</sup> Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992.

<sup>36</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал

<sup>37</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл.

2015 оны Сонгуулийн тухай хуулийн хүрээнд сонгогчид нь санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө өөр Хэсгийн хороонд шилжих боломжгүй гэж заасан.<sup>38</sup> Ихэнхи сонгуулийн тойрог дээр шилжсэн сонгогчдын тоо нь бүртгэгдсэн сонгогчдын нийт дүнгийн нэг хувиас хэтрээгүй байх ёстой. Гэхдээ 4 сонгуулийн тойрог дээр шилжсэн сонгогчдын тоо 20 хүртэл хувьд хүрсэн.<sup>39</sup> 2016 оны 6-р сарын 21-нд АН болон МАН-аас Сонгуулийн Ерөнхий Хороонд хандаж 5 тойрог дээр шилжилт их байна хэмээн гомдол гаргасан. Сонгуулийн Ерөнхий Хорооны зүгээс дээрх шилжилт хөдөлгөөн нь Сонгуулийн тухай хуулийн дагуу явагдсан, хууль зөрчөөгүй гэсэн хариу өгч байсан. Зарим хэсгийн хороодын ажилтнууд цагдаагийн албан хаагчид өөрсдийн бүртгэлтэй Хэсгийн хороодоос өөр хороодод ажиллаж байсан учраас саналаа өгөх боломжгүйд хүрч байсан. Эдгээр дутагдлууд нь Сонгуулийн тухай хуульд цаашид сонгогчдын шилжилт хөдөлгөөн болон бусад холбогдох асуудлуудын талаар тодорхой дэлгэрэнгүй тусгаж өгөх нь зүйтэй.

Монгол улсын сонгуультай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтад дараахь алдаа дутагдлууд байна. Тухайлбал, Сонгуулийн арга хэмжээнд төрийн эх үүсвэрийг урвуулан ашиглахыг хориглосон заалт байхгүй. Хэвлэл мэдээллийг ашиглах талаарх нарийн зохицуулалтгүй явж ирсэн. Төрийн эх үүсвэрийг урвуугаар ашиглах боломж олгож буй хүчин зүйл нь нэг нам дангаараа төрийн эрхийг барьж байгаатай холбоотой. Мөн төрийн эх үүсвэрийг албаны бус зорилгод ашигласан тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлага сул, хэрэгжих механизм байхгүй байна. Ялангуяа сонгууль, төрийн алба, хэвлэл мэдээллийн тухай хууль тогтоомж учир дутагдалтай бөгөөд эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн механизм сул байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрийн хяналтанд байдаг бөгөөд хараат бус байж чадахгүй байна. Гэвч төрийн өмчийн хэвлэл мэдээллийг сонгуульд ашиглах талаар хуульд дараахь байдлаар зохицуулалт хийсэн. Тодруулбал, 2015 оны 12-р сарын 25-ны Сонгуулийн тухай хуульд *“Олон нийтийн радио, телевиз нь сурталчилгааны нэвтрүүлгийн Сонгуулийн төв байгууллагаас сонгуульд оролцогч нам, эвсэл, түүнчлэн Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч тус бүрээр тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн үнэ төлбөргүй нэвтрүүлнэ”*<sup>40</sup> гэж заасан. 2012 оны УИХ-ын сонгууль явуулах хүртэлх хугацаанд олон нийтийн радио телевизийг сонгуулийн сурталчилгаанд ашиглахдаа үнэ төлбөргүй явуулна гэсэн энэ заалт сонгуулийн эрх зүйн зохицуулалтад байгаагүй. Харин 2019 оны УИХ-ын сонгуулийн хуулийн шинэ төсөлд *“Олон нийтийн радио, телевиз нь сурталчилгааны нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлнэ”*<sup>41</sup> гэж заасан. Энэ хуулийн төслийн өөрчлөлтийг харахад энэ асуудлын хүрээнд зохион байгуулж хяналт тавих эрх бүхий байгууллагад өөрчлөлт оруулснаараа онцлогтой.

Мөн улс төрийн намын болон сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилтийг олон нийтэд нээлттэй байлгах тухай хуулийн зохицуулалт зохих хэмжээнд байдаг ч хэрэгжилт, үр дүн байхгүй байна. 2015 оны 12-р сарын 25-ны өдрийн Сонгуулийн тухай хуулийн 60.3 дэх хэсэгт *“Төрийн аудитын байгууллага зардлын тайланг хянаж, хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн*

<sup>38</sup> 2016 оны УИХ-ын сонгуулиар Нийт 18,309 сонгогч түр шилжих тухай хүсэлт гаргасан. Сонгогч нь санал авах байраа нэг аймаг, эсвэл Улаанбаатар хотдотор өөрчлөх боломжгүй.

<sup>39</sup> Увс аймгийн 31-р тойрог руу нийт 2778 сонгогч шилжих хүсэлт гаргасан нь бүртгэлтэй сонгогчдын тоог 20 орчим хувиар нэмэгдүүлсэн. Баянхонгор аймгийн 9-р тойрог руу 1909 сонгогч шилжих хүсэлт өгсөн нь бүртгүүлсэн сонгогчдын нийт дүнг 11 хувиар нэмэгдүүлсэн. Хөвсгөл аймгийн 39 болон 37-р тойрог руу шилжихээр хүсэлтээ гаргасан сонгогчдын тоо нийт сонгогчдын тооны долоо, таван хувь орчмыг тус тус төлөөлж байв.

<sup>40</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2017.

<sup>41</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл.

**иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана”<sup>42</sup>** гэж заасан байдаг ч олон нийтэд мэдээлэх ажил хангалтгүй, энэ заалтын хэрэгжилт сул, тунхагийн шинжтэй байна. Харин 2019 оны УИХ-ын сонгуулийн тухай хуулийн шинэ төслийн 65.1 дэх хэсэгт **“Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана”<sup>43</sup>** 90 хоногийн дотор нийтэд мэдээлэх гэсэн заалтыг 60 хоногийн дотор болгож хугацааны хувьд 30 хоногоор наашлуулсан энэ өөрчлөлт нь цаг хугацааны хувьд өөрчилсөн заалт. Асуудлын гол 30 хоногийн наана эсвэл хойно гэж өөрчлөхдөө гол нь биш. Хамгийн гол асуудал нь олон нийтэд цаг хугацаандаа үнэн зөв, хүртээмжтэй мэдээлэх, мөн сонгогчдыг мэдэх эрхээр хангаж шударга байдлыг бий болгох явдал юм. Хэрвээ хуульд заасан энэ заалтыг зөрчвөл хяналт тавьж, хариуцлага тооцдог механизм байх ёстой. Хяналт хариуцлага байхгүй учраас энэ заалтын хэрэгжилт сул байна.

2016 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын үеэр УИХ-ын сонгуулийн хууль, Авилгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Улс төрийн намын тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зэрэг хуулийг зөрчсөн олон тохиолдлууд ажиглагдаж байсан. Энэ нь Сонгуультай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих тогтолцоо болон сонгуультай холбогдох зөрчил, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаа нь тодорхойгүй байгаатай холбоотой. Мөн Сонгуулийн Ерөнхий Хорооны бие даасан, хараат бус байдал бүрэн хангагдаж чадахгүй байна.

Монголын Сонгуулийн тухай хуулинд УИХ, Засгийн газар, УИХ-ын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнууд нь алдаа гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизм байдаггүй. Тэдгээр алдаа гаргасан албан тушаалтныг зөвхөн огцруулаад өнгөрдөг. Алдаатай бодлогын улмаас улсад учруулсан хор хохирлын хэмжээг төлүүлэх, шийтгэх, ял эдлүүлэх зэрэг арга хэмжээ талаар хууль эрх зүйдээ нарийн тодорхой тусгаагүй зэрэг дутагдлууд байсаар байна. Ийнхүү дээр дурьдсан Монголын сонгуультай холбоотой бүхий л асуудлууд болон хуулийн хэрэгжилт, үр дүнг харахад цаашид анхаарах, хууль эрх зүйн зохицуулалтанд зайлшгүй өөрчлөлт оруулах шаардлагатай асуудлууд нилээдгүй байна.

### ***Хоёр. Өмнө нь мөрдөгдөгж байсан Сонгуулийн тухай хууль болон УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн зарим зүйл, заалтын хоорондын ялгаа***

*(Улс төрийн намтай холбоотой зарим зүйл заалтуудыг УИХ-ын сонгуулийн хуулийн жишээн дээр)*

Монгол улсын Үндсэн хуульд 2019 оны 11-р сарын 14-ний өдөр зарим нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан билээ. Тухайлбал, Үндсэн хуулийн 19-р зүйлийн 1 дэх хэсэгт **“Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана. 2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна”**.<sup>44</sup> гэж заасан бөгөөд энэ зүйлийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Мөн түүнчлэн Үндсэн хуулийн 3 дахь хэсэгт **“Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын**

<sup>42</sup> Монгол улсын сонгуулийн тухай хууль. УБ., 2017.

<sup>43</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн хуулийн төсөл.

<sup>44</sup> Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992.

зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно”<sup>45</sup> гэж заасан. Энэ хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тус тус өөрчилсөн.

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн хүрээнд одоо хөндөгдөж байгаа сонгуультай холбоотой хуулиудын зүйл заалт тус бүрийг нэг бүрчлэн энд авч үзэх боломжгүй тул зөвхөн УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн зарим зүйл заалтын жишээн дээр авч үзэж байна.

УИХ-ын сонгуулийн шинэ хуулийг санаачлагчид сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын ил тод байдал, түүнийг хариуцлагатайгаар тайлагнадаг, тайланг хүлээн авсан төрийн байгууллага ил тод мэдээлдэг, нягтлан шалгах үйл ажиллагаанд төрийн бусад байгууллагын чиг үүргийг нарийвчлан тодорхойлж тусгахаар зааснаараа энэ хуулийн давуу талтай гэж үзсэн.<sup>46</sup>

Мөн 2019 онд батлагдсан шинэ хуулийн гол гол онцлогийг дурьдвал:

- 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар бүх сонгуулийг нэг багц хуулиар зохицуулдаг байсан бол шинэ хуулиар УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг тус тусдаа бие даасан хуулиар зохицуулахаар хуульчлан баталгаажуулсан.
- Өмнө нь хэрэгжиж байсан Сонгуулийн тухай хуульд цаг хугацааны хувьд зөрүүтэй, зөрчилтэй асуудлууд байсан. Харин УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулиар цаг хугацааны хувьд зөрөөтэй, зөрчилтэй асуудлуудыг шийдэж, тодорхой болгож өгсөн. Тодруулбал, өмнөх хуульд сонгууль болохоос тэдээд доошгүй хоногийн өмнө гэж зааж байсан бол энэ хуулиар хэрэгжих хугацааг сар, өдрөөр тодорхой болгож нарийн зааж өгсөн.
- Өмнө нь УИХ-ын гишүүнд нэр дэвшигч үнэмлэхээ авчихад сурталчилгаагаа 4 хоног хүлээдэг байсныг өөрчилж нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс сурталчилгаа явуулахаар заасан.
- Улс төрийн намуудад өгдөг иргэн, хуулийн этгээдийн хандивын хэмжээнд өөрчлөлт оруулсан. Өмнөх хуулиар хандивын хэмжээ иргэн 3 сая төгрөг, хуулийн этгээд 15 сая төгрөг байхаар заасан байсныг шинэ хуулиар иргэн 5 сая, хуулийн этгээд 20 сая төгрөг болгож өөрчилсөн.
- Сонгуулийн сурталчилгаанд цахим орчныг ашиглаж болно. Өмнөх хуулиар зарим тодорхой бус заалтуудыг энэ хуулиар харицлаа холбооны зохицуулах хорооны саналаар тодорхой болгосон. Шинэ УИХ-ын сонгуулийн тухай хуулийн “47.2.Нэр дэвшигч энэ хуулийн 47.1.1, 47.1.2-т заасан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглах тохиолдолд цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлнэ”<sup>47</sup> гэж заасан.
- Улс төрийн намууд эвсэж сонгуульд оролцож болно. Эвсэл нь сонгуулийн жилд хүчинтэй байна. Эвсэлд орсон намууд олонхи нь тарсан бол эвслийг тарсанд тооцно гэсэн зохицуулалтыг оруулсан.
- Авилга албан тушаалтны гэмт хэрэгт холбогдож байсан нь шүүхийн тогтоолоор тогтоогдсон хүмүүсийг УИХ-д нэр дэвшүүлэхийг хориглосон.

<sup>45</sup> Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992.

<sup>46</sup> <https://www.gec.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

<sup>47</sup> Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2019.

- Сонгуулийн маргаантай холбоотой асуудлыг 10-аад байгууллага өөр өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэхээр заасан.
- Сонгуулийн сурталчилгааны хугацаа өмнөх хуулиар 18 хоног байсныг шинэ хуулиар 22 хоног болгож өөрчилсөн.
- Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээнэ”<sup>48</sup> гэж заасан.
- Харилцаа Холбооны Зохицуулах Хороо нь интернеттэй холбоотой асуудлыг зохицуулна.
- УИХ-д нэр дэвшиж байгаа төрийн албан хаагчид болон төрийн өмчийн оролцоотой газар ажилладаг албан хаагчид 01-р сарын 01-нээс албан тушаалаа өгөхөөр заасан.
- Гадаад улсад сурч, ажиллаж амьдарч байгаа Монгол улсын сонгогчдын УИХ-ын сонгуульд оролцох, саналаа өгөх эрхийг хуульчилж заагаагүй. Санал өгөх эрх нь хязгаарлагдсан.

2015 оны 12-р сарын 25-нд батлагдан мөрдөгдөж байсан “Сонгуулийн тухай хууль”-ийн зарим зүйл заалтуудыг 2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн баталсан “УИХ-ын сонгуулийн тухай” шинэ хуулийн зарим зүйл заалтуудыг харьцуулан ялгааг илрүүлж тайлбар хийв. (гол өөрчлөлтүүдийг хар өнгөөр тэмдэглэв).

| 2015 оны 12-р сарын 25-нд батлагдан өмнө нь мөрдөгдөг байсан Монгол улсын сонгуулийн тухай хууль                                                                       | 2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль                                                                                                |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 16 дугаар зүйл.Ээлжит сонгууль, түүний санал авах өдрийг товлон зарлах<br>16.1.Ээлжит сонгуулийг санал авах өдрөөс <b>65-аас доошгүй хоногийн өмнө</b> товлон зарлана. | <b>9 дүгээр зүйл.Сонгууль товлон зарлах</b><br>9.1.Улсын Их Хурал ээлжит сонгуулийг <b>сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө</b> товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно. |

Энэ зүйл заалтын хувьд 02-р сарын 01-нээс өмнө УИХ-ын сонгуулийг товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно. Санал авах өдөр нь 06-р сарын сүүлийн хагасын ажлын өдөр байна гэж заасан. Өмнөх УИХ-ын сонгуулиудын санал авах өдрийг 06-р сарын сүүлчээр товлдодог байсан жишгээрээ тогтоосон. Энэ заалт нь санал авах өдрийг тодорхой байдлаар сарын өдрийг нь зааж өгсөнөөрөө онцлогтой.

<sup>48</sup> Монгол Улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2019.

| 2015 оны 12-р сарын 25-нд батлагдан<br>өмнө нь мөрдөгддөг байсан Монгол улсын<br>сонгуулийн тухай хууль                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн<br>батлагдсан Монгол Улсын Их Хурлын<br>сонгуулийн тухай хууль                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 22 дугаар зүйл. Сонгуулийн тойрог<br>22.4. Улсын Их Хурлын сонгуулийг<br>явуулах зорилгоор Монгол Улсын нутаг<br>дэвсгэр нь сонгуулийн тойрогт хуваагдана.<br>22.5. Улсын Их Хурлын сонгуулийн<br>тойргийг энэ хуульд заасан сонгуулийн<br>тогтолцоо, аймаг, нийслэл, сум, дүүргийн<br>хүн амын тоо, засаг захиргаа, нутаг<br>дэвсгэрийн нэгжийн хуваарийг харгалзан<br>санал авах өдрөөс 45-<br>аас доошгүй хоногийн өмнө Улсын Их<br>Хурал байгуулж, тойргийн нутаг дэвсгэр,<br>дугаар, төв, мандатын тоог тогтооно. | <b>11 дүгээр зүйл. Сонгуулийн нутаг дэвсгэр,<br/>тойрог</b><br>11.1. Сонгуулийн нутаг дэвсгэр нь Монгол<br>Улсын нутаг дэвсгэр байна.<br>11.2. Сонгуулийн нутаг дэвсгэр нь тойрогт<br>хуваагдана.<br>11.3. Сонгогчийн саналыг авах, тоолох<br>зорилгоор тойрог нь хэсэгт хуваагдана.<br><b>12 дугаар зүйл. Сонгуулийн тойрог<br/>байгуулах</b><br>12.1. Улсын Их Хурал ээлжит сонгуулийн<br>жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө<br>сонгуулийн тойрог /цаашид “тойрог” гэх/-ийг<br>байгуулна. |

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01-р сарын 30-ны өдрийн 15-р тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” тогтоож өгсөн байна. Тодруулбал, 2020 оны 01-р сарын 30-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2020 оны УИХ-ын сонгууль нийт 29 тойрогтой байхаар тогтоосон. Мөн орон нутагт 20 тойрог, нийслэлд 9 тойрог байхаар тогтоосон.

Тойрог хуваарилсан байдлыг тодруулбал:

1. Дундговь, Говьсүмбэр аймгийн нэгтгэн сонгуулийн 6-р тойрог
2. Багахангай, Багануур, Налайх дүүргийг нэгтгэн сонгуулийн 21-р тойрог
3. Баянзүрх дүүргийн 4, 5, 6, 8, 13, 14, 15, 16, 18, 25, 26 дугаар хороог нэгтгэн сонгуулийн 22-р тойрог
4. Баянзүрх дүүргийн 1, 2, 3, 7, 9, 10, 11, 12, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 27, 28 дугаар хороог нэгтгэн сонгуулийн 23-р тойрог
5. Сонгинохайрхан дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 20, 22, 24, 26, 32, 33, 34, 35, 36, 37, 41 дүгээр хороог нэгтгэн сонгуулийн 27-р тойрог
6. Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 21, 23, 25, 27, 28, 29, 30, 31, 38, 39, 40, 42, 43 дугаар хороог нэгтгэн сонгуулийн 28-р тойргийг тус тус байгуулахаар болов.
7. Бусад аймаг болон нийслэлийн бусад дүүргүүд тус бүрдээ сонгуулийн нэг, нэг тойрог байхаар зохицуулсан байна.

2020 оны УИХ-ын сонгуулийн тойрог хуваарилсан байдлыг харуулбал:<sup>49</sup>

| Аймгийн нэр | Мандатын тоо | Хүн амын тоо     |
|-------------|--------------|------------------|
| Баян-Өлгий  | 3            | 103,765          |
| Говь-Алтай  | 2            | 58,280           |
| Завхан      | 2            | 73,088           |
| Увс         | 3            | 83,617           |
| Ховд        | 3            | 88,447           |
| Архангай    | 3            | 95,994           |
| Баянхонгор  | 3            | 88,359           |
| Булган      | 2            | 61,794           |
| Орхон       | 3            | 103,217          |
| Өвөрхангай  | 3            | 116,645          |
| Хөвсгөл     | 3            | 134,371          |
| Говьсүмбэр  | 2            | 17,489           |
| Дундговь    |              | 46,820           |
| Дархан-Уул  | 3            | 104,238          |
| Дорноговь   | 2            | 69,560           |
| Өмнөговь    | 2            | 69,124           |
| Сэлэнгэ     | 3            | 109,255          |
| Төв         | 3            | 95,045           |
| Дорнод      | 2            | 82,295           |
| Сүхбаатар   | 2            | 62,611           |
| Хэнтий      | 3            | 77,664           |
| <b>Нийт</b> | <b>52</b>    | <b>1,741,678</b> |

| Дүүргийн нэр | Мандатын тоо |  | Хүн амын тоо |
|--------------|--------------|--|--------------|
| Багануур     | 2            |  | 29512        |
| Багахангай   |              |  | 4399         |
| Налайх       |              |  | 37608        |
| Баянзүрх     | 5            |  | 343619       |
| Баянгол      | 3            |  | 226869       |

<sup>49</sup> <https://ikon.mn/n/1so2>

|                |           |  |                  |
|----------------|-----------|--|------------------|
| Сонгинохайрхан | 5         |  | 321150           |
| Сүхбаатар      | 3         |  | 145335           |
| Хан-Уул        | 3         |  | 178919           |
| Чингэлтэй      | 3         |  | 157258           |
| <b>Нийт</b>    | <b>24</b> |  | <b>1,444,669</b> |

УИХ-ын сонгуулийн мандатын хуваарилалтыг хийхдээ нийслэлд 24 мандат, орон нутагт 52 мандат байхаар тогтсон. Үүнээс харахад нийслэлээс 4 мандатыг хасч, орон нутагт нэмсэн байна. Тойрог, мандатын хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, байршил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг харгалзсан гэж үзсэн. Гэхдээ энэ нь тойргийн хэмжээг ингэж харилцан адилгүй зааж, орон нутагт мандатын тоог нэмж, нийслэлээс тойрог, мандатын тоог хасаж тогтоосон нь зарим сөрөг үр дагаврыг бий болгож болох юм. Тухайлбал, тойргийн тооноосоо шалтгаалж нийслэлд хөрөнгө оруулалт бага очиж, нийслэлийн хөгжил, бүтээн байгуулалт багасах, 1992 онд нийслэлд хүн амын 26.6% амьдарч байхад мандатын 26.3% ногдож байсан бол одоогийн байдлаар Хүн амын 45 хувь нь амьдардаг нийслэлийн иргэдийн УИХ-д төлөөлөх хувь 31 хувь байгаа нь тэгш эрхийн зарчмыг зөрчиж байна. Энэ үүднээсээ ч УИХ-ын 76 мандатаас нийслэл Улаанбаатар хотод 24 тооны мандат хуваарилсан нь Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2, 2-р зүйлийн 1-д “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна” гэснийг тус тус зөрчиж байна гэж үзэж зарим хуульчид Үндсэн хуулийн цэцэд хандсан байна.

#### Улс төрийн нам, эвсэл сонгуульд оролцох талаар

| 2015 оны 12-р сарын 25-нд батлагдан өмнө нь мөрдөгдөг байсан Монгол улсын сонгуулийн тухай хууль                                                                                                                                            | 2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль                                                                                                                                                                                                                                                  |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Нам нь сонгуульд оролцох хүсэлтдээ дараахь баримт бичгийг хавсаргана гэсэн хэсэгт:<br>121.3.7 сүүлийн нэг жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан; | 26.3.6.ээлжит <b>сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд</b> , ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан; |
| 121.4.6 сүүлийн нэг жилийн хугацаанд эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;                                                                      | 26.4.6.ээлжит <b>сонгуулийн жилийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд</b> , ээлжит бус, нөхөн сонгуулийн тухайд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд уг намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан; |

### **Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх талаар**

2016 оны УИХ-ын сонгуулийг явагдахаас өмнөхөн тулгаж сонгуулийн тогтолцоог өөрчилсөнтэй холбоотойгоор УИХ нэр дэвшигчдийн бүртгэлийн эцсийн хугацааг 57 хоног гэж заасан байсныг 25 хоног болгож өөрчилсөн. Энэ нь Сонгуулийн Ерөнхий Хороонд дарамт шахалт, ачаалал бий болгосон. Гэхдээ ч нэр дэвшигчдийн бүртгэл бүх талын төлөөллийг оролцуулсан, сонгогчдод улс төрийн олон сонголтыг өгч чадсан.

2016 оны УИХ-ын сонгуулийн өмнө Сонгуулийн Ерөнхий Хороонд 12 улс төрийн нам, 3 эвсэл бүртгэгдсэн. Хоёр улс төрийн намыг хуулийн хүрээний шаардлага хангаагүй гэсэн шалтгаанаар бүртгэхээс татгалзсан. Сонгуулийн Ерөнхий Хорооноос бүртгэхээс татгалзсан тухай асуудал нь зарим нэг улс төрийн намын нэхэмжлэл шат шатны шүүхийн шатанд сунжирч байсан нь сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх журам тодорхой бус, алдаатай байгааг харуулж байсан<sup>50</sup>. Түүнчлэн нэр дэвшигчдийн бүртгэлтэй холбоотой 19 хэргийг хэрэг үүсгэхээс татгалзах, эсвэл цаг хугацаанд нь ил тод байдлаар шийдвэрлээгүй нь тэдний шүүхээр хамгаалуулах эрхийг нь хязгаарлаж байсан асуудал болсон.

2015 онд батлагдсан сонгуулийн тухай хуулиар өргөдөл гомдол гаргах, давж заалдах үйл явцыг тодруулж өгсөн. Сонгуультай холбоотой өргөдөл, гомдлыг шүүхээр шийдвэрлэх хуулийн эцсийн хугацааг багасган ч хэт удаашралтай хэвээр байна.<sup>51</sup> Мөн сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаа нь албан ёсны бус болон ил тод байх явдал учир дутагдалтай байна. Мөн гомдлыг удаашруулах нь шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг нь бууруулж байна.

Харин УИХ-ын сонгуулийн тухай хуулийн шинэ хуулиар “28.5. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуульд заасны дагуу нам, эвслийг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт, лавлагааг холбогдох этгээдээс гаргуулан авах эрхтэй.”<sup>52</sup> гэсэн заалтыг шинээр оруулж ирсэн. Энэ нь нам, эвслийг бүртгэхдээ шаардагдах баримт лавлагаа нь тодорхой болгосноор аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлэхэд тус дөхөмтэй заалт болсон.

### **Нэр дэвшүүлэх нийтлэг журмын талаар**

| 2015 оны 12-р сарын 25-нд батлагдан өмнө нь мөрдөгдөг байсан Монгол улсын сонгуулийн тухай хууль                                                                                                                                                                                       | 2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль                                                                  |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 125.1 Сонгуульд оролцох нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс <b>37 хоногийн өмнө эхлүүлж, тав хоногийг хугацаанд дуусгана. (өмнө нь 55 хоногийн өмнө эхлүүлж, тав хоногийн хугацаанд дуусгана гэснийг 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)</b> | 29.1. Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс <b>45 хоногийн өмнө эхлүүлж, 7 хоногийн хугацаанд дуусгана.</b> |
| 125.2 Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс <b>37 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.</b>                                                                                                                                                        | 27.2. Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс <b>45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.</b>                              |

<sup>50</sup> СЕХ-ноос гарсан нэр дэвшүүлэхээс татгалзсан шийдвэр нь түүний ял шийтгэлтэй гэх бүртгэлийг үндэслэсэн. Цагдаагийн газраас түүний үйлдсэн гэмт хэргийн нэг нь 2015 оны "Өршөөлийн тухай" хуулиар өршөөлд хамрагдахгүй учраас ял шийтгэлтэй эсэх тухай бүртгэл нь хэвээр байна гэж тайлбарлав.

<sup>51</sup> Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх сонгуультай холбоотой хэргийг 40 хүртэл хоногийн дотор шийдвэрлэх ба Дээд шүүх 21 хүртэл хоногийн дотор гомдлыг шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн цэцэд хэрэг шийдвэрлэх эцсийн хугацааг заагаагүй байна.

<sup>52</sup> <https://www.ges.gov.mn/> Сонгуулийн Ерөнхий Хорооны вэб сайт. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөл.

(өмнө нь 55 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана гэснийг 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)

**126.2 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх**

126.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна. (Энэ хэсэгт Өмнөх хуульд нэр дэвшигчийн 30-иас доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэж заасан байсныг 2016 оны 05-р сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан).

**30 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх**

30.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нийт нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна.

Энэ зүйл заалтын хувьд УИХ-ын эмэгтэй гишүүд нилээд бухимдалтай хандаж байсан. Монгол улсын хүн амын 51.3 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Энэ нэг талаасаа мөн л сонгох, сонгогдох эрхэд хязгаар тогтоосон асуудал юм. Өнгөрсөн түүхээс харахад 2015, 2016 онд Сонгуулийн тухай хуульд эмэгтэйчүүдийн квот 30-аас доошгүй байсан. Гэтэл 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнөхөн 30 гэсэн квотыг 20 болгож нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хэдийгээр зөвхөн эмэгтэй гишүүдэд хамааралтай бус хуульд аль нэг хүйсийн гэж заасан гэж тайлбарлаж байгаа боловч өнгөрсөн 2016 оны сонгуулиар МАН 20 хувийн квотод тааруулж 16 эмэгтэйг нэр дэвшүүлсэн нь эмэгтэйчүүдэд хамааралтай болохыг харуулж байна.

### **Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар**

2015 оны 12-р сарын 25-нд батлагдан өмнө нь мөрдөгдөг байсан Монгол улсын сонгуулийн тухай хууль

2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль

67.1 Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

38.1.Сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь **дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих** сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

38.6.Нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 03 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

36.7.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

36.8.Төрийн аудитын дээд байгууллага нь нам, эвслийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан

|                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Өмнө нь мөрдөж байсан хуульд энэ заалт байхгүй</b></p> | <p>шаардлагад нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.</p> <p>36.9.Төрийн аудитын дээд байгууллага нь энэ хуулийн 23.3.6-д заасан тайлан, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 22 хоногийн өмнөөс эхлэн өөрийн байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулна.</p> |
|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай шинэ хуулиар дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөртэй байна гэх мэт бусад заалтуудыг тусгасан нь өмнөх хуульд хугацаа заагаагүй байсныг тодорхой болгож хугацаа зааж өгсөн байна.

### **Сонгуулийн сурталчилгааны талаар**

| <p>2015 оны 12-р сарын 25-нд батлагдан өмнө нь мөрдөгдөг байсан Монгол улсын сонгуулийн тухай хууль</p>                                                                                                 | <p>2019 оны 12-р сарын 20-нд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль</p>                                                                                                                                                                   |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>68 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаа Энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгуулийн сурталчилгааг санал авах өдрөөс <b>18 хоногийн өмнө эхлүүлж санал авах өдрөөс нэг хоногийн өмнө</b> дуусгана.</p> | <p>37 дугаар зүйл. Сонгуулийн сурталчилгаа 37.1.Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс <b>24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00.00 цагаас өмнө зогсооно. (сурталчилгааны хугацаа 21 хоног)</b></p> |

2015 оны 12-р сарын 25-ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуулиар албан ёсны сонгуулийн сурталчилгааны хугацааг 21-ээс 18 хоног болгон богиносгосон нь жижиг намууд болон олонд танигдаагүй нэр дэвшигчид, бие даан нэр дэвшигчдэд сурталчилгаа явуулах, өөрсдийгөө бүрэн таниулах хугацаа хомс дутагдалтай тал илэрсэн. Энэ байдал нь олонд танигдсан, төрд олон удаа сонгогдсон улс төрчид болон улс төрийн томоохон намуудад ашигтай байсан нь тэгш шударгаар сонгуульд өрсөлдөх боломжийг хаасан явдал болсон.

2016 оны УИХ-ын сонгуульд сонгуулийн тогтолцоог өөрчлөх заалтыг хэдхэн хоногийн өмнө хийсэн маш их шүүмжлэл дагуулсан бөгөөд сонгогчдод сонгуулийн хуулийн өөрчлөлтийн талаар таниулах, сурталчлах хугацаа байхгүй байгаа нь маш дутагдалтай байсан. Мөн ижил 2019 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуульд сонгуулийн сурталчилгааны хугацаа 18 хоног байсныг 21 хоног болгож өөрчилсөн. Ингэж 2015 оны сонгуулийн тухай хуулиар 21 хоногийг 18 хоног болгосон, 2019 оны УИХ-ын сонгуулийн тухай хуулиар 18 хоногийг 21 хоног болгосноор дэвшилттэй зүйл заалт гэж үзэх нь өрөөсгөл бөгөөд ингэж өөрчилснөөр асуудал шийдэгдэхгүй.

### **Дүгнэлт**

Өнөөгийн Монголын улс төрд эрх зүйт төр, сайн засаглал тогтоох, иргэний нийгэм хөгжүүлэх, ард иргэдэд нийгмийн идэвхи, улс төрийн ухамсар төлөвшүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Ардчилсан сонгуулийг зохион байгуулж явуулахад учирч байгаа гол бэрхшээлтэй асуудал нь сонгуулийн эрх зүйн орчин тодорхойгүй, ойлгомжгүй, цоорхой ихтэй, хяналт, хариуцлагын хатуу тогтолцоог хуульчилж зохицуулаагүй, хэрэгжилтийн байдал сул байна. Монгол улсад сонгуулийн болон бусад эрх зүйн зохицуулалтыг улс төрийн намуудын тохиролцооны хүрээнд шийдвэрлэсээр байна. Ийм учраас улс төрийн намуудын тухай хууль, Сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудыг өөрчлөх, шинэчлэх, боловсронгуй болгох нь хамгийн чухал асуудал юм. Энэ ч үүднээсээ 2019 онд сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж нэг багц хуулиар сонгуулийг зохион байгуулж явуулж байсныг өөрчилж УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн бие даасан тус тусдаа хуулиар зохицуулахаар баталсан. Гэсэн хэдий ч шинэ хуульд нэр дэвшигчдийн цenzур, шалгуур үзүүлэлтийг нарийн тусгаагүй, улс төрийн намуудын бүтэц-зохион байгуулалт, дотоод ардчиллын асуудал, намын санхүүжилт, сонгуулийн үйл явцын үе шат, эрх хэмжээ, хяналт, хариуцлагын тогтолцооны талаар нэг бүрчлэн авч үзээгүй, гадаадад суугаа сонгогчдын эрхийг орхигдуулсан нь ардчиллын үндсэн зарчмуудыг гажуудуулаад зогсохгүй, хуульд буй зарим заалтуудтайгаа зөрчилдөж байгаа зэрэг дутагдлууд ажиглагдсан хэвээр байна.

Цаашид сонгуульд нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн гэж квот тогтоож, ялгаварлахгүйгээр эрх зүйн зохицуулалтдаа тусгавал шударга бөгөөд тэгш эрхийг хангасан алхам болох юм. Мөн нийслэлийн сонгогчид, орон нутгийн сонгогчдын сонголт хийх ялгаатай байдлаас хамаарч орон нутгаас сонгогдох нь төрийн эрхийг ээлжлэн барьдаг хоёр том намаас олон жил төр барилцсан, олонд танигдсан нэр дэвшигчдэд илүү хялбар байх боломжтой байхыг ч үгүйсгэхгүй юм.

2020 УИХ-ын сонгуулийг УИХ-ын 15-р тогтоолоор томсгосон мажоритар тогтолцоогоор явуулахаар Монгол улсыг 29 тойрог болгож томсгосон. Гэхдээ энэхүү өөрчлөлт нь цоо шинэ, шинэлэг өөрчлөлт биш юм. Учир нь өмнөх болж өнгөрсөн сонгуулиудын түүхэнд томсгосон мажоритар тогтолцоогоор 1992 онд болсон анхны УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулсан. Мөн дараа нь 2008 оны УИХ-ын сонгуулийг бас томсгосон тогтолцоогоор явуулсан. Монгол улс томсгосон мажиртар тогтолцоогоор хоёр ч удаа туршиж сонгуулиа явуулж байсан туршлага бий.

Сонгуулийн сурталчилгааны хугацаа 18 хоног байсныг 21 хоног болгож өөрчилсөн нь дорвитой өөрчлөлт гэж үзэхэд бэрхшээлтэй юм. Учир нь 3 хоногоор сунгаснаар бодит өөрчлөлт гарахгүй. Улс төрийн жижиг намууд болон бие даан нэр дэвшигчдэд энэ богино хугацаанд өөрсдийгөө сурталчилж, таниулахад бэрхшээлтэй юм. Энэ заалт нь улс төрийн хоёр том нам болон олон жил төр барилцсан, олонд танигдсан УИХ-ын гишүүдэд давуу талтай заалт гэж үзэж болох юм.

Ардчилсан сонгуулийг шударга явуулахад хэд хэдэн зүйл саад болж байна. Тухайлбал, төрийн эрх барьж байгаа улс төрийн намуудад хэт их давуу байдлыг олгож байна. Сонгогчдын бүртгэлийг үндэс болгож сонгуулийн тойрог тогтоохоос эхлээд сурталчилгаа явуулах, санал хураах, санал тоолох, дүнг гаргах, мэдээлэх хүртэлх бүх үйл явцыг бие даасан, хараат бус сонгуулийн хороод удирдан явуулах хэрэгтэй.

УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн “36.1.Сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна”<sup>53</sup> гэж хугацааг тодорхой зааж өгсөн нь сайшаалтай. Гэхдээ мөрийн хөтөлбөрийн

<sup>53</sup> Мөн тэнд

хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн үр дүн тооцох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх заалтууд энэ хуульд үгүүлэгдсээр байна.

Улс төрийн намуудын зарцуулж болох мөнгөний хэмжээнд хатуу хязгаар тогтоох, сонгуулийн хорооноос баталсан хуваариар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй сурталчилгаа явуулах боломжоор тэгш хангах нь хамгийн чухал юм. Шинэ хуулийн зохицуулалтаар МҮОНТ-ээр зар сурталчилгаа явуулах боломжийг тэгш хангаж, үнэ төлбөргүй сурталчилгаа явуулахаар заасан байна.

Мөн сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг томилох асуудлыг илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай бөгөөд энэ нь дан ганц төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчдаас томилох үндсэн шаардлагаас гадна тухайн төрийн албан хаагчид тусгайлсан шалгуур тавьдаг болох нь сонгогч болон улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллагуудын сонгуульд итгэх итгэлийг нэмэгдүүлэх сайн талтайг анхаарах нь зүйтэй. Дан ганц төрийн албан хаагчдаас сонгуулийн хэсэг, хороодод ажиллах ажилтнуудыг томилж байгаа нь нэг талдаа сайшаалтай хэдий ч нөгөө талдаа төрийн байгууллагуудын ажилтнууд нь тухайн үед төрийн эрх барьж буй нам, эвслийн гишүүд байдаг учир мөн л намдаа үйлчлэх магадлал өндөр. Ийм учраас сонгуулийг зохион байгуулж явуулах сонгуулийн хэсэг, хороодын ажилтнууд нь улс төрийн намаас ангид байж чадах төгс зохицуулалтыг судлан шинжилж хэрэглэх нь зүйтэй.

Монгол улсын сонгогчдыг сонгуульд оролцохыг үүрэг болгосон хуулийн заалт байхгүй байгаа учраас сонгуульд оролцох нь тэдний зөвхөн сайн дурын асуудал төдийгүй тэдний ашиг сонирхлыг хөндсөн сонирхол татсан чухал асуудлуудын нэг гэж сонгогчдын санаа бодолд суухаас нааш сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх нь боломжгүй асуудал хэвээр байна. Сонгуульд оролцоход бэрхшээл учруулж буй хүчин зүйлсүүдийг анхаарч судлан цаашид алдаа дутагдлыг засах, залруулах тал дээр тусгай журам боловсруулж ажиллах шаардлагатай байна. Монголын сонгогчдыг сонгуульд бүрэн хамруулахад чухал ач холбогдолтой асуудлын нэг нь сонгогчдын нэрийн жагсаалтад сонгуулийн насны бүх сонгогчдыг бүрэн хамруулах асуудал юм. Монгол улсын Иргэний Бүртгэл Мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг өндөржүүлж, дээшлүүлэх, хариуцлага тооцох механизмыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байна. Мөн түүнчлэн Монголын сонгогчдын улс төрийн мэдлэг боловсрол, улс төрийн ухамсар, соёлыг дээшлүүлэхүйц зүйл заалтуудыг хуулиндаа тусгах нь зүйтэй.

Монгол улсын бүхий л сонгуулиудад ажиллаж байгаа тэнцвэртэй, үнэн бодит мэдээлэл түгээх үүрэгтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудыг төрөөс хараат бус байлгах нь зүйтэй. Төрийн эрх барьж байгаа намууд хэвлэл мэдээллийг илүүтэйгээр ашигладаг нь сонгуулийн жилүүдийн үйл ажиллагаанаас харагддаг. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгслийг төрөөс хараат бус, намаас хараат бус байлгах, тэнцвэртэй мэдээлэл түгээх орчин бүрдүүлэх, далд болон төлбөртэй сурталчилгаа сонгуулийн үеэр явуулахыг хориглах зэрэг хууль эрх зүйн чанга хатуу зохицуулалт шаардлагатай байна.

Цаашид Монгол улсын Үндсэн хуулиас эхлээд сонгуультай холбоотой бүхий л хууль тогтоомжуудад суурь томоохон өөрчлөлтүүдийг тусгах зайлшгүй шаардлага тулгараад байгаа нь саяханы Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал харуулж байна. Гэхдээ энэ удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлт нь зарим талаар дэвшилттэй хэдий боловч зарим талаар дорвитой барьцтай өөрчлөлт оруулахад бүрэн анхаарч чадаагүй гэж хэлж болно. Тухайлбал, Монгол улсын сонгууль явуулдаг тогтолцоог холимог тогтолцоогоор явуулах талаар яригдаж УИХ-ын чуулганы гуравдугаар хэлэлцүүлэгт энэ санал орсон ч гишүүдийн

ихэнхийн дэмжлэг аваагүйгээс унасан. Монгол улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор холбогдох органик хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал зайлшгүй тулгамдаж байна. Мөн Монгол улсад сонгуулийн болон бусад хууль тогтоомжийг өөрчлөх шаардлага хэдийнээ болсон гэдгийг ч мөн энэ өөрчлөлтүүдээр батлан харуулсан юм.

2020 оны УИХ-ын сонгуульд 15 нам, 4 эвсэл оролцохоор бүртгүүлсэн. Мөн өмнөх сонгуулийн жилүүдийн түүхэнд байгаагүй 208 нэр дэвшигч биеэ дааж нэрээ дэвшүүлж сонгуульд оролцохоор болсноороо бусад сонгуулиудаас онцлог байна. Энэ удаагийн сонгуулиар олон бие даан нэр дэвшигчид өрсөлдөх болсон нь хоёр үндсэн хүчин зүйлээс шалтгаалж байна. Үүнд:

1. Сонгогчид улс төрийн хоёр том намаас дайжих хандлагатай байна.
2. Төрийн босго хэт намхан болсон бөгөөд сонгуульд өрсөлдөх босго, шалгуур үзүүлэлт сул байна.

Иймд эрх зүйн орчинд томоохон суурь өөрчлөлтүүд хийснээр эдгээр бэрхшээлтэй асуудлуудыг багасгах, сайжруулах нөхцөл бололцоо бүрдэнэ гэж үзэж байна. Мөн хуулийг дагаж мөрдөх, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцдог механизмыг маш нарийн, чанга зохицуулж өгөх шаардлагатай байна. Ингэж гэмээнэ Монголын сонгууль шударга явагдаж чадна.

#### ***Цаашид эрх зүйн зохицуулалтад үгүйлэгдэж буй асуудлууд***

1. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг сонгож дэвшүүлэхдээ төрийн бодлого тодорхойлж боловсруулах улс төр, эрх зүй, эдийн засаг болон бусад салбарын өргөн мэдлэг, боловсролтой, мэргэшсэн, өмнө нь авлига, албан тушаалтны хэрэгт холбогдож байгаагүй, ашиг сонирхлын зөрчилгүй гэх мэт маш хатуу (өндөр босго) шалгуур бий болгох талаар эрх зүйд тусгах хэрэгтэй. Хуульд ямар зүйл заалт оруулбал хандив нэрээр өгдөг авилгалыг өөгшүүлэхгүй байж болох талаар нухацтай судлах нь зүйтэй.
2. Төрөөс зохих хувиар намыг санхүүжүүлж, гишүүдийн хандивын хэмжээг багасгаж, мөнгөний хэмжээг тодорхой тусгаж, намын санхүүжилтыг хянадаг хатуу тогтолцоог эрх зүйдээ тусгах нь зүйтэй байна. Ингэснээр төрд бизнесийн бүлэглэл гарч ирэхээс сэргийлнэ.
3. Сонгуулиар ялалт байгуулсан улс төрийн намд өгдөг төрийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулалт болон иргэд, байгууллагуудаас өгсөн хандивын талаар эргэж тайлагнадаг, мэдээлдэг, тайлагнаагүй намд хатуу хариуцлага тооцдог болгох шаардлагатай.
4. Төрөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг үр ашиггүй, буруу зүйлд зарцуулсан, хувьдаа ашигласан тохиолдолд УИХ-ын гишүүнээс эргүүлэн татаад зогсохгүй хохирлыг эргэн төлүүлдэг төрөөс хянаж, хариуцлага тооцдог болох нь зүйтэй.
5. УИХ-ын гишүүд хариуцлага алдахад зөвхөн үүрэгт ажлаас нь чөлөөлөөд зогсохгүй учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, төрийн өндөр албан тушаал хаших эрхийг нь тодорхой хугацаагаар эсвэл бүр мөсөн хаах, тухайн харъяалах улс төрийн намд ч хариуцлага тооцох гэх мэт эрх зүйн зохицуулалт тусгах шаардлагатай.
6. УИХ-ын гишүүд сонгуулийн мөрийн хөтөлбөрийн биелэлтээ жил бүр тайлагнадаг. Мөрийн хөтөлбөрийн ихэнхи нь хэрэгжээгүй тохиолдолд хариуцлага тооцох, эргүүлэн татах зэрэг арга хэмжээ авахаар хуульд тусгах хэрэгтэй. Тодруулбал, жил бүр мөрийн хөтөлбөрийн хэдэн заалт хэрэгжсэн талаараа мэдээлдэг, ард түмэн нь хянадаг, дүгнэдэг тогтолцоонд шилжих нь зүйтэй.

7. Улс төрийн нэг хүчин дангаараа төрийн эрхийг барьж байгаа нөхцөлд Засгийн газрын тогтвортой байдлыг хэрхэн хангах талаар хуулийн зүйл заалтад тусгах хэрэгтэй. Хэрэв Засгийн газрын тогтвортой ажиллуулаагүй тохиолдолд тооцдог хатуу хариуцлагын механизм бий болгох шаардлагатай.
8. Монгол улсад ардчилсан сонгуулийн үндсэн зарчмуудыг гажуудахаас сэргийлсэн зүйл, заалтын талаар нарийвчлан эрх зүйдээ тусгах, сонгуулийн үндсэн зарчмуудын гажуудлыг арилгасан заалтууд оруулах. (гадаад суугаа Монгол улсын иргэдийг сонгууль өгөх эрхийг нь хуулиар баталгаажуулах)
9. Сонгуулийн Ерөнхий Хороо нь нам, сонирхлын бүлгээс хараат бус бие даасан байх бүхий боломжийг бүрдүүлж хуульчлан баталгаажуулах нь зүйтэй.
10. Сонгогчдын оролцоог нэмэгдүүлэхийн тулд сонгуульд оролцохыг уриалсан, ухуулга сурталчилгааг нийтэд хүргэх, түгээх, сонгогчдын улс төрийн эрх, үүргийг ойлгуулах таниулах, энэ ажилд хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах, мөн түүнчлэн сонгууль өгсөн сонгогчдод урамшууллын ямар нэг хэлбэрийн заалт оруулж ч болох юм. (сонгуулийн өгсөн иргэдэд нэг өдрийн, эсвэл хагас өдрийн цалингаар урамшуулах гэх мэт).
11. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хаалтын гэрээг хориглох, төлбөртэй далд сурталчилгааг багасгах, эрх баригч нам, эвслээс хараат бус байх, тэнцвэртэй мэдээллээр хангах бүхий л боломжийг бүрдүүлсэн заалтын нарийн тодорхой болгож оруулах. Зөрчсөн тохиолдолд хүлээдэг хариуцлагыг өндөрсгөх.
12. Сонгуулийг шударга бус болгодог бас нэг асуудал нь улс төрийн нам, нэр дэвшигчдийн хууль бус үйлдэл, авилга өгөх, авах, гүтгэх, дайрч доромжлох, дарамт үзүүлэх, сонгогчдын саналд нөлөөлөх, сонгогчдыг дахин санал өгүүлэх гэх мэт бусад хууль бус олон үйлдлүүдийг хийдэг. Үүнээс сэргийлэх заалтуудыг нарийн нэг бүрчлэн ойлгомжтой хуульчлах нь зүйтэй. Сонгуулийн бохир технологи ашиглаж шударга бусаар өрсөлдсөн, хууль бус сурталчилгаа явуулсан, сонгуулийн хууль зөрчсөн нам, эвсэл, нэр дэвшигчдэд хариуцлага тооцох талаар хуульд заасан ч бодит байдалд хэрэгжихгүй байна. Ийм учраас хариуцлагын тогтолцоог улам бүр тодорхой болгож хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэрэв бохир технологи ашиглаж, шударга бусаар ялалт байгуулсан нь тодорхой болсон тохиолдолд ялалтыг хүчингүй болгох гэх мэт хяналтын хатуу тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.
13. Сонгуулийн үйл ажиллагаанд эрх барьж буй намууд төрийн санхүүгийн эх үүсвэрүүдийг ашиглах байдал ажиглагдсаар байна. Тухайлбал төрийн албан хаагчид, төрийн байгууллагын эд хөрөнгө байр, машин техник хэрэгсэл, төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт. Төрийн санхүүгийн эх үүсвэрийн сонгуульд ашиглахгүй байх заалт зарим хуульд туссан байдаг. Гэсэн хэдий ч дээрх заалт огт хэрэгждэггүй, түүнийг дагаж мөрдөхгүй байна. Хуулийн заалт зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна. Цөөн тохиолдолд зөвхөн торгуулийн арга хэмжээ аваад л өнгөрдөг. Энэ талаар холбогдох хууль журамд нарийн тодорхой зохицуулалт хийх шаардлагатай байна.
14. Өмнө нь хэрэгжиж байсан Сонгуулийн тухай хууль болон, 2019 онд шинэчлэн баталсан УИХ-ын сонгуулийн хуульд гадаадад суугаа **Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах талаарх зохицуулалт тусгаагүй. СЕХ-ны дарга гадаадад байгаа Монгол улсын сонгогчдоос холимог тогтолцооны үед энэ асуудлыг зохицуулж байсан. Энэ удаад зохицуулах боломжгүй гэж тайлбарласан. Ерөнхийлөгчийн**

сонгуулийг явуулахдаа гадаадад суугаа Монгол улсын иргэдийн сонгох эрхийг баталгаажуулж зохицуулалт хийсэн хирнээ УИХ-ын сонгуулийг явуулахдаа гадаадад суугаа иргэдийн сонгох эрхийг хасч байгаа нь:

- УИХ-ын сонгуулийн тухай шинэ хуулийн 5 дугаар зүйл. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх: 5.1. Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шаашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.
- “7 дугаар зүйл. Сонгуулийн зарчим. 7.1. Сонгуулийн зарчим нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад үндэслэнэ, 7.2. Сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй, 7.3. Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа нууцаар гаргана”<sup>54</sup> гэх зэрэг зүйл заалтуудыг зөрчсөн явдал болж байна. Мөн дээр нь Монгол улсын иргэд бүх нийтээрээ сонгуульд оролцох ардчилсан сонгуулийн үндсэн зарчмууд болох бүх нийтийн болон тэгш эрхийн зарчмуудыг зөрчиж байна. Иймд УИХ-ын сонгуулийн хуульд гадаадад суугаа иргэдийн сонгох эрхийг баталгаажуулж өгөх хэрэгтэй.

### **Abstract**

It is impossible to discuss all the articles of Election laws, or Parliament, as well as Local Elections only in this article. Thus, it discusses the changes in election laws, its implementations, consequences, some differences of new amended laws of election, some proper requirements to develop election laws, and proposals to make amendments in the election law. The purpose of this paper is to compare some articles related to only political parties to make distinctions between current election laws and newly developed bills of election laws of the parliament in 2019. Key words: Election, Democracy, Election law, Parliamentary elections.

**Key words:** emocracy, Democratic Election, Election law, Electoral institution, Electoral principle, Party, Voter's participation, The State Great Hural election.

### **Ашигласан эх сурвалж**

1. Д.Чулуунжав. Монгол төрийн тогтолцоо, түүний хууль эрхийн үндсүүд дэх дутагдлал, согог, асуудлууд (1990-1999). УБ., 1999
2. Ж.Ядамсүрэн. Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. УБ., 2002
3. Сонгогчдын боловсрол төв. Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. УБ., 2003
4. Г.Бурмаа. Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. УБ., 2004
5. Д.Түмэнжаргал. Монголын сонгуулийн систем. УБ., 2012
6. Монгол улсын Үндсэн хууль. УБ., 1992
7. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль. УБ., 2006
8. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 1992
9. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 1996
10. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2005
11. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2008

<sup>54</sup> Монгол УИХ-ын сонгуулийн тухай хууль. УБ., 2019 он.

12. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2008
13. Монгол дахь сонгуулийн үйл явц: онол, практик \эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл\.. УБ., 2009
14. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль.УБ., 2011
15. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2011
16. Сонгуулийн баримт бичгийг бүртгэх, хүлээлцэх журам. УБ., 2012
17. Монгол улсын Сонгуулийн тухай хууль. УБ., 2015
18. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт" (*Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон*)
19. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2019
20. <https://www.geg.gov.mn/>

**УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮД, ДЭМЖИГЧДИЙН  
ОРОН ЗАЙН ТАРХАЛТЫГ СОНГУУЛИЙН ГАЗАРЗҮЙН  
ҮҮДНЭЭС ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА  
/УИХ-ын 2016 оны сонгуулийн 60-р тойргийн жишээн дээр/**

**Д.Оюунчимэг**

МУИС, ШУС, Нийгмийн Ухааны Салбар,  
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

**Г.Цогтдэлгэр**

МУИС, ШУС, Байгалийн Ухааны Салбар,  
Газарзүйн тэнхимийн докторант

**Түлхүүр үгс:** Сонгууль, нам, үзэл баримтлал, халуун цэгийн шинжилгээ, орон зайн төлөв

**Оршил**

Аливаа байгаль, нийгмийн үзэгдэл үйл явц өөрийн гэсэн орон зай, цаг хугацааны хүрээнд явагддаг. Байгалийн үзэгдэл үйл явцыг тусгай аргачлалын дагуу орон зайн хил хязгаарыг судалсан байдаг боловч нийгмийн үйл явцын орон зайн хил хязгаарыг төдийлөн тодорхойлж чадаагүй байна. Нийгмийн үзэгдэлд үйл явц болох улс төрийн нам хүчний байршил, сонгуулийн үйл явц зэрэгт орон зайн хил хязгаарыг тогтоох хэрэгтэй юм. Түүнчлэн сонгуулийн үйл явц, сонгогчдын үзэл хэрхэн хувьсан өөрчлөгдөж болох сонгуульд хэрхэн нөлөөлөх зэргээс орон зайн ялгарал гарна. Аливаа сонгуулийн үйл явц нутаг дэвсгэрт явагдах бөгөөд оршин суугчдын хувьсан өөрчлөгдөж байгаа хандлага, үзлийг тодорхойлох нь чухал юм. Мөн тухайн иргэдийн үзэл, хандлага нь улс төрийн шийдвэр, сонгуульд нөлөөлж байгааг тодорхойлох юм. Улс төрийн чиглэлээр судалгаа явуулдаг байгууллагууд, улс төр судлаач нар намуудын төлөвшилт, сонгуулийн систем, улс төрийн пи-ар, улс төрийн хэв маяг зэргийг судалж байгаа боловч сонгуулийн газарзүйн судалгаа орхигдож байна. Иймээс орон зайн шинжилгээний зарим асуудлыг болон сонгуулийн газарзүйн судалгаа хийх зорилт тавин судалсан.

Газарзүйн шинжлэх ухааны судалгаанд аливаа нийгмийн болон байгалийн юмс үзэгдлийн орон зайн шинжилгээ, бүс нутаг, хүн ам ба газар зүйн хоорондын хамаарал болон дэлхий судлалтай холбоотой судалгаа багтдаг байна (Pattisom 1990). Сүүлийн жилүүдэд сонгуулийн газарзүйн судалгааны ажлыг Флориан Стоффил, Халлдор Жанетзко, Флориан Манстанн нар болон Ж.Эгнивтүлхүү судалж байна. Улс төрийн нам хүчин ард иргэдэд хэрхэн хүрч ажиллах, иргэдийн улс төрийн үзэл баримтлал хэрхэн өөрчлөгдөх, улс төрийн нам хүчний байгууллагууд хэрхэн зөв оновчтой ажиллахыг сонгуулийн газарзүйн судалгаагаар тодорхойлох боломжтой юм. Манай улсын нийгмийн үзэгдэл үйл явцыг хэрхэн, хувьсан өөрчлөгдөж байгааг тогтоож байгаа юм.

### ***Судалгааны арга, аргазүй***

Энэхүү судалгаа нь иргэдийн үзэл баримтлалын мэдээлэл төр, захиргааны байгууллагууд, нам, улс төрийн хүчнүүдэд тойм байдлаар байх боловч иргэн нэг бүрийн үзэл баримтлалын мэдээлэл, өөрчлөлт нь байдаггүй. Тиймээс мэдээ, мэдээллийг цуглуулахын тулд социологийн судалгааны арга, аргачлалыг ашигласан. Аливаа судалгааны ажил амжилттай болох үндэс нь судалгааны зорилго зорилтод нийцсэн судалгааны арга зүйгээ зөв тодорхойлоход оршино (McDaneil, Gates 2012). Тиймээс төлөөлөх чадвар бүхий олон тооны оролцогчдыг хамарсан, мэдээллийг үнэн зөв хариулах боломжтой, шалгах аргачлалыг тусгасан судалгааны арга нь асуулгын арга юм. Асуулга нь эх олонлогоос мэдээлэл цуглуулж авах хэлбэрийн хувьд бичгийн болон аман гэж ангилна. Тус судалгаанд бичгийн буюу анкетын аргыг ашигласан.Брайманы (1989) тодорхойлолтоор асуулгын судалгаа гэдэг нь хэд хэдэн хувьсагчийн тухайд тоогоор илэрхийлж болох мэдээллийг системтэй цуглуулахын тулд хэд хэдэн нэгжээс ихэвчлэн цаг хугацааны тодорхой нэг мөчид мэдээлэл цуглуулан авч дараа нь уялдаа хамаарлын зүй тогтлыг шинжлэх явдал юм (Колин, Робсон 2006). Анкетын арга гэдэг бол судлах асуудал, судалгааны зорилгоос хамаарч нийгмийн үзэгдэл, үйл явцын тоо чанар, шалтгаан үр дагаврын холбоо, учир холбогдол, онцлогийг нээн илрүүлэхэд чиглэгдсэн тодорхой агуулга, бүтэц, зохион байгуулалт, дарааллаар урьдчилан бэлтгэж хэвлэсэн асуулт хариултын цогц юм (ШУА 2008). Анкетын загварыг үндсэн хоёр хэсгээс бүрдүүлсэн. Нэгдүгээр хэсэг нь хувь хүний мэдээллийн хэсэг болох боловсрол, нас, хүйс, яс үндэс, өрхийн орлого зэрэг болно. Хоёрдугаар хэсэг нь улс төрийн мэдээлэл болох улс төрийн намын гишүүнчлэл, сонгуульд санал өгсөн байдал зэргийг оруулсан.

Нийт эх олонлогоос бүгдээс нь судалгаа авах нь цаг хугацаа, зардлын хувьд маш өндөр тул нийт эх олонлогоос авсан хэмжээний ижил үнэн зөв дүн гаргах стратеги нь түүвэрлэх явдал юм. Судалгааны эх олонлог буюу 20125 сонгуулийн насны хүн амаас 99%-ийн магадлалаас  $\pm 6\%$ -иар тооцоолж нийт 480 оролцогчдыг сонгож авсан. Тухайн судалгааны үнэмшил хамгийн багадаа 93%-ийн магадлалтай буюу түүнээс дээш хувь гэсэн үнэлгээтэй байна. Социологийн судалгааны байгууллагуудын хувьд 93%-ийн магадлалтай түүврийн хэмжээ нь нарийн төвшний судалгаанд тооцогддог. Эх олонлогийн мэдээллийг цуглуулж авахдаа кластерын түүврийн аргыг ашигласан. Кластер түүврийн аргачлал буюу олон шатлалт санамсаргүй бүсчлэл нь судалгаанд оролцогч хүмүүсийг түүврийн гишүүн гэж үзэхээс илүү өөрийн оршин суудаг нутаг дэвсгэрт хамаатуулан авч үзнэ. Тогтмол оршин суудаг газраас судалгааг авснаар хөдөлгөөнтэй байгаа хүмүүсээс авснаас илүү үр дүнтэй гардаг. Сонгуулийн үр дүнг бүс нутаг, улсын хэмжээний зураглах ажил хийгдэж байсан. Нутаг дэвсгэрийн засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн статистик баримт мэдээлэл дээр тулгуурлан дүн шинжилгээ гаргаж авдаг. Энэхүү арга нь талбайн (polygon) хэмжээнд орон зайг мэдээлэл ашиглан дүрслэн гаргадаг. Судалгааны талбайнхувьд микро төвшний боловсруулалт хийх тул засаг захиргааны хил хязгаарын мэдээллээс нарийн гаргах шаардлагатай юм. Зураглалын арга, аргачлалыг ашиглан талбайн (polygon) мэдээллээс маш нарийн мэдээлэл ашиглах тул үндэс эх сурвалжийг цэг (point) хэлбэрээр мэдээллийг цуглуулан боловсруулалт хийх шаардлагатай юм. Цэгэн мэдээлэл дээр ашиглах нь нарийвчлал сайтай гарна. Цэгэн мэдээллийг боловсруулах аргыг нийгмийн үйл явц болох гэмт хэргийн шинжилгээнд, халуун цэг (hot spot) шинжилгээнд ашигладаг. Цэгэн мэдээлэл дээр боловсруулалт хийх нь нарийвчлал сайтай бөгөөд орон зайн хил хязгаарыг тогтоох боломжтой юм. Энэхүү судалгаа нь 2017 оны V сараас X сарын хооронд явагдсан судалгааны үр дүнгээс танилцуулж байна.

**Судалгаанд хамрагдсан иргэдийн мэдээлэл**

Энэхүү судалгааны талбарыг сонгохдоо гэр хорооллын болон орон сууцны нутаг дэвсгэрийг хамруулсан нутаг дэвсгэрийг сонгох шаардлага тавьсан. Тус талбарыг нь орон зайн болон нутаг дэвсгэрийн ялгавартай байдлыг шалгуур болгож сонгосон. Судалгааны талбайд Сүхбаатар дүүргийн VII, VIII, IX, X-р хороод буюу нийт 4-н хороог хамруулсан. Судалгаанд нийт 480 иргэн (2017/05-2017/11) оролцсон бөгөөд алдааны магадлалыг 99%-иар тогтоож 6%-ийн хэлбэлзэлтэй. Эх олонлогийг түүвэрлэх боломжит хамгийн бага хувилбар 93%-ийн магадлалтай. Судалгаанд оролцсон иргэдийн нас, хүйсийн бүтцийг доорх хүснэгтээс үзнэ үү.

**Хүснэгт 1. Судалгаанд оролцсон иргэдийн нас, хүйсний байдал**

| №        | Хамрагдах дүүрэг | УИХ –ын сонгуулийн тойрог | Хороод               | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | Хүйсний харьцаа |       |
|----------|------------------|---------------------------|----------------------|------------------------------------|-----------------|-------|
|          |                  |                           |                      |                                    | Эр              | Эм    |
| 1        | Сүхбаатар дүүрэг | 60-р тойрог               | 7-р хороо            | 120                                | 38,3%           | 61,6% |
| 2        |                  |                           | 8-р хороо            | 120                                | 35,8%           | 64,1% |
| 3        |                  |                           | 9-р хороо            | 120                                | 40,8%           | 59,1% |
| 4        |                  |                           | 10-р хороо           | 120                                | 41,6%           | 58,3% |
| Нийт тоо |                  |                           | 7, 8, 9, 10-р хороод | 480                                | 39,3%           | 60,7% |

**Судалгааны үр дүн**

Нийгэм, эдийн засгийн газарзүйн судалгааны үндсэн үзүүлэлт бол хүн амын байршил, тархалт орно. Сонгуулийн тойрог, мандатын тоо, сонгуулийн тойргийн хилийг тогтооход сонгогчдын тоог харгалзан үзэж тогтоодог. Монгол улсын Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол улс гурван сая гаруй иргэнтэй бөгөөд үүний 1,4 сая иргэд нь Улаанбаатар хотод оршин сууж байна (Монгол улсын статистикийн хороо 2017). Монгол улсын үндэсний статистикийн хорооны Улаанбаатар хотын хүн амын тархалтыг байршлаар нь авч үзвэл Баянзүрх дүүргийн 5-р хороонд 20959 буюу хамгийн их хүн оршин сууж байна. Мөн 16-р хороо, 8-р хороонд 16000 гаруй иргэд оршин сууж байгаа нь хүн ам ихээр суурьшсан нутаг дэвсгэр юм. Сүхбаатар дүүргийн хороодод 3000-11000 орчим хүн амтай байгаа нь бусад дүүрэгтэй харьцуулахад хүн ам багатай нутаг дэвсгэр юм. Чингэлтэй дүүргийн 12-р хороо, 17-р хорооны хүн ам 14000 гаруй байгаа нь дүүрэгтээ хамгийн их хүн амтай хороо болж байна. Тус хороонд томоохон худалдааны байгууллагууд ихээр төвлөрсөн Дэнжийн мянга гэж нэрлэсэн нутаг дэвсгэр юм. Хан-уул дүүргийн 11-р хороо нь дүүрэг дотроо хамгийн олон хүн амтай буюу 14000 гаруй хүн амтай. Тус хороо нь шинээр баригдсан барилга байгууламж ихтэй Удирдлагын Академи их сургуулийн орчим юм. Баянгол дүүргийн 1, 6, 7-р хороод нь дүүрэг дотроо хамгийн олон 16000-17000 орчим хүн амтай. Сонгино-хайрхан дүүрэгт 7, 22, 26-р хороод 17000-20000 гаруй хүн амтай, хотын хэмжээнд хүн ам ихтэй хороод юм. Тус хороод нь гэр хорооллын бүсэд хамаарагдах бөгөөд шинэ оршин суугчид нэмэгдэх хандлагатай байна.

Монгол улсад сонгуулийн насны нийт хүн амын тоо, хүн амын байршлыг харгалзаж сонгуулийн тойргуудыг байгуулдаг. 1992-2016 оныг хүртэл нийт 7 удаа УИХ-ын сонгууль болж өнгөрсөн бөгөөд сонгууль болохоос өмнө УИХ-ын сонгуулийн тойрог байгуулах,

мандатын тоо, тойргийн төвийг батлан гаргадаг. 1992 оноос хойш 5 удаа УИХ-ыг 76-н тойрог болгож, 2 удаа 26-н тойрог болгон хуваажээ. 2011 оны 12 сарын 28-ны УИХ-ын 67-р тогтоолын дагуу УИХ-ын сонгуулийн тойргийг 26 тойрог болгож хуваасан байдаг (Сонгуулийн ерөнхий хороо). Тухайн тойрог тус бүрийн сонгуулийн насны хүн амын тоо зэргийг харгалзаж, мандатын тоог батлан гаргасан. Мандатын тоо нь сонгуульд нэр дэвшигч нарыг гаргах боломжтой хэмжээ юм. УИХ-ын сонгуулийг Нэг мандаттай тойргууд нь Булган, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар зэрэг аймгууд ба Дорноговь, Говьсүмбэрийг нэгтгэж нэг мандаттай тойрог болгосон. УИХ-ын сонгуулийн хоёр мандаттай тойргууд нь Архангай, Баян-Өлгий, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Улс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон аймгууд юм. Улаанбаатар хотыг УИХ-ын сонгуулийн 6 тойрог болгож хуваасан. Үүнд: Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол зэрэг дүүргүүдийг хоёр мандаттай тойрог болгож Хан-Уул, Багахангай, Багануур зэрэг дүүргүүдийг нэгтгэж хоёр мандаттай тойрог болгосон. Үлдсэн Сонгино-хайрхан, Баянзүрх дүүргүүдийг гурав мандаттай тойрог болгож хуваасан. 2012 оны Улаанбаатар хотын сонгуулийн дүн авч үзвэл: Баянзүрх дүүргийн гурван мандаттай тойргийн хоёр мандатыг Ардчилсан нам, I мандатыг Монгол ардын нам авсан. Мөн гурван мандаттай Сонгино-хайрхан дүүргийн хоёр мандатыг Ардчилсан нам, нэг мандатыг Монгол ардын хувьсгалт нам авсан бол хоёр мандаттай Чингэлтэй дүүргийн хоёр мандатыг Ардчилсан нам, нэг мандатыг Монгол ардын хувьсгалт нам авсан. Үлдсэн Сүхбаатар, Баянгол, Хан-уул дүүргүүдийн хоёр мандатыг Ардчилсан нам авсан. Улаанбаатар хотын 9-н дүүргийг 6 тойрог болгон хувааж, арван дөрвөн мандаттай сонгууль болсон. Нийт арван дөрвөн мандатын арван нэгийг Ардчилсан нам, хоёр мандатыг Монгол ардын хувьсгалт нам, нэг мандатыг Монгол ардын нам тус тус авсан (Сонгуулийн ерөнхий хороо).

2016 оны УИХ-ын сонгуулийн хамрах хүрээг УИХ-ын 41-р тогтоолыг үндэслэн сонгуулийн тойрог, нутаг дэвсгэр, мандатын тоог батлан гаргасан (Сонгуулийн ерөнхий хороо 2016). Тус тогтоолд 76 тойрог бүхий аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийг дахин хуваарилсан. Тойрог бүр нэг мандатын эрхтэй бөгөөд сонгуулийн насны иргэдээс хамааран нутаг дэвсгэрийг харилцан адилгүй хуваарилсан. УИХ-ын сонгуулийн 1 тойрог бүхий аймгууд нь Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Сүхбаатар зэрэг орно. УИХ-ын сонгуулийн 2 тойрог бүхий аймгууд нь Дорнод, Завхан, Өмнөговь зэрэг орно. УИХ-ын сонгуулийн 3 тойрог бүхий аймгууд нь Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул, Орхон зэрэг орно. УИХ-ын сонгуулийн 48 тойрог аймаг, суманд байрласан. Үлдсэн 28 тойрог Улаанбаатар хотод байна. Улаанбаатар хотын Баянзүрх болон Сонгино-хайрхан дүүргүүд 6 тойргоос бүрдэж байгаа бол Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-уул зэрэг дүүргүүд 4 тойргоос бүрджээ. 2016 оны Улаанбаатар хотын сонгуулийн дүнг харвал: Баянзүрх дүүргийн 53 тойрог, Чингэлтэйн 69-р тойрог, Хан-Уулийн 57-р тойрогт Ардчилсан нам мандатын эрхийг авсан. Баянзүрх дүүргийн 54-р тойрогт бие даан нэр дэвшигч мандатын эрхийг авсан бол үлдсэн 24-н тойрогт Монгол Ардын Нам мандатын эрхтэй болсон. Улаанбаатар хотын 2016 оны сонгуулийн дүнг Зурагл-аас харна уу.




**Зураг 1. Улаанбаатар хотын 2016 оны УИХ-ын сонгуулийн дүн**

[www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)

2012 оны сонгуулийн тойргийн нутаг дэвсгэрээр сонгуулийн дүнг зураглан дүрсэлсэн бол 2016 оны сонгуулийн тойрог нь хороогоор хуваагдсан нь сонгуулийн үр дүнг илүү нарийвчлах боломж олгож байна. Гэвч сонгуулийн үр дүнг картограммын аргаар дүрслэх нь ерөнхий мэдээллийг өгөх учир нарийн мэдээлэл ялгарах боломжгүй юм. Тухайн тойргийн сонгуулийн дүн, иргэдийн төлөв, нам хүчний харилцааны талаар мэдээллийг хааж байгаа юм. Тиймээс мэдээллийг нарийн гаргахын тулд цэгэн мэдээллийг ашиглан тухайн тойргийн мэдээлэлтэй ажиллавал нарын төвшний мэдээлэл гарах боломжтой юм.

Судалгааны ажлын хүрээнд сонгуулийн нэг тойргийг сонгож авахдаа орон сууц, гэр хорооллын суурьшлын бүсүүдийг хамарсан нутаг дэвсгэрийг сонгосон. Тухайн шалгуурыг Улсын Их Хурлын 60-р тойрог хангаж байгаа бөгөөд тухайн тойргийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 7, 8, 9, 10-р хороод хамрагдаж байна. Улсын Их Хурлын 60-р тойргийн 8-р хорооны хамрах газар нутаг нь урд талаараа Энх тайвны өргөн чөлөө, баруун талаараа Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай байрласан. Хорооны төв хэсгээр 1970-1980 оны хооронд баригдсан орон сууцтай, хүрээлсэн байдалтай шинэ баригдсан /2000 оноос хойш/ орон сууцуудтай. Тус тойргийн 7-р хороо баруун талаараа үйлчилгээний газруудтай. Үүнд: Номин дэлгүүр, шатахуун түгээх газар, Монголын Ардчилсан Холбоо зэрэг байгууллагатай бол хорооны зүүн хойд хэсэгт 1980-1990 оны хооронд баригдсан угсармал 9 давхар байрнууд байрласан. Зүүн урд хэсэгт шинээр баригдсан /2000 оноос хойш/ орон сууцтай. Харин 10-р хорооны орон зайн төлөвийг үзвэл зүүн талаараа худалдаа үйлчилгээний газар болох “100-н айлын худалдааны төв” урд болон төв хэсгээр 1970-1980 оны хооронд баригдсан орон сууцтай. Баруун хойд хэсгээсээ шинээр баригдсан /2000 оноос хойш/ орон сууц төвлөрч байна. Тус тойргийн 9-р хорооны орон зайн төлөв: нийт нутаг дэвсгэрийн 90% гаруй хувийг гэр хорооллын бүс эзэлж байна. Зүүн урд хэсгээр төв зам дагуу шинэ орон сууцууд баригдсан байна. Улсын Их Хурлын


60-р тойргийн төлөв нь 8-р хороонд Худалдаа үйлчилгээний томоохон төвтэй. 7, 8, 10-р хороодод орон сууцны бүс төвлөрсөн байгаа бол 9-р хороонд гэр хороолол төвлөрсөн байна (Зураг 2).



**Зураг 2. Монгол ардын намын гишүүд, дэмжигчид тэдгээрийн халуун цэг (hot-spot) шинжилгээ**


Ардчилсан намын дэмжигчдийн нягтшилыг авч үзвэл: 8-р хорооны урд хэсэгт байрлах 29, 30, 26-р байруудад дэмжигчдийн нягтшил өндөр гарсан бол 45, 46, 47, 48-р байранд нягтшилын хэмжээ харьцангуй бага гарсан. 7-р хорооны нутаг дэвсгэрт жигд дундаж тархалттай гарсан бол хорооны хойд хэсэг болох 130-р байр орчин нягтшилын хэмжээ өндөр байна. 10-р хорооны 17, 18, 19, 20-р байранд нягтшилын хэмжээ ихтэй. Мөн хорооны хойд хэсэгт байрлах 43-р байр, 130-р байранд нягтшилын хэмжээ ихтэй байна. 9-р хорооны нутаг дэвсгэрийн төв хэсэг нягтшилын хэмжээ өндөр гарсан байна. Нийт тойргийн хэмжээнд 7-р хороо болон 8-р хорооны 1990 оноос хойш баригдсан байранд нягтшилын хэмжээ өндөр

гарсан байна. 10-р хорооны хуучны орон сууцанд илүүтэй нягтшилтын хэмжээ ихтэй байна (Зураг 3).



**Зураг 3. Ардчилсан намын гишүүд, дэмжигчид тэдгээрийн халуун цэг (hot-spot) шинжилгээ**

МАХН болон бусад нам хүчний дэмжигчдийн байршлыг авч үзвэл. МАХН-ын дэмжигч нар 8-р хорооны 45, 46, 47, 48, 2, 3-р байруудад болон 7-р хорооны 15 байранд гишүүд дэмжигчид олонтой байна. Харин Бусад нам болон бие даагч нарын дэмжигч нар 8-р хорооны 29, 25-1, 14-2-р байрнууд болон 7-р хорооны 4, 5, 6, 7, 8-р байранд их нягтшилтай байна (Зураг 4).



**Зураг 4. Монгол ардын хувьсгалт нам, Бусад нам хүчний гишүүд дэмжигчид тэдгээрийн hot-spot шинжилгээ**

Улс төрийн нам хүчний орон зайн төлөв, нягтшилын төвшнөөр МАН 10-р хороо, 7-р хорооны нутаг дэвсгэр дээр хамгийн өндөр байгаа бол АН, бусад нам хүчин харьцангуй бага төвшинтэй байна. Тус хороодын сонгогчдын саналаар МАН 13%-ийн саналаар илүү байна. Улсын Их Хурлын 60-р тойргийн 8-р хороонд АН нийт сонгогчдын 34,1%-ийн санал, МАН нийт сонгогчдын 36,1%-ийн санал, бусад нам хүчин 23%-ийн санал авсан бөгөөд үлдсэн 11,8% сонгуульд санал өгдөггүй иргэд байна. Харин 9-р хорооны орон зайн төлөв МАН тархалтын хувьд илүү буюу нийт сонгогчдын 38,2%-ийн санал, АН нийт сонгогчдын 33%-ийн санал, бусад нам хүчин 6,6%-ийн санал авах магадлалтай байна. Тус тойргийн орон зайн төлөвийг үзвэл МАН саналын хувьд илүү гаргах нь тодорхойлогдож байна. Энэхүү судалгаа нь цаашид дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хуралд ашиглагдах боломжтой. Дүүргийн иргэдийн төлөөлөгчийн хурлын орон зайн төлөвийг тодорхойлбол: 10, 7-р хороодод МАН илүү

сонгогчдын саналыг авах ба 9, 8-р хороонд улс төрийн гол хүчний байдал 2%-5% ийн зөрөөтэй байна. Нийт нутаг дэвсгэрийн хүрээнд МАН саналын хувьд илүү байна. 11-р хороолол орчимд байрлах орон сууцнууд нь 1980-аад оны үед баригдсан. 1992 оны үндсэн хуулийн өөрчлөлтөөр улсын өмчийг хувийн өмчид шилжүүлэх ажлыг эхлүүлсэн. Тэр үед орон сууцанд амьдарч байсан иргэдэд 1995 оны өмч хувьчлалаар амьдарч байсан иргэдэд байрыг нь өөрийн нэр дээр нь шилжүүлэх эрх өгсөн байдаг.

### ***Дүгнэлт***

Энэхүү судалгаа нь улс төрийн газарзүйн асуудал болох сонгуулийн газарзүйн чиглэл дэх судалгааны аргазүйг илүү боловсронгуй болгох нарийн төвшний судалгааны ажил болсон. Тус судалгаа нь эмпирик судалгаа бөгөөд аргазүйн хувьд асуулга (*анкет*) судалгаа авч, түүврийн кластерын аргачлал ашигласан. Асуулга судалгааг 480 иргэдээс авсан нь түүврийн хэмжээг тогтоох тооцооллоор 99%-ийн магадлалаар  $\pm 6\%$ -ийн үнэмшилтэй тооцоолсон. Судалгаа ажил нь нийт эх олонлогийг хамгийн багадаа 93%-ийг магадлалтай тооцсон бөгөөд түүнээс дээш хувийн эх олонлогийг тооцох юм. Тухайн намуудыг сонгох иргэд тодорхой нутаг дэвсгэрт хамаарагдах бөгөөд МАН-ыг 1980-1990 оны хооронд баригдсан орон сууцанд амьдарч буй иргэд сонгосон байна. Харин АН-ыг сонгосон иргэд 2000 оноос хойш баригдсан орон сууцанд амьдарч байгаа юм. Мөн МАХН, бие даагч нарыг сонгож байгаа иргэд 1990 оноос хойш баригдсан орон сууцанд амьдарч байна. Тухайн иргэдийн төлөвийг орон зайн дүн шинжилгээгээр гаргасан болно. МАН-ыг дэмжигч нар 7, 9, 10-р хороод нягтшилихтэй байгаа бол АН-ыг дэмжигч нар 8, 9-р хороод нягтшил ихтэй байна.

Энэхүү судалгаагаар сонгуулийн нэг тойргийг сонгон авч улс төрийн нам хүчин түүнд нөлөөлөх иргэдийн үзэл баримтлалын төлөв байдлыг тооцоолсон. Уламжлал, улс төрийн сонгуульд нөлөөлөх имиж, пиар гэхээс илүүтэй орон зайн дүн шинжилгээ хийсэн нь сонгуулийн үр дүнг тооцоолох оновчтой аргачлал байх талтай. Мөн түүнчлэн сонгуулийн газарзүйн судалгаа нь сонгуулийн үр дүн дээр шинжилгээ хийдэг бол энэхүү аргачлалаар цаашдын хэтийн төлөвийг тооцоолох боломжтой.

### ***Abstract***

Electoral geographic study is evaluates the election result and spatial dependence. Therefore, the election result is described all over the country and region by the cartography approach. The aim of this research is to determine the micro environmental situations and impact factors using the hot-spot analysis. In addition, the size of research area as an electoral district and gathered information from 480 respondents. The respondents were choses by cluster collection approach using questionnaire method and considered the level of collection as 99% probability and respondents as  $\pm 6$  interval. This research is significant to determine the political attitude of the citizens, the spatial situations of the political parties, define the spatial dependence and evaluate. The spatial situations by studying the political attitude of the citizens using hot-spot analysis. This research work is the basic study which will be carried out at micro level of electoral geographic study.

### ***Ашигласан ном, материал***

1. Монгол Улсын Үндсэн хууль, УБ., 1992.
2. McDaneil C. and Gates R. Marketing Research Essentials, 8th Edition, SouthWestern College Publishing, 2012.

3. Warf.B and Leib.J, Revitalizing Electoral Geography, USA.2011.
4. Pattison, W.D., 1990, Four Traditions of Geography, Journal of Geography,202-6
5. Колин Робсон., 2006, Бодит ертөнцийг судлахуй, Нийгмийн ухаан болон мэргэжлийн судлаачдад зориулсан гарын авлага. УБ хот.
6. Баатартогтох Ц., 2012, Нийгмийн шинжлэх ухааны судалгааны аргазүй, УБ.,
7. Баянтөр.М, Батцэнгэл В, Одхүү.Н, Улс төрийн газарзүй, УБ., 2012.
8. Болд-Эрдэнэ Д., Монголын улс төрийн нам, намын систем, УБ.,2000.
9. Даш.Д, Мандах.Н, Газарзүйн шинжлэх ухааны хөгжлийн түүх, 583-р тал, 2011.
10. Долгор.Б нар, Улс төр судлал, УБ., 2010.
11. Колосов.В.А, Политическая география сегодня, стр 12М.,1995.
12. Нандин-Эрдэнэ Б., Улс төрийн маркетинг ба улс төрийн нам, Магистрын зэрэг горилсон бүтээл, Монгол улсын их сургууль, Монгол улс.2013
13. Социологийн судалгааны аргазүй, аргачлал, Шинжлэх ухааны академи философи, социологи, эрхийн хүрээлэн, УБ.,2008.
14. Урантогоо Н., Улс төрийн PR–ийн мэдээллийн үйл ажиллагаа 2008 оны УИХ-ын сонгуульд нөлөөлсөн нь, Магистрын зэрэг горилсон бүтээл, Монгол улсын их сургууль, Монгол улс.2009.
15. Agnew, J.A “Making Political Geography. London: Arnold.” (2002)Цахим хуудас:<https://journals.openedition.org/> /2016.11.24-нд хандсан/
16. Florian Stoffel, Halldor Janetzko, Florain Mansmann., (2012) “Proportions inCategorical and Geographic Data: Visualizing the Results of Political Elections” Цахиим хуудас: <https://dl.acm.org/> /2016.11.24-нд хандсан/.
17. Jonathan L, Nicholas Q., (2011). On the Shores of the “Moribund Backwater”? Trends in Electoral Geography Research Since 1990 Цахим хуудас: <https://www.taylorfrancis.com/> /2016.05.14-нд хандсан/
18. Улаанбаатар хотын хүн ам, Монгол улсын үндэсний статистикийн хороо, Цахим хуудас: <http://www.nso.mn/> /2016.10.23-нд хандсан/
19. 2016 оны Улсын их хуралын сонгуулийн дүн, Монгол улсын сонгуулийн ерөнхий хороо, Цахим хуудас: <http://www.gec.gov.mn/> /2016.10.24-нд хандсан/
20. “ESRI, “ArcGIS”, Redlands, CA, хувилбар 10.1.(2012),
21. “MicrosoftOffice 2010”, Redmond, Washington .(2010),
22. “IMB”, “SPSS statistics 23”(2015),

## НЭР ДЭВШИГЧИЙН ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТ БА СОНГУУЛЬ

**У.Батцэрэн**

Удирдлагын Академийн Төрийн Албаны Сургуулийн  
Сургалтын менежер

### **Товч утга**

Сонгууль, сонгуулийн үйл явц тэр дундаа сонгуульд нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх явдал нь төлөөллийн ардчилалын нэгэн бүрэлдэхүүн үнэт зүйл юм. Төлөөллийн ардчилалын өөр нэгэн үнэт зүйл бол иргэдийн нийгэм улс төрийн оролцооны асуудал юм. Өөрөөр хэлбэл төлөөллийн ардчилалын зарчмын дагуу иргэд өөрийн сонгосон гишүүнээрээ дамжуулж төрийг удирдах үйл хэрэгт оролцох явдал юм. Энэ талаар эрдэмтэн Gustave A De Cocq “Иргэдийн оролцоо бол ардчиллын оршин тогтнох, сүүлийн тулах цэг”<sup>1</sup> хэмээн бичсэн байдаг. Манай улсын хувьд 1992 оноос эхлэн төлөөллийн ардчиллын зарчмын дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг удаа дараа явуулж иргэдийн үндсэн хуулиар олгогдсон улс төрийн оролцооны хэлбэрийг хангаж ирлээ.

Иргэд сонгуульд оролцон саналаа өгөх нь улс төрийн оролцооны нэгэн чухал хэлбэр байдаг хэдий ч өнөөдөр зөвхөн иргэд санал өгөгч, сонгогч байхаас татгалзаж эхэлж байгаа нь тэдний сонгуульд оролцох идэвхээс ихээхэн шалтгаалж байдаг. Иргэдийн улс төрийн оролцоо зөвхөн сонгуулиар хязгаарлагдахгүй нь ойлгомжтой бөгөөд бид оролцооны олон төрлүүдийг ашиглаж сурах нь чухал юм. Мөн сонгуулийн кампанийн үйл явцад нэр дэвшигчийн имиж бүрдүүлэлтийн талаарх асуудлыг судлан дүгнэх хэрэгтэй. Учир нь зарим талаараа иргэд, сонгогчдод тухайн нэр дэвшигчийн имиж таалагдахгүй хүлээн зөвшөөрөхгүйгээс байгаагаас шалтгаалан тэдний улс төрийн оролцоо буурах хандлагатай байж болох юм.

Иймд энэхүү өгүүлэлээ сонгуулийн албан ёсны сурталчилгааны үед нэр дэвшигчийн улс төрийн имижийг “*шинэ бодлогын*” зарчмын дагуу хэрэн бий болгох талаар онол, практикийн зарим асуудлыг хөндөн авч үзэхийг зорив.


**Түлхүүр үгс:** Шинэ бодлого, ардчилал, төлөөллийн ардчилал, иргэдийн улс төрийн оролцоо, сонгууль, кампани, нэр дэвшигч, имиж, имижийн стратеги, улс төрийн лидерийн имиж, имижмейкер, PR, рейтинг.

\* \* \*

1992 оноос хойш зохион байгуулсан Улсын Их Хурлын нийт 7 удаагийн сонгуульд иргэд, сонгогчдын оролцооны ирц тогтмол буурч ирсэн нь төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлж буй манай улсын хувьд хүндхэн асуудал болоод байна. Харин 2016 оны сонгуульд сонгогчдын ирц нэмэгдсэн дүн гарсан байна. (*График №1*)

<sup>1</sup> Gustaaf Adolf De Cocq. “Citizen participation: Doomed to extinction or last foothold of democracy? An exploratory study in four west European countries: the Netherlands, ... to North America, (Atlantic series, nr. 7). USA., 1969. 25-р тал.

График №1 УИХ-ын сонгуулийн ирц, 1992-2016 он.<sup>2</sup>



Сонгуулийг зохион байгуулж буй хороо, нэгж байгууллага нэр дэвшигчид болон түүний сурталчилгааны баг, нэр дэвшүүлсэн нам, эвсэл зэрэг нь зөвхөн сонгуулийн кампанит ажлын явцад сонгуулийн ирц буюу иргэдийн улс төрийн оролцооны асуудалд анхаарлаа хандуулчихаад сонгууль дуусмагц энэхүү асуудлыг орхидуулж байна. Өөрөөр хэлбэл энэхүү асуудлаар талууд тайлбар, дүгнэлт хийх бус иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах нь зүйтэй юм. Сонгуулийн кампанийн явцад иргэдийн улс төрийн оролцоо олон зүйлээс шалтгаалж байгаагийн нэг шалтгаан нь сонгуульд нэр дэвшиж буй субъектийн улс төрийн имижийн асуудал юм. Өөрөөр хэлбэл тухайн субъектийн нэр хүнд, улс төрийн байр суурь, нэр дэвшүүлж буй нам, эвсэл мөн сонгуулийн сурталчилгааны арга, технологи зэргээс ихээхэн шалтгаалж иргэдийн улс төрийн оролцоо тодорхойлогддог.

Орчин үед аливаа сонгуулийн өмнөх кампаний стратегийн гол чиглэл нь нэр дэвшигчээс сонгуульд ялалт байгуулах явдлыг хангахад нөлөөлөхүйц байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл нэр дэвшигч нь сонгогчдийн хувьд сэтгэл татам нийгэм-улс төрийн имижтэй байх шаардлагатай. Өнөө үед нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэхийн тулд сонгуулийн кампанийг амжилттай удирдан явуулах хэрэгтэй. Сонгуулийн кампанийг амжилттай удирдан явуулах, сурталчилгааны үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах үйл явц нь маш нарийн дэс дараалалаар явагддаг. Манай улсын хувьд сонгуульд нэр дэвшиж буй нэр дэвшигч болон түүний сурталчилгааны багийхан сонгуулийн кампанийн үйл явцыг дараах байдлаар тодорхойлон үзэж имиж бүрдүүлэх арга хэлбэрээ тодорхойлж байна. Үүнд: олон нийтийн санал бодол, ард түмний аж байдал болон тухайн сонгуулийн тойрог, орон нутагт тулгамдаж буй асуудал мөн өрсөлдөгч талын болон өөрийн имижийг талаар эерэг ба сөрөг мэдээлэл цуглуулах явдал юм. Үүний дараагаар цуглуулсан мэдээллээ дүгнэн, санал зөвлөмж боловсруулж, сонгуулийн үеийн кампанит ажлын төлөвлөгөөгөө боловсруулах зэрэгээр ажиллаж байна.

Өнөө үед сонгуулийн кампани нь улам нарийн арга технологийн ашиглан өөрчлөгдөж байна. 1960-аад оны АНУ-ын улс төрийн тэмцлийн үед *“шинэ бодлогын”* зарчим буюу имиж бүрдүүлэх стратегийг бий болгож өнөөг хүртэл олон улс орон өөрийн дотоод сонгуулийн

<sup>2</sup> Сонгуулийн Ерөнхий хорооны цахим хуудас. <http://gec.gov.mn/uploads/IHsonguuli2012.pdf> УБ., 2019.10.06.

кампанит ажилдаа ашиглан хэрэглэж байна. Энэ нь манай улсын хувьд 2016 оны УИХ-ын сонгуульд гарч ирсэн үзэгдэл юм.

Шинэ бодлогын үзэл баримтлал нь: олон нийтийн санал асуулгыг явуулж түүний үндсэн дээр олон талт судалгааны үр дүнг хэвлэл мэдээлийн хэрэгслийн тусламжтайгаар олон нийтэд идэвхтэй нэвтрүүлж, ойлгуулах мөн сонгогчдын зан байдлыг судлан загварчлан түүнд нь тохирсон нэр дэвшигчийн давуу байдлыг ил гаргасан буюу тодорхойлсон улс төрийн имижээ үүсгэх, бүрдүүлэх зарчмаар ажилдаг нэр дэвшигчийн сонгуулийн кампанит ажил юм.

Орчин үеийн сонгуулийн технологи нь нийгмийн санал бодлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар өөрт ашигтай байдлаар ашиглаж байна. Энэхүү үйл явцыг дагаад олон нийтэд нөлөөлөх мэдээллийн хэрэгслийн арга технологи нь улам бүр нарийсч улмаар шинэ аргуудыг бий болгож байна. Жишээ нь, хэн нэгэн нэр дэвшигчийн сурталчилгааны багийхан цахим мэдээллийн хэрэгслийг ашиглан уламжлалт хэвлэл мэдээлийн хэрэгсэлрүү дайрсан тэр дундаа бусдынхаа нэр хүндийг гутаасан мэдээлэл түгээх боломж, арга замыг ямагт ирэлхийлж байна. Үүнийг манай улсын 2013 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцаас хархад нэрээ нууцалсан, өөр нэр ашигласан хэн нэгэн этгээд цахим мэдээллийн хэрэгслийг ашиглан нууц серверээр мэдээллийг анхлан илгээж тэр нь цаашдаа олон нийтийн ухамсарт нөлөөлж, тархаж байсан билээ.

Судалгааны үр дүнд сонгуулийн кампанийг зохион байгуулагчид сохроор бус харин аргаар сонгуулийн стратегийг бүтээх шинэ боломжийг олж хардаг байна. Нэр дэвшигчийн имиж нь тодорхой хэмжээгээр түүний зорилтот нийгэм-сэтгэл зүйн шинжээр урьдчилан тодорхойлогддог. Имижийн “гол үндсэн цөм” нь сонгогчийн зорилтот бүлгийн хүлээлтэд нийцэх явдал. Тухайн хандлагийн үндсэн арга барил нь маркетингийн болон худалдааны зар сурталчилгааны онол практикаас гаралтай юм. Оросын эрдэмтэн Ф.Н.Ильясов сонгуулийн кампанийн мэдээлэл-шинжилгээг 2 үе шатанд хувааж үзсэн байна<sup>3</sup>. Үүнд:

1. Эхний үе шат нь улс төрийн зах зээлийг судлах болон түүнийг хэсэгчлэн бүлэглэх явдал юм. Өөрөөр хэлбэл сонгогч-хэрэглэгчдийг улс төрийн сонирхлын хэв шинжээр нь бүлэглэх болон нэр дэвшигчийн онцлог шинжийг сонгогчийн бүлэг тус бүрт зориулан тодорхойлох.
2. Дараагийн үе шат нь нэр дэвшигч улс төрийн орон зайд давуу байр сууриа олох явдал юм. Давуу байр сууриа олохдоо юуны өмнө нийгмийн хэсэг, бүлэг тус бүрийн боломжийг судалж өөрийн имижийн объектив шинжийг харгалзан үзэж өрсөлдөгчөөсөө давуу байдлыг олж авах.

Сонгуульд нэр дэвшигчийн хувьд өрсөлдөгч нэр дэвшигчийнхээ талаарх олон нийтийн судалгаа, хувийн мэдээлэлтэй нь холбоотой зарим нэгэн асуудлыг судлан авч үзэх нь зүйтэй. Учир нь:

- өрсөлдөгчийнхөө тодорхой нэгэн онцлох зүйл, сул талыг тодруулснаар нэр дэвшигч өөрийн имижээ өрсөлдөгчтэйгээ харьцуулж гарган улмаар сайжруулах;
- сонсогчдод зохих шаардлагатай мэдээллээр нөлөөлөх бодит нөөц бололцоог нээж бий болгох;
- олон нийтэд таалагдахгүй байгаа нэр дэвшигчийн тогтсон имижийг засахын тулд цаг хугацаа болон хэвлэл мэдээлийн хэрэгсэл зэргийг түрүүлж өөрт ашигтайгаар ашиглах боломжтой.

<sup>3</sup> Ильясов, Ф.Н. “Политический маркетинг, или как продать вождя”. Полис. Политические исследования. Москва., 1997. №5. 97-р тал.

Дээрх арга зүйн чухал хүчин зүйл нь нэр дэвшигчийн үүсгэсэн имижийг дараагийн ахисан түвшиний имижд шилжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл түүний анхны имиж нь дараагийн имижийн загвартайгаа үргэлж харилцан хамааралтай байдаг. Нэг талаас нийгмийн санаа бодлыг судласны үндсэн дээр тухайн субъект олон нийтэд хэрхэн танигдаж буй болон түүнд саналаа өгөхөд бэлэн байгаа сонгогчдын тодорхой хувийг тогтоох явдал юм. Харин нөгөө талаас түүний сонгуулийн кампанийн үйл явц болон ялалтын бодит байдал хоёрын хоорондох зүй тогтолыг нээн илрүүлэх хэрэгтэй.

Мөн олон нийтийн сэтгэл зүй маш хурдан өөрчлөгдөж байдаг. Өөрөөр хэлбэл нийт сонгогчдын 100% нь танил байсан нэр дэвшигч сонгогчдын саналыг авч сонгогдох магадлал зарим тохиолдолд их бага байдаг. Жишээ нь, 2004-2008 онд УИХ-ын гишүүн, Үйлдвэр худалдааны сайд асан монголчууд бид бүхний сайн мэдэх БНН-ын дарга, “Буян”-ын хэмээх тодотгол имижтэй Б.Жаргалсайхан юм. “Тэрээр 1992 УИХ-ын 22-р тойрогт нэр дэвшин 14,210 хүний санал буюу 24,4 хувь, 1996 онд УИХ-ын 67-р тойрогт нэр дэвшин 1208 хүний санал буюу 8,4 хувь, 2000 онд УИХ-ын 70-р тойрогт нэр дэвшин 3019 хүний санал буюу 23,5 хувь, 2008 онд УИХ-ын 26-р тойрогт нэр дэвшин 16,824 хүний санал буюу 18,5 хувь, 2012 онд УИХ-ын 26-р тойрогт нэр дэвшин 12,529 хүний санал буюу 10,99 хувийн саналыг авсан бол 2002 оны УИХ-ын 11-р тойргын нөхөн сонгуульд нэр дэвшин 3,032 хүний санал буюу 24,3 хувийн саналыг авсан боловч УИХ-ын гишүүнээр сонгогдож чадаагүй байна. Харин тэрээр 2004 онд УИХ-ын 70-р тойрогт нэр дэвшин 5,849 хүний санал буюу 43,72 хувийн саналыг авч УИХ-ын гишүүнээр анх удаагаа сонгогдож байсан байна.”<sup>4</sup> Мөн тэрээр “2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшин 128,784 хүний санал буюу 13,83 хувийн саналыг авч байсан байна.”<sup>5</sup> Түүний сонгогдож чадаагүй учир шалтгаан нь улс төрчийн имиж бус бизнесмэн удирдагчийн имижтэй нь холбоотой байж болох юм. Ийм тохиолдолд нэр дэвшигчийн нэгэнт төлөвшин тогтсон имижийг өөрчлөх нь ихээхэн төвөгтэй байдаг.

Өөр нэгэн тод жишээ бол манай улсад төдийгүй улс төрийн имиж судлалын салбар өндөр хөгжсөн Орос улсад хүртэл гарж байсан тохиолдол байна. Тухайлбал, бидний сайн мэдэх Оросын Либерал Ардчилсан намын дарга В.Жириновский юм. Тэрээр 1993 оноос 2008 оныг хүртэл парламент нэр дэвшсэн боловч түүний төлөө иргэд сонгогчид тиймч хангалтай бус санал өгсөнөөр сонгогдож чадаагүй. Гэтэл тэрээр нийгэмд 100% танигдсэн бизнесмэн, нийгэм улс төрийн лидер байсан нь түүнийг сонгуульд нэр дэвших бүрийд түүний имиж бүрдүүлэлтийн багийхан имиж үүсгэх, имиж бүрдүүлэх стратегийг сайн хийж гүйцэтгэхийн зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарт маш өндөр идэвхтэй ажиллаж байсан ч түүний имиж тогтмол буурж байсан. Түүний олон нийтийн өмнө илтгэх шинж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчидтэй харилцах арга барил, зан чанар мөн улс төрийн өрсөлдөгч, шүүмжлэгчидтэй харилцах харилцааны хэв маяг зэрэг түүний биеээ авч яваа байдал нь хувь хүнийх нь имижтэй нийцдэг. Энэхүү байдал нь сонгогчдын тодорхой хэсгийг өөрт нь санал өгөхөд нөлөөж чадахуйц боловч нийгмийн хэм хэмжээ ба үнэт зүйлсийн хүрээнээс ихэнхдээ хэтэрдэг байна.

Дээрх жишээний нэгэн адил БНН-ын дарга Б.Жаргалсайхан нь нийгмийн чиг үүрэг, хэм хэмжээний хувьд нийгэм-улс төрийн ашигтай лидер боловч түүний бизнесийг удирдах чадвар, үйл ажиллагаа нь илүү юм. Иймээс түүний хувийн имиж, нийгэмд тодоор үлдсэн үнэхээр мартагдашгүй имижийг жинхэнэ улс төрчийн имижээр солих болон шинээр имиж үүсгэх

<sup>4</sup> Нээлттэй нийгэм форумын цахим хуудас. [http://www.forum.mn/index.php?sel=news&menu\\_id=12](http://www.forum.mn/index.php?sel=news&menu_id=12) УБ., 2019.10.04

<sup>5</sup> Сонгуулийн Ерөнхий хороо. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993-2013)”. УБ., 2013. 113-р тал

боломж хомс. Мөн түүний одоо байгаа олон нийтэд танигдсан явцуу имиж нь түүний дараа дараачийн шинээр бүрдүүлэх болон үүсгэх, засан зүгшрүүлэх имижийн цар хүрээг мэдэгдэхүйц хэмжээгээр хязгаарлаж байна. Үүний гол санаа нь имижийн стратегийг анхнаас нь сонголтоо зөв хийж ул суурьтай суулгах хэрэгтэй юм.

Энэхүү имижийг тодорхойлох судалгааны арга зүй нь нэр дэвшигчийн имижийг тодорхойлох, загварыг сонгох, үүсгэх хүрээнд багтан улмаар сонгуулийн кампанийн эхний үе шатанд хамаарах анхан шатны имиж бүрдүүлэх үндсийг бий болгодог. Харин имижийн стратегийн дараагийн үе шатанд суртал нэвтрүүлэг буюу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хамаарна. Тухайн үе шатны өвөрмөц онцлогийг бүрдүүлэгч мэдээлэл болон олон нийтийн зүгээс ирэх сэтгэл зүйн бүх үйлдлийг нэгтгэн дүгнэж дараах байдлаар бүлэглэн хувааж үзэж болох юм. Үүнд:

1. Сурталчилгаа, мэдээллийн үйл ажиллагаа;
2. Үзүүлэн таниулах үйл ажиллагаа;
3. Зохион байгуулалтын үйл ажиллагаа болно.

Нэр дэвшигч бүрийн имиж бүрдүүлэлт болон сонгуулийн кампанит ажлын **зохион байгуулалтын үйл ажиллагаа** ямагт өөр хоорондоо харилцан адилгүй. Харин дахин сонгогдож байгаа нэр дэвшигчийн хувьд тэрээр засаглалын болон засаг захиргааны нөөцтэй байдал нь түүний давуу тал болдог. Зохион байгуулалтын үйл ажиллагааг сонгогчдод үзүүлэх сэтгэл зүйн нөлөөг хангах эсвэл түүний үр ашгийг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээний тусламжтайгаар гүйцэтгэдэг байна. Зохион байгуулалтын үйл ажиллагаа нь нийгмийн хамгийн чухал, илүү их ач холбогдолтой бүхий асуудлыг тодорхойлон тусгаж улмаар олон нийт ямар имиж хүсч байгааг тодорхойлох зорилготой байдаг. Мөн зохион байгуулалтын үйл ажиллагаа нь нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх зорилготой янз бүрийн хурал, цуглаан, уулзалт зэрэг улс төрийн үйл ажиллагаа юм.

Нэр дэвшигчийн имиж бүрдүүлэх багийн үйл ажиллагааны өөр нэгэн сурталчилгааны чиглэл бол **үзүүлэн таниулах үйл ажиллагаа** юм. Үүнд олон төрлийн арга хэмжээ, улс төрийн үйл ажиллагаа хамаарагдах боловч зохион байгуулалтын үйл ажиллагаанаас ялгаатай нь бодит үр дүнд чиглэгдсэн бус харин ч хүмүүст сэтгэл зүйн нөлөө үзүүлэхэд чиглэгдсэн байдаг. Энэ нь эцсийн дүндээ нэр дэвшигчийн болон нам, эвслийн эерэг имижийг бүрдүүлэх зорилго бүхий нийгмийн ач холбогдолтой санал санаачлага, уриалга, төсөл хөтөлбөрүүд зэргийг дэвшүүлэн тавьсан улс төрийн үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааны логик үргэлжлэл нь зохион байгуулалтын үйл ажиллагааны үр дүнгээс ихээхэн хамааралтай гарч ирсэн байдаг.

**Имижмейкер** болон түний сурталчилгааны багийхан нэр дэвшигчид тохирох имижийг тодорхойлж бүрдүүлэхдээ сонгогчдод илүү ойр байх хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан сонгогчид **сурталчилгаа, мэдээллийн үйл ажиллагаагаа** хүргэх нь чухал юм. Энэхүү үйл ажиллагааг ихэвчлэн олон нийтийн сэтгэл зүйд хүргэх үүднээс хэвлэл мэдээллийн тодорхой хэрэгслийг ашиглах цэнгээнт нэвтрүүлэг, ток-шоу, чөлөөт ярилцлага зэрэг хэлбэрээр олон нийтэд хүргэдэг байна.

Нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх үйл явцын чухал зүйл бол социологийн судалгаа, олон нийтийн санаа бодлыг тандах асуулга юм. Судалгааны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ бүрэлдэж буй дүр, шаардлага ба боломжийг засаж залруулах “тулгуур цэгийг” зөвхөн гишүүнчлүүлээд зогсохгүй өрсөлдөгчдийнхөө хувьд нөгөө л гарцад прогноз хийдэг. Тухайн тохиолдолд сонгогчдын зан байдалд нөлөөлдөг хүчин зүйлсийн судалгаанд үндэслэн нэр

дэвшигчийн **рейтингийг** тодорхойлдог. Өнөө үед нэр дэвшигчийн рейтингийн талаарх мэдээллийг мэргэжилтнүүд **PR**-ийн асуудал хэмээх судлахаас биш бодит мэдээллийн төсөөлөл талаас нь судлан үзэхгүй байна.

Сонгогчдын ухамсарт, ялангуяа улс төрийнхөө эрхэмлэн дээдлэх зүйлээ хараахан тодорхойлоогүй байгаа сонгогчдод рейтинг шахалт үзүүлэх багаж хэрэгсэл болгох үүднээс судлах нь зүйтэй юм. Сэтгэл зүйчдийн тогтоосноор үүний шалтгаан нь нийгэмд дэлгэрсэн зан байдал, санал бодол болон олон нийтийн ухамсрын өвөрмөц онцлог шинжээр үндэслэдэг хэмээн үзжээ.<sup>6</sup> Ийм нөхцөлд санал бодол нь тодорхойгүй ихэнх сонгогчдын хувьд нийгмийн олонхийг даган адил төстэй шийдвэр гаргахыг илүүд үздэг. Рейтинг нь судлаачидийн үзэж байгаагаар сонгуульд нөлөөлдөг сэтгэл зүйн хүчтэй хэрэгсэл юм. Мөн сонгогчдын хувьд сонгуульд оролцох эрх чөлөөг нь нэлээн хязгаарладаг байна. Учир нь санал асуулгаар нэр дэвшигчийн овог нэрийг асуулгад байнга байлгах нь сонгогчдын хувьд тухайн нэр дэвшигчийн талаарх төсөөлөл болон хэлбэршсэнээр сонголтонд нь нөлөөлдөг. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдэж буй санал асуулгын дүнд түүний рейтинг тогтмол өсөж байх нь нийгмээс түүнд хандах хандлага болон сонгогчдын хувьд нэр дэвшигчийн имижийг далд хэлбэрээр ямагт өсгөж байгаа хэрэг.

### ***Товч дүгнэвэл***

Орчин үеийн сонгуулийн кампанийн зохион байгуулалтын үндэс нь сонгуулийн кампаний далд хэлбэрийг бий болгож байна. Учир нь дараагийн сонгуульд нэр дэвших бодолтой хүмүүс ард иргэдэд өөрийгөө таниулах, өөрийн имижээ бүрдүүлэх зорилгоор далд хэлбэрээр нөлөөлж байна.

Сонгуулийн кампанийн явцад нэр дэвшигч болон түүний суралталчилгаа, судалгааны багийхан нийгмийн санал бодлыг системтэй судлах; социологийн болон нийгэм-сэтгэл зүйн судалгааг явуулах; сонгогчдыг бүлэглэн хувааж харилцах; тухайн нөхцөл байдалдаа тохируулан улс төрийн чиг баримжаагаа буюу төлөвлөгөө боловсруулах; олж авсан мэдээллээ ашиглан имижээ бүрдүүлэх; аливаа оюуны болон материаллаг зарлагыг оновчтой болгох; нэр дэвшигчийн тухайлсан зар сурталчилгааг явуулах; түүнийг шаардлагатай үед хэрэгцээтэй газар нь байрлуулах зэргээр сонгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн тийм л бүтээгдэхүүн буюу нэр дэвшигчийг бий болгох хэрэгтэй.

Сонгуулийн үйл явцыг бид сайн ажиглаж үзвэл түүний үр дүн хэд хэдэн хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, нийгэм, эдийн засаг, улс төрийн орчны шинж байдал буюу сонгуулийн тойргийн бүтэц, газар нутгийн хэмжээ, онцлог, нийгмийн янз бүрийн бүлэг, сонгогчдын төсөөлөлд байдаг нэр дэвшигчийн “төгс дүр” буюу имиж, сонгогчдын ашиг сонирхлын онцлог зан байдал зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай байна. Эдгээр хүчин зүйлс нь ерөнхийдөө сонгуулийн кампаний мэдээлэл-шинжилгээний технологийн хүрээнд хамааралтай. Тухайн хүчин зүйлсийн үр дүн нь сонгуулийн өмнөх оновчтой стратеги болон тактикийг боловсруулахад оршдог. Өөрөөр хэлбэл сонгогчдын хувьд дээд зэргээр дэмжих тэрхүү дэмжлэгийг олж авахын тулд нэр дэвшигчийн мэдээллийн үйлдлийн бүдүүвчийг тодорхойлж улмаар сонгуулийн өмнөх болон сонгуулийн сурталчилганы үеийн имижээ хэрхэн бүрдүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан ажиллах явдал юм.

---

<sup>6</sup> Федотова Л.Н. Социология рекламы. Москва, 1999. С. 117-р тал.

Сонгуулийн кампаний явцад бидний анзаардаггүй хамгийн том нэг алдаа бол маркетингийн хандлагыг орхигдуулдаг явдал юм. Энэ нь улс төрийн үйл явцад зарим талаараа сөрөг нөлөө үзүүлдэг. Сонгуулийн кампаний ийм зохион байгуулалтын үед сонгогчдыг **манипуляцийн** объектоо болгоод харин нэр дэвшигчид нь өөрсдийгөө имижийн кампанийг зохион бүтээгчийн оронд тавьдаг байна. Үүнээс гадна, маркетингийн аргыг хэрэглэхдээ сонгуульд ялалт хүрэх гол эх үүсвэр нь мөнгө болдог учир эцсийн эцэст сонгуулийн сурталчилгааны зардлын өсөлтөд нөлөөлж, улмаар санхүүгийн хувьд хязгаарлагдмал нэр дэвшигч болгох нь түүний сонгогдох боломжийг бууруулдаг байна.

### **Ном зүй**

1. Сонгуулийн Ерөнхий хороо. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993-2013)”. УБ., 2013.
2. Ильясов.Ф.Н. “Политический маркетинг, или как продать вождя”. Полис. Политические исследования. Москва., 1997. №5.
3. Федотова Л.Н. Социология рекламы. Москва.,1999.
4. Gustaaf Adolf De Cocq. “Citizen participation: Doomed to extinction or last foothold of democracy? An exploratory study in four west European countries: the Netherlands, ... to North America, (Atlantic series, nr. 7). USA., 1969.
5. **Цахим хуудас**
6. Сонгуулийн Ерөнхий хорооны цахим хуудас. <http://www.gec.gov.mn/> УБ., 2019.
7. Нээлттэй нийгэм форумын цахим хуудас. <http://www.forum.mn/> УБ., 2019.

## ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ, ШИНГЭЭХ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

**Ц.Чулуунцэцэг**

СЭЗИС-ийн Гадаад хэлний  
институтын ахлах багш

**Б.Эрдэнэдалай**

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,  
Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

### *Товч агуулга*

Дэлхийн улс орнууд өөрийн онцлог, түүхэн уламжлал, давуу тал, геополитикийн орчин нөхцөл зэрэг олон хүчин зүйлийг харгалзан гадаадын хөрөнгө оруулалтын бодлогоо боловсруулж хэрэгжүүлдэг байна. Эдгээрээс гадна, гадаадын хөрөнгө оруулалт тухайн улсын нийгэм, эдийн засгийн урт хугацааны хөгжлийн бодлогод нийцэж байх нь чухал гэж үздэг. Ихэнх улс орнууд тухайн хөрөнгө оруулалтын эдийн засгийн нөлөө ажлын байрны хангамж, технологи, ноу хау, зах зээлд үзүүлэх нөлөө, хөгжил буурай орон нутагт хувь нэмэр, дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, импортыг орлох чадвар, үйлдвэрлэлд ашиглах дотоодын нөөц баялаг, үнэ ханшид үзүүлэх нөлөө зэргийг түлхүү анхаарч байна. Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтыг татах болон түүнийг улс орондоо шингээх чадвар үр өгөөжийг нэмэгдүүлэх асуудал чухал болоод байна.

**Түлхүүр үгс:** Гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, эдийн засгийн боломж, уул уурхай, санхүүгийн тогтолцоо, ажиллах хүчин

Зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх хөрөнгө оруулалт гэдэг нь “investment” буюу ашиг, орлого олох, эсвэл өөр тааламжтай үр дүнд хүрэх зорилгоор пүүс компанид оруулж байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, бусад хөрөнгө, түүний дотроос мөнгөн үнэлгээгээр илэрхийлэгдэх хөрөнгийн эрх зэрэг үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа<sup>7</sup> гэж тодорхойлогддог байна.

АНУ-ын эдийн засагч Жозеф Кортрайт (Joseph Cortright) 2001 онд боловсруулсан шинэ өсөлтийн онолын дагуу ажиллах хүчинд шинэ мэдлэг, ур чадварыг эзэмшүүлж, үйлдвэрлэлийг удирдах шинэ арга барилыг нэвтрүүлэх замаар тухайн орны эдийн засгийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, өсөлтөд нөлөө үзүүлдэг болохыг тайлбарлажээ. Энд гадаадын хөрөнгө оруулалтыг дагасан шинэ техник технологи, мэдлэг нь тухайн орны үйлдвэрлэлийн хүчин чадал, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг<sup>8</sup> гэж үзсэн байна.

<sup>7</sup> "Об инвестиционной деятельности в Российской Федерации, осуществляемой в форме капитальных вложений" Федеральный закон от 25.02.99 №39-ФЗ. Нормативные акты для бухгалтера-1999 №7, с-88.

<sup>8</sup> Thomas Dudas. Main Theories of Foreign Direct Investment. 2004

Их Британийн эдийн засагч Жон Даннинг (John Dunning) гадаадын хөрөнгө оруулалтыг татахад шийдвэрлэх нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлсийн талаарх онолыг дэвшүүлсэн байдаг. Төгс бус өрсөлдөөнт зах зээлд тээвэрлэлтийн зардал өндөр, худалдааны саад бэрхшээл ихтэй, гадаад зах зээлийн талаар хангалттай мэдээлэл байхгүй, худалдагч болон худалдан авагч талууд харилцан мэдээлэлгүй байх, олж буй орлогоо саадгүй шилжүүлэх нь тодорхой бус, зардал нь өсөх магадлалтай байх нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах орчин болж чадахгүйг судлаачид тодорхойлсон байна.


“Хөрөнгө оруулалтын шингээх чадвар” гэсэн нэр томъёог анх Америкийн эрдэмтэн Весли М.Кохен (Wesley M.Cohen), Даниел А.Левиндаль (Daniel A.Levinthal) нар 1990 онд туурвижээ. Тэд “Шингээх чадвар: суралцах болон шинээр санаачлах тал дээрх цаашдын төлөв - технологи, зохион байгуулалт, шинэ санаачилга” гэсэн хамтын бүтээлдээ хөрөнгө оруулалтын шингээх чадварын онолыг дэвшүүлсэн байна. Үүнээс хойш тэд хөрөнгө оруулалтын шингээх чадварын судалгаа шинжилгээнд зориулж онол, практикийн олон бүтээлдээ хөрөнгө оруулалтын шингээх чадвар нь хувь хүн, байгууллагын, улс орны түвшинд ашиглагдах ойлголт бөгөөд улс орны шингээх чадвар, компани, байгууллагуудын шингээх чадвараас шалтгаалж, байгууллагын шингээх чадвар хувь хүний шингээх чадвараас шалтгаалдаг гэж үзсэн байна. Тухайн улс орны гадаадын шууд хөрөнгө оруулалтын шингээх чадвар гэдэг нь тухайн хөрөнгө оруулалтаас өөртөө юуг үлдээж авах, хэр зэрэг үр өгөөжтэй, хүртээмжтэй хөрөнгө оруулалт гэдгийг тодорхойлсон ойлголт байна.

Аялал жуулчлалын судалгааны улс төрийн хэмжүүрийн өөр нэг чиглэл бол аялал жуулчлалын асуудал, үзэгдлийг төрийн салбарын менежментийн үүднээс судлах явдал юм. Аялал жуулчлалын уламжлалт судалгаа нь зөвхөн аялал жуулчлалын эдийн засгийн өгөөж, ашиг тусад анхаардаг боловч аялал жуулчлал нь олон нийтийн сайн сайхны талаас болон нөөцийг хөгжүүлэх, ашиглах, хамгаалах талаар ч төдийлөн анхаардаггүй. Өнөөгийн аялал жуулчлалын зах зээл дээр аялал жуулчлалын эрэлт улам бүр нэмэгдэж, эрчимжиж, аялал жуулчлалын нөөц харьцангуй хязгаарлагдмал байна. Аялал жуулчлалын нөөц, үзэгдэл, асуудлыг улс орны өндрөөс үр дүнтэй удирдах талаар засгийн газрын бүхий л хүчин чармайлтыг хэрхэн ашиглах нь өнөөдөр аялал жуулчлалын судалгааны чухал зорилт болжээ. Төсвийн байгууллагын менежментийн хэтийн төлөв нь засгийн газар аялал жуулчлалыг хэрхэн удирдах, тухайлбал бодлогын томьёолол, аялал жуулчлалын менежментийн зохион байгуулалтын бэлтгэл, орон нутгийн засаг захиргааны зохицуулалт, нисэхийн болон нөхцөл байдлын хяналт, тогтвортой хөгжлийн талаар аялал жуулчлалыг хэрхэн удирдан зохион байгуулах талаар ярилцах янз бүрийн арга хэлбэр юм<sup>12</sup>.

**3. Улс төрийн харьцуулалтын хэтийн төлөв:**

Харьцуулсан аргууд бол улс төрийн шинжлэх ухааны судалгааны үндсэн арга юм. Аялал жуулчлалын улс төрийн шинжлэх ухааны хэмжүүр нэмэгдсэнээс хойш харьцуулсан улс төрийн арга нь аялал жуулчлалын улс төрийн шинжлэх ухааны хэмжүүрийн нийтлэг, үр дүнтэй шинжилгээний хэрэгсэл болжээ. Төрөл бүрийн тогтолцоо, улс төрийн тогтолцоо, улс төрийн соёл, бодлогын боловсруулалтын үйл явц зэрэг улс төрийн нөхцөл байдлыг харьцуулж үзэхэд энэхүү баримт бичигт улс эсвэл бүс нутагт аялал жуулчлалын хөгжил, аялал жуулчлалын бодлогыг томьёолох зэргээр бүхий л тохиолдлуудад нөлөөлөх нөхцөл болж

<sup>10</sup>Cheong So-Min, Miller M.L., "Power and tourism: a Foucauldian observation", *Annals of Tourism Research*, 2000, 27(2) pp.371-390.

<sup>11</sup>Pizam A. "Does tourism promote peace and understanding between unfriendly nations?" In Lickorish, L. & Jenkins, C. *An Introduction to Tourism* (M) Oxford: Butterworth-Heinemann, 1997, pp.211.

<sup>12</sup>Elliot J., *Tourism and Public Sector Management* (M) London, New York: Routledge, 1997.

байна. Жишээлбэл, Рихтер (1989) Хятад, Филиппин, Тайланд, Энэтхэгийн улс төрийн систем, бодлогын үйл явцыг харьцуулж Азийн аялал жуулчлалын улс төрийг судалжээ<sup>13</sup>. Холл ба Пэйж (2000) нар "Өмнөд Ази ба Зүүн Өмнөд Азийн аялал жуулчлал, асуудал ба тохиолдол" номондоо Өмнөд ба Зүүн өмнөд Азийн орнуудын улс төрийн тогтолцоог улс төрийн харьцуулсан арга замаар харьцуулж, эдгээр бүс нутгийн аялал жуулчлалын асуудлыг судалжээ<sup>14</sup>. Иймээс улс төрийн харьцуулсан харьцангуй байдал нь аялал жуулчлалын бодлого, хөгжил, үйл ажиллагаа, асуудлыг судлах харьцангуй давуу тал бүхий аналитик арга, хэрэгслийг бий болгож өгдөг.

#### 4. Улс төрийн системийн шинжилгээний хэтийн төлөв:

Аялал жуулчлалын улс төр үүссэнээс хойш улс төрийн системийн онол нь эрдэмтэн судлаачдын дуртай хүчирхэг хэрэгсэл болжээ. Аялал жуулчлалын улс төрийн судлаачдын анхдагчдын нэг Мэттьюс Холл "Олон улсын аялал жуулчлал: Улс төр ба нийгмийн шинжилгээ", "Аялал жуулчлал ба улс төр судлаач" сэдвээр улс төрийн системийн удирдлагаас улс төрийн системийн шинжилгээний загварт нийцүүлэн улс төр ба засгийн менежементийн өнцгөөс аялал жуулчлалын улс төрийн системийн загварыг санал болгосон. Энэхүү загвараа Мэттьюс аялал жуулчлалын шийдвэр гаргах, үйл ажиллагааг аялал жуулчлалын улс төрийн системийн загварт нөлөөлөх хоёр үндсэн хувьсагч гэж үздэг. Шийдвэр гаргагчид ба системийн гишүүд харилцаа холбоог оролт, гарцаар ойлгодог<sup>15</sup>. Холлын аналитик загвар нь улс төрийн шинжилгээний систем дээр суурилдаг боловч эрх мэдэл, үнэт зүйлс, байгууллагын зохион байгуулалт зэрэг нь аялал жуулчлалын шийдвэр гаргахад үзүүлэх нөлөөг онцолдог гэсэн<sup>16</sup>.

#### *Аялал жуулчлалын улс төрийн үндсэн бүтэц*

Аялал жуулчлалын судалгааны улс төрийн шинжлэх ухаан, улс төрийн бүтэц загвар нь олон улсын, үндэсний, орон нутгийн эсвэл бүс нутгийн болон хувь хүний түвшинг хэвтээ байдлаар хамардаг болохыг харуулж байна. Үүнд аялал жуулчлал ба засгийн газар, бодлого, олон улсын улс төр, улс төрийн хүчирхийлэл, улс төрийн хөгжил, улс төрийн үзэл суртал, улс төрийн нийгэмшил, капиталист харилцаа зэрэг орно. Төр засаг нь аялал жуулчлалын үйл ажиллагааны үндсэн давхарга бөгөөд олон улсын, орон нутгийн бүс нутаг, хувь хүмүүсийн хоорондын холболтын цэг юм. Орон нутгийн бүс нутаг, хувь хүмүүсийн хувьд муж, түүний төв засгийн газар нь аялал жуулчлалын хөгжлийн тулгуур салбар юм. Олон улсын нийгэмлэгт тухайн улс төрийн хүчин чадал нь хамтран ажиллахын суурь болдог. Гэвч төр засгийн бие даасан эрх мэдэл нь илүү давуу эрхийг эдэлнэ.

Төр засаг бол аялал жуулчлалын бодлого боловсруулагчид мөн. Мөн ч аялал жуулчлалын менежемент, аялал жуулчлалтай холбоотой маргаантай асуудлуудыг шийддэг ба аялал жуулчлалын хөгжлийн явцад чухал байр суурьтай. Улс орнуудын улс төрийн тогтолцоо, захиргааны тогтолцоо нь өөр өөр байдаг тул нам засгаас аялал жуулчлалын байгууллагуудад өгч байгаа эрх мэдэл нь ч ялгаатай. Гэвч нэг засаглалтай улс нь ардчилсан засаглалтай улсаас аялал жуулчлалын албан байгууллагын эрх мэдэл нь их байдаг.

Аялал жуулчлалын шийдвэр гаргах, үйл ажиллагаанд суурилсан аялал жуулчлалын улс төрийн системд засгийн газар ба түүний чиг үүргийн удирдах албан байгууллагууд болон

<sup>13</sup>Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 2006, 21-р боть 7 № 7.

<sup>14</sup>Hall C.M., Page S. Tourism in South and Southeast Asia, Oxford: Butterworth-Heinemann, 2000.

<sup>15</sup>Matthews H. G. International tourism: a political and social analysis (М). Schenkman Publishing Company, Inc. USA., 1978, pp.88, pp.91-92.

<sup>16</sup>Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 2006, 21-р боть 7 № 7.

хувийн хэвшил, оролт, гарцаар дамжуулан тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг явуулах алхмуудыг хэрэгжүүлдэг. Улс төрийн хэрэгцээнд үндэслэн засгийн газар болон түүний функциональ хэлтэсүүд нь дотоод болон гадаад орчны шаардлага, хувийн хэвшилийн дэмжлэгийг оруулан аялал жуулчлалын холбогдох эерэг буюу сөрөг бодлогыг боловсруулж, хэрэгжүүлдэг. Төрийн байгууллагууд нь ашиг сонирхлын дагуу янз бүрийн тусгал, сонголтыг хийх бөгөөд эдгээр сонголт, сонголтуудыг засгийн газар, түүний чиг үүргийн хэлтэст дахин хянуулахаар санал солилцдог.

Аялал жуулчлал оршин тогтнох, хөгжих нь улс төрийн тогтвортой, эв найрамдалтай байдалтай салшгүй холбоотой. Аялал жуулчлалын хөгжил сул байдгаас улс төрийн хүчирхийлэлд мэдрэг чанартай ба олон улсын хамтын нийгэмлэг улс төрийн янз бүрийн маргаантай асуудлын дунд хөгжлийг оновчтой шийдвэрлэх хэрэгтэй. Улс төрийн нийгэмшил нь өнөөгийн улс төрийн хөгжлийн чухал хандлага юм. Дэлхийн олон нийтийн нөхцөлд улс, бүс нутгийн аялал жуулчлалын солилцоо, хамтын ажиллагааны давалгаа улс орон, бүс нутгийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд нөлөөлж байна. Энэ нь нэг талаас, энх тайван, тогтвортой олон улсын улс төрийн бүтэц бий болгох, улс орон эсвэл бүс нутгийн харилцан хүндэтгэл, тэгш байдал, харилцан ашигтай байх нь аялал жуулчлал оршин тогтнох, хөгжих улс төрийн үндсэн баталгаа юм. Нөгөө талаас аялал жуулчлалын соёлыг төлөвшүүлэх, танин мэдэхүйн тогтолцоог бий болгох, улс орон эсвэл бүс нутгийн аялал жуулчлалын үйлчилгээний худалдаа хоорондын харилцан хамаарлыг бэхжүүлэх нь ашиг сонирхлын зөрчил, соёлын ялгаатай байдлаас үүдэлтэй улс орнуудын хоорондын зөрчлийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Улс орон, бүс нутгийн хоорондын зайг сайжруулах нь улс эх орны харилцан итгэлцэл, эдийн засгийн харилцан ашиг, соёлын солилцоог дэмжих, улмаар олон улсын харилцааг сайжруулж, дэлхийн энх тайвныг дэмжихэд чухал ач холбогдолтой юм. Аялал жуулчлалын улс төрийн шинжлэх ухаан нь ирээдүйд ийм чухал практик, алс холын түүхэн ач холбогдолтой байх болно<sup>17</sup>.

### ***Төрийн захиргаа ба аялал жуулчлалын алба***

Энгийн байдалд захиргааг албаны ажлыг ахиулах буюу нийтийн захиргаа гэж хэлж болно. Төрийн байгууллагууд эсвэл нийтийн байгууллагуудын янз бүрийн бизнесийг хэрхэн сурталчлах вэ гэдэг нь захиргааны арга юм. Бодлогын үүднээс удирдлага гэдэг бол бодлогыг хэрэгжүүлэх, харин менежментийн үүднээс "Удирдлага гэдэг нь засгийн газар, байгууллага, нийгмийн байгууллага, үйлдвэрчний эвлэл гэх мэт байгууллагаас үүрэг хариуцлагаа биелүүлж, хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. "Захиргаа гэдэг нь төрийн байгууллагууд албан тушаалтнуудын албан тушаалтнуудыг сурталчлахад аж ахуйн нэгжийн удирдлагын зарчмуудыг ашигладаг арга гэж хэлэхэд илүү тохиромжтой юм. Захиргаа нь төрийн болон төрийн байгууллагуудын бүхий л үйл ажиллагаатай холбоотой бөгөөд удирдлагыг өргөн утгаар нь авч үзвэл бодлогын үйл ажиллагаа, зохицуулалтыг тусгаж хэрэгжүүлэх ёстой. Иймээс Ян Жэньчуан (2000) засаг захиргааны холболтыг дараах байдлаар нэгтгэв: Нэг, олон нийттэй холбоотой асуудлыг засгийн газар эсвэл төрийн байгууллагууд зохицуулах ёстой. Хоёр, засгийн газрын салбарт ажилладаг байгууллага, ажилтнууд (хүнд суртал). Гурав, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх. Дөрөв, төрийн байгууллагуудын

<sup>17</sup>Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 21-р боть. 2008 оны 7-р дугаар, хуудас 88-89.

ажил үүрэг, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд удирдлагын аргуудыг (төлөвлөлт, зохион байгуулалт, манлайлал, харилцаа холбоо, зохицуулалт, хяналт гэх мэт) ашиглах явдал юм. Тав, нийтийн эрх зүй эсвэл захиргааны харилцаанд суурилсан менежментийн урлаг гэж үзсэн.

Хятад улсын эрдэмтэд Ян Ёубинг, Фан Шимин<sup>18</sup> (2006)нар захиргаа нь захиргааны хэргийг ахиулах төрийн хэрэг гэж нэрлэж болно хэмээсэн. Өөрөөр хэлбэл ард түмний асуудал гэдэг бол ихэнхи иргэдтэйхарилцаатай нягт холбоотой зүйл юм. Олон нийтийн харилцаанд хүн ам, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, тээвэр, нийтийн аюулгүй байдал, даатгал, халамж, эрүүл мэндийн нөхцөл байдал багтдаг бөгөөд эдгээр нь бүгд засаг захиргааны удирдлагын үндсэн зорилгыг бүрдүүлдэг. Төрийн захиргаа буюу төрийн удирдлага гэж нэрлэдэг захиргааны менежмент нь ашиг олох, ашгийн бус нийгмийн олон нийтийн байгууллага эсвэл хувийн байгууллагуудын нийгмийн олон нийтийн харилцааг удирдах явдал юм. Захиргааны менежмент нь бусад менежментээс ялгаатай.Улсын засаг захиргааны байгууллагуудаар удирдуулдаг, улс төрийн, албадлагын, эрх зүйн болон үйлчилгээ зэрэг өөрийн онцлог шинж чанартай төрийн удирдлагатай үйл ажиллагаа юм. Захиргааны эцсийн зорилго бол бүх нийтэд үйлчлэх явдал юм. Аялал жуулчлалын менежментийг аялал жуулчлалын удирдлага, менежмент, захиргааны менежемент гэж нэрлэдэг. Аялал жуулчлалын удирдлагын нарийн мэдрэмжээс харахад энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй газрууд болон аялал жуулчлалын удирдлагаас хамаарч болно. Гэсэн хэдий ч, өнөөгийн аялал жуулчлалын салбар нь дотоод хэрэг, гадаад харилцаа, үндэсний батлан хамгаалах, эдийн засаг, нийгэм, соёл, хөдөө аж ахуй, хөдөлмөр, боловсрол, санхүү, хот байгуулалт, эрүүл мэнд, байгаль орчин зэрэг олон асуудлыг хамарсан цогц ажил юм. Засгийн газар болон олон нийтийн албан байгууллагууд нь бодлогод анхаарч үүнтэй холбоотойгоор улс орны нийт хүч чадал, нөөцийг бүрэн, үр дүнтэй ашиглах, харилцаа холбооны сувгийг бий болгох, зохицуулах, хамтран ажиллах, зөвшилцлийг бий болгоход холбогдох төрийн байгууллагуудаас шаардагдана. Ингэж аялал жуулчлалын бизнесжигд хөгжинө. Тиймээс аялал жуулчлалын нэгдсэн удирдлага нь засгийн газрын бүх түвшний төрөл бүрийн хэлтсийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг хэлдэг бөгөөд бодлого, журамд үндэслэн засгийн газрын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд төлөвлөлт, зохион байгуулалт, удирдан зохион байгуулах, харилцах, зохицуулах, хянах арга зүйг ашигладаг. Аялал жуулчлалын захиргааны менежемент гэдэг нь аялал жуулчлалын салбарыг муж улс эсвэл бүсээр удирддаг байгууллага бөгөөд ерөнхий захиргааны менежменттэй нягт уялдаатай боловч зарим талаараа бүрэн нийцдэггүй. Аялал жуулчлалын менежментийн онолын дагуу аялал жуулчлалын салбарын онцлог шинж чанарыг хослуулан менежментийг дараахь байдлаар тодорхойлдог: муж улсын аялал жуулчлалын засаг захиргааны алба нь бүх шатны холбогдох хууль тогтоомж, төрийн удирдамж, бодлогын дагуу аялал жуулчлалын хөгжлийн хуулийг дагаж мөрдөх, улс орон эсвэл бүс нутаг руу чиглүүлэх, аялал жуулчлалын салбар нь макро менежмент, цогц зохицуулалттай ажлуудыг явуулдаг.Аялал жуулчлалын хөгжил дэх менежментийн тогтолцоо нь улс орон, бүс нутгийн хоорондох улс төрийн тогтолцоо, менежментийн систем, аялал жуулчлалын хөгжил харилцан адилгүй байдаг тул аялал жуулчлалын засаг захиргааны удирдлагын тогтолцоо, холболт, үйл ажиллагааны хувьд ялгаа байдаг тул улс орон, бүс нутаг бүр тухайн улс, бүс нутагт тохирсон аялал жуулчлалыг тухайн нөхцөл байдлын дагуу сонгох ёстой.

<sup>18</sup>Ян Ёубинг редакторууд: "Аялал жуулчлалын удирдлага", Бээжингийн аялал жуулчлалын боловсролын хэвлэл 2006, анхны хэвлэл, 4-8-р хуудас.

Түүний менежментийн агуулга нь дараахь дөрвөн үндсэн зүйлийг багтаах ёстой: нэг, аялал жуулчлалын удирдлагын сэдэв, объект:хоёр, аялал жуулчлалын удирдлагын арга зам: гурав, аялал жуулчлалын удирдлагын зорилго: дөрөв, аялал жуулчлалын удирдлагын мөн чанар.

Аялал жуулчлалын менежментийн хамгийн чухал удирдлага нь дээр дурдсан засаг захиргааны ерөнхий менежментээс гадна улс төрийн, албадлагын, хууль ёсны үйлчилгээний онцлогоос гадна бүгдэд зөвшөөрөгдсөн цогц онцлогтой.

### *Дүгнэлт*

Аялал жуулчлалын салбарын хөгжил нь бидэнд түүхэн өв уламжлал, ёс заншлаа хадгалан, үр хойчдоо өвлүүлэн үлдээх, олон улс орнуудад сурталчилан таниулах гол түлхүүр болох юм. Ерөнхийдөө аялал жуулчлалын бодлогын хувьд стандарт, зохицуулалтыг боловсронгуй болгох нь харьцангуй богино хугацаатай бөгөөд тодорхой хугацаанд аялал жуулчлалыг хөгжүүлэх бодит хэрэгцээнд хариу өгөх боломжтой. Энэхүү уян хатан байдал ба цаг үеэ олсон байдал нь тодорхой асуудлууд дээр илүү тод харагддаг. Аялал жуулчлалын бодлогын зорилтуудын олон талт байдал нь хөгжлийн түвшин янз бүр байдгаас шалтгаалж, улс орнуудын аялал жуулчлалын хөгжлийн ялгаа нь тусгагдсан байдаг байна. Аливаа улс оронд аялал жуулчлалын бодлогын зорилго нь хөгжлийн янз бүрийн үе шатуудад өөр өөр байдаг. Нэмж дурдахад, аливаа улс орны хувьд өөр өөр бүс нутгийн аялал жуулчлалын бодлогын зорилтууд хоорондоо эрс ялгаатай байдаг. Заримдаа бодлого тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж, дасан зохицох, хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдалд хүргэдэг. Гадаад орчны өөрчлөлтөөс үүдэлтэй бодлого, зорилтын хоорондын зөрүүг арилгахын тулд сайн бодлогыг автоматаар шинэчлэн боловсруулж болно. Мөн сайн бодлого нь уян хатан байдлыг хангаж, бодлогын хэрэгжилтийг нэмэгдүүлдэг. Тиймээс бодлогын түвшин өндөр байх тусам бодлогын уян хатан чанарыг хангахын тулд "Бүх асуудлыг нэг аргад нийцүүлэн шийдэхгүй" гэсэн асуудлуудаас ерөнхий заалт, тайлбарыг гаргаж өгөөд энэ нь орон нутгийн хувьд илүү тодорхой зүйлийг боловсруулахад тохиромжтой юм. Бүс нутгийн ялгаа асар их байгаа хөгжиж буй орнуудын хувьд бодлогын заалтуудын уян хатан чанар хадгалах нь илүү чухал юм.

### *Abstract*

The sources are reported that the world's tourism development has started since the 1960s. After a half-century, tourism has become the world's largest industry. Thus, countries are aiming to develop tourism industry.

In the age of globalization, tourism has become a important motivation in its history of development and known as most peaceful and generous industry. The society has created a strong tourism demand by itself in now-days, more and more tourists are interested in unique culture, civilization and virgin nature from developed counties. It is a best opportunity for those countries to participant with this huge tourism market by their own unique way. The tourist industry brings the economic growth, increase in employment and its responsibility of sustainable development.

**Ном зүй**

1. Dunn,William. (1994) ,Public Policy Analysis:An Introduction.Englewood Cliffs,N.J..Prentice-Hall, Циу Чантай иш татсан: "Бодлогын шинжилгээ", Тайпей Скай Их сургууль, 2008 оны хэвлэл, хуудас 13-14.
2. Hogwood,B.W. and Gunn,L..A (1984) .Policy Analysis for the Real World.Oxford:Oxford University Press. pp 15-16.
3. Radin,Beryl A. (2000) .Beyond Machiavelli:Policy Analysis Comes of Age. Washington,D.C.:Georgetown University Press.
4. Cochran, Charles L. and Malone,Eloise. (1995) . Public Policy:Perspectives and Choices. New York:McGraw-Hill,Inc.
5. ᠑Циу Чантай: Бодлогын дүн шинжилгээ, Тайпей Скай Их Сургуулийн Хэвлэл, 2008, хуудас 26-31.
6. Richer L.K.,The Politic of Tourism in Asia ( М ) . Honolulu,University of Hawaii Press, 1989,PP.1-2.
7. Hall C.M.,Tourism and Politics:Policy, Power and Place ( М ) Chichester, U.K.:Wiley,1994.PP.2,PP.195,PP.92-93,PP.62-91,PP.65-66,PP.18.
8. Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 2006, 21-р боть, № 7, хуудас 85.
9. David L. Edgell,International Tourism Policy ( М ) .New York:Van Nostrand Reinhold,1990,pp.163-164.
10. Cheong So-Min,Miller M.L.,“Power and tourism: a foucauldian observation”, Annals of Tourism Research, 2000,27(2)pp.371-390.
11. Pizam A. “Does tourism promote peace and understanding between unfriendly nations?” In Lickorish, L.& Jenkins,C. An Introduction to Tourism ( М ) Oxford:Butterworth-Heinemann,1997,pp.211.
12. Elliot J., Tourism and Public Sector Management ( М ) ,London,New York:Routledge,1997.
13. Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 2006, 21-р боть 7 № 7.
14. Hall C.M.,Page S. Tourism in South and Southeast Asia,Oxford:Butterworth-Heinemann,2000.
15. Matthews H. G. International tourism: a political and social analysis ( М ) .Schenkman Publishing Company,Inc.USA.,1978,pp.88,pp.91-92.
16. Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 2006, 21-р боть 7 № 7.
17. Жимин Тан: "Аялал жуулчлалын улс төрийн улс төрийн шинжилгээ", Аялал жуулчлалын сэтгүүл, 21-р боть. 2008 оны 7-р дугаар, хуудас 88-89.
18. Ян Ёубинг редакторууд: "Аялал жуулчлалын удирдлага", Бээжингийн аялал жуулчлалын боловсролын хэвлэл 2006, анхны хэвлэл, 4-8-р хуудас.

## **“ХЯТАД, МОНГОЛ, ОРОСЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР”-ЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЯТАД МОНГОЛ ХАМТРАН ЭЛСЭН ШУУРГААС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ АНХНЫ ШИНЖИЛГЭЭ**

**Э.Наран**

Өвөр Монголын Их Сургуулийн  
Монгол улсыг судлах хүрээлэнгийн  
профессор, шинжлэх ухааны доктор

### ***Товч утга***

“Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” байгуулах урьтал бол сайн сайхан экологийн орчин шаарддаг. 2015 онд Хятад, Монгол, Орос гурван улсын тэргүүний баталсан “Хятад, Монгол, Орос гурван талын хамтын ажиллагааны дунд хугацааны чиглэлийн график” болон 2016 онд байгуулсан “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын төлөвлөгөөний хөтөлбөр”-т цөм экологи байгаль орчныг хамгаалах талын хамтын ажиллагааг агуулгыг тодорхой заасан билээ. Урт хугацааны турш, элсэн шуурга нь Хятад, Монгол болон холбогдох улс орнуудад байнга шуурч, тэдгээр газруудын зам харилцаа зэрэг дэд бүтцийг ноцтой эвдэн сүйтгэж, эдийн засаг нийгмийн тогвортой хөгжилд харшилж байгаа бөгөөд элсэн шуургын хор хөнөөл нь Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорын урагштай хөгжихөд сөргөөр нөлөөлөх нь зайлшгүй билээ. Хятадад жил бүр хор хөнөөл учруулж байсан элсэн шуургын хагасаас дээш хувь нь хилийн чанадаас илрэлтэй бөгөөд голдуу Монгол улсаас ирдэг гэснийг судалгаа харуулжээ. Иймээс “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ын сайн сайхан нөхцөл байдалд, Хятад, Монгол хоёр улс Орос болон олон улсын нийгэмтэй хамтран элсэн шуургатай тэмцэж, элсэн шуургын хор хөнөөлийг үндсээр нь устгах буюу бууруулах нь гурван улсын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад алс хэтийн стратегийн ач холбогдол өгөх болно.<sup>1</sup>

**Түлхүүр үг:** Гурван улсын эдийн засгийн коридор, элсэн шуурга, Хятад Монгол хамтран тэмцэх.

2014 оны 09-р сард БНХАУ-ын дарга Ши Жиньпин Душанбэд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин болон Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой гурван улсын тэргүүний уулзалт хийхдээ “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг хамтаар байгуулах санаачилга дурьдаад Монгол Орос хоёр талын идэвхтэй дэмжлэгийг олсон. Хятад Монгол Орос гурван улс “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг ОХУ-ын “Ази Европыг дамнасан их төмөр зам” болон Монгол улсын “Хөгжлийн зам” (Талын зам)-тай холбож, Хятад Монгол Оросын эдийн засгийн коридор байгуулахаар болсон.

2015 оны 07-р сард, ОХУ-ын Уфа хотод болсон Хятад, Монгол, Оросын гурван улсын

<sup>1</sup> “Хятадын Боловсролын яамны нийгмийн ухааны төсөл—Хятадын “Нэг бүс нэг зам” болон Монголын “Талын зам” санаачлагын уялдааг түлхэн ахиулах судалгаа”-ны (16JJDGJW008) үе шаттай үр дүн юм.

тэргүүний уулзалт дээр Монгол Оросын гурван талын хамтын ажиллагааны дунд хугацааны чиглэлийн график”-ийг баталсан. “Дунд хугацааны чиглэлийн график”-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны хэсэгт экологи байгаль орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах зүйлүүдийг жагсаасан байна.

Мөн түүнчлэн 2016 оны 06-р сард Хятад, Монгол, Орос гурван улсын тэргүүн Ташкентад уулзахдаа “Хятад Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах төлөвлөгөөний хөтөлбөр”-т гарын үсэг зурсан. “Төлөвлөгөөний хөтөлбөр”-т эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтын бодитой агуулгыг тодорхойлж, экологи байгаль орчныг хамгаалах ажлыг оролцуулсан арван томоохон салбарын хамтын ажиллагааны төслийг хэлэцэн тохиролцсон. Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулахад сайн сайхан экологи байгаль орчин шаардаж байгаа нь бодитой зүйл юм. Үүнээс үндэслэн, энэхүү өгүүлэлд бүх дэлхийд нүүрлээд байгаа, ялангуяа Хятад, Монголд ноцтой нөлөөлж байгаа элсэн шуургын асуудалд анхны шинжилгээ хийх болно.

### **Нэг. Хятад, Монгол хоёр улс элсэн шуургын хор хөнөөлд хамгийн илүү өртдөг болох нь**

#### **1. Хятад оронд шинэ нэг ээлжийн элсэн шуургын оргил үе ирж болзошгүй**

XX зууны сүүлийн хагасаас эхэлж, Хятадын нутаг дэвсгэрт элсэн шуурга шуурах тоо нэмэгдэх хандлагатай болсон. Элсэн шуурга XX зууны 60-аад онд жилд дунджаар 8 удаа шуурдаг байснаа 90-ээд оноос нааш жилд дунджаар 15-20 удаа (Хүснэгт №1) шуурах болж, шинэ зууны дараа элсэн шуурга мөн жил дараалан тасралтгүй шуурч, жил бүрийн хавар нийслэл Бээжинг оролцуулсан дунд баруун бүсэд шуурах болсон. 2002 оны 03-р сард Монгол улсаас шуурч ирсэн хоёр удаагийн элсэн шуурга нийслэл Бээжингийн харагдах байдлыг 200 м ч хүрэхгүй болгосон<sup>2</sup>. Шуурах бүртээ 50 цагаас дээш хугацаа үргэлжилж, унасан тоосны хэмжээ 30 мянган тоннд хүрсэн нь Бээжингийн хүн бүрд 2 кг ногдож, элсний тархалтын өндрийн хэмжээ 2500-3000 м байж, агаар дахь хөвмөл мөхлөгт бодис хэвийн хэмжээнээсээ 100 дахин хэтэрсэн байна. Энэ удаагийн элсэн шуурга Монгол улс, Хятадын Бээжин, Ганьсү зэрэг найман муж хот өөртөө засах оронд нөлөөснөөр барахгүй, цаашлаад далайг гаталж Тайвань болон зүүн хойд азийн орнуудад хүрсэн байна.

#### **Хүснэгт № 1 Хятадын газар шорооны цөлжсөн талбай болон элсэн шуургын тоо**

|                                                   |                     |       |           |           |           |            |      |
|---------------------------------------------------|---------------------|-------|-----------|-----------|-----------|------------|------|
| Он                                                |                     |       | 1950-1960 | 1970-1980 | 1990-1995 | 1995--2000 |      |
| Цөлжилтийн тэлэлтийн талбай (хдк/жил бүр)         |                     |       | 1560      | 2100      | 2400      | 3436       |      |
| Элсэн шуурга(удаа/жил бүр)                        |                     |       | 5---8     | 13---14   | 15---20   |            |      |
| Хүчтэй элсэн шуурга болон онц хүчтэй элсэн шуурга | Он                  | 1950- | 1960--    | 1970--    | 1980--    | 1990--     | 2000 |
|                                                   | Жил бүр шуурсан тоо | 0.5   | 0.8       | 1.3       | 1.4       | 2.3        | 14   |

<sup>2</sup> Шао Лүн-И: “2002 оны хаврын Бээжингийн онц хүчтэй элсэн шуургын мөхлөгт эрдэс бодисын бүрэлдлийн тухай анализ”, “Хятадын шинжлэх ухаан”, 2007 оны 2-р хугацааны 216-р хуудас.

Материалын илрэлт: Шы Пэйжюний “Хятадын элсэн шуургын эрсдлийн үнэлгээ болон удирдлага” (Азийн элсэн шуургын эрсдлийн үнэлгээ болон удирдлага эрдэм шинжилгээний хурал) болон Ван Жин-Айн “2000 оны Хятадын элсэн шуургын хор хөнөөлийн орон зайн байдал болон хор хөнөөлийн үнэлгээ” (“Байгалийн гамшиг” эрдэм шинжилгээний сэтгүүл, 2001 оны 10-р сарын 4-р хугацаа)-гийн холбогдох тоо баримтад дурьдсан байна.

2009 онд Хятадын умард хэсэгт нийт 8 удаа элсэн шуурга шуурсан нь өнгөрсөн жилүүдээс жаахан бага болсон боловч хэсэг газарт учруулсан байгалийн гамшиг нь мөн л нэлээд хүнд ноцтой билээ. Жишээлбэл 04-р сарын 23-25-ны өдөр хүчтэй элсэн шуурга болж, шуурсан талбай нь 730 мянган хавтгай дөрвөлжин км-т хүрч, 20 сая хүн амыг нөлөөлж, үүнд элсэн шуургад нөлөөлөгдсөн бүс нутаг 300 мянган хавтгай дөрвөлжин км-т хүрсэн. Тус удаагийн элсэн шуурга баруун хойт бүсийн агаарыг бохирдуулж, газар тариалан ноцтой хохирсон байна.<sup>3</sup>

Сүүлийн жилүүдэд, элсэн шуурга жаахан намдсан хэдий ч Хятадын хойд хэсэг болон баруун хойт хэсэгт байнга шуурч байна. 2017, 2018, 2019 оны 03-05-р сард Хятадын хойт хэсгийн Өвөр монгол, Бээжин хот, Ганьсү муж зэрэг муж хотод цөм том салхин элсний цаг агаар болж, үүнээс Өвөр Монголын баруун биеийн зарим газарт хүчтэй элсэн шуурга шуурсан байна. Хятад оронд шинэ нэг ээлжийн элсэн шуургын оргил үе ирж болзошгүй гэж цаг агаарын мэргэжилтнүүд таамаглаж байна. Иймээс Хятад орон эдийн засгаа өндөр хурдаар хөгжүүлэх ба “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ыг байгуулахын хамт, заавал элсэн шуургыг эртхэн сэргийлэн засах хэрэгтэй, энэ бол Хятад, Монгол, Орос гурван улсын хамтын ажиллагаанд нөлөөлж болшгүй бодит байдал мөн.

## **2. Монгол улс бол Азийн элсэн шуургын чухал голомт**

Монгол улс бол Азийн элсэн шуургын чухал голомт, дэлхийд элсэн шуурга их үүсдэг газрын нэг юм. Хятадтай харьцуулбал, Монгол улс элсэн шуургын хор хөнөөлд нэн хүнд ноцтой нөлөөлөгдөж байна. XX зууны 90-ээд оноос нааш, Монгол улсад элсэн шуурга шуурах давтамж тасралтгүй нэмэгдэж, жил бүр хэдэн арван удаад хүрч байгаа бөгөөд хүч болон хор хөнөөл нь улам ихээр нэмэгдэж байна. 2002 оны 03, 04-р сард шуурсан хоёр удаагийн хүчтэй элсэн шуургын хор хөнөөл хамгийн их юм. Монгол улсын баруунаас зүүн тийш 13 аймгийг нөлөөлж, салхины хурд 34-40 м/секундэд хүрч, харагдах байдал хэдхэн метр байж, урд бүсийн аймгуудын авто зам тасалдаж, галт тэрэг явахын аргагүй болж, нисэх онгоц албадлагаар зогсож, эд хөрөнгийн хохирол 4 тэрбум төгрөг (400 шахам мянган ам.доллар)-т хүрсэн<sup>4</sup>. 2008 оны 05-р сарын сүүлчээр, Монголын дунд, зүүн бүсийн 7 аймгийг хамарсан цасан шуурга болон хүчтэй элсэн шуурганд 242 хүн сураггүй болж<sup>5</sup>, их хэмжээний мал хорогдсон байна. Сүүлийн жилүүдэд, Монгол улсын хүчтэй элсэн шуургын давтамж удааширсан боловч жил бүрийн хавар бол мөн л “Элсэн шуургын улирал” хэвээр байж, адил бус хэмжээний хор хөнөөл болж байна. Монгол улсын өмнөд бүс нутгийн 28 цаг агаарын станцын элсэн шуургыг ажигласан тоо баримтаас харахад, сүүлийн 10 жилд элсэн шуургын давтамж хамгийн их газар

<sup>3</sup> “Энэ жилийн 1-5-р сард манай улсын хойт биеийн нутагт элсэн шуурга жаахан бага болсон байна”, “Хятадын цаг агаар сүлжээ”, 2009 оны 06-р сарын 13-ны өдөр.

<sup>4</sup> Ли Жянь: “Хөх тэнгэр нэлгэр их элс, Хужийж цөлжсөн нутагт үхэр хонид цөөн: Монголын элсэн шуурга”, (Монгол) “Өнөөдөр сонин”, 2002 оны 04-р сарын 09-ний өдөр. Монголын судлаачид элсэн шуурган дунд ажиллаж байгаа нь

<sup>5</sup> (Монгол) Монгол улсын MNB телевиз 2008 оны 05-р сарын 29-ний өдрийн оройн мэдээнд мэдээлэв.

бол Өмнөговь аймаг, 03-05-р сарын хаврын улиралд, элсэн шуурга шуурах хоногийн тоо өсөх хандлагатай байна<sup>6</sup>.

### ***Хоёр. Элсэн шуурга бүрэлдэх шалтгаан ба түүний хор хөнөөл***

Элсэн шуурга бүрэлдэхэд голдуу гурван зүйлийн хүчин зүйл байдаг. нэгдүгээрт их салхи үүсэх нөхцлийн хүчин зүйл. хоёрдугаарт, тухайн газрын газар зүйн орчинд элсэн манхны голомттой. Гуравдугаарт, солих урсгалын давхаргын доод давхаргад эгц тогтворт бус хүчин зүйл үүсгэнэ. Монголын дунд өмнөд хэсэгт 5 говийн аймаг (Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говь-Алтай, Говьсүмбэр) байж, тэдгээрийн говь цөлөрхөг талбай нь Монголын нийт талбайн гуравны нэгийг эзлэх бөгөөд энэ бүс нутагт циклон дахин давтан үүсэж, циклон эргэлдэж дээшлэх үед агаарын урсгал элс тоос зэрэг хөвмөл бодисыг агаарт дагалдуулан аваачиж, элсэн шуурга үүсдэг. Монголын дунд өмнөд хэсгийн бүс нутгийн газрын дүрс болон цаг агаарын нөхцөл элсэн шуурга дахин давтан үүсэх хүчин зүйлийг бүрдүүлж, Монгол улсыг дэлхийн дөрвөн том элсэн шуургын голомтын нэг болгожээ<sup>7</sup>. Тэгэхэд Хятадын Шиньжян, Ганьсү болон Өвөр монгол нь элсэн шуурга шуурах хүчтэй газар болсон байна.

Хэдийгээр элсэн шуурга шуурах механизмыг шинжлэх ухаанчид улам ихээр судлах шаардлагатай боловч, элсэн шуурга үүсэх шууд шалтгаан нь хүн амын өсөлт болон дураараа атар газар хагалбарлаж, бэлчээрийн малын даац хэтэрч, байгалийн ургамлын хучилт эвдэгдэн, хөрсний өнгөн давхарга идэгдэж байгаа нь үүнийг гэрчилж байна. Иймээс, элсэн шуурга бол хүн төрөлхтөн экологийн тэнцвэрийг эвдсэнээс үүссэн байна.

Хятадын өнөөгийн цөлжөөд байгаа газар нутгийн 24.5% нь хэтэрхий их атар газар хагалбарласан, 31.8% нь хэт их мод огтолсон, 28.6% нь хэт их малжсанаас болсон юм. Ой модны яамны материалыг үндэслэвэл: “Хятадын цөлжилт өргөжсөн шалтгаан жинхэнэ байгалийн хүчин зүйлээс болсон нь дөнгөж 5.5%, 90% нь зориудын хүчин зүйлээс болсон байна”<sup>8</sup>. Хятад улс бол дэлхий дээр цөлжилт, элсжилт хамгийн ихтэй улс юм. Цөлжсөн газар нутгийн талбай бараг 2.62 сая хавтгай дөрвөлжин км байж, нутаг дэвсгэрийн талбайн 1/4-ээс дээшийг эзэлж байна. Элсжсэн газар нутгийн талбай 1.73 сая хавтгай дөрвөлжин км, нутаг дэвсгэрийн талбайн 1/5-ийг эзэлж, 400 шахам сая хүн цөлжилтөд нөлөөлөгдөж, Хятад улсын 18 муж, өөртөө засах орох, хот, 471 шянь хотыг хамарч байна. Цөлжилтийн нөлөөнөөс болж, бүх Хятадын 40%-ийн тариалах газар адил бус хэмжээгээр муудсан<sup>9</sup>. Жил бүр цөлжилтөөс болж байгаа эдийн засгийн шууд хохирол 54 тэрбум юаньд хүрч байна. Иймээс Хятад улсын цөлжилтөөс сэргийлж цөлжилттэй тэмцэх ерөнхий байдал маш хүнд ноцтой болоод байна.

Монгол улсад, цаг агаар дулаарч, ган хуурай болж байгаагаас гадна, Монголын тал нутгийн цөлжилт болон элсэн шуурга шуурахыг түргэтгэж байна. Сүүлийн 40 шахам жилд, суурьшил, хүн амын нягтрал нэмэгдсэнээс Монгол улсын нутаг дэвсгэрийн 42.5% нь адил бус хэмжээгээр цөлжсөн бөгөөд жил бүр 13%-18%-ийн хурдаар өргөжин тэлж байна. Монгол улсын Байгаль орчны яамны бүртгэлээр, Монгол улсын 76.8%-ийн газар нутаг адил бус хэмжээгээр цөлжиж байгаа, үүнд цөлжсөн тал нутгийн хохирсон хэмжээ хамгийн ноцтой, ургамлын төрөл 33 зүйл

<sup>6</sup> Юнмэй, Бао Юйхай: “Сүүлийн 10 жилийн Монгол улсын элсэн шуургат цаг агаарын онцлогт анализ хийх нь”, “Эсрдлийг задлан шинжлэх ба хямралын тусгал дахь мэдээллийн технологи—Хятадын Гамшгаас сэргийлэх нийгэмлэгийн Эсрдлийг задлан шинжлэх тусгай комиссын 6-р ээлжит хурлын өгүүллийн эмхтгэл”, 2014 он.

<sup>7</sup> (Монгол) Л.Хайсандай, Боржигин Цэцэнбат: “Монголын аюулгүй байдлын асуудал—стратегийн судалгаа болон задлан шинжлэлт”, Улаанбаатарын Бямба хэвлэлийн газар, 2008 оны 04-р сар, 248-р хуудас.

<sup>8</sup> Мэн Шүбяо, Вэнь Сүчин: “Манай улсын умардын газар нутгийн цөлжилтийн шалтгаан болон түүнээс сэргийлэх зохистой арга”, “Хэбэйн ойн жимсний судалгаа” 2002 оны 3-р хугацаа. (<http://www.cnki.com.cn/Journal/D-D4-HBLY-2002-03.htm>).

<sup>9</sup> Фү Жяньчао: “Манай улсын газар нутаг цөлжиж байгаа ба түүнээс сэргийлэх арга—агрономи—агрономи ой мод—мал аж ахуй загасны аж ахуй—мэргэжлийн бичиг материал”. “Шинжлэх ухаан технологийн инновац болон хэрэглээ”, 2013 оны 15-р хугацаа.

байснаа 18 зүйл болон буурч, нэг га талбайн ургамлын хураалт 320 кг байснаа 230 кг болон буурсан<sup>10</sup>. Оршин амьдрах нөхцөл муудсаны улмаас жил бүрийн хаврын улирал болоход 10 мянга шахам зээр болон бусад зэрлэг амьтан Хятадын Өвөр монголын хил хязгаарын тал нутагт орж ирдэг. Сүүлийн жилүүдэд Монгол улсын ховор амьтан болох мазаалайн тоо огцом буурч, 50 гаруй байснаа одоо 30 гаруй болон буурч, мөхөх аюул нүүрлээд байна. Газар шороо ноцтой цөлжсөний уршгаар, тал нутаг аажмаар муудаж, Монгол улсын өмнөд бүсийн цөөн бус газарт зуны улиралд ногоон бүрд харагдахгүй болсон.

### ***Гурав. Хятад Монгол элсэн шуургыг зассан арга хэмжээ***

#### **1. Хятадын талын авч буй арга хэмжээ**

##### ***1. Элсэн шуургыг ажиглах сүлжээ байгуулах нь***

Хятад орон Таримын элс, Тэнгэр элс, Шар хөрст өндөрлөгийн хойт талд элсэн шуургыг ажиглах станц байгуулсан суурин дээр 2002 онд Өвөр монголын Хорчины элсэрхэг газрын зүүн биед элсэн шуургыг ажиглах станц байгуулсан. Хорчины элсэрэг газар бол Хятадын дөрвөн том элсэрхэг газрын дотор талбайгараа хамгийн том (50 мянган хавтгай дөрвөлжин км) элсэрхэг газар юм. 2009 онд Бадйан жараны элсэнд элсэн шуургыг ажиглах станц байгуулж, 2010 онд Эзнээ хошуунд элсэн шуургыг хэвийн ажиглах хоёр станц байгуулж, голдуу Монгол улсын элсэн шуургын голомтыг өдөржин шөнөжин ажиглаж, элсэн шуургын үүсэхийг нэн оновчтой урьдчилан мэдээлэхэд зориулагдсан байна. Өвөр монголын цаг агаарын байгууллага бас өөртөө засах орны хэмжээнд 5 доплер радар (多普勒天气雷达), төрөл бүрийн чадавхтай цаг агаарын 11 радар байрлуулж, дунд баруун хэсэгт элсэн шуургыг ажиглах 6 станц байгуулж, цаг агаарын стерео хайн хэмжилтийн сүлжээ, компьютерын мэдээллийн сүлжээ, хиймэл дагуулийн аслын удирдлагын хянан шалгах сүлжээ болон цаг агаарын үйлчилгээний сүлжээ байгуулж, их хэмжээний элсэн шуургат цаг агаарыг оновчтой цаг тухайд нь урьдчилан мэдээлэх болжээ<sup>11</sup>. Одоогоор, Хятадын эл байгууллагад төрөл бүрийн цаг агаарын ажиглах станц 3000 гаруй бий, тухайлбал хиймэл дагууль, радар, нисэх онгоц зэрэг төрөл бүрийн хайн шинжлэх арга хэмжээгээр элсэн шуургад стерео, диманик хянан хэмжилт хийж байна. Элсэн шуургыг хянан шинжлэх болон урьдчилан мэдээлэх нь Хятадын эл шатны цаг агаарын станцуудын өдөр тутмын ажил болсон.

##### ***2. Бээжин, Тяньжиний салхин элстэй тэмцэх төсөл хэрэгжүүлэх нь***

Бээжин Тяньжиний салхин элсийг засах төсөл бол хөрсийг тогтворжуулж элснээс сэргийлэн, Бээжин, Тяньжиний элсэн шуургат цаг агаарыг бууруулахын тулд боловсруулсан Бээжин, Тяньжиний ойр хавийн бүс нутгийн хөрс шороо цөлжиж байгаад зориулсан засах арга хэмжээ болно. Төслийн нэгдүгээр ээлжийн ажил 2002 онд эхэлсэн. Төсөл хэрэгжсэн эхний 10 жилд, улсаас нийт 41.2 тэрбум юаний хөрөнгө оруулж, тариалахыг болиулж ойжуулсан ба мод тарьсан талбай 6 сая гаруй га болж, өвсөт газрыг 130 гаруй сая мүү (亩) засан сайжруулж, жижиг урсгалыг ерөнхийлөн зассан хэмжээ 12 мянган хавтгай дөрвөлжин км болж, 170 мянга гаруй хүнийг экологийн нүүлгэлт хийлгэсэн. Төслийн бүс дэх ойн хүчилтэн хэмжээ 15% болж дээшилсэн. Бээжин, Тяньжинь зэрэг газрын салхин элсний хор хөнөөлийг улам нэг алхам бууруулах шаардлагын дагуу, Хятад орон Бээжин, Тяньжиний салхин элсийг засах хоёрдугаар ээлжийн төслийг хэрэгжүүлж байна. “Бээжин, Тяньжиний салхин элсийг засах хоёрдугаар

<sup>10</sup>(Монгол) Монгол улсын Хөгжлийн судалгааны төв: “Монгол улсын байгаль орчин болон тал нутгийн мал аж ахуйн зарим асуудал”, Улаанбаатарын хэвлэлийн газар, 1999 оны 03-р сар, 30-р хуудас.

<sup>11</sup>Хятадын Үндэсний ой модны товчоо, “Хятадын ногоон хөгжлийн таймс” сонин, 2006 оны 05 сарын 17.

ээлжийн ажлын төлөвлөгөө (2013-2022)”-ний дагуу, Хятад орон 10 жилийн хугацаанд 87.8 тэрбум юанийн хөрөнгө оруулах болно.

### **3. Ногооруулалт ба элсийг засах арга хэмжээ**

Хятадын Өвөр монголын өөртөө засан орон цөлжилттэй тэмцэх талаар ихээхэн амжилтад хүрсэн. Хөвчийн элсийг засах, Аохан хошууны мод тарьж ногооруулах ажлыг өрнүүлж НҮБ-ын (联合国) шагнал хүртсэн. 2017 оны 07-р сарын 03-05-ны өдөр Ираны нийслэл Тегеранд (德黑兰) болсон Олон улсын элсэн шуургаас сэргийлэх их хурал дээр, Хятадын Хөвчийн элсийг зассан загвар хуралд оролцсон улсуудын анхаарлыг ихээр татаж, “Элсэн шуурганаас сэргийлэх сайн арга” хэмээгдсэн байна. Хөвчийн элс бол Хятадад 7-р байр эзэлдэг том элс, нийт талбай нь 18.6 мянган хавтгай дөрвөлжин км, Бээжин, Тяньжинь, Хэбэйнь гурван том салхин элсний голомтын нэг байсан юм. 30 жилийн өмнө, Хөвчийн элс бол халцгай газар байж, элсэн шуургын гамшиг ихтэй байсан. Өдгөө, ногоорон хөхөрсөн мод, элсний бургас зэрэг бутлаг модод болон таримал бэлчээр нь элсэн далайд ногоон цув нөмрүүлсэн байна.

НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Байгаль орчны хөтөлбөрийн дарга Солхэймер их хуралд тавьсан илтгэлдээ Хятадын Хөвчийн элсийг зассан удирдагч, Или группын ТУЗ-ийн дарга Ван Вэньбяог дэлхийн “Элс зассан удирдагч” хэмээн өндрөөр үнэлж, Хөвчийн элс нь Хятадын Засгийн газрын байгаль орчныг хүндэтгэн үзэж байгаа эрч хүч болон элсэн шуургатай тэмцэх талаар хийсэн идэвхтэй хайлт, “Нэг бүс нэг зам” дагуух улс орнууд болон дэлхийн суралцууштай зүйл хэмээсэн байна.

Өвөр монгол бол Хятадын экологийн чухал чадамжийн бүс юм. Тал нутагт амьдардаг хүмүүс эх байгалиа нандигнан хайрлаж, тэнгэр газрыг эцэг эх, ус бэлчээрийг өмсөх хувцас шигээ үздэг. Одоогоор Өвөр монголд 182 дархан цаазтай газар, 43 үндэсний ой модны парк, 49 нугын парк, дэлхийн геологийн парк 3, үндэсний геологийн парк 8 бий<sup>12</sup>.

### **2. Монголын авч буй арга хэмжээ**

Монгол улсын 90%-ийн нутаг дэвсгэр нь хуурай ба хагас хуурай бүс нутаг, Ази болон дэлхийн элсэн шуурга ба цөлжилт хамгийн ихтэй улсын нэг. Монголыг НҮБ-аас цөлжилт хамгийн их байгаа 11 улсын нэгээр жагсаасан. Монгол улсын Засгийн газар 1996 онд цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулж, Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо байгуулсан бөгөөд “НҮБ-ын цөлжилттэй тэмцэх конвенц”-ийн гишүүн улсаар элссэн. Монгол улс бас 2005 оноос эхэлж “Ногоон бүс төлөвлөгөө” хэрэгжүүлж, 3000 км урт, 600 км өргөн ногооруулсан зурвас байгуулахаар дурьдсан. Дараа нь 2030 он гэхэд цөлжсөн газар нутгийн талбайг 10% бууруулахын зэрэгцээ улсынхаа нутаг дэвсгэрийн талбайн 1/3-ийг үндэсний дархан цаазтай газрын хүрээнд хамруулах төлөвлөгөө боловсруулсан.

Байгаль экологийн хүнд ноцтой байдалд зориулж, Монгол улс цөлжилттэй тэмцэх үндсэн шатны хянан удирдах цэг 1500 байгуулж, 14 аймаг цөлжилттэй тэмцэх төлөвлөгөө боловсруулсан. “Ногоон бүс төлөвлөгөө”-ний хүрээнд, Засгийн газрын төсөв болон олон улсын байгууллагын хөрөнгө мөнгийг ашиглан 70000 га ойн хамгаалалтын зурвас байгуулж, нутаг дэвсгэрийн 10%-ийг эзэлдэг говийн цөл газрыг дархан цаазтай газар болгосон байна.

<sup>12</sup>Бү Шяолин: “Өвөр монголыг хайрлах N шалтгаан”. ХКН-ын ӨМӨЗО-ны хорооны нарийн бичгийн даргын орлогч, ӨЗО-ны Засгийн газрын дарга Бү Шяолин БНХАУ-ын Гадаад Явдлын яамны Өвөр монголыг танилцуулах арга хэмжээн дээр хэлсэн үгэндээ Өвөр монголыг хайрлах N шалтгааныг бүх дэлхийд танилцуулсан байна.

Бэлчээрийг хамгаалж, элсэн шуургатай тэмцэж байна. Бэлчээрийг хамгаалан, тал нутгийн экологийн сайн сайхан эргэлтийг ахиулахын төлөө, Монгол улсын Засгийн газар малчдыг уриалж шинжлэх ухаанчаар мал маллаж, малын сүргээ зохистой тохируулж, малын чанар чансааг дээшлүүлж байна. Үүний тулд Засгийн газраас махны зүйлийн экспортыг нэмэгдүүлж, ямааны тоог бууруулж, малын тоо толгойг тал нутгийн ачаалах хэмжээтэй зохицуулж байна. Монгол улсын Засгийн газар дэвшилтэт шинэ тоног төхөөрөмж ашиглаж, усны нөөцийг хэмнэж, байгаль орчныг бохирдуулах ба экологийг эвдэхээс сэргийлэхийг уул уурхайн олборлох аж ахуйн нэгжид шаардаж байна. Монгол улсын Засгийн газар бас урьдчилан 3-7 хоногт элсэн шуургатай цаг агаарыг урьдчилан мэдээлэхийг цаг уурын байгууллагад шаардаж, элсэн шуурганаас сэргийлэх арга хэмжээ авахыг малчдад сануулж байна.

***Дөрөв. Хятад, Монгол улс хамтран элсэн шуургатай тэмцэх***

**1. Хятад, Монгол хоёр тал хамтран элсэн шуургатай тэмцэх ажлыг дээд хэмжээнд авч үзэх нь**

2002 оны 01-р сард Монгол улсын экс Ерөнхийлөгч Н.Энхбаяр Хятадад айлчилж байх үедээ хоёр улсын холбогдох байгууллага хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, элсэн шуургатай хамтаар тэмцэх санаачлага гаргаж, үүний тулд хоёр тал холбогдох гэрээ байгуулсан. Хятад Монгол хоёр талын олон талын хамтын ажиллагааны үндсэн дээр, 2009 оны 07-р сард Хятадын Засгийн газар Монгол улсад элсэн шуургыг хянан шинжих хоёр станц бэлэглэж, Монгол улсын төв хэсгийн Өвөрхангай аймаг болон зүүн хэсгийн Хэнтий аймагт угсарсан.

2013 оны 10-р сард Монгол улсын экс Ерөнхий сайд Н.Алтанхуяг Хятадад айлчилж, Хятадын талтай уулзалт хийх үеийн ярилцлагын гол сэдвийн нэг бол экологийн орчныг хамгаалах асуудал байсан. Тухайн үед Монгол улсаас БНХАУ-д суугаа элчин сайд Сүхбаатар уул уурхайн олборлох ажлын хөгжихийг дагалдан, экологийн орчинд нөлөөлөх нь зайлшгүй. Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “Ногоон бүс” төсөл Хятадын талтай хамтран ажиллах, Хятадын дэвшилтэт технологийг оруулж ирэхийг хүсэж байна гэсэн. Монголын талын шаардалагад Хятадын тал чадахын хэрээр тусалж байна. Сүүлийн жилүүдэд, Монголын тал Хятадын талын технологийн дэмжлэгээр, Хятадын шилдэг чанарын модыг оруулж амжилтад хүрч, Улаанбаатар болон Өмнөговь аймгийн ногооруулалтын талбай тэлж байна. Өвөр монголын Их Хянган даваанд ургуулж Монгол улсад экспортлосон 15 сортын 120 мянган ширхэг ногооруулалтын мод хэдэн өвлийг өнгөрөөх туршилтаар дамжиж тухайн газрын орчинд бүрмөсөн дасч, ургалт нь 90%-д хүрч байна.

**2. Элсэн шуурга бол хүн төрөлхтөнд нүүрлэсэн хамтын гамшиг**

Элсэн шуурга голдуу ган хуурай бүс нутагт үүсдэг боловч дамжуулан хүргэсэн болон тунамал нь дэлхийн цаг агаар болон экологийн орчинд нөлөөлж, хүн төрөлхтний хамтын гамшиг болж байна. Сүүлийн жилүүдэд, Монгол улс болон Хятадын нутаг дэвсгэрт шуурсан хүчтэй элсэн шуурга нь нэгэнт зүүн хойд азийн зарим улс орнуудад дахин давтан нөлөөлж, цаашлаад умард Америкийн эх хуурайд хүртэл шуурсан байна. Өргөн уудам нутаг дэвсгэр, үзэсгэлэнт сайхан байгаль орчноороо алдаршсан ОХУ ч үүнээс зайлсхийж чадаагүй, 100 сая шахам га талбай газар нь цөлжилтийн аюул нүүрлэж, үүнд урд зүгийн бүс нутгийн цөлжилтийн аюул хамгийн хүнд ноцтой байж, Сибирийн өмнөд хэсэг болон хойт Байгалын бүс нутгийг нөлөөлсөн байна. Иймээс элсэн шуургын гамшгийн нөлөөг устгахад заавал бүх дэлхийн хүрээнд тэмцэх хэрэгтэй. 2017 оны 07-р сард Тегеранд болсон Элсэн шуургатай тэмцэх олон

улсын их хурал дээр НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Байгаль орчны хөтөлбөрийн дарга Солхэймер илтгэлдээ олон улсын нийгмийг элсэн шуургатай тэмцэх болон цөлжилттэй тэмцэх хүрэн дэх хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, НҮБ-ын 2030 оны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг бүх талаар баталгаажуулах хэрэгтэй гэж уриалсан. Ираны ерөнхийлөгч Рохани тус хурал дээр хэлсэн үгэндээ<sup>13</sup>, элсэн шуурга бол хүн төрөлхтөнд нүүрлэсэн экологи, үйлдвэрлэл амьдралын хамтын хүндрэл мөн. Элсэн шуурга бол нэг улс орон, бүс нутгийн асуудал биш, дэлхийн асуудал, дэлхийн улсууд хамтаар шийдвэрлэхийг шаардаж байна гэж хэлсэн байдаг.

*Эцэст нь хэлэхэд:* Байгаль орчныг хамгаалах бодлого нь хүн ба хүрээлэн буй орчны бодлогын хамаарлыг хэрхэн засаглах тухай бодлого гэж ойлгож болох юм. Байгаль орчны бодлогыг ойлгох нэг арга зам нь түүхэн хөгжил хувьслыг ажиглах явдал юм. Дэлхийн улс орнууд байгаль орчны бодлогыг төрийн хэмжээн авч үзэж, ихээр дэмжиж явуулж байна. Энэ асуудлыг нухацтай авч үзэж, шийдвэрлэхийн тулд улс төрийн бодлого, төрийн үйл ажиллагаанд судалгаа шинжилгээтэй бодлого явуулж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Ийм учраас “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ын сайн сайхан нөхцөл байдлыг түшиглэн Хятад, Монгол хоёр улс ОХУ болон дэлхийн нийгэмлэгтэй хамтран элсэн шуургын хор хөнөөлийг үндэснээс нь устгах буюу бууруулах нь гурван улсын эдийн засгийн коридор байгуулахад алс хэтийн стратегийн ач холбогдолтой билээ.

### ***Abstract***

The necessary condition for building a "China-Mongolia-Russia economic corridor" is to have a good ecological environment. Both 《the mid-term cooperative road map of China-Russia-Mongolia》 authorized by the leaders of China-Russia-Mongolia in 2015 and 《constructive plan of China-Russia-Mongolia economic corridor》 subscribed in 2016 specifically set the content of ecological cooperation. Sandstorms frequent attacks for a long time, including China, Mongolia and other countries and regions, and also sandstorms seriously damage the transportation and infrastructure in the frequent areas and hinder the sustained development of the economy and society. The harm of sand storms will certainly affect the smooth implementation of China-Mongolia-Russia economic corridor. Base on research, more than half of the sandstorms in China come from other countries, mainly from the southern part of Mongolia. So, depend on The excellent background China-Mongolia-Russia economic corridor, China Mongolia Russia and international community Prevention and Control sand storm, To avoid or reduce the damage of sandstorms, and to promote the construction of the China-Mongolia-Russia economic corridor has long-term strategic significance.

***Keywords:*** China-Mongolia-Russia economic corridor, Sand storm, China and Mongolia Collaboration on the Prevention and Control

<sup>13</sup>Ван Зыхөү, Чяо Шюэфэн: “Дэлхий нийтээрээ элсэн шуургатай тэмцэхэд анхаарлаа хандуулж байна, Хятадын Хөвчийн элсний загвар таалагдаж байна” Синтхуа сүлжээ, 2017 оны 07-р сарын 07-ны өдөр.

### ЗОХИОГЧИД

| Зохиогчийн нэр    | Ажил, албан тушаал                                                                                           | E-mail                  |
|-------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|
| Ж.Төртогтох       | МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, профессор                             | turtogtokh@yahoo.com    |
| Д.Уртнасан        | МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн магистрант                                     | toto_bear@yahoo.com     |
| Т.Заяа            | ХИС-ийн ОУХНС-ын тэнхимийн багш                                                                              | Zaya.t@humanities.mn    |
| О.Хатанболд       | ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр – эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан                   | khatanboldo@gmail.com   |
| Дамдин Д.Бадараев | ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвд, Буддын судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан | Damdin80@mail.ru        |
| М.Мөнхзул         | ХААИС-ЭЗБС-ХААХЭЗТ тэнхимийн ахлах багш                                                                      | munkhzul@mul.su.mn      |
| Д.Ундрах          | МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн дэд профессор                                  | ddj_undrakh@yahoo.com   |
| Ц.Ганболд         | МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн зөвлөх профессор                               | Ts.ganbold@gmail.com    |
| С.Жавхлан         | МУИС, ШУС, Нийгмийн Ухааны салбар, Улс төр судлалын тэнхимийн докторант                                      | doljko_18@yahoo.com     |
| Э.Саранцэцэг      | БНСУ-ын Сүншил их сургуулийн Улс төр судлалын докторант                                                      | e.saraa_elite@yahoo.com |
| Д.Сүхболд         | Улаанбаатар Эрдэм Оюу Их Сургуулийн ахлах багш                                                               | sukheemodun@yahoo.com   |

|               |                                                                                                             |                              |
|---------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|
| Д.Түмэнжаргал | МУИС, ШУС, Нийгмийн<br>Ухааны Салбар,<br>Улс төр судлалын тэнхимийн<br>ахлах багш                           | Tumeedavaa12@gmail.com       |
| Г.Эрдэнэбаяр  | МУИС, ШУС, Хүмүүнлэгийн<br>Ухааны Салбар,<br>Философи, шашин судлалын<br>тэнхимийн дэд профессор            | erdenebayar.g@num.edu.mn     |
| Д.Оюунчимэг   | МУИС, ШУС, Нийгмийн<br>Ухааны салбар, Улс төр<br>судлалын тэнхимийн ахлах<br>багш                           | <u>oyun_de@yahoo.com</u>     |
| Г.Цогтдэлгэр  | МУИС, ШУС, Байгалийн<br>Ухааны Салбар,<br>Газарзүйн тэнхимийн<br>докторант                                  | share.quick30@gmail.com      |
| У.Батцэрэн    | Удирдлагын Академийн<br>Төрийн Албаны Сургуулийн<br>Сургалтын менежер                                       | battseren@naog.gov.mn        |
| Ц.Чулуунцэцэг | СЭЗИС-ийн Гадаад<br>хэлний<br>институтын ахлах багш                                                         | chuluuntsetseg.ts@ufe.edu.mn |
| Б.Эрдэнэдалай | МУИС, ШУС, Нийгмийн<br>ухааны салбар, Улс төр<br>судлалын тэнхимийн ахлах<br>багш                           | erdenedalai.bat@gmail.com    |
| С.Хасчулуу    | МУБИС, Нийгэм,<br>Хүмүүнлэгийн Ухааны<br>Сургууль,<br>Нийгмийн Ухааны Тэнхимийн<br>докторант                |                              |
| Э.Наран       | Өвөрмонголын Их<br>Сургуулийн<br>Монгол улсыг судлах<br>хүрээлэнгийн<br>профессор, шинжлэх ухааны<br>доктор |                              |

